

ЖОН БИВЭР

БЭСТСЕЛЛЕР ЗОХИОЛЧ

**БУРХАНААС
ЭМЭЭХҮЙ**

БУРХАНААС ЭМЭЭХ
ЭРҮҮЛ АЙДАС ТАНЫ АМЬДРАЛЫГ
ЕР БУСААР ӨӨРЧИЛНӨ


Хүндэт найз минь

Эмээхүйг аймшиг, гайхамшгийг хослуулсан бишрэл бүхий мэдрэмж хэмээн дүрслэх. Бурханаас эмээх энэхүү эрүүл, хүндэтгүүштэй, ариун айдсыг итгэгч хүн болгон эрэлхийлэх ёстой. Учир нь Бурханы амлалт бүрийн суурь нь Бурханаас эмээхүй болой.

Ийм эмээхүй нь цэц ухаан, Бурхантай дотно амьдрах, урт удаан наслах, нэр хүнд, аюулгүй байдал, өнө мөнхийн настай өвийг бүтээх зэрэг үй олон ашиг тустай. Өөрийг нь дуулгавартай бөгөөд үнэнээр дагахыг эрэлхийлэн мөшгидөг хүмүүстэй Бурхан ойр байдгийг Бичээс тов тодорхой өгүүлдэг. Есүс Өөрөө ч энэ чанарыг юу юунаас дээдээр нандигнаж явсан тул бидний хувьд ч Түүнийг үлгэрлэн дууриах нь ухаалаг буюу.

Миний бие таныг Христийн нэрийг барьсан амьгүй, гунигт шашинлаг амьдралаа Бурхантай насан туршийн, амьд харилцаатай, дотно, утга төгөлдөр, үр жимстэй, бүрэн бүтэн, элдэв айдас зовнилоос эрх чөлөөт амьдралаар арилжихыг уриалан дуудаж байна.

Христ доторх



Жон Бивэр ахаас чинь
JohnBevere@ymail.com



MessengerX



Messenger
INTERNATIONAL

БУРХАНААС ЭМЭЭХҮЙ

Бурханаас эмээх эрүүл айдас таны
амьдралыг ер бусаар өөрчилнө

ЖОН БИВЭР

The Awe of God, (Mongolian), by John P. Bevere

© 2023 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as The Awe of God

ISBN 978-1-400-33670-8

Author photo © Meshalli Mitchell

Additional resources in Mongolian are available

for free download and video streaming at

MessengerX.com and on the **MessengerX** app

To contact the author : JohnBevere@ymail.com

This international leadership seeding edition of the Awe of God book has been produced in collaboration between **Thomas Nelson** and **Messenger International**.

It is a free gift and is

NOT FOR SALE

Printed in Mongolia

Бурханаас эмээхүй: Бурханаас эмээх эрүүл айдас

таны амьдралыг ер бусаар өөрчилнө, Жон Бивэр

© 2023 Мессенжер Интернэйшнэл

MessengerInternational.org

Номын англи нэр: The Awe of God

ISBN 978-1-400-33670-8

Зургийн зохиогч © Meshalli Mitchell

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа

MessengerX.com болон **MessengerX** app -аас шууд үзэх эсвэл
утсандаа татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Бурханаас эмээхүй номыг олон улсын удирдагч нарт зориулан **Thomas Nelson**
болон **Мессенжер Интернэйшнэл** байгууллагаас хамтран бүтээв. Энэ номыг
Монголчууддаа бэлэг болгон өгч буй тул

ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв



App Store бол Apple ХХК-ийн АНУ болон олон улсад бүртгэлтэй худалдааны тэмдэг.

Google Play болон Google Play лого нь Google ХХК-ийн худалдааны тэмдэг.

*Миний ер бусын гэргий, дотны найз,
хамгаас хайрт Лиза Бивэрдээ:*

*“ЭЗЭНээс эмээгч эмэгтэй л магтаал авах учиртай.”
Сургаалт үгс 31:30*

*Энэ номоо би гал голомтоо асаасныхаа
40 жилийн ой дээр бичлээ. Бидний амьдрал жил ирэх тутам
улам л цэцэглэсээр байх агаад дахиад хувь завшаан тохиох аваас
би чамтайгаа дуун дээрээ л гэрлэнэ. Зүрхийг минь гийгүүлдэг аз
жаргал, баяр хөөрийг ямархан үгээр илэрхийлэх билээ.
Чиний хайр, түшигийн ачаар л өнөө би өдий зэрэгтэй явна.
Цэц ухаантай, хөөр хөгжилтэй, хайлуулж бас уяраадаг, хатуу
бас чадуу, шинийг эрэлхийлэгч, үзэсгэлэнт чамдаа
би мөнхөд хайртай.*

*Эзэнээс эмээхүй нь гагцхүү машид ихээр хайрлагдсан хүмүүст л
өгөгдсөн ... эрдэнэс, шилмэл эрдэнэ болой.*

АГУУЛГА

Энэ номоор хэрхэн аялах вэ?	9
Танилцуулга	13

Нэгдүгээр долоо хоног: ГАЙХАМШИГТ БУРХАН

1. Бурханы эрдэнэс	19
2. Эсрэг тэсрэг хоёр айдас	25
3. Ариун эмээхүй гэж юу вэ?	31
4. Бурханы биет оршихуй	37
5. Мартагдашгүй орой	43
6. Эзэнийг үзэгтүн	49
7. Бурханы алдар	55

Хоёрдугаар долоо хоног: ИЛЧЛЭГДСЭН

8. Таны үнэ цэнэ	63
9. Аюултай мөргөлдөөн	69
10. Бурхан харахгүй	75
11. Айдас бөгөөд чичрэл	81
12. Хоёр нүүрлэх нь халдвартай бөгөөд халтай	87
13. Гурван дүр	93
14. Мөнхийн шийдвэр	99

Гуравдугаар долоо хоног: Тэсвэрлэшгүй ариун чанар

15. Хүнээс айх нь	107
16. Эрх	113
17. Ёрын муугаас зайл	119
18. Мөнхөд тогтох	125
19. Өөрсдийгөө цэвэрлэх	131
20. Ариун байдлыг мөшгихүй	137
21. Дур хүсэл ба эрх хүч	143

Дөрөвдүгээр долоо хоног: БУРХАНЫ ҮГД ХАРИУЛАХУЙ

22. Бурханы Үгд чичрэхүй	151
23. Үтэр түргэн	157
24. Ямар ч утгагүй гэмээр	163
25. Ил харагдах ашиг байхгүй үед ч	169
26. Ашигтай зовиур	175
27. Гүйцээ	181
28. Мөс чанараа хуйхлуулах?	187

Тавдугаар долоо хоног: БУРХАНТАЙ ДОТНО БАЙХ

29. Дотносол эндээс л эхэлнэ	195
30. Өөр Есүс	201
31. Чамайг мэдэхгүй	207
32. Эзэний нууц	213
33. Ойрын хүрээлэл	219
34. Нүүр нүүрээрээ	225
35. Та нар Миний нөхөд	231

Зургадугаар долоо хоног: ЭРДЭНЭСИЙН АШИГ ТУС

36. Бурханы амлалтыг тогтноох	239
37. Айдсыг сөнөөдөг айдас	245
38. Өв	251
39. Хамгийн чухал зүйл	257
40. Амжилттай амьдрал	263
41. Төгсгөсөн шиг төгсгөх	269
42. Эрдэнэсийг олох	275

<i>Хавсралт: БУРХАНЫ АУГАА ЧАНАРЫН ЗАХ ЗУХААС</i>	285
<i>Номын зүүлт</i>	293

ЭНЭ НОМООР ХЭРХЭН АЯЛАХ ВЭ?

Хүндэт уншигч та,

Энэ ном зүгээр нэг ном бус, харин миний итгэж, итгэл дээрээ үндэслэн үйлдэж ирсэн, амь амьдралын үг болой. Эдгээр үнэн миний төдийгүй, өөр үй олон хүний амьдралыг өөрчилсөн болохоор би ч үүндээ итгэл төгс байна. Надаас гэрлэлт, гэр бүл, үйлчлэл тэргүүтэй зүйлсийн талаар зөвлөгөө асуух бүрийд би энэ номын агуулга руу л ордог.

Чухал болохоор нь ч үүнийг хэрхэн танилцуулах тал дээр олон ч цаг, залбирал зориуллаа. Өнөөгийн бидний амьдралын давалгаа, урсгал - бидний ажил амьдарлын цагийн хуваарь, хэмнэлийн хурдыг бодолцохдоо, эдгээр үнэнийг хумсны толион чинээ атлаа хүлхүүртэй байлгах үүднээс яг нэг өдөртөө под хийсэн хэмжээгээр танилцуулахаар шийдлээ.

Эхлээд чимээгүй цагийн материал шиг санагдаж болох ч, биш болохыг хэлье. Тайлбарлая. Чимээгүй цагийн материал нь голдуу өдөр өдөртөө ондоо сэдэвтэй байдаг бөгөөд эдгээр нь явсаар нэг цогц системтэй мессеж болж угсрагдах албагүй. Тиймээс ном маань чимээгүй цагийн материал шиг харагдаж болох ч, яг л бүрэн хэмжээний зохиол шиг шинэ өдрийн үг нь өмнөх өдрийнхөө бүлэг дээр хэлбэршинэ. Ерөнхийдөө, уншигч өөрөө хэрхэн уншихаа шийддэгээрээ давуу талтай. Хүсбэл, ганц, хоёр хоногийн дотор маналзуулаад дуусгаж ч болно. Тийм боловч миний зүгээс танд өдөр нэг бүлгийг унших маягаар зургаан долоо хоногийн хугацаанд дуусгах эсвэл өглөөдөө нэгийг, оройдоо нэгийг унших маягаар гурван долоо хоногийн хугацаанд дуусгахыг л зөвлөнө.

Бүлэг бүрийн төгсгөлд тухайн агуулгын шингэцийг сайжруулах зорилгоор дотроо таван багаж бүхий “Хувийн сургамж” нэртэй хэсгийг багтаасантай танилцана уу:

Энэ номоор хэрхэн аялах вэ?

1. **Эшлэл:** Энд тухайн өдрийн мессежийн голыг базаж гаргасан юмуу мессеж дотроо оруулаагүй боловч, агуулгад хүч нэмэх эшлэлийг бичсэн болно. Эдгээр эшлэлийг нүдлэн цээжлэхийг машид санал болгож байна.
2. **Санаа:** Энэ нь тухайн бүлгийн агуулгын амийг давтан сануулж, дахин давтсан хэсэг болно. Бүлгийнхээ гол санааг сэргээх үүднээс энэ хэсгийг эргүүлэн харж, сурсан эрдмийнхээ үр нөлөөг идэвхижүүлж болно.
3. **Эргэцүүлэл:** Энэ тун чухал. Магтаалч “Би тушаалуудыг тань бясалгаж, Таны замуудыг эргэцүүлэх болно” (Дуулал 119:15) гэсэн. Бурханы Үг бидний одоогийн нөхцөлд хэрхэн хэрэгжих талаар тархиндаа эргэлдүүлснээрээ тунгаан боддог. Ингэснээр бидний зам хөгжин цэцэглэж, бид сайн сайхан амжилтанд хүрнэ гэсэн (Иошуа 1:8, Дуулал 1, 1Тимот 4:15-ыг үзнэ үү).
4. **Залбирал:** Энэ нь тухайн бүлгийн сургаалыг тунгаасан залбирлыг ч багтаасан хэсэг. Бурхан бидний дуу хоолойг сонсож, бид ч Бурханд Үгийнхээ дагуу биднийг өөрчлөхийг зөвшөөрөх нь тун чухал.
5. **Шийдвэр:** *Ухэл, амьдрал нь* бидний үзэж харах зүйлийн хүчинд орших гэдэг (Сургаалт үгс 18:21). Бидний дээгүүр Бурханы мэдэгддэг үгсийг тунхаглах аваас сүнс, сэтгэл, бие маань бидэнд хандсан Түүний хүсэлтэй зэрэгцэх бөгөөд энэ нь амийг бүрэн дүүрнээр илэрхийлэх багтай арга буюу.

Тэгэхээр, энэ номд үнэхээр цаг гаргахын ахин дахин зоригжуулж байна. Тэгж байж л Бурханы Үгийн үнэн зүрх, тархинд чинь нэвт шингэнэ. Ирэх хэдэн долоо хоногийн турш өдөр бүр эдгээр үнэнийг ухаж түнхэж, шингээж, амьдралынхаа хөрсөнд нэг мөр үндэслүүлээд аваарай. Зүгээр нэг мэдээлэл гэж андуурав! Үгүй шүү. Энэ чинь Бурхантай дотносох зам. Бүлгээ уншаад, “Хувийн сургамжаа хийнгээ” цээжиндээ хий гүйлгээд өнгөрөлгүй, давхар тэмдэглэгээ хөтлөхийг санал болгомоор байна. Түүн дээрээ өдөр тутмын бодол, залбирлаа бичбэл, хожим сэргээж харах ч боломжтой, Ариун Сүнсний сануулсан зүйлс ч үлдэцтэй болно.

Эцэст нь дахин ганц, хоёр зүйл зөвлөе: Нэгдүгээрт - Бүлэг,

Энэ номоор хэрхэн аялах вэ?

“Хувийн сургамж”, тэмдэглэлээ хийж дуусгахад хэр хугацаа зарцуулж байгааг цагаараа хэмжээрэй. Гялс дуусгахын төлөө бүү хийгээрэй. Уралдаан биш шүү. Хугацаагаа хэмжихийн гол учир нь - ийм маягаар хэдэн бүлэг уншсаныхаа дараа та цааш цаашдын бүлгээ хийх арга ухаанаа олж авна.

Хоёрдугаарт - дадал хөгжүүлээд, энэ цагаа юунд ч бүү алд. Бурхан өнгөрсөн дөчин жилийн хугацаанд миний дотор хийснээ энэ номоор дамжуулан таны ч дотор хийхийн төлөө найдаж бас залбирч байна.

Гуравдугаарт - сурснаа найз нөхөддөө заах юмуу ярьж өгөх нь өөрт хамгийн тустай байдаг. Ойрын дотно хүмүүсээ сонгоод, хамтдаа сурцгаа. Эхлээд Ариун Сүнстэй хоёулхнаа суралцаад дуусгасан бол, найз нөхдөө цуглуулаад, Түүний зааж өгснийг хуваалц. Үүнийгээ өдөр тутамдаа хий.

Бүлгээрээ суралцмаар байгаа бол, долоо хоног тутам бүлгээрээ судлах боломжтой *Бурханаас эмээхүй* нэртэй Библи судлалын цогц сургалтыг гарын авлагатай нь хэрэглээрэй.¹ Энэ сургалт Бурханы Үгийг бүр ч олон аргаар судлах боломжийг бүрдүүлсэн байгаа. Бичээс “Харин ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонсдог. ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг болгоодог хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ” (Малахи 3:16) гэдэг.

Бурханаас эмээхүй номоор хийх аяллын явцад Бурхан, та хоёрын харилцаа улам дотносохын төлөө залбирч байна. Шууд бүлэгтээ орохоосоо өмнө танилцуулга - оршил хэсгийн заавал уншаарай. Аялалд гарахын өмнө зүрх сэтгэлийг чинь тайлах учиртай чухал хэсэг шүү. Тэгээд номоо дуусгасан хойно чинь Бурханаас эмээхүйгээр таны итгэл, амьдралд ямар өөрчлөлт гарсныг сонсохоор чих тавьж байна.

Хүндэтгэсэн
Жон Бивэр

Санамж: Танилцуулга хэсгээ алгасуузай. Тэнд л таны дотор энэ номд гүн шумбуулах ариун эмээхүйн гал асах учиртай.

ТАНИЛЦУУЛГА

Айдас. Он жил өнгөрсөөр, хүмүүс ч үүнээс салах гэж оролдсоор. Айдсын нөлөөнөөс амьдралаа ангижруулах гэсэн олон ч судалгаа, тэмцэл, кампанит ажил өрнүүлсээр. Франклин Рүзвелт гуайн ч алдартай үг бий: “Бидний айж явах ёстой ганц зүйл бол айдас өөрөө юм.” Тайзан дээрээс айдсыг ялах тухай хашхирсаар, айдсыг хэрхэн ялах мянга мянган биш юмаа гэхэд, хэдэн зуун бие даалтын ном гарсаар. 1980-аад оны адгаас газар газрын хүмүүс “Айдас үгүй” хэмээн бүдүүнээр бичсэн, зүрх чангалсан уриа бүхий хувцас өмсөх болов. Хүн төрөлхтөн амьдралаасаа бүх айдсыг таягдан хаях байлдан дагуулалдаа шулууджээ гэмээр.

Энэ байлдан дагуулал маань утгатай, эрэлхэг, ухаалаг мэт санагдах бөгөөд энэ нь ч олон талаараа үнэн байж болох ч, үнэндээ “*Айдас болгон муу байх албагүй*” юм. Тэгвэл яахаараа ингэтэл улайрна вэ? Бүх айдсыг тэр чигээр нь “хор хөнөөлтэй” гэдэг ангилалд чихчихдэг болохоороо л тэр байх. Гэхдээ тийм гэж үү?

Нэгдүгээрт - үнэхээр ч зөв дүртэй ч, хөнөөлтэй айдас гэж бий. Тухай нь мөнгөгүй, хөрөнгөгүй болохоос айдаг хүн үүндээ автаж, бүхнээс дээгүүр мөнгө, хөрөнгийг шүтэж болно. Хань ижлээ алдахаас айдаг хүн мөнхийн дагуул мэт дагаж, үйл болгоныг нь тагнаж мөрдөнө. Аль аль нь дургүйцэлд хүргэж, эцэстээ харилцааг нь сөнөөнө. Ямар нэг юмнаас хоцрохоос айдаг хүн цаг үргэлж шинэ зугаа, үйл явдалтай хөөцөлддөг бөгөөд энэ нь бүрэн үнэнч зориулалттай хамт явдаг эрүүл хамт олон, жинхэнэ харилцаа, амгалан тайвных нь өртгөөр олдох. Үр хүүхдийнхээ аюулгүй байдлын төлөө айдаг бол, алхам тутмыг нь боомилж, нууцлаг, далдуур зан авирт хүргэж, өсөлтийг нь боогдуулна.

Нөгөөтэйгүүр, *учир зүйтэй* айдас нь ашигтай цэц ухаан хайрладаг. Өндөр хаднаас унах айдас нь хальтрахаас сэргийлэн зах руу нь хэт ойртохгүй байх цэц ухаан хайрлана. Хүрэн баавгайнаас

айх айдас нь бамбаруушт нь хүрэхгүй байх ухаан хайрладаг. Гуравдугаар зэргийн түлэгдэлээс айх айдас нь халуун зуухнаас хоолоо гаргахдаа бээлий өмсөх ухаан хайрладаг.

Учир зүйтэй айдас нь хэдий ийн ашигтай ч бас л завхарч, амьдралыг минь хохироох боломжтой. Эрүүл ухаантай байхгүй бол, унах айдас нь хүнийг онгоцонд суухаас хорьж, нэг ёсоороо чөдөрлөнө. Баавгайнаас айх айдас нь хүнийг ой модон дундуур алхахаас минь хорино, зуухандаа амттай сайхан хоол идэхээс минь хорино.

Тиймээс *бид юунаас хамгийн их айдаг вэ?* гэдгээ л асуух ёстой. Энэ нь хөнөөлтэй айдсыг хэрхэн сөнөөх дээр юмуу учир зүйтэй айдсаа зохицуулах дээр хамаг анхаарлаа барахаас хавьгүй дээр. Зөв хариулж чадах аваас бусад бүх айдсыг байранд нь тавьж, энэ бөгөөд ирээдүйн амьдралыг маань дэмжиж өгдөг ухаалаг асуулт юм. Энэ нь сайн бөгөөд дүүрэн амьдралд хүргэх замыг минь гэрэлтүүлж өгдөг. Библи айдсын талаар ихийг хэлдэг бөгөөд Эзэнээс эмээхүй нь цэц ухааны эхлэл (Сургаалт үгс 1:7) гэдэг нь үндсэн тоосго нь болно. Зүгээр нэг цэц ухаан бус, харин Бурханы цэц ухаан шүү. Энэ нь гараагаа хийх сайн эхлэл шүү.

Тэгэхээр, зөв чигтэй айдас нь *чанар* мөн байвал, яах уу? гэдгийг бодох л хэрэгтэй. Бурханаас эмээхүй нь Түүнтэй жинхэнэ харилцаанд хүргэх парадокс бүхий зам байвал, яах уу? Ариун эмээхүй нь Есүсийн дагалдагч нарын зуун зууны явцад эдэлсэн бүрэн дүүрэн амьдралыг нээдэг бол, яах уу? Энэ айдас нь бизнесээ эхлүүлэх, төр засгийнхаа үйл хэргээс, үр хүүхэддээ зовних, сэтгэцийн өвчин юмуу депрессэнд хүргэдэг айдас зэрэг тоочиж барашгүй бусад бүх айдсыг сөнөөдөг байвал, яах уу?

Аяллаа эхлүүлэхээсээ өмнө үнэний дөрвөн мэдэгдэл хийхийг минь болгооно уу:

1. Бид хүн бөгөөд айдаг.
2. Бурханаас эмээж айх явдал нь олон хүнд төсөөлөшгүй гүн гүнзгий, үзэсгэлэнтэй, дотно зүйл.
3. Бурханаас эмээхүй нь бусад бүх айдсыг залгидаг.
4. Бурханаас эмээхүй нь сайн сайхан бүхний эхлэл.

Библи дээр 365 удаа “бүү ай” гэж хэлдгийг зарим нөхөд маань зүй ёсоор сануулах байх. Үүнээс болоод Христэд итгэдэг олон хүн Бурхан биднийг айж эмээгээсэй гэж хүсдэггүй гэсэн дүгнэлтэнд хүрдэг. Гэхдээ эдгээр нь *хөнөөлтэй* айдсын талаар хэлсэн үг юм. Тэгээд ч би Библиэс “Бурханаас эмээхийг” сургасан 200 гаруй эшлэлийг зааж чадна. Хамгийн сайхан хэсэг нь: Бид амьдралаасаа аливаа айдсыг хөөх тэмцэл өрнүүлж байхдаа (Энэ дундаа Бурханаас эмээхүй чанарыг ч багтаачихдаг) итгэлийнхээ энэ хэсгийг нягтлалгүй, хэрэгжүүлж ч үзэлгүй, ашиг тусыг нь гаргалгүй орхидог.

Эзэнээс эмээхүй нь бидний санаснаас ч сүр жавхлантай, гайхал төрүүлмээр, тэр бүү хэл баясгамаар юм. Би та бүхэнд айдсыг - тэр дундаа юу юунаас тэргүүтэй Бурханаас айж эмээх чанарыг хэрхэн зөвөөр шалгах нь таны төсөөлснөөс хол аваачих амьдралд хүргэдгийг харуулмаар байна. Чарльс Спержен гуай “Бурханаас айх айдас нь бусад бүх айдсыг сөнөөх. Өмнөө байх бүх айдсыг аугаа арслан мэт зайлуулдаг”¹ гэдэг.

Та энэ номыг уншихдаа, энэ чанарт гүн шумбаад, буруугаар танилцуулдаг бүх шашинлаг гадрыг нь хуулж хаяад, хөлийг тань тогтвортой гадар дээр бат зогсоодог сайн сайхныг нь танин мэдээрэй. Тийм ээ, муугаас айж яв. Гэхдээ буруугаар танигдсан Эзэнээс эмээхүй чанар нь амьдралыг чинь үнэхээрийн зэрлэг гоо үзэсгэлэнтэйгээр цэцэглүүлдгийг мэдээрэй.

Бурханы ямар аугааг мэдэцгээе. Үүнийг бид Бурханаас эмээхүй гэдэг!

ГАЙХАМШИГТ БУРХАН

Нэгдүгээр долоо хоног

*Эзэнээс эмээхүй нь
гагцхүү Бурханаар хайрлагдсан
хүмүүст л заяагдсан сонгомол эрдэнэс,
үнэт эрдэнэ болой.*

— Жон Буняан

1 | БУРХАНЫ ЭРДЭНЭС

Үндсэндээ амь амьдралын алтан түлхүүр болох нэгэн нууцат чанар байдгийг би танд дуулгабал, яах уу? Энэ нь таны оршин буйн зорилгыг тайлж, Бүтээгчийн тань оршихуй, хамгаалалт, хангамжийг сорон татдаг. Энэ нь хамаг л сурвалжит зан чанарын язгуур, аз жаргалын суурь бөгөөд танд нүүрлэж болзошгүй бүхий л дэгэн догон нөхцөл байдал дунд шаардлагатай зохицуулалтаар хангаж өгдөг. Бат баримталж явбаас, энэ чанар нь амьдралыг тань уртасгаж, эрүүл мэндээр тэтгэж, гачигдаж хомсдохын зовлонг үл мэдүүлэн, амжилт, аюулгүй байдлыг баталгаажуулан, үе дамнасан үнэт өвийг тамгалж өгнө.

Итгэмээргүй сонсголонтой байна уу? Та энэ чинь одоо зөгнөлт ном уу? гэж бодож байна уу? Тэгвэл, үгүй гэдгийг батлан хэлье - хэлсэн бүхэн маань үнэн.

Амьдрал дээр буулгабал, ихэнх хүн “Хэцэс! Ийм юм байдаггүй юм!” гэж ирээд л эсэргүүцэх байх. Гэвчиг дээр бичигдсэн амлалт нэг бүрийг хүмүүний түүхэн дэхь хамгаас мэргэн нэгэн эрхэм Бүтээгчийнхээ онгодоор хөглөгдөн бичсэн бөгөөд харин Бүтээгчийн маань үгс ширхэг ч алдаа мадаггүй!

Гэхдээ энэ амьдралыг орхихоосоо өмнө мэргэн Соломоны зүрх цэц ухааныхаа Эхээс урван, ерөөлтэй амьдралынхаа замаас шарвасан тул дээр өгүүлэн бичсэн сайн сайхнаасаа өөрөө тасарсан юм.

Соломоны түүхийг товч өгүүлбээс. Тэрбээр хүүхэд ахуйдаа энэхүү чанарт хичээнгүйлэн суралцаж, мөнөөх сурвалжит чанараар батжин, хурц ухааныг олов. Даруй онцсайн удирдагчийн зэрэгт хүрч, эцэстээ сая сая хүнийг жолоодох болжээ. Бурханаас хүсэн гуйсныхаа улмаас ер бусын цэц ухааныг олсон бөгөөд үнэндээ түүний хувьд ухаан үл хүрэх зүйл бараг л байсангүй. Соломон мянга мянган зүйр цэцэн үг

бичиж, зуу зуун дуу зохиосон: Тэр бас Ливаны хуш модноос эхлээд ханан хэрмэн дээгүүр ургадаг балуун ургамлын тухай ч хүүрнэж мөн ан амьтад, шувууд, хэвлээр явагчид, загасны талаар хүртэл ярьдаг байв (1Хаад 4:33).

Цэцдийн цэцэн Соломон хэний ч, хэзээ ч хүрч үл дийлсэн амжилт, аз хийморь, суу алдрын оройд залрав гэнэ. Энэ дэлхийн хаад, хатад, элчин сайд, эрх ямбатнууд тэр эрхмийн оршихуйд сөгдөж, ухааныг нь биширч, онцсайныг нь үзэж, ард албатуудынх нь үнэнчийг гайхаж, улс гүрнийг нь хүч, баялагт хүргэсэн шинэ бүтээлээс нь суралцахын төлөө газрын холоос үл бэрхшээн, зочлох. Нэгэн хатан бүр өөрийн биеэр айлчлан үзэхээсээ өмнө өрөөлийн дам үгд итгээгүй гэдэг. Тэгээд Соломонтой цагийг өнгөрөөсөн хойноо “Би ирж, энэ бүхнийг өөрийн нүдээр үзэх хүртэлээ энэ үгэнд итгээгүй байлаа. Гэтэл, хараач, миний сонссон зүйлс энэ бүгдийн хагаст нь ч хүрэхгүй байж. Үнэндээ таны мэргэн ухаан, эд баялаг миний сонсож дуулсан сургаас үлэмж давуу ажээ. Таны хүмүүс юутай ерөөлтэй вэ! Таны өмнө үргэлж зогсож, таны мэргэн ухааныг сонордох эдгээр албат нар юутай ерөөлтэй вэ!” (1Хаад 10:7-8) хэмээн дуу алдаж.

Умшбал, хаан нь ард олноо ажил хөдөлмөртөө аз жаргалтай бөгөөд үр нөлөөтэй удирдан амьдруулж чаддаг байжээ. Ядуурал зүдүүрэл байхгүй, тэр хаант улсын иргэн бүр гэр оронтой, цэцэрлэг хашаатай байж. Хүмүүс нь “далайн эргийн тоо томшгүй элс шиг олон байсан бөгөөд тэд идэж ууж, баярлан цэнгэлдэж” (1Хаад 4:20) байсныг түүх гэрчлэх. Амар тайван, аюулгүйгээр амьдран суудаг байжээ тэд.

Гэвчиг цаг хугацаа өнгөрсөөр, мөнөөх жолоодогч маань тэр их ололт амжилтыг нь бадраасан зүйлээсээ буруулан ухарчээ. Тэрбээр өөрийнхөө нүдэнд мэргэн харагдаж, нөгөө чанарынхаа цэц ухаанд анхаарах шаардлагагүй хэмээн үзэв. Тэгээд замаа алдан, адагтаа шүүрс алдсан, увайгүй этгээд болжээ. Буруутай шүүхээрээ тэрбээр өөрийгөө ч, иргэдээ ч зовоов.

Түүнд амьдрал утгаа алджээ. Тийнхүү “Бүх зүйл уйтай, дэндүү уйтай - үүнээс хэн ч, ямар ч утга эс олно”¹, “Наран дор ширхэг ч шинэ юм үгүй мэт зүгээр л түүх эргэн эргэн давтагдах”² гэх мэт уйтай мэдэгдэл хийх болов. Энэ байтугай “Үхэх өдөр чинь төрөх өдрөөс чинь дээр”³, “Бурууг зөв болгож чадахгүй. Алдагдсаныг эргүүлж

авч чадахгүй”⁴ гэх мэт нүд орой дээр гаргам үг ч унагасан. Үнэндээ, амьдрал утгагүй хоосон болох, түүний хувьд бүх юм утгаа алдсаныг гашуудан дуулсан бүхэл бүтэн ном ч бичсэн. Энэ нэгэн хүн алга эргүүлэхийн дотор амжилтын оргилоос уй гунигийн ёроолд ультлаа урууджээ. Өнөөдөр байсан бол, сэтгэл зүйч нар түүнийг маниак депрессийн хурц хэлбэр тусч хэмээн оношлох байсан биз. Гэхдээ нэг л хүн яаж ингэж нэг туйлаас нөгөө туйл руу харвадаг байна аа?

Сайн мэдээ нь: Соломоны түүх уй гашуугийн ёроолоор дуусаагүй. Соломон эцэстээ амь амьдралын хамгийн чухал чанар руугаа эргэж чадсан. Тэрбээр “Харууслын ботио” хэдэн жил бичсэнийг мэдэхгүй ч, сүүлийн хэдэн бүлэг нь түүний аж байдал сайжирсныг цухас харуулдаг. Соломон “Бүтээгчээ санаарай” гэдэг үгийг янз бүрийн хэлбэрээр долоон удаа⁵ бичсэний хамгийн сүүлийнх нь:

Энэ бүхнийг дүгнээд, сонордуулахад *Бурханаас эмээж*, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна (Номлогчийн үгс 12:13) гэдэг.

Өгүүлээд байгаа чанар маань энэхүү *Бурханаас эмээхүй* болой. Соломон хаан үүнийг бүрэн бүтэн, баялаг амьдралын болзол хэмээжээ. Бичээс “ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ?, Түүнд тэрээр сонгох ёстой, *замыг нь* зааварчилна” (Дуулал 25:12) гэх. Соломон хаан харанхуйд төөрөхдөө, өөрийнх нь мэргэн ухаан л аз жаргал, амжилтыг авчирна гэж итгэсэн шиг, олон хүн ч үүнд итгэдэг. Тэгвэл ариун эмээхүйгээр бид юу биднийг тэтгэж, юу үл тэтгэдгийг мэддэг Бүтээгчийнхээ цэц ухаантай холбогддог юм.

Бичээс хуудас бүртгээ ариун эмээхүйг бусад бүх чанараас өргөмжлөхдөө, энэ нь Есүсийн *таалал* (Исаиа 11:3), “ЭЗЭНээс эмээхүй нь түүний *эрдэнийн сан*” (Исаиа 33:6) хэмээн гайхтал өгүүлдэг. Тэгэхээр, түр зогсоод эргэцүүлнэ үү: Ариун эмээхүй нь Аугаа хүчирхэг Бурханы *таалал* бөгөөд *эрдэнэс* аж. Биширмээр ээ! Бүгдээрээ энэ гайхамшигт үнэнийг илүү нарийн судлана аа. Гэхдээ урьдаар Соломоныхоо түүхийг дуусгая.

Би юуны учир номоо тэр хүний амжилт, уналт, эцсийн сэргэлтээр эхлүүлэх болов? Үйлчлэлийн маань гараан дээр нэгэн

Бурханаас эмээхүй

мэргэн удирдагчийн хэлсэн үг өнөө хүртэл миний дотор явдаг юм. Тэрбээр “Би төгс намтартай хүнийг эрх мэдэл өөд дэвшүүлэхээс азнахыг зарчим болгодог” гэж билээ.

Учыг нь лавлалат, тэрбээр “Хүний зан чанарыг юу юунаас илүүтэй бүтэлгүйтэл дунд үзүүлж байгаа хариу үйлдэл нь л илтгэнэ. Хариуцлагаа хүлээж байна уу, гэмшиж байна уу, сургамж аваад өсч байна уу? Эсвэл зан үйлдлээ зөвтгөөд л, таарсан бүхнээ буруутгаж байна уу? Үүгээр нь л хариуцлагад тэнцэх эсэхийг нь харж болно” гэж хариулж билээ. Үүнээс би: *Үүгээр нь тэр хүн цэц ухааныг юу юунаас дээгүүр тавьдаг үгүйг харж болохыг* сурсан юм.

Соломон хэдийгээр Ариун Сүнсний хөгөөр бусдад сургадаг байсан ч, өөрөө бурханлаг эмээхүйн үнэ цэнийг бүрэн ухаараагүй аж! Магадгүй тиймээс ч амархан алдуурч одсон байх. Бүтэлгүйтэхээсээ өмнө тэр хүн бурханлаг эмээхүйг *таашаалаа ч, эрдэнэсээ ч* болгоогүй, санаа сэдэл, үйлдлийнхээ хөдлөшгүй бат сууриа ч байлгаагүй. Харин бүдрээд, бүтэлгүйтээд, эцэстээ эргэж сэргэх үедээ л Эзэнээс эмээхүй нь ямар хүчирхэг болохыг бүрэн гүйцэт ухаарсан гэлтэй.

Энэ талаар элч Паул:

харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог (1Коринт 9:27) хэмээн бичсэн.

Өөрт нь Бурханы Сүнсний итгэмжилсэн цэц ухааныг нандигнаж, Соломон хаан шиг алдахгүй байхын ач холбогдлыг Паул ойлгожээ. Паулд үй олныг чөлөөлөх чадалтай, Бурханы гэрээний нууц үнэн илчлэгдсэн байсан боловч, тэрбээр бурханлаг эмээхүйг үнэлж, бат сахиагүй бол, ялгаагүй л үл тэнцэн, хүлээн зөвшөөрөгдөлгүй, гологдож, найдвараа алдсан увайгүй, хулхи амьтан болох байсан.

Бурханлаг эмээхүйг сахих нь биднийг үнэнд захирагдахуй дор үлдэх хүчээр цэнэглэж, ингэснээрээ ер бусын шагнал бүхий амийн зам дээр тогтоох, хамгийн үнэт эрдэнэ мөн.

Дийлэнх нь эмээж айхыг хор хөнөөлтэй, ашиггүй зүйл гэж үздэг болсон цаг үе дор *Эзэнээс эмээхүйг* ач тустай, шагнал бүхий чанар хэмээн мэдэгдэх нь эрүүл бус сэтгэлгээ мэт. Гэхдээ үүнийг

сахисан хүн амийн зам дээрээ тогтох хүчтэй байхыг би Бичээсийн эрх мэдэлд тулан, батлан хэлнэ. Тэнд л бид Бурхантай жинхэнэ дотносож, амьдрал өөрчлөх олон ач тусыг хүртэхийн нэг нь Есүс Христийн дүр төрх рүү хувирах өөрчлөлт болой. Иймийн тул Бурханаас эмээхүйг танин мэдэх аялалдаа гарцгаая.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Тэр чиний цаг хугацааны бат суурь бөгөөд, мэргэн ухаан, мэдлэг ба авралын баялаг мөн. ЭЗЭНээс эмээхүй нь түүний эрдэнийн сан билээ. (Исаиа 33:6)

Санаа: Ариун эмээхүй нь Бурханы эрдэнэ. Бид үүнийг өөрийн болгох ёстой.

Эргэцүүлэл: Ариун эмээхүйг нандигнах гэдэг нь амьдрал дээр яг яана гэсэн үг вэ? Үүнийг хэрхэн үзэх вэ? Хэрхэн шийдвэрлэх вэ? Хэрхэн баримтлах вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Эзэнээс эмээхүйтэй танилцах энэ аяллаараа би энэ тухай мэдэж авч бас үүнд дурлахыг хүсч байна. Та нандигнадаг шиг, би ч бас нандигнамаар байна. Бүрэн дүүрэн, амжилттай амьдрахад минь хэрэгтэй, Таны мэлмийд таалалтай цэц ухаан, мэдлэгийг надад хайрлах болтугай. Үүгээр барахгүй миний хайртай хүмүүс, таньдаг хүмүүс ч гэгээрч, үнэ цэнийг нь ухаарах болтугай. Эзэн бөгөөд Аврагч Есүсийнхээ нэрээр залбирч байна.

Шийдвэр: Би сайн сайхан амьдралын зам дээрээ бат тогтохын тулд ариун эмээхүйг амьдралынхаа хамгийн үнэт эрдэнээ болгоно.

*Бурханаас бүү ай,
харин эмээж яв.*

— Жэй. Эй. Спендер

2 | ЭСРЭГ ТЭСРЭГ ХОЁР АЙДАС

Тэртээ 1994 оны зун Америкийн Өмнөд нутгийн чуулганы конференцэд номлох урилга хүлээн авлаа. Тэр нь хоёр жилийн өмнө, дэлхийд нэр алдартай нэгэн сайнмэдээ дэлгэрүүлэгч дөрвөн долоо хоногийн турш ер бусын сэргэлт авчирсан, томоохон цуглаан байв. Тэр сэргэлтийн цуглаан Бурханы сайн сайхан чанар, хайр, баяр хөөрийг давуулан таниулж, олон ч хүний амьдралд ер бусаар нөлөөлжээ. Харамсалтай нь, тэр чуулган мөнөөх сэргэлтийнхээ туршлага дээгүүр л эргэлдээд, Бурханы зүрхийг лавшруулан танин мэдэхэд шамдсангүй. Үндсэндээ хоёр жилийн өмнөх дээрээ гацаад, тэнцвэрээ алдчихсан байв.

Тухайн үед би ариун эмээхүйд суралцах аян замдаа гарсан байлаа. Чухал болохыг нь мэдээд байсан хэрнээ, мэдлэгээр дөнгөж л өсч яваа болохоороо, олон нийтэд зааж арай л зүрхлэхгүй байв. Тийм боловч энэ бодлоо хойш тавиад, эхнийхээ орой Эзэнээс эмээхүйг зааж өгөх ёстойг бат мэдэрсэн юм.

Тайзан дээр гараад л сонсогч нарт өөрийнхөө мэддэг өчүүхэн юмаа зааж эхэллээ. Өөдөөс ямар ч хариугүй, хоосон нүдээр таг мэлрэх хүмүүсийн царай надад өөртөө итгэх итгэл хайрласангүй. Яг л хэлсэн үг маань тэдний чихэнд наалдалгүй, газар пүд пад хийх шиг. Гэвч тун удалгүй энэ бүхний учир тайлагдаж, миний тавьсан онош зөв болох нь батлагдах гэж байсныг мэдсэнгүй.

Маргааш орой нь магтаалын дараа тэргүүн пастор нь тайзан дээр гарахаар нь би ёсын дагуу намайг танилцуулах гэж байна хэмээн санатал, байдал өөрөөр эргэв. Тэрбээр миний урьд оройн сургаалд арван таван минутын турш задлан хийж, засварлав. Тэгээд “Эзэнээс

эмээхүй нь Хуучин Гэрээнд хамааралтай боловч, Христэд итгэдэг бидэнд айдсын сүнс өгөгдөөгүй” хэмээн 2Тимот 1:7-г эшлэв.

Түрүү эгнээнд сууж байсан миний бие яг л хар дарсан зүүдэн дунд орсон мэт цочров. Пасторыг ярих тусам, яриа нь улам л эвгүйтсээр байлаа. За, тэгээд л: “‘Хайр дор айдас үгүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна’ (1Иохан 4:18) хэмээн Шинэ Гэрээ бидэнд заадаг. Тэгэхээр, өчигдөр орой Жоны заасан алдаатай үгээс би та нарыг хамгаалмаар байна” гэлээ. Ийм маягаар пастор дахин хэдэн минутын турш минийхээ номлолыг зориуд зад засварлав.

Тэгээд хамгийн сонирхолтой нь ярьж дууссанаа намайг танилцуулаад, тайзан дээр урьдаг юм даа. Би ч тайз руу гарч явахдаа “*Худлаа байгаа даа. Энэ хүнийг ийм юм ярьсны дараа би энэ хүмүүст одоо юугаа заах юм бэ?*” гэж л бодож байлаа. Гэхдээ энэ явдал жинхэнээсээ өрнөж байгаа учраас, би зовхио өргөөд, гүйлтээ дуусгахаас өөр замгүй. Мэдээж надад конференцэд оролцож байгаа хүмүүст амийн үгийг заах нь бүү хэл, цэгц сэтгэхэд ч хүнд байв.

Яриад байгаа атлаа бодол маань нөгөө л шүүмж үг рүү эргэж буцаад, сэгсэрч хаяж чадахгүй байлаа. Ер бусын ч гэх үү, аймаар ч гэх үү, тийм л нэгэн явдал. Би ярианыхаа жолоог алдчихгүйн тулд хэдэнтээ толгой сэгсрэн, бодлоо эмхлэв. *Март, амиа хамхиад, зүгээр л наанаасаа яв* гэдэг мэдрэмж хэмлэсээр. Үгээр илэрхийлэшгүй муухай байсан даа. Тэгээд товчхон заачихаад, цуглааныг пасторт шилжүүлээд, бушуухан шиг зочид буудалдаа очоод, орондоо ялтан аятай шургаад, гөлийсөөр хэвтэж билээ.

Маргааш өглөө нь буудлын маань ойролцоо нэгэн барилгын эзгүй талбай олоод, Бурханы засвар үгийг авахаар, үнэн голоосоо залбирав. Тэгээд “Эзэн минь ээ, би Таны чуулганыг хохироочихов уу? Би худал зүйл заачихав уу? Таны хүмүүсийг хүлчихэв үү?” гээд л чин сэтгэлээсээ л асуулаа.

Ийнхүү хэсэг залбирсны эцэст залбирал маань алгуураар өөрчлөгдөхийг мэдрэв. Би ч тэр орой заасан үгдээ эргэлзэхээ болиод, харин ариун эмээхүйг илүү таньж мэдэхийн төлөө улайдан залбирч эхэлсэн юм. Зүрхний минь угаас олгойдсон энэ гувшин гуйлтад би өөрөө ч гайхлаа. Бурхан тэр оройн үйлдэлд минь дургүйцэхийг огт мэдэрсэнгүй. Харин ч Бурхан Эзэнээс эмээхүйн тухай Шинэ Гэрээний хэд хэдэн эшлэлийг сануулж гарав. Тэр үед

би нэгэнт эргэлзэхээ болиод, харин ч “Аав аа, би Эзэнээс эмээхүйг танин мэдэж, түүгээр амьдармаар байна!” хэмээн үнэн голоосоо хашхирч байлаа.

Пасторын эш татсан эшлэлийг бичсэн Шинэ Гэрээний бичээч нар доорх эшлэлийг ч бас бичсэн билээ:

- Элч Паул “Өөрсдийн авралыг *айдас* ба *чичрэлээр* гүйцээ.” (Филиппой 2:12)
- Мөн “*Бурханаас эмээж*, ариун чанарыг төгс болгоё.” (2Коринт 7:1)
- Еврейн зохиолч “Хүндлэл, *айдас бүхий тааламжит үйлчлэлийг* Бурханд өргөх” (Еврей 12:28) гэж бичсэн.
- Элч Петр “Та нар ялгаварлалгүйгээр хүн бүрийг үйлсийнх нь дагуу шүүдэг Нэгэнийг Эцэг гэж дууддаг юм бол, энд байх хугацаандаа *эмээн биеэ авч яв*” (1Петр 1:17) гэж бичсэн.
- Иуда ч “*Эмээнгүй... ханд*” (Иуда 23) гэж мэдэгдсэн.
- Есүс Өөрөө ч “Махбодыг хөнөөгчдөөс бүү ай. Учир нь тэд сэтгэлийг хөнөөж үл чадна. Харин махбод болоод сэтгэлийг хоёуланг нь тамд устгаж чадах Түүнээс айгтун” (Матай 10:28) хэмээн ятгасан.

Энэ мэт үргэлжлүүлээд байж болох ч, гол нь та “*Ариун эмээхүй* нь Шинэ Гэрээний үнэн мөн” гэдэг гол санааг ойлгосон байх аа. Эдгээр нь намайг залбирч байх үеэр зүрхэнд минь Эзэний түгээсэн цөөн хэдэн эшлэл болой.

Тэгээд тэр өглөө пастор “Айдсын сүнсийг”, “Эзэнээс эмээхүйтэй” эндүүрснийг ухаарав. Эдгээр нь том ялгаатай бөгөөд үүнийг Мосе Израилийг Бурхантай уулзуулахаар Синай уул руу дагуулах үед өрнөсөн үйл явдал тод дүрслэн харуулдаг.

Израилийг зорьсон газартаа очмогц, Мосе Бурхантай хувьчлан уулзахаар ууланд гарсан. Бурхан ч түүнд энэхүү хүчирхэг чөлөөлөлтийн цаад зорилгыг илчилдэг:

“Мосе, Бурханд өгсөж очсонд ЭЗЭН түүнийг уулнаас дуудан,— Чи Иаковын гэрт, Израилийн хөвгүүдэд ингэж хэл. “Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн Өөртөө яаж авчирсныг та нар өөрсдөө харсан” (Гэтлэл 19:3-4).

Бурхан хүмүүсээ бүгдийг нь Өөр дээрээ цуглуулах ганц амин шалтгаанаар л чөлөөлжээ. Хүмүүсийнхээ мөрөөсөл нь байж, хүмүүс нь Түүнийг Мосе шиг л таньж мэдэхийг Бурхан хүссэн. Гэтэл гурав хоногийн дараа Бурхан Өөрийгөө танилцуулахаар уулан дээр бууж иртэл, хүмүүс нь шууд гэдрэг ухарсан. Тэд үхтэл айсандаа Мосед хандан “Та бидэнтэй яриач. Бид сонсьё. Харин Бурхан бидэнтэй бүү яриг. Эс тэгвэл бид үхнэ” (Гэтлэл 20:19) хэмээн хашхиралджээ. Удирдагч Мосе ч хүмүүсээ тайвшруулахаар “Бүү ай. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм” (Гэтлэл 20:20) гэжээ.

“Бүү ай. ... Түүнээс эмээхүй нь та нарт байг.” Өнгөц харбал, Мосе хэлсэн үгээ няцаагаад ч байх шиг. Орон гаран ч юм шиг. Гэвч үгүй юм. Мосе ердөө л “Бурханаас айх”, “Бурханаас эмээхүйн” ялгааг нь гаргаж байна. Энэ хоёр нь том ялгаатайг дахин хэлбэ.

Нууж хаах юмтай хүн л Бурханаас айна. Цэцэрлэгт Адам нүгэл үйлдчихээд, гэргий Еватайгаа Эзэний оршихуйгаас нуугдсан байдаг. Энэ нь ч сондгой содон ганц тохиолдол биш юм. Бичээсээр нэг харанхуй руу гишгэж үзсэн хүмүүсийн ийм авир.

Тэгвэл Бурханаас эмээдэг хүнд нууж хаах юм байхгүй. Харин ч тэрбээр Бурханаас холдохоос л айна. Үүнийг Бурханаас ухарч зугтсан Израильчууд, Бурхан руу улам ойртсон Мосе дүрслэн харуулдаг. Бурханаас эмээдэг хүн өөртөө “Яаж онхолдчихгүйгээр нүглийн хилд аль болох ойртож болох бол?” гэж хэлэлгүй, харин “Би тэр нүглийн хил хязгаар руу харах ч үгүй, Бурхантайгаа л ойр байх минь” гэдэг.

Тиймээс ариун эмээхүйг тодорхойлж, ашиг тусыг нь ярилцахаасаа урьдаар энэ нь юу биш болох талаар ярилцъя. Энэ нь Бурханаас айх явдал биш учраас, Түүнээс ухарч няцах үйлдэл биш юм. Айдаг хүнтэйгээ хэрхэн дотносох билээ? Ухарч няцах нь Бурханы хүслийн эсрэг зүйл юм. Дуулал дээр “Миний царайг эрэн хайцгаа!” гэхэд, зүрх минь Танд, “ЭЗЭН, царайг тань би эрж хайюу” гэв” (Дуулал 27:8) гэдэг. Та дотносох дуудлагыг сонсож байна уу? Бурхан таныг ойр байж, яриа дэлгэж, хамтдаа инээлдэж, хуваалцаж, хамтдаа амьдраасай гэж хүсдэг. Магтаалч мөн “ЭЗЭНий андлал, Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр

тэдэнд гэрээгээ мэдүүлнэ” (Дуулал 25:14) гэдэг. Тэгэхээр, үнэндээ: Бурхан тантай хамтдаа, ойр дотно байхыг хүсдэг. Тэгэхээр, ариун эмээхүй нь дотнослыг унтраалгүй, харин ч эсрэгээрээ - Бурхантай тогтоох харилцааг маань дэмжин тэтгэдэг.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Бүү ай. Учир нь Бурхан та нарыг зөвхөн шалгахын тулд ирсэн. Мөн Түүнээс эмээхүй нь та нарт байж та нарыг нүгэл бүү үйлдээсэй гэсэндээ ирсэн юм (Гэтлэл 20:20).

Санаа: Ариун эмээхүй нь Бурханаас айж, дөлөх явдал бус, Бурханаас холдохоос айх явдал юм.

Эргэцүүлэл: Бурхан ямар гол зорилгоор Израилийг Египетээс чөлөөлөв? Бурхан ямар гол зорилгоор биднийг дэлхийн дөнгөнөөс чөлөөлсөн бэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Эзэн Есүс Христээр дамжуулж намайг айдсын сүнснээс чөлөөлсөнд баярлалаа. Ариун эмээхүй байхгүй бол, би Таны ч надтай, миний ч Тантай тогтоохыг хүсдэг дотно харилцаанаас салах учир, Таны эсрэг нүгэл үйлдэхгүйн тулд надад ариун эмээхүйг хайрлаач.

Шийдвэр: Бурхан намайг Өөртэйгээ дотно байлгахаар дуудсан болохоор, би Бурханаас айлгүй, харин Бурханы эсрэг нүгэл үйлдэхгүйн тулд Түүнээс эмээж амьдарна.

*Бурханаас эмээхүй нь оюун ухаант
бүтээлийн нэн тэргүүний бөгөөд
хамгийн том үүрэг болой.*

— Чарльз Инглис

3 | АРИУН ЭМЭЭХҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Ариун эмээхүйг ганц өгүүлбэр, параграф, бүлгээр хэлчих боломжгүй л дээ. Яг л ийм хэмжигдэхүүнээр Бурханы хайрын бүрэн эзэлхүүнийг тайлбарлах гэж оролдохтой л адил юм болно. Үүнийг хэдэн ботиор ухаж тайлсан ч, хүний ухаан хүрэшгүй. Үнэндээ, ариун хайр, ариун эмээхүйн гүний цөмийг бид өнийн мөнхөд ч үргэлжлүүлэн танин мэдсээр байна гэдэгт би итгэж явдаг.

Тиймээс, ариун эмээхүйг ерөнхийд нь тоймлох гэж оролдъё. Жишээлбэл, биднийг хүүхэд байхад буддаг ном гэж байгаагүй юу. Номоо нээгээд, хуудсаа сонгоод, ямар өнгөөр яаж будах ерөнхий зургаа гаргана. Үүнтэй адил, номын маань энэ бүлэг ерөнхий араамыг нь зангидаж өгөөд, үлдсэн бүлэг нь алаглах өнгө будаг нь болно гэж ойлгож болно. Энэ бүлгийг уншаад л зогсчих юм бол, та ариун эмээхүйг ерөнхийд нь ойлголоо ч, өөрчлөгч хүчийг нь үзэхгүй.

Эзэнээс эмээхүй нь биднийг Бурханы оршихуйгаас холдуулалгүй, харин ч ойртуулдгийг бид өмнөх бүлгээр тогтоосон. Гайхмаар сайхан тэр эмээхүй нь биднийг Бурханд ойртуулдаг ба цаашаа явахаасаа өмнө энэ бат суурийг тавих нь амин чухлаа.

Зарим хүн Эзэнээс эмээхүй гэдэг нь зүгээр л Бурханыг мэхийн хүндэтгэхийн нэр гэдэг. Үүнийг нэр алдартай номлогч нар тайзан дээрээс ч, яриандаа ч, хоол идэж байхдаа ч хэлэхийг би сонссон. Гэхдээ энэхүү тодорхойлолт нь амсар төдий л ойлголт бөгөөд бүрэн бүтэн зураглалын хаана нь ч хүрэхгүй. Тухай нь Бурханы хайрыг ердөө л “Тэвчээртэй бөгөөд эелдэг” (1Коринт 13:4) хэмээн тодорхойлохоос ялгаагүй юм. Ийм ойлголтоор хязгаарлагдбаас, бид жинхэнэ байгаа онолгүй, хол дутна.

Лиза, бид хоёрыг дөч дөнгөж гарч явахад, нэгэн алдартай удирдагчийн хүргэн хүү нь манайд зочлоод, компанид нь хөрөнгө оруулах боломжийг танилцуулж билээ. Хэдэн цаг ярилцахад, тэр эрхэм хайлсан тугалга шиг л эелдэг, тэвчээрэй загнаж байсныг тод санаж байна. Ер нь ажигласан хэнбугай нь ч түүнийг хайр татмаар хүн гэдгийг үг дуугүй батлан зөвшөөрөх байлаа. Тэгэв ч хэдэн өдөр залбирсныхаа дараа Лиза, бид хоёр хөрөнгө оруулж болохгүйг мэдрэв. Үүндээ ч энэ олон жилийн дараа, эдүгээ баярладаг. Учир нь тэр эрхэм Понзи схем гэдэг сүлжээний бизнесийн томоохон хэрэгт холбогдоод, олон жил хоригдсон юм.

Тэр хүн эелдэг, тэвчээртэй байсан уу? Яриангүй байсан. Хайраар амьдарсан уу? Ёстой үгүй. Яагаад? Яагаад гэвэл Бичээс “Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих явдал юм” (1Иохан 5:3) гэдэг. Хулгайлах нь амиа бодсон хэрэг бөгөөд Бурханы хайрын тушаалыг зөрчсөн явдал мөн (Ефес 4:28). Хүүхэд хүчирхийлэгч ч тэвчээртэй бөгөөд эелдэг байж чаддаг ч, дөнгөж нахиалж байгаа нандин амьдралыг алах. Тэр этгээд тэр хүүхдийг хайрлаа юу? Ёстой үгүй!

Үүнтэй адил ариун эмээхүйг гүнээ мэхийх хүндэтгэлээр хязгаарлах нь биднийг байгаа онолгүй, буруу чиглэхэд хүргэнэ. Тиймээс, эхлээд тоймоо гаргаад, дараа дараагийнхаа бүлгийн сургааль, Бичээсийн жишээ, түүхэн жишээгээр өнгө алаглуулъя. Тэгэхээр, эхлэхээсээ өмнө ариун эмээхүйг тодорхойлоход зарим нэг сэрд хийлгэм, аймаар үгс гарч ирэх боловч, айж сүрдэх юм огтоос байхгүйг урьдаас батлан анхааруулъя. Аян зам дээрээ бат зогсбоос, ариун эмээхүй нь бидний төлөө амь тавин анхаарч, бидний мөрөөсөл болж явдаг Бүтээгчийн маань хайр, хамгааллын бэлэг болохыг мэдэж авна.

Гараагаа эхлүүлэх Шинэ Гэрээний олон эшлэл байв ч, доорх эшлэлээр эхлэх нь хамгийн зөв суурь өнгө тавина гэдэгт би итгэнэ:

Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр *хүндэтгэл, айдас бүхий* тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм. Яагаад гэвэл бидний Бурхан шатаах гал мөн. (Еврей 12:28-29)

Нарийн харбал, энд *хүндэтгэл, бурханлаг эмээхүй* гэсэн хоёр нэр томъёо гарч байна. Энэ нь ч бурханлаг эмээхүйг дан хүндэтгэлээр хязгаарлаж ойлгож болохгүйг шууд хэлэх. Учир нь тийм байсан бол, бичээч зүгээр л санаагаа дахин давтсан болчих гээд байна.

Эдгээр нь Англи хэл дээрээ ч хоёр өөр үг байдаг төдийгүй, Грек хэл дээр ч *айдос*, *эулабеиа* гэсэн ондоо хоёр үг байдаг.

Хүндэтгэл нь эхний Грек үгийн онцсайн хөрвүүлэг мөнөөс мөн. Үг судлалын бүрэн толь бичиг дээр *хүндэтгэлийг* “гүнээ аюуж биширсэн хүндэтгэл” гэж тайлбарласан байдаг. Би энэ дөрвөн үгийн хослолд тун дуртай; нэгээс нөгөө рүүгээ ахих тусмаа ойлголтыг маань нэг төвшин ахиулах мэт!

Хоёр дахь нэр томъёо нь *бурханлаг эмээхүй*, *аюух* гэсэн утгыг тээдэг. *Аюух* гэдэг үгийг 1928 оны Ноа Уэбстериин толь бичгийн эх хувиас харгал, ингэж тодорхойлсон байв: алив нэг аугаа, аймшигтай зүйлээс улбаалсан айдас, сүрдэн айх; аюудас, хүндэтгэл үзүүлэх. Айдас, аймшиг юмуу хүндэтгэлээр нөлөөлөх.”² *Айж сүрдэх*, *аймшиг* гэдэг үгсээс бүү жихүүцээрэй. Грек толь бичиг дээр ч эдгээр үгийг хэрэглэдэг хэдий ч, ариун эмээхүй нь түлхэх бус, харин татах нөлөөтэй билээ. Тиймээс бид: Энэ үгст эерэг бөгөөд эрүүл тал бий юу гэж асуух хэрэгтэй. Байдгийг нь ч Бичээс харуулдаг гэдэгт би итгэдэг бөгөөд үүнийг нь ч бид цааш цаашдаа өнгө нэмэхдээ өөрсдөө үзнэмз.

Тэгэхээр, тодорхойлолтоо жагсаацгаая. Бурханаас эмээхүй нь Түүнээс бүрэн төгс аюуж, хүндэтгэх явдал.

Бурханаас эмээхүй нь Түүнийг *оройлон дээдлэх* явдал. *Оройлох дээдлэх* нь “гүнээ хүндэтгэх” гэсэн үг. Бурханаас эмээхүй нь Түүнийг хэн бүхнээс, юм бүхнээс дээгүүр үнэлж, хүндэтгэж, дээдэлж, өргөмжилж, бишрэх явдал.

Бурханаас эмээдэг хүн Бурханы зүрхийг өвлөдөг. Бурханы хайрладгийг хайрлаж, жигшдгийг нь жигшинэ. (Түүний жигшдэгт “дургүйлхэх” биш, харин “жигших” гэж байгааг тэмдэглээрэй.) Бурханд чухал нь бидэнд чухал болж, Бурханд тэгтэл чухал биш нь бидэнд тэгтэл чухал биш болно.

Бурханаас эмээх нь нүглийг үзэн ядах.

Бурханаас эмээх нь шударга бус явдлыг үзэн ядах.

Бурханаас эмээх нь муугаас бодол, үг, үйлдэл - бүх утгаараа ангижрах. Худал ярихыг эрс эсэргүүцэх. Зүрх, бодолдоо худал юмыг зөвшөөрөлгүй, ярилгүй, дүр эсгэлгүй явах. Дотроо ч, гаднаа ч нэг л ижил бодол, сэдэл, итгэл үнэмшилтэй байх.

Бурханаас эмээх нь Бурханы ч өмнө, хүмүүний ч өмнө жинхэнэ даруу чанар дор амьдрах.

Бурханаас эмээхүй нь Түүнд бүрэн эрхт магтаал, бишрэл, талархал, хүндэтгэлийг нь өргөх.

Бурханаас эмээхүй нь Түүнд харъяа хамааралтай бүхнийг нь өргөх.

Бурханаас эмээхүй нь Түүний өмнө айж, гайхаж, чичрэхүй.

Түүний Үг, оршихуйд хамаг анхаарлаа хандуулна гэсэн үг.

Бурханаас эмээхүй нь Түүнийг дуулгавартай дагах. Энэ нь

Түүнийг зүгээр нэг хүсэх бус мөн ямар ч атугай үнэ төлөөсөөр

Түүний хүслийг гүйцэтгэх дотоод хүчийг тээнэ. Бид ямар

ч ашиг харагдахгүй байсан ч, ямар ч утга илэрхийлэхгүй

байсан ч, хэлэгдсэн даруйд нь үтэр түргэн, үнэн голоосоо

дуулгавартай дагаж, бүрэн гүйцэтгэх хүртлээ явна.

Бурханаас эмээхүй нь алив төрлийн гомдол, гонгиноо, амандаа

бөгөөд чангаар үглэхийг цээрлэхүй юм.

Бурханаас эмээхүй нь Бурханы зааварчилгаанд болоод

Бурханы төлөөний эрх мэдэлтнүүдийн чиглүүлэгт бөхийж,

хүндэтгэж, захирагдахуй юм. Мөнчлөн Бурханы төлөөний

эрх мэдэл биднийг гэм нүгэлд уруу татахаас бусад бүх

нөхцөлд тэдний үгийг дагахуй юм.

Эзэнээс эмээхүй нь бидний санаа сэдэл, бодол, үг, үйлдлийг

хэлбэршүүлэн хэвлэдэг.

Тэгэхээр, ариун эмээхүйн ач тусыг хэсэглэн жагсаая. Ариун

эмээхүй дотор явсан хүнд амлагдсан Библийн үй олон амлалтаас

хэсэглэн дурьдахад ийм байна:

Эзэнээс эмээхүй нь Бурхантай тогтоох дотно харилцааны эхлэл

цэг авай. Бид Бурханы нөхөд болж, Түүний нууц бидэнд

нээгддэг.

Эзэнээс эмээхүй нь цэц ухаан, ойлголт, мэдлэгийн эхлэл. Энэ

нь холч хараа, тодорхой тэнгэрийн чиглүүлэг өгдөг.

Эзэнээс эмээхүйгээр бид авралдаа төлөвшиж, Есүсийн дүр

төрх руу баталгааждаг.

Эзэнээс эмээхүй нь цэвэр; энэ нь бидний амьдралд жинхэнэ

ариуслыг бүтээдэг.

Эзэнээс эмээхүй дотор байхуй нь өнө мөнхийн өвийн

баталгаажуулалт болой.

Эзэнээс эмээхүй нь өөртөө итгэх итгэл, үл айдас, аюулгүйн

баталгааг бий болгодог. Энэ нь бусад бүх айдсыг - тэр дундаа

хүнээс айх айдсыг залгидаг.

Эзэнээс эмээхүй нь биднийг хэний хэн болохыг маань тогтоон тодорхойлж, биднийг үр бүтээлтэй болгож, үржих хүчин чадлаар хангадаг.

Эзэнээс эмээхүй нь бидэнд тэнгэрэлч нарын замчлал, хүслийн биелэл, тогтвортой амжилт, нэр төр, нэр нөлөөлөл, урт удаан нас, үр бүтээлтэй өдөр хоног, амьдралын таашаал, аз жаргал, ажиллаж хөдөлмөрлөхийн жаргалан, биеийн эдгэрэл тэргүүтнийг хайрладаг.

Эзэнээс эмээхүй нь хэзээ ч мөхөлгүй, мөнхөд орших. Эзэнээс эмээхүй нь тэнгэрийн Аавын минь нандин бэлэг.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархалаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм. Яагаад гэвэл бидний Бурхан шатаах гал мөн (Еврей 12:28-29).

Санаа: Эзэнээс эмээхүй нь Бурханы хайрладгийг хайрлаж, үзэн яддагийг нь үзэх ядахуй. Түүнд чухал нь бидэнд чухал болж, Түүнд чухал биш нь бидэнд чухал биш болох.

Эргэцүүлэл: Бурханыг хэн бүхнээс, юм бүхнээс дээгүүр үнэлж, хүндэтгэж, дээдэлж, өргөмжилж, бишрэх гэдгийг амьдрал дээр бодитоор хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны нэрээс, Үгээс, оршихуйгаас - Танаас бүхэлд нь эмээхийг зааж өгөөч. Ариун эмээхүйг тань хайрлаж, дурлахад сургаач. Ариун Сүнс ээ, аян замын минь явцад миний дотор Бурханы арга замыг суулгаач; мэдлэг төдийхнийг олох бус, харин үг амьдралыг минь Эзэн Есүс Христийн дүр төрх рүү хувирган өөрчлөх болтугай. Есүсийн нэрээр хичээнгүйлэн гуйж байна. Амень.

Шийдвэр: Амны үг, зүрхний бясалгал маань Бурханы Сүнс мэлмийд таашаагдах болтугай.

*Түүний зан чанар бүхэлдээ биднээс
хүндэтгэлийг тушаадаг. Учир нь энэ
нь туйлын ариун бөгөөд Түүний нэр
алдар нь бидний хувьд хэзээ ч амныхаа
зоргоор бус, гагцхүү чин эргэцүүлэл,
үнэн мөргөлөөр л дурсах, өндөр
хүндэтгэл бүхий үг болой.*

— Си. Эйч. Спержен

4 | БУРХАНЫ БИЕТ ОРШИХУЙ

Бурханаас эмээхүй нь эрүүл ухаантай мөргөлдөж байдгийг өмнө хэлсэн. *Эмээхүй* гэдэг үгийг сонсохоор, хор хөнөөлтэй юмуу тэр байтугай аюул осолтой нөхцөл толгойд буух. Гэхдээ Бурханаас эмээхүй нь ертөнц дээрх бүх оршигсодод өөртөө итгэх итгэл, тайвшрал, хамгаалалтын хамгийн том хүч болдгийг батлан хэлье. Аялал маань үргэлжлэх тусам, энэ үнэн улам задарна. Гэхдээ ариун эмээхүйг юуны түрүүнд хоёр том ангилж болно:

1. Бурханы оршихуйд *чичрэх*.
2. Бурханы Үгд *чичрэх*.

Бид аль алийг нь хэлэлцэх боловч, дарааллаараа явъя. Магтаалч “Ариун хүмүүсийн чуулалд Бурханаас эмээнэ. Түүнийг тойрох бүхнээс, Тэрээр аугаа болоод сүрдмээр” (Дуулал 89:7) гэсэн. Энд зүгээр нэг “Айх” гэж хэлээгүй, харин сүрдэж айх тухай хэлжээ. Үнэн болбоос - Бурханыг хүндэтгэхгүй, эмээхгүй байгаа уур амьсгалд Бурханы гайхамшигт оршихуй хэзээ ч олодохгүй.

Үүнийг миний бие 1997 онд бодитоор харсан билээ. Би Бразилийн нийслэлд болсон үндэсний хэмжээний конференцэд номлохоор уригдсан юм. Тэр аугаа улсад анх удаа зочилно гэхээс бөөн догдлол.

Онгоц маань өглөө эрт Бразилд газардсан болохоор надад ерөөндөө залбирч, бэлтгэж, амрах бүтэн өдөр олдов. Орой нь болзоот газар руугаа явтал, биднийг ирэхээс ч өмнө гудмаар увралдан цувралдсан машин - цуваа шууд л нүдэнд туслаа.

Машины зогсоол ч пиг байсан нь конференц эл хуль оргихгүйг илтгэв.

Намайг заал руу оруулаад, тэндээ хэд хэдэн удирдагчтайгаа уулзуулаад, шууд л тайзан дээр гаргалаа. Би ч Бурханаар өлсөж цангасан мянга мянган итгэгч нартай Бурханыг магтана гэхээс хөөрөөстэй. Гэвчиг төдөлгүй тэр их аагиж саагисан уур амьсгал дунд Бурханы оршихуй эзгүй байгааг анзаарах үед нөгөө их догдлол маань сарнив. Би гайхав. Учир нь энэ чинь итгэгч нарын чуулал. Магтаалын баг нь ч улсынхаа шилдэг баг. Гэтэл яагаад Бурханы оршихуй заларсангүй вэ?

Цааш өгүүлэхээсээ өмнө Бурханы оршихуйн талаар хэдэн үг хэлье. Бичээс хоёр төрлийн оршихуйг ярьдаг. Эхнийх нь Бурханы газар сайгүй байгч оршихуй. Энэ тухай Давид “Таны Сүнснээс би хаашаа одох вэ? Эсвэл Таны оршихуйгаас би хаашаа зугтах вэ? Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд. Хэрэв би үхэгсдийн оронд ор дэрээ засвал, Харагтун, Та тэнд... Харанхуй ч Танд харанхуй биш бөгөөд, шөнө ч өдөр мэт гэрэлтэнэ. Гэрэл харанхуй адил юм” (Дуулал 139:7-8, 12) хэмээн гэрчилсэн. Энэ бол “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” (Еврей 13:5) хэмээн амласан Бурханы оршихуй.

Тэгвэл хоёрдугаар төрлийн оршихуй нь “Би ч түүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд *илчилнэ*” (Иохан 14:21) хэмээн Есүсийн мэдэгдсэн оршихуй болой. Илчлэх гэдэг нь “ил болгох... өөрийгөө дотно таниулах, ойлгуулах” гэсэн утга бүхий *эмфанизо* хэмээх Грек үг. Бурхан Өөрийгөө бидний оюун бодол, мэдрэмжинд илчлэх үед ийм зүйл болдог. Есүс “Хоёр буюу гурвуулаа Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна” (Матай 18:20) хэмээн мэдэгдсэн. Есүс Бурханы газар сайгүй байх оршихуйн талаар өгүүлээгүй нь тодорхой байна. Учир нь Есүс ингэж мэдэгдэх нь утгагүй болно. Есүс Өөрийнхөө илэрхий бологч оршихуйн талаар өгүүлжээ. Гэтэл Бурханы яг энэ оршихуй тэр оройн чуулал дээр заларсангүй. Би ч үүнийг мэдэрсэн даруйдаа нүдээ аниад, *Таны оршихуй хаачив?* гэж Ариун Сүнснээс асуулаа.

Тэгээд нүдээ нээгээд, тэр даруй өмнө хараагүй ч, тухайн эгшинд тодорхой болоод байсан нэгэн зүйлийг анзаарав. Хүмүүсийн дийлэнх хувь нь Бурханд ямар ч хүндэтгэлгүй хандаж байлаа. Зарим нь гараа хармаандаа шургуулчихсан, зарим нь элгэндээ

эвхчихсэн, залхсан шинжтэй ийш тийш гиюүрнэ. Эмэгтэйчүүд түрийвчээ ухаад л, хүмүүс ч үүгээр түүгээр багшралдан, гарч идэж уух юм худалдаж аваад ч байх шиг. Бас хоорондоо ярьж, хөхрөлдөх ч дүр зураг. Яг л шоу эхлэхийг хүлээж байгаа хүмүүсээс дээрдэх юмгүй. Би ч дотроо *“Яваандаа болиод, хүндэтгэж эхлэх байлгүй дээ”* гэж бодов. Гэвч тийм юм болсонгүй.

Хамгийн жигтэй нь магтаал хүндэтгэл дуусаад, зохион байгуулагч нэгэн удирдагч тайзан дээр гараад Бичээсээс уншаад байхад л арын хөгжим унтарсныг эс тооцбол, хүмүүс янзандаа байгаа нь намайг ёстой ангайлгав. Зогсолтгүй ангалзах тасралтгүй чимээ нь чих дүнгэнүүлэх. Би ч юу харж байгаадаа итгэж ядсандаа, дотор бачуурсаар.

Тэгтэл зүрхэнд минь Бурханы Сүнс *чи энэ байдалтай шууд тул* гэж хэлэхийг сонсов.

Намайг танилцуулсны дараа би орчуулагчаа дагуулан тайзан дээр гарлаа. Би юу ч дуугаралгүй, хүмүүс рүү ширтэв. Тайзан дээрх үйл ажиллагааг бүрэн зогсоох нь хүмүүсийн анхаарлыг олзлох ганц арга гэж дүгнэсэн хэрэг л дээ. Санаа минь ч бүтэж, бүтэн минут чимээгүй зогссоны эцэст хүмүүсийн анхаарлыг бүрэн татав. Бүгд нам болоод, тайз руу анхаарч, нам гүм тогтлоо. Энэ эгшинд бүх нүд тайзнаа зогсох миний дээр тогтож байлаа.

Би ч “Бразилд ирээд сайхан байна. Намайг урьсанд баярлалаа!” гэсэн мялаалгаар номлолоо эхлүүлсэнгүй. Өөрийгөө ч танилцуулсангүй. Харин шууд л “Таныг юм ярьж байхад, ширээний нөгөө талд өөдөөс чинь хараад сууж байгаа хүн таныг хүн ч гэж үзэлгүй, өөр тийшээ гөлрөөд байх юмуу эсвэл өөр хүнтэй яриад байвал, танд ямар байх бол?” гээд л чангаар асуучихлаа.

Тэгээд хэсэг чимээгүй зогсоод, өөрийнхөө асуултад өөрөө хариулав: “Таалагдахгүй. Тийм үү?”

Тэгээд цааш нь: “Таныг хөршийндөө зочлох бүрий хөрш чинь хялам зэхэн хийгээд л: “Ёоо, бас л чи юу...” хэмээн ёозгүй дуугардаг бол, танд ямар байх уу? Тэр айлд инээгээд л зочлоод байх уу?” гэлээ.

Тэгээд дахиад л хэсэг байзнаад: “Үгүй ш дээ!” гэж хариулав.

Дараа нь “Ертөнцийн Хаан Өөрийг нь хүндэтгэхгүй, Өөрт нь бөхийхгүй байгаа газарт Оршихуйгаа үзүүлж, үгээ хэлнэ гэж

Бурханаас эмээхүй

бодож байна уу?” гэж хэлээд, араас нь шууд шахуу “Хэзээ ч үгүй!” хэмээн хатуу хэллээ.

Цааш нь “Хэрэв энэ тайзан дээр танай улсын ерөнхийлөгч гарч ирсэн бол, та нар түүнд яаж анхаарч, яаж хүндэтгэх байсан бол. Эсвэл хайртай хөл бөмбөгчин чинь гарч ирсэн бол, та нар хөөрсөндөө сандлынхаа үзүүр дээр тогтон, хүзүүгээ сунгаад, үг бүрийг нь залгилах байсан даа. Гэтэл дөнгөж сая Бурханы Үгийг уншихад, та нар огт анхааралгүй, дүнгэнээн шиг л өнгөрөөв!”

Тэгээд ерэн минутын турш хүмүүст Эзэнээс эмээхүйн талаар ярьж өглөө. Бараг л зүү унасан ч, сонсогдохоор байв. Миний үг хүмүүсийг үнэхээр дэлссэн бөгөөд тэд хамаг л зүрхээ дэлгэн байж сонсов.

Сургаалынхаа дараа “Та хэдий итгэгч хүн мөн ч гэлээ, ариунаар эмээдэггүй явдлаа гэмшмээр байгаа бол, босоод зогс!” хэмээн уриаллаа.

Танхимын 75 хувь нь нир хийтэл босов. Хамтдаа залбирч эхлэв үү, үгүй юу Бурханы оршихуй танхимд цүл хийтэл буув. Бурханы гайхамшигт оршихуй амьдралд нь хүрэлцэв үү, үгүй юу хүмүүс уйлан хайлж эхэллээ. Ариун эмээхүй тэднийг Бурханаас айж дөлөх бус, харин ч бүр ойртуулав.

Үүний дараа миний дөчин жил үйлчлэхдээ үзэж явсан, хамгийн ер бусын үйл явдал өрнөсөн юм. Гэхдээ энэ түүх рүү орохоосоо өмнө дараах үгээр хичээлээ дуусгая.

Ингээд би үгийг нь сонслоо. Үгийг сонсонгуут би *нүүрээрээ газар унаж, гүн нойронд* автав. Харагтун, нэгэн гар надад хүрсэнд би *чичирсээр* өвдөг хийгээд гарынхаа алган дээр босов. Тэрээр надад,—*Ихээр хайрлагдсан* Даниел аа, чамд хэлэх гэж буй үгийг ойлгож, цэх зогсогтун. Би чам уруу илгээгдсэн юм гэв. Тэр надад энэ үгийг хэлэхэд би *чичирсээр* босов. (Даниел 10:9-11)

Даниел Бурханд машид хүндтэй хүмүүн байсан чиг, хөл дээрээ тогтож чадахгүй, газар унажээ. Өвдөг дээр нь өндийлгөж, хөл дээр нь босгосон ч, Даниел чичирсээр л байж. Хүн Бурханы элч - тэнгэрийн элчийн өмнө л ингэж байхад, Бурханы биет Оршихуйн өмнө яах билээ?

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Ариун хүмүүсийн чуулалд Бурханаас эмээнэ. Түүнийг тойрох бүхнээс, Тэрээр аугаа болоод сүрдмээр (Дуулал 89:7).

Санаа: Өөрийг нь дээдлэн хүндэтгэсэн уур амьсгалд л Бурхан Өөрийгөө илэрхийлнэ.

Эргэцүүлэл: Бурханы оршихуйд чичирнэ гэж юу гэсэн үг вэ? Үүнийг ганцаараа байхдаа, найзуудтайгаа байхдаа, олон нийтийн газарт байхдаа, цуглаан дээр байхдаа тус тус хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны магтаал хүндэтгэлийн уур амьсгалд хамаа намаагүй хандлагаар нэвтэрснийг минь уучилж хэлтрүүлээрэй. Таны оршихуйд зүй бус хандсандаа гэмшиж байна. Есүсийн цус намайг цэвэрлэх болтугай. Таны өмнө өөрийгөө даруусгаж, өөрчлөлтийг хүсэн гуйж байна. Хаа ч байсан, юу ч хийсэн, Таны оршихуйг мэдэрч, хүндэтгэмээр байна. Цаг үргэлж Таны оршихуйг эмээж хүндэтгэхийг хүсч байна. Есүсийн нэрээр гуйж байна. Амень, амень.

Шийдвэр: Би Бурханы Үгд бүрэн анхаарч, хэлэх, хийх бүхнээрээ Түүний оршихуйг хүндэтгэж амьдарна.

*Залбирахаасаа өмнө хүчин зүтгэл
гаргаад, Хэнд хандаж, Хэний оршихуйд
нэвтэрч, Хэнтэй ярих гэж байгаагаа
оюун санаандаа ухааран сана.*

— Авилагийн Тереса

5 | МАРТАГДАШГҮЙ ОРОЙ

Эзэн дагалдагч нартайгаа хамт ажиллаж, “... дагалдах тэмдгүүдээр үгийг баталсаар байсныг” (Марк 16:20) Маркийн сайнмэдээ баталдаг. Энэ хамтын ажиллагаа нь Есүсийг тэнгэр өөд өргөгдсөн цагаас эхэлсэн бөгөөд энэ явдал Түүнийг ирэхээс өмнө тасалдах талаар Шинэ Гэрээ нэг ч хэлээгүй.

Тэгэхээр, бүгдээрээ нөгөө Бразилийн түүх дээрээ эргээд очъё. Бурханд хүндэтгэлгүй хандсанаа гэмшихийг дуудтал, хүмүүсийн 75 хувь нь босоцгоов. Би ч гудайгаад, “Эзэн Бурхан минь, энэ орой тунхагласан үгээ батлаач” хэмээн чангаар залбирлаа.

Эгшин зуурын дотор хүмүүс энгэнэтэл уйлалдав. Хэдэн минутын турш уур амьсгал Бурханы оршихуйгаар дүүрэн давалгаалж, тэнд байсан хүмүүсийн зүрхийг цэвэрлэн, сэргээв. Энэ бүхний дараа ч ер бусын амар тайван үргэлжилсээр байлаа.

Хүмүүс амаараа уучлал эрэн залбирахаа зогсоосон ч, зүрхэн дэхь өөрчлөлтийнх нь улмаас Бурханы оршихуй илэрхийлэгдсээр байлаа. Би хожим энэ талаар тунгааж байхдаа, тэнүүлч хүүгээ эргэж ирээд уучлал гуйж ч амжаагүй байхад нь аав нь өөдөөс нь тосон гүйсэн байдгийг санав. Хүү харьж ирснээрээ л өөр зүрхтэй хүн болсноо батлан харуулсан бөгөөд аавынх нь хувьд хүүгээ тосч гүйгээд, тэвэрч үнэрлэхэд үүнээс илүү юм хэрэггүй байж. Гэтэл Бразилд яг л ийм үйл явдал тохиосон гэлтэй.

Үнэхээрийн онцгой цаг байлаа. Хүндэтгэл бүхий нам гүм дунд бөхийсэн, хайлсан зүрхтэй хүмүүс. Тэднийг гэмшлийн залбиралд удирдах хэрэгтэй мэт харагдав ч, зүрхнийхээ угаас юулж буй, чин сэтгэлийн үгсийг нь таньж ядах юмгүй байлаа. Хэсэг залбирсны дараа тэр цэнгэлдэхэд Бурханы илэрлийн удаах давалгаа сад тавив.

Мөн л энд тэндгүй асгарсан хүмүүс - гэхдээ энэ удаа хавьгүй хүчтэй. Үнэхээрийн үзэсгэлэнтэй энэ үзэгдэл хэдэн минутын дараа мөн л харьчихав.

Бид Бурханы хоёр удаагийн ер бусын амар тайван, илэрхийллээр сэргэсэндээ баярлаад барсангүй. Уур амьсгалыг тэнгэрлэг амар тайван эзэгнэхэд, бүх хүн улам илүүг хүсэн хүлээсээр байлаа. Аниргүйн дунд Бурханы Сүнс зүрхэнд минь *“Би дахин нэг үзэгдэнэ”* хэмээн айлдахыг нь би сонсов.

Би ч сонссоноо чангаар хэлсэн боловч, дараа нь юу болохыг хэн нь ч мэдсэнгүй - бид тэс өөр оршихуйтай уулзах гэж байжээ. Дараа нь юу болсныг үгээр илэрхийлэх боломжгүй учир, бичиглэхэд хэцүү байна. Миний бичих зүйл бодит байдлаас харьсан, “Сансрын” түүх шиг санагдаж болох ч, хориос олон жилийн хойно одоо ч тэр үйл явдлыг үй олон хүн батлан хэлдэг юм шүү.

Хүчтэй шуурганаар ой модон дунд торойж байна гээд төсөөл дөө. Хүчирхэг салхи моддын оройг шавхуурдан исгэрээ л. Гэтэл тэр цэнгэлдэх хүрээлэнгийн дээгүүр яг тийм чимээ сонсогдсон юм. Бид салхи мэдрээгүй ч, баттай сонсов. Тэр даруй оролцогч хүмүүс пир хийтэл залбиран, уйлалдаж эхлэв. Би өөрөө ч Бурханы оршихуйг бишрэхээр барахгүй, бүр айсан. Хөдөлж ч чадахгүй, ярьж ч чадахгүй, хамаг биеийн шар үс босоотой. Тэр уур амьсгалаас миний хэзээ ч үнэртэж яваагүй, эрх мэдэл ханхалж байв. Тэгээд би *“Энэ чинь Аавын оршихуй биш, харин ариун, аймшигт, аугаа, хүчирхэг Хааны оршихуй байна!”*¹ гэж бодож билээ.

Салхины архираа ер орчим секунд үргэлжлэв. Тэгээд аажмаар сарнихдаа, хүмүүсийг уйлуулахыг нь уйлуулж, ухаан балартуулахыг нь балартуулж, зарим нь урд суудлынхаа арыг даваад уначихсан байсан ч, бүгд айж эмээсэндээ чичрээд ямар ч сөхөөгүй байлаа. Энэ үйл явдал дахин арваад минут үргэлжилсэн байх. Би юу ч хэлж чадсангүй. Бүгд нам гүм, чив чимээгүй. Тэгээд би цуглааныг удирдагчид нь шилжүүлээд, машин руугаа замчлууллаа.

Хэсэг хугацааны дараа тэр оройн гоцлол дуучин, нөхөртэйгээ машинд орж ирээд *“Тэр салхийг сонссон уу?”* гэснээ өмөлзөөд л явчихав.

Бичшуудлхариулахаастатгалзаад, өөр хүнээр баталгаажуулахыг хүслээ. Тиймээс “Магадгүй цэнгэлдэх дээгүүр жижиг оврын онгоц нисээд өнгөрсөн ч юм билүү” гэлээ (Агааржуулалтыг дэмжих үүднээс тэр цэнгэлдэхийн гадаад дээвэр, дотор дээврийн хооронд зайтай байдаг байв).

Тэгтэл өмнө сууж байсан тэр эмэгтэй цочирдсон янзтай эргэж хараад “Үгүй ээ, Бурханы Сүнс байсан!” хэмээн үнэн голоосоо эсэргүүцлээ.

Үг цөөтэй нөхөр нь ч хажуугаас “Үгүй ээ эрхэм ээ, онгоц байгаагүй” гэв.

Тэгэхээр нь би “Та яаж мэдэж байгаа юм?” гэж асуулаа.

Тэгтэл тэрбээр “Цэнгэлдэхийн гадаа аюулгүйн албаныхан, цагдаа нар олноороо байсан. Олонх нь итгэгч биш хүмүүс. Тэд ч тэр салхины чимээг сонсоод, яаравчлан дотогш орж ирээд, байшин дотроос юун салхи чангаар исгэрээд байгааг манай багийнхнаас лавлаж асуусан. Үүгээр ч барахгүй, би өөрөө гол саунд боард дээр сууж байсан (Тэрбээр гэргийгээ дуулах үеэр саундынх нь төвшин зөв байгаа эсэхийг шалгах үүрэгтэй суужээ). Тэгтэл саунд систем дээр ямар ч дуу чимээ бүртгэгдээгүй - салхи исгэрэх хугацааны турш децибелын хэмжүүр юу ч бүртгээгүй” гэж хэлсэн юм.

Хацраараа урсах нулимсаа барьж дийлэхгүй байгаа гэргий нь ч “Би байшин дотор галан давалгаа давалгаалахыг харсан бас тэнгэрэлч нар газар сайгүй байхыг мэдэрсэн” хэмээн үргэлжлүүлэв.

Би ч зочид буудалдаа хүргүүлэхийг хүслээ. Буцах замдаа бүгд чив чимээгүй явав. Тэр орой би олон цаг өрөөнийхөө тагтан дээр суугаад, Бурханыг магтан хүндэтгэхээс өөрийг хийж чадсангүй.

Маргааш өглөө нь цэнгэлдэхэд ортол, тэс өөр уур амьсгал угтлаа. Өнгөрсөн оройн Бурханы оршихуйн илрэл бас л мэдэгдсээр. Хүмүүсийн зүрхэнд Бурханаас эмээхүй сэргээгдэж, тэд Бурханы ер бусын оршихуй, ерөөлийг улам ихээр хүсэн хүлээж байв. Тэр оройн үйл явдал амьдралд нь хэрхэн нөлөөлснийг олон хүн захидал, и-мэйл, биеэрээ гэрчилж байсныг хэлсэн. 2016 онд арван хоёр мянган удирдагчид заахаар Бразилийн Гойаниад зочлох үед гар атган, тосч авсан нэгэн пастор хамгийн түрүүнд “Би хорин жилийн өмнө Бразилийн нөгөө салхи исгэрдэг цуглаан дээр байсан хүн. Тэр явдлаас хойш миний амьдрал орвонгоороо

Бурханаас эмээхүй

эргэсэн” гэсээр уулзаж билээ. Тэрбээр арван зургаахан жилийн дотор 300,000-с олон хүнтэй болтлоо өссөн сүлжээ чуулганы нэгэн удирдагч байв.

2019 онд гэргий минь Бразилийн конференцэд заах үеэрээ хорин жилийн өмнө салхи исгэрсэн тэр цуглаанд оролцож явсан өөр нэгэн хөдөлгөөний удирдагчтай уулзсан гэдэг. Тэр бүсгүйн ч амьдрал орвонгоороо өөрчлөгдсөн гэх.

Бурханы оршихуйд байх нь итгэгч хүн бүрийн сүнсний эрүүл мэндэд амин чухал. Би залбирахдаа Бурханы оршихуйд орох гэж зүдэрдэг байлаа. Гэтэл нэг өдөр тун санамсаргүй байдлаар нэгэн зүйлийг хийж эхэлсэн бөгөөд ямар нэгэн дуу хуур, мялаалгийн үгээр залбирлаа эхлүүлэхгүй байхаар шийдсэн юм. Зүгээр л Бурхан юутай гайхамшигтай, ариун болохыг бодож эхэлтэл, шууд л оршихуй пөн хийтэл буугаад ирэв. Маргааш нь ч адил зүйлийг хийтэл, яг л ижил үр дүн гарч билээ. Гурав дахь өдөр нь ч ялгаагүй.

Би ч гайхаад, асуулаа: “Эзэн минь, сүүлийн гурван өдөр яагаад Таны оршихуйд нэвтрэх ийм амархан байна?”

Тэгтэл Бурханы Сүнс “*Есүс дагалдагч нартаа залбирахыг яаж заалаа?*” гэхийг нь дуулав.

Би ч Эзэний залбирлыг эшлэв: “Тэнгэр дэхь бидний Аав аа, таны нэр *ариунаар өргөгддөг.*” Тэгснээ “Гийм байна! Есүс дагалдагч нартаа Бурханы оршихуйд ариун эмээхүй, хүндэтгэлээр ирэхийг заасан байна!” гээд л дуу алдаж билээ. Ингэж л хамаг учир тайлагдсан юм.

Энэ үнэнийг Давид ч: “Таны ариун сүмд, Таныг мэхийн хүндэтгэнэ” (Дуулал 5:7) хэмээн баталсан. Бурхан - бидний Аав. Есүс - бидний Эзэн бөгөөд Аврагч. Бурханы Сүнс бидэнд гүнээ хайртай. Гэхдээ нөгөөтэйгүүр, Шинэ Гэрээ Бурханыг “залгигч гал” (Еврей 12:29) хэмээдгийг бүү мартаарай. Есүс Өөрийнхөө хамгийн дотно байсан, хайртай дагалдагч Иоханаа дуудах үед Иохан үхэнгээ алдан, нүүрээрээ унасан (Илчлэл 1:7) бөгөөд Бурханы Сүнс инү бүхэл бүтэн хотын анхаарлыг татах үүднээс Бурханы хүчийг үзүүлэгч (Үйлс 2), байшин барилгыг чичирхийлүүлэгч (Үйлс 4) зэрэг ер бусыг үйлдэгч Нэгэн болой.

Дүгнэлт нь: *Эзэнийг хаана хүндэтгэнэ - Эзэний оршихуй тэнд илэрхийлэгдэнэ.*

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Мөхөсдөл, айдас, үлэмж чичрэл дор би та нартай хамт байсан. Үг минь ч, тунхаглал минь ч мэргэн ухааны ятгалгын үгээр бус, харин Сүнс ба хүчний илрэлээр байсан нь итгэл чинь хүмүүний мэргэн ухаанд бус, харин Бурханы хүчинд байхын тулд байлаа. (1Коринт 2:3-5)

Санаа: Эзэнээс эмээхүй уур амьсгалыг өөрчилдөг. Энэ нь Ариун Сүнсний дотор бидний болоод бусдын амьдралыг өөрчлөх уур амьсгалыг хөгжөөдөг.

Эргэцүүлэл: Би Бурханы оршихуй, хүчний илэрхийлэлд итгэж, хүсэн хүлээж үзсэн үү? Бурхан дээр ариун эмээхүйгээр очиход, миний залбирлын амьдрал хэрхэн өөрчлөгдөх бол? Энэ шилжилтийг хэрхэн хийх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, өнгөрсөн туршлага, өрөөлийн нөлөөллөөр Таны оршихуйн илрэлд хорио тогтоож, Таны үйл хэргийг хязгаарлаж байсныг минь уучлаарай. Би Танд нэг ч хорио хязгаарлалт тавилгүй, цэвэр ариун эмээхүйгээр Таны оршихуйн өмнө ирж байна. Миний асууж, бодож, найдаж чадах хэмжээнээс минь давуулан, хүчээ илчлээрэй. Үүнийгээ Эзэн Есүсийг минь алдаршуулж, миний хүрээлэл, нөлөөлөлд байдаг хүмүүст хүрэхийн тулд хийгээрэй. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Итгэж, Бурханаас ариунаар эмээж байгаа нөхцөлд бүх зүйл боломжтой.

*Бурханыг хамаг л биширэм ариун,
гийгүүлэм алдраар нь нүүр тулан үзэх
үедээ бид өмнө Түүний талаар тийн
энгийнээр сэтгэж явснаасаа ч айна.*

— Жой Ваусон

6 | ЭЗЭНИЙГ ҮЗЭГТҮН

Бидний ариун эмээхүй Бурханы аугаа чанарын талаарх ойлголтын маань хэм хэмжээг дагаж ургадаг. Гэвч үнэн болбоос: “ЭЗЭН аугаа бөгөөд, машид ихээр магтууштай, аугаа нь илрүүлшгүй” (Дуулал 145:3). Учир нь Түүний алдарт орой үгүй. Түүний алдар хязгаар үгүй, эн үгүй, хүрэшгүй, эгнэшгүй. Тийм хэдий ч, бид ойлголтоо тэлэхийн төлөө л явах ёстой.

Ойролцоогоор МЭӨ 742 онд Уззиа хаан ч таалал төгсөж, эш үзүүлэгч Исаиа ч тэнгэр өөд авагдсан байдаг. Исаиа сэнтийдээ хамаг л алдраараа өргөмжлөгдөн залрах Эзэнийг үзэв. Эзэний гайхамшиг магад тэрбум илүү оршигсдыг багтаах, нүсэр байгууламжаар нэг давалгаалан байдаг.

Исаиа Бүтээгчээ автан бишрэхээр барахгүй, Бурханы сэнтийг нөмөрлөн бүрхэх аугаа серафим тэнгэрэлч нарт ч автсан. Тэдгээр сүрдэм оршигсдын уруулаас Исаиа:

“Түг түмдийн ЭЗЭН, ариун, ариун, ариун, бүх л газар алдраар нь дүүрэн байна” (Исаиа 6:3) хэмээх үгийг сонсов.

1800-гаад онд Жон Бакус Дайксын зохиосон, “Ариун, ариун, ариун” хэмээх мөнөөх үг бүхий сонгодог дууллыг бид бүгдээрээ мэднэ. Энэ үг хоёр зуугаад жилийн турш чуулганы сонгомол үг болсоор ирсэн бөгөөд сүүлээрээ уянгын магтаал гэдэг нэрийг ч авсан. Гэхдээ үүнээс Исаиагийн харсан үзэгдэл тэнгэр газар шиг ялгаатай байсан юм.

Тэдгээр аварга оршигсод Бурханы сэтгэлийг засах гэмээн уянгалуулсан гэхээсээ илүүтэй, харж буй зүйлдээ өөрийн эрхгүй

дуу алдан хариулсан нь тэр авай! Ар араасаа хөврөн тодрох Бурханы оройгүй аугаа чанарын шив шинэхэн гялбааг үзэх тоолондоо: “Өө ариун, ариун, ариун...” хэмээн тэнхээ мэдэн дуу алдахаас өөрийг хийж эс чаджээ тэд.

Серафимууд “Ариун” гэдэг үгийг гурав давтаад л зогсчихсон гэж бүү бодоорой. Исаиа тэргүүтэй Еврей бичээч нар аливаа утгыг хүчитгэхдээ тухайн үгээ хоёр удаа давтдаг. Тухай нь Есүс “Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй” (Матай 7:21) хэмээн айлдсан байдаг. Та Есүсийн энэ үгийг сонсож суугаа Матай байсан бол, Есүс хэрхэн *Эзэн* гэдэг үгийг дууныхаа өнгөөр тодосгож байгааг мэдрэх байж. Тэгээд Эзэнийхээ цохолтыг олзлон харуулах үүднээс Матай уг үгийг хоёронтоо давтаж. Англи хэлтэй бид үгийг онцотгохдоо, “Болд” юмуу “Италик” болгож тэмдэглэдэг.

Тэгвэл Еврей бичээч нар аливаа үгийг гуравдугаар төвшин өөд тулгаж өргөсөн тохиол тун цөөн. Үнэндээ Бичээс дээр ганц, хоёр л тохиодог. Энэ нь тухайн үгийг тултал нь өргөн цохож байна гэсэн утга илэрхийлнэ. Тэнгэрэлч нарын хоолойн тэр нүргээнд мөнөөх нүсэр байгууламжийн үүдэн багана нь ганхан доргисон гэдэг.

Манайх Флорида руу нүүхдээ, тэндхийн усны төвшин өндөр учраас, байшин барилга нь доод давхартаа хонгилгүй байдгийг мэдэж билээ. Барилгачид маань “Хар шуурга хаяанд ирбэл, өрөөнийхөө хаалганы тотгон дор хорогдоорой. Учир нь хаалганы тотго аливаа байгууламжийн хамгийн бөх бүтэц байдаг” хэмээн зааварчилж билээ. Тиймээс Исаиа тэрхүү нүсэр байгууламжийн тотгон багана чичирхийлж байсныг цохсон нь онц сонирхолтой болж таарч байна. Тэгэхээр, тэрхүү аварга тэнгэрэлч нарын нүргээнт хашхираанд байгууламж тэр аяараа доргио байх!

Эзэний алдрыг үзээд Исаиа хэрхэн хариу үйдсэн бол? “Уау л даа!” гээгүй.

Үгүй ээ, Исаиа “Би сүйрсэн тул золгүй еэ! Яагаад гэвэл би бузар уруултай хүн” (Исаиа 6:5) хэмээн орилсон. Бодоод үз дээ: Исаиа бол бурханлаг хүн - эш үзүүлэгч - номынхоо яг өмнөх бүлэг дээр “мууг сайн гэдэг хүмүүс золгүй, бардам хүмүүс золгүй, согтуурагсад золгүй!” (Исаиа 5:20-22, зохиогчийн өөрийн үг) хэмээн хашхирч явсан хүн. Гэтэл ганц бүлгийн дараа Бурханы аугааг халыг үзсэн тэрбээр “Нүгэлтнүүд золгүй еэ!” гэж хашхиралгүй, “Хийгээгүй

зүйлийнхээ улмаас би золгүй еэ!” гэж хашхирчээ (6:5). Бурханыг мэддэг хэмээн сэтгэж явсан Исаиа эдүгээ Аугаа хүчирхэг Бурханыг хавьгүй илүү ухаарч. Исаиа ариун Бурханы өмнө өөрийгөө ч хэн болохыг мэдэв. Энэ уулзалт юу авчрав? Исаиагийн ариун эмээхүй олон төвшин өссөн!

Эзэнийг алдраар нь үзсэн хүмүүс ийнхүү үйлдэх нь Бичээст олонтаа гардаг. Иов яасан билээ? Аугаа хүчирхэг Бурхан түүний тухай “Миний боол Иовыг анзаарав уу? Өөлөх өөгүй, зөв шударга агаад Бурханаас эмээж ёр муугаас хол явдаг түүн шиг нь газар дэлхий дээр үгүй” (Иов 1:8) хэмээн айлддаг. Бурхан та, бид хоёрын тухай ийм үг хэлбэл, яахыг төсөөлж байна уу? Дэвхцэн баярлана! Гэтэл Иов Бурханы алдрыг үзээд, “Таны тухай чихээрээ сонсож л байлаа, би. Тэгтэл одоо нүд минь Таныг харж байна. Харин би хэлснээсээ буцаж байна. Үнс шороон дунд гэмшье” (Иов 42:5-6) хэмээн хашхирсан байдаг.

Тэгвэл Езекиел? Эзэнийг үзсэн тэрбээр “Үзэгдэх төрх нь ЭЗЭНий цог жавхлантай адил байв. Би түүнийг хармагцаа нүүрээрээ унаад, айлдагч нэгний дууг сонсов” (Екекиел 1:28) хэмээн бичжээ.

Абрахам яасан? Абрахам Бурханыг үзээд “Нүүрээрээ газар унасан” (Эхлэл 17:3).

Бурхан Синай уулнаа яруу алдраараа үзэгдэхэд, “Мосе ‘Би айдаст автаж, чичирсэн’ ” (Еврей 12:21) гэдэг.

Есүсийн аминчлан хайрладаг байсан элч Иохан яруу алдарт Есүстэй уулзахдаа “Би Түүнийг хармагц хөлд нь, үхсэн мэт уналаа” (Илчлэл 1:17) гэсэн.

Эдгээр нь бүх жагсаалт биш юм. Ийм тохиолдол Бичээс дээр үй олон.

Саяхны түүхээс дурьдбал, 1266-1273 оны хавьцаа Томас Акуинас өөрийнхөө хамгийн том бүтээл болох Самма Теоложика номоо бичиж байжээ. Гэтэл нэгэн өдөр Бурхантай ер бусаар учран уулзаж, үзэл бодол нь орвонгоороо өөрчлөгдөөд, цаашид бичихээ больжээ. Анд нөхөр Режиналд нь Томасыг цааш бичихыг ятгатал, Томас Режиналдад “Миний хөдөлмөр дуусав. Надад илчлэгдсэн зүйлийн дэргэд миний бичсэн юмс сүрэл төдий л юм”¹ хэмээн хариулсан гэдэг.

Израильд нэгэнтээ Бурхан хүмүүсийнхээ ариун эмээхүйг гүнзгийлэхийн төлөө тодорхой асуулт тавьсан түүх бий. Эзэний алдрыг үзсэн Исаиа “Хэн ЭЗЭНий Сүнсийг удирдаж эсвэл Зөвлөх нь болж Түүнийг сургасан бэ? Тэр хэнтэй зөвлөлдөв? Хэн Түүнд ухаарлыг өгч, Шударга ёсны замыг Түүнд зааж, Мэдлэгийг сургаж, ухаарлын замыг мэдүүлсэн бэ?... Тэгвэл та нар Бурханыг хэнтэй адилтгах юм бэ? Түүнийг ямар дүртэй зүйрлэх вэ?” (Исаиа 40:13-14, 18) хэмээн асуусан.

Тэгтэл Бурхан шууд л “Тэгвэл та нар Намайг Хэнтэй адилтгаж, хэнтэй харьцуулах вэ?” (Исаиа 40:25) хэмээн асуув.

Ийм асуултыг гүйлгээд өнгөрөлгүй, гүнээ тунгаах ёстой цаг гэж байдаг бол, тэр нь өнөөдөр. Энэ өдөр, энэ цагт дийлэнхийн маань оюун ухаан ийм амин чухал асуултыг тунгаах ч завдалгүй, энэ дэлхийн эрээвэр хураавар мэдээллээр бөмбөгдүүлж явна. Ариун эмээхүйн хөгжил маань доголдож зогсож, олон итгэгч эцэстээ хүмүүний ололт амжилтын бардал, олз, хүслээр тэжээгддэг, дэлхийн системийн өмнө бөхөлзөн, автах.

Үүнээс гадна авъяаслаг тамирчид, Холливүүдийн оддын гоо үзэсгэлэн, чадварлаг хөгжимчин дуучид, бизнесийн гүрү, карисматик удирдагч зэрэг томчуудын нэр нөлөөлөл зэрэгтэн нь тархи угааж, нүүр нүдгүй шавна. Зурагт, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээний томоохон суваг тэргүүтэй бүх талбар тэдний алдар нэрийг дөвийлгөж шовойлгоно. Хамгийн эмгэнэлтэй нь иймэрхүү гэм хоргүй гэмээр жижиг сажиг мэдээлэл, хүмүүний алдар гавьяа нь биднийг Бурханыг бишрэх аугаа урилгыг хүлээн авч, Түүнтэй дотнсохоос чангаадаг нь үнэн.

Түр зогсоод, дотогш эргээд, Бурханы цог жавхланг ширтэх аваас, цээж тэгшрээд л, сэтгэл түвшрээд л, дотор дүүрээд л явчихна. Бидэнд:

Учир нь “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн царайн дахь Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн (2Коринт 4:6) гэсэн амлалт бий.

Ариун Сүнтэй нэгдэж, сэтгэлээ түвшитгэж, Есүсийн Үгийг тунгаах үедээ бид Түүнийг үзнэ. Эзэний царайг ширтэх нь бидний

зүрхийг Түүний алдраар гийгүүлэх бөгөөд үүний үр дүнд бидний ариун эмээхүй шат ахидаг. Бид Эзэнтэй уулзаж, Түүнтэй хамт алхаж амьдарч, гэрээний амлалтыг нь хүлээн авч, амьдралаа сайн төгсгөсөн Исаиа тэргүүтэй аугаа хүмүүсийн адил болно. Хамгийн сайхан нь, Эзэнийг үзсэнээрээ бид “...Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг” (2Коринт 3:18) хэмээн амласан.

Та хэний дүр төрхөөр баталгаажмаар байна - энэ цагийн алдартнуудын уу эсвэл ертөнцийг бүтээсэн Нэгэний юу? Мэргэн сонголт хийж, сонсож байгаа юмдаа, ухаанаа өгч байгаа юмдаа анхааралтай хандаарай.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Ариун хүндэтгэл дунд,ЭЗЭНд мөргөгтүн! Бүх дэлхий Түүний өмнө чичрэгтүн! (Дуулал 96:9)

Санаа: Бидний ариун эмээхүй Бурханы аугаа чанарын талаарх ойлголтын хэм хэмжээг дагаж ургадаг.

Эргэцүүлэл: Өдөрт гурван удаа гадны бүх нөлөөг хааж байгаад, арван минутын турш Бурханы аугаа чанарыг тунгаах цаг гаргабал, яах бол? Үнэтэй хөрөнгө оруулалт болж чадах болов уу? Ариун эмээхүй минь өсч, би өдөр тутмынхаа амьдралд илүү үр нөлөөтэй болж, яваандаа илүү цэц ухаантай болж чадах болов уу?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Та надад Есүсийг цоо шинээр харуулаач, Есүсийг зүрхэндээ үзбэл, би Түүний дүр төрх руу хувирч, алдрын нэг төвшнөөс нөгөө рүү ахихыг Таны Үг амладаг. Бурханы алдар амьдралд минь бодитой болохын хэм хэмжээгээр миний ариун эмээхүй ч өсөх болтугай. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би алдраас алдарт Есүсийн дүр төрх рүү өөрчлөгдсөөр байна.

Хүн Бурханд эс мэхийх атлаа

нэг нэгэндээ бөхөлзөх

— Хенри Давид Тореау

7 | БУРХАНЫ АЛДАР

Бурханы алдрыг ярилгүйгээр ариун эмээхүйн талаар ярилтгүй. Бид энэ талаар өмнөх бүлгээрээ хальт дурьдаад өнгөрсөн бол, одоо гүнзгийлж ярьцгаая.

Хүний мөнх бус бие Бурханы алдрын оршихуйд байж гэвчихгүй. Эш үзүүлэгч Хаббакук энэ тухай “Түүний туяа нь нарны гэрэл мэт юм. Түүний мутраас цацрагууд гялбадаг бөгөөд, Түүний хүч чадал нууцлагдсан” (3:4) хэмээн мэдэгдсэн. Паул ч Есүсийг “Түүнд ганцааранд нь үхэшгүй мөнх буй бөгөөд *хүршгүй гэрэл* дотор оршдог. Ямар ч хүн Түүнийг хараагүй бөгөөд харж чадахгүй” (1Тимот 6:16) гэдэг. Еврей номын бичээч ч мөн “Яагаад гэвэл бидний Бурхан шатаах гал мөн” (Еврей 12:29) гэдэг.

Эдгээр мэдэгдлийг сонсоод, мод түлээг хуйхлан шатаадаг ч, ойртож болоод байдаг галыг төсөөлөх хэрэггүй шүү. Харин цэнхэр дэлхийг маань гэрэлтүүлэгч нараар төсөөлбөл яаж байна? Гал улаан наранд хүрэлтгүй. Гэхдээ тэр нар ч “Гэрэл (бөгөөд) Түүний дотор харанхуй огт үгүй” (1Иохан 1:5) тэр Бурханд дөхөж ч очихгүй. Нар хурц гэрэлтдэг боловч бас л хар, хар толботой. Үнэндээ Паул “Хаантан, тэгтэл үд дунд зам дээр нарнаас ч хурц гэрэл тэнгэрээс гэрэлтэж, намайг болон надтай хамт явагсдыг хүрээлэн авахыг би харсан” (Үйлс 26:13) гэсэн.

Паул Есүсийн царайг үзэлгүй, Түүнээс цацрах, Ойрхи Дорнодын нарнаас ч хурц гэрлийг л үзсэн! Гэтэл тухайн цагийн нар нь өглөөний юмуу үдийн нар бус, харин бүр яг их үдийн нар байв.

Миний бие дэвэн дэлхийг хэдэнтээ тойрсон хүн. Хааяа нарныхаа шилийг мартаад явчихна аа. Ихэнх газарт шилтэй шилгүй явж болдог ч, Ойрхи Дорнодод бол ёстой бүтэхгүй юм

билээ. Тийшээ анх аялахдаа, нарны шилгүй явахгүйг шууд л ойлгосон. Шилгүй бол, нарны шууд бус, сарнисан цацрагт нь л юу ч үгүй онийж үрчийгээд явчихна. Тэндхийн нар жигтэйхэн хурц. Энэ нь гурван шалтгаантай: Цөлийн хуурай цаг агаар, байгалийнх нь тогтоцын хурц өнгө, тусгал тэгээд эцэст нь экваторын бүстэй ойр байршил. Өглөө эрт, орой үдэш зөөлөн боловч, үд дундын нар нь шилээр хамгаалахгүй л бол, сохлох нь уу гэмээр л байв.

Тэгэхээр, сая уншсан зүйлээ тунгаая. Есүсээс ялгарах гэрэл нь Ойрхи Дорнодын их үдийн нарнаас ч хурц байсныг Паул хэлэх! Есүсийн алдар нарны шижир туяаг хэдэнтээ давах ажээ.

Энэ нь Иоел, Исаиа хоёр юуны учир Есүсийг эргэж ирэх өдөр нар, сар харанхуйлж, одод гэрэлтэхгүй (Исаиа 13:9-10, Иоел 2:31-32) гэж хэлснийг тайлбарлаж байна. Ийм юм. Цэлмэг тэнгэртэй шөнө гадаа гараад өөдөө харбал, юу харагдах уу? Тэнгэр дүүрэн од. Гэхдээ өглөө нар мандахад яадаг уу? Одод алга болдог. Нар мандах үед одод бушуулан нуугдаад, нар жаргах үед буцаад бушуулан байр байрандаа тогтдог уу? Мэдээж, тийм юм байхгүй. Тэгэхээр яадаг байх нь уу? Одод нэг зиндааны алдартай бол, нар хавьгүй өндөр зиндааны алдартай ажээ. Тиймээс, нарны хурц гэрэл оддыг давдаг байна.

Есүсийн алдар нарыг хол хаяна. Нар шардгаараа шарсаар байв ч, Есүсийн алдар нарыг харанхуйлна! Одоо Есүсийн алдрыг арай илүү ойлгож байна уу? Тиймээс л дэлхийн хүн ард бултаараа “уулс ба хадуудад хандан,—Бидний дээр унаж, биднийг сэнтийд Залрагчийн нүүрнээс ба Хурганы уур хилэнгээс *далдлаач*” (Илчлэл 6:16) хэмээн хашхиралдана гэсэн болов уу гэж би итгэдэг.

Тэгэхээр хамгийн гол асуулт нь: Эзэний алдар гэж юу вэ? Үүнд хариулахын тулд Мосегийн: “Алдраа надад үзүүлээч, гуйж байна” (Гэтлэл 33:18) гэсэн хүсэлтийг авч үзье.

Алдрыг Еврейгээр *кабод* гэдэг. Үүнийг Стронгийн Библийн толь бичиг дээр “аливаа зүйлийн жин” хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн хүндэтгэл, эрхэмсэг байдлыг ч оноож нэрлэдэг. Тэгэхээр Мосе “Надад Өөрийнхөө хамаг л сүр сүлд, цог жавхланг үзүүлээч” гэж гуйсан байна. Тэгвэл үүнд нь Бурхан хэрхэн хариулсныг анхааралтай харна уу:

Би бүх сайн сайхнаа өмнүүр чинь өнгөрүүлж, ЭЗЭНий нэрийг чиний өмнө тунхаглана. (Гэтлэл 33:19)

Мосегийн алдрын хүсэлтэд Бурхан “Сайн сайхнаараа” хариулжээ. *Сайн сайхныг* Еврейгээр “Хамгийн өргөн утгаараа - бүхий л сайн сайхан” хэмээн тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, хамаг сайн сайхан гэсэн үг.

Үүнийхээ дараа Бурхан “Эзэний нэрийг чиний өмнө тунхаглана” гэжээ. Газрын хаадыг сэнтийн өрөөндөө залрахаас өмнө албат нь хааны нэр алдрыг зарлан тунхагладаг. Бүрээ үлээж, хаан хамаг л сүр жавхлангаа гайхуулсаар сэнтийн өрөөндөө нэвтэрнэ. Ийнхүү хааныг цог жавхлангаа бадраан залрах үед танхим ч хааныг хэнтэй ч андуурахааргүй танина. Гэхдээ, тэр хаан энгийн хувцаслаад, гудманд олны дунд бараа бологч наргүй, ганцаараа явж байвал, хүмүүс түүнийг танихгүй өнгөрч мэдэх.

Есүс Христийн царайнаас Эзэний алдар гийснийг бид өмнөх бүлгээрээ үзсэн. Олон хүн Есүсийг үзсэн гэдэг. Ингэх боломжтой. Гэхдээ бүрэн алдраар нь үзэх боломжгүй. Үүнийг Паул ингэж тайлбарласан: “Тэгэхээр бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ дараа нь би бүрэн мэдэх болно.” (1Коринт 13:12) Есүсийн алдар Хуучин Гэрээнд бараан үүлээр далдлагддаг байсан шигээ л нууцлагдсан байгаа.

Есүс үхлээс амилуулагдсаныхаа дараа хамгийн эхлээд Магдалын Мариатай ярилцгал, Мариа Түүнийг цэцэрлэгч гэж бодсон (Иохан 20:15-16). Дагалдагч нар эрэг дээр Есүстэй хамт загас идэх үедээ эхэндээ Түүнийг таниагүй (Иохан 21:9-10). Есүстэй хамт Эммау руу алхсан хоёр дагалдагчийн “нүд нь халхлагдсан” (Лук 24:16) байсан гэдэг. Есүс алдраа бүрэн нээгээгүй учраас, энэ хүмүүс Түүний царайг үзээгүй ажээ.

Хуучин Гэрээнд Эзэнийг үзсэн хүмүүс байдаг ч, Бурхан тэдэнд алдраа үзүүлээгүй юм. Мамрегийн царс модны дор Эзэн Абрахамд үзэгдэхдээ, алдраараа үзэгдээгүй (Эхлэл 18:1-2). Иаков Бурхантай барилдсан ч мөн л алдраар нь үзээгүй (Эхлэл 32:24-30). Иерихогийн ойролцоо илд далайсан Эзэнийг харсан Иошуа Түүнийг Израилийн талд эсэхийг нь асуусан. Гидеон болоод Самсоны аав, ээж тэргүүтэй хүмүүс ч ялгаагүй.

Бурханаас эмээхүй

Тэгвэл эсрэгээрээ - Патмос арал дээр элч Иохан Сүнс дотор Эзэнийг хамаг л алдар дотор нь үзсэн. Иохан Эзэний царайг үзээд үхдэл мэт унаад өгсөн бөгөөд Эзэний алдрыг хамаг л хүчин чадлаараа тулгал цацрах нартай адилтгасан юм. Исаиа тэргүүтэй хүмүүсийн хувьд ч ялгаагүй. Гэтэл Мосе мөнх бус бие дотроо байсан болохоороо Бурханы царайг харж чадаагүй.

Бурханыг алдар нь л Бурхан болгодог. Бурханы зан чанар, эрх мэдэл, эрх хүч, цэц ухаан нь Бурханы хэмжээлшгүй даацын болоод хүчний жин болой. Бурхан л оддыг хуруугаараа байр байранд нь тогтоож, нэг бүрчлэн нэр өгсөн. Бурхан л даяар ертөнцийг хуруугаараа хэмжээлэн, мутартаа атгаж байдаг. Бурхан л бөмбөрцгийг элсэн ширхэг мэт хуруундаа атгаж, усыг дусал дуслаар нь, газар шороо, уулсыг мутраараа жинлэдэг. Бурханыг л бид зүрхэндээ ширтсээр, эцэстээ Түүний дүр төрх рүү өөрчлөгдөж, алдраас алдарт хүрнэ!

Бурхан л биднийг гэр бүлдээ багтаах гэсэндээ нүглийн шүүхийн төлөөсийг минь төлөх хүртлээ хайрлан хайрласан. Та яадгийг мэдэхгүй ч, би бол баярлаад бардаггүй!

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Ерөөлт бөгөөд цор ганц хэмжээлшгүй Эрхт, хаадын Хаан, эздийн Эзэн цагт нь үүнийг харуулна. Түүнд ганцааранд нь үхэшгүй мөнх буй бөгөөд хүршгүй гэрэл дотор оршдог. Ямар ч хүн Түүнийг хараагүй бөгөөд харж чадахгүй. Түүнд хүндэтгэл ба мөнх ноёрхол нь байг! Амен. (1 Тимот 6:15-16)

Санаа: Бурханыг алдар нь л Бурхан болгодог. Бурханы зан чанар, эрх мэдэл, эрх хүч, цэц ухаан нь Бурханы хэмжээлшгүй даацын болоод хүчний жин болой.

Эргэцүүлэл: Ямар ч харанхуй, сүүдэр, бүрхэг, бүрэнхий нь байж дийлэшгүй, тийм хурц, шижир гэрлийг төсөөлнө үү. Энэ гэрэл зүрхийг маань цоо гэрэлтүүлж байна гэж төсөөлнө үү. Ийм байтал би Түүнээс юугаа бас хэрхэн нуух билээ? Боломжгүй.

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, надад алдраа ойлгуулаач. Би Таны алдарт хийсвэр зүйл шиг эсвэл байдаг л зүйл шиг юмуу үе үе дурсдаг зүйл шиг бус, харин намайг хүрээлэх энэ дэлхийгээс ч бодитой, хэзээ ямагт биедээ авч явдаг зүйл шигээ хандмаар байна. Таны алдар зүрх, тархинд минь цаг үргэлжид дурайх болтугай. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Надтай уулзсан хүн бүрийн хувьд би Христийн дотор Эзэнийхээ алдрыг гийгүүлсэн, дэлхийн гэрэл байх болно.

ИЛЧЛЭГДСЭН

Хоёрдугаар долоо хоног

Айдас дээр бус, хайр дээр үндэслэн

Бурханаас эмээх ёстой.

— Ариун Францис Де Сэйлс

8 | ТАНЫ ҮНЭ ЦЭНЭ

Энэ хичээл нилээд хүнд, магадгүй бүр чанга сэдэв байна байх. Тиймээс эхлэхээсээ өмнө түр завсарлаад, биднийг гэх Бурханы ер бусын хайрын ойлголтыг гүнзгийлье. Тэгэхээр би бүлгийнхээ амин хэсэг болох Есүсийн чанга - магад бүр аймшигтай мэдэгдлээр эхэлмээр байна. Агуулгаар нь уншихгүй бол, энэ үгийг ташаа ойлгоод, эрүүл бус айдаст автах боломжтой учраас, Бурханаас эмээнгүй, захирагдангуй зүрхээр уншихыг хичээнгүйлэн гуйя.

Харин хэнээс айж эмээвэл зохихыг та нарт сануулья. Хөнөөсний дараа тамд хаях эрх мэдэлтэй Нэгэнээс эмээгтүн. Тийм ээ, Би та нарт хэлье, Түүнээс эмээгтүн. (Лук 12:5)

Есүс Бурханаас *эмээж яв* гэжээ. Ганц удаа хэлэлгүй, бүр давтан тэмдэглэсэн байна. Энэхүү анхаарал олзолсон өгүүлбэр нь “тамд хаях” гэдэг үгээр эхэлжээ. Тун хатуу үг! Гэхдээ дараагийнх нь үгийг үзнэ үү:

Таван бор шувууг хоёрхон задгай зоосоор худалддаг бус уу? Гэсэн хэдий ч тэдний нэг нь ч Бурханы өмнө мартагдахгүй. Та нарын толгой дээрх ширхэг үс чинь хүртэл тоологдсон. *Тиймээс бүү ай.* Та нар олон бор шувуунаас ч эрхэм *үнэтэй*. (Лук 12:6-7)

Тавдугаар эшлэл дээрх “Бурханаас эмээ”, 7-аар эшлэл дээрх “Бүү ай” гэдэг үгийг тодруулсан байгааг тэмдэглээрэй. Мөн л *ариун* бөгөөд *ариун бус* айдсын ялгааг сөргүүлэн харуулж байна. Ялгааг нь ойлгож аваад, энэ үнэн дотор байгуулагдах нь маш чухал.

Есүс туйлын аймшигтай, сүрдэм үгээр эхлүүлсэн атлаа бараг л нэг амьсгал дор араас нь Бурханы хувьд бид ямар *үнэ цэнэтэй* байдгийг учирлажээ. Үндсэндээ Бурхан биднийг аминчилдаг учраас л ариун эмээхүйг зөвшөөрчээ. Энэ бэлэг л биднийг амь хайрлагч Нэгэнтэй минь ойр байлгаж, ариун эмээхүйн эсрэг зүйл болох *хүнээс айх айдсаас* хол байлгадаг. Цаашдаа энэ хоёр сэдвээр нилээд ярих боловч, эхлээд өөрсдийнхөө *үнэ цэнийн* талаар ярих ёстой.

Есүсийн хэлснээр, Бурхан таны толгой дээрх үсийг ширхэг ёсоор нь мэдэх хүртлээ таныг нандигнадаг ажээ. Хүн толгойдоо дунджаар 100,000 үстэй байдгийг эрдэмтэд хэлдэг. Танхимд байгаа арван мянган хүний чухам хэн нь 99,569 үстэй болохыг та тодорхойлж амжих уу? Яахав, зөв таачихдаг юмаа гэхэд, минутын дараа л таны таамаг алдаа заана. Учир нь хүн өдөрт дунджаар 50-100 ширхэг үсээ алддаг. Тэгвэл бидний үс минут тутамд хэрхэн хэлбэлзэж, хэдэн ширхэг болж байгааг Бурхан л ганцаараа мэднэ. Энэ юу гэсэн үг вэ? Бурхан таныг цаг үргэлж бодголоо л нандигнаж явдаг байх нь.

Аяа Бурхан, надад хандсан бодлууд тань хичнээн нандин бэ!
Нийлбэр нь хичнээн их вэ! Би тэдгээрийг тоолбол, тэд элсний ширхгээс ч даван гарна. Сэрэхдээ ч би Тантай хамт билээ.
(Дуулал 139:17-18)

Бүх элснээс шүү! Дэлхий дээрх бүх элсийг төсөөлж чадах уу? Эрэг дээрх, цөл дэхь, гольфийн талбай дээрх. Ой тоймд буушгүй их элс! Ширхэгийнхээ хэмжээ дамжаа, сул чанга чигжсэн байдлаасаа шалтгаалаад далайн эргийн 1 фут куб газарт ойролцоогоор таван зуун саяас нэг тэрбум элсэн ширхэг багтдаг болохыг эрдэмтэд, математикч нар тооцоолдог.¹ Ганц Флоридагийн эрэг дээрх элсний тоо ширхэгийг ч төсөөлж амжимгүй. Гэтэл энэ дэлхий дээрх бүх элсэн ширхэгийг нэмээд нэмээд, таны талаар боддог Бурханы бодлыг гүйцэхгүй гэх!

Тэгэхээр, өөрөөсөө асуугаад үз: Та юуны талаар хамгийн их боддог вэ? Чухал бус юмаа бодоод байх нь юу л бол. Лиза, бид хоёр Христмас баяраар агуулахаа ухах болгондоо нэг шинэ эд зүйл *олж илрүүлдэг* юм. Манайд тийм юм байсныг мэдэхгүй болтлоо таг мартчихсан гэдэг утгаараа л олж илрүүлдэг гээд байна. Нэг

их үнэ цэнэ өгөхгүй учраас, бүтэн жил дурсаагүй. Би Лизатайгаа амьдарсан 40 жилийнхээ хугацаанд түүний тухай бодсон бодлоо нэмээд нэмээд, гутлын хайрцагны талыг дүүргэх болов уу. Хоёр зуун сая бодол болох бөгөөд 6.3 секунд тутамд бодно гэсэн үг л дээ. Эхнэртээ жолоогүй дурласан эр хүн л эхнэрийнхээ тухай байн байн бодно.

Гэтэл Бурхан таныг энэ дэлхий дээрх бүх элснээс ч олон бодох! Үүнийг ойлгож чадах нь уу? Гэтэл Бурхан юуг ч давсалж хэлдэггүй нь бүр ч гайхмаар! Хүмүүс үнэнээс хол зөрүүтэй ярьж, хачирлаж чаддаг ч, Бурхан үнэнээс ганц иота ч зөрүүлж чадахгүй, худал хэлж чадахгүй. Тиймээс таны талаар энэ гариг дээрх бүх элснээс ч олон боддог гэдэг нь яахын аргагүй нүсэр мэдэгдэл!

За, цаашаа явцгаая. Тэгэхээр бид чухам ямар үнэ цэнэтэй юм бэ? Үнэ цэнийг худалдан авагч л тодорхойлно. Хүүгийн маань компани Билл Расселийн 1960-аад оны аваргын тэмцээнд өмсөж байсан цамцыг худалдаж авах сонирхлоор дуудлага худалдаанд оролцсон юм. Гэхдээ цамцыг 1,044,000 доллараар худалдаж авах өөр хүн гарсан учраас, тэд авч чадаагүй! Билл Рассел хэдийгээр аугаа тамирчин мөн ч гэлээ би л хувьдаа ЭнБиЭй-гийн тамирчны хувцсанд үсрээд л хэдэн зуун доллар л төлнө. Зүгээр л эрээн даавуу шүү дээ.

Хүмүүс биднийг янз янзаар үнэлэх учраас, тэдэнд хэр үнэтэй байх нь чухал биш. Тэгээд ч энэ дэлхий хүмүүсийг зохих ёсоор нь үнэлж байсан түүхээрээ маруухан. Эхийнхээ хэвэлд ургаж яваа хүүхдийг сая саяар нь л хөнөөдөг. Хүмүүс тэдгээр нялхсыг үнэлсэн гэж үү? Бэлгийн мөлжлөгө, хүний наймаанд өртсөн охид, эмэгтэйчүүдийг яах уу? Хэргийн эзэд нь тэднийг хэдхэн зуун доллараар үнэлжээ.

Энэ ертөнц дээр үнэ цэнийн жинхэнэ хэмжүүрийг хүн бус, Бурхан л тогтоодог юм. Бидний үнэлдэг юмсын тухайд Есүс “Хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы өмнө жигшмээр юмс байдаг” (Лук 16:15) хэмээн айлдсан байдаг. Түүнчлэн Түүний хэлсэн “Учир нь хүн бүх ертөнцийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?” (Матай 16:26) гэдэг онцгой үг ч бий.

Энэ дэлхийн баялгийг төсөөлөх гээд үзье л дээ. Хэдэн сая долларын орд харш, сайхан сайхан үл хөдлөх хөрөнгө, эрдэнийн

Бурханаас эмээхүй

чулуу, үнэт метал, үнэтэй машин, усан онгоц, тэнгэрийн хүлэг. Төсөөлөх ч аргагүй. Саяхны судалгаараар дэлхийн нийтийн бүтээгдэхүүний дүн нь 84.97 триллион доллар хэмээн тооцоолсон байна. Ухаан хүрэмгүй их мөнгө. Гэвч Есүс энэ бүхнээр амиа солих нь ашгүй наймаа гэх!

Тэгэхээр, та ямар үнэ цэнэтэй байх нь вэ? Паул “Та нарыг үнэтэйгээр худалдан авсан тул биеэрээ Бурханыг алдаршуул” (1Коринт 6:20) хэмээн бичсэн. Бурхан дараах үгээрээ таны төлөө төлөхөд бэлэн, үнээ тогтоожээ: “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн” (Иохан 3:16). Нөгөө Билл Расселийн цамцаас хавьгүй өндөр үнэ! Бурхан биднийг Өөрийнхөө хамгийн хайртай зүйлтэйгээ дүйцүүлэн үнэлжээ. Хамгийн гайхамшигтай нь: Бурханы хувьд бид Есүсээс ганц зоосоор л хямд байсан бол, ашиггүй наймаа хийдэггүй Бурхан маань арай хямд зүйлийн төлөө илүү үнэтэй зүйлийг өгөхгүй байх байж. Тэгэхээр, та Бурханд хичнээн үнэ цэнэтэй болохоо ойлгож эхэлж байна уу?

Таныг гэх Бурханы хайр хичнээн аугаа вэ? Есүс залбирахдаа үнэхээрийн ангайлгам мэдэгдэл хийсэн:

Намайг хайрласны адилаар тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно. (Иохан 17:23)

Үүнийг ойлгох бараг боломжгүй! Бурхан Есүсийг хайрладаг шигээ л танд хайртай! Гэлээ ч та “Гэхдээ Есүс дагалдагч нарынхаа л тухай хэлсэн шүү дээ” гэж бодож байгаа байх. Энэ чинь буруу. Учир нь Есүс “Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна” (Иохан 7:20) хэмээн тодруулсан. Та Есүст итгэдэг л бол, дагалдагч нарын гэрчлэлийн шууд байна уу, шууд бус байна уу үр дүн мөн. Таныг гэх Бурханы хайр, танд өгөх үнэ цэнийн гүнийг ойлгох боломжгүй.

Үүнийг баттай тогтоочихоод, цааш нь Бурхантай харилцаа тогтооход ариун эмээхүйн бэлэг нь яагаад чухал болохыг ухварлан мэдэцгээе.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Хэн нэгний амийн төлөөх золилт үнэхээр байхгүй. Бурханд төлж чадах төлөөс гэж ч байхгүй. Учир нь амийн төлөөс нь үнэ цэнэтэй, түүнийг мөнхөд төлж баршгүй. Энэ нь тэр нэгэн, булшийг үзэхгүй, мөнхөд амьдрахын тулд юм. (Дуулал 49:7-9)

Санаа: Ухаалаг хүн хямд зүйлийн төлөө үнэтэй зүйлийг өгч, ашиггүй наймаа хийхгүй. Үүнтэй ижил Бурхан ч ашиггүй наймаа хийхгүй. Бурхан таны төлөө Өөрийнхөө цорын ганц аминаас хайрт Хүүгийнхээ амийг өгсөн нь таныг Хүүгийнхээ амийн дайтай үнэлдэг гэсэн үг. Мөн таны эргэн тойрны хүмүүсийг ч Есүсийг үнэлдэг шигээ л үнэлдэг.

Эргэцүүлэл: Амьдралд чинь өгсөн Есүсийн үнэлгээг бодолцоод, өөрийгөө юу гэж үзэж байна? Энэ байдал өдөр тутам уулздаг хүмүүсээ үзэх үзэлд маань хэрхэн нөлөөлж байна?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Есүсийг оронд минь өгөх хүртлээ миний амьдралыг хайрлаж, үнэлсэнд баярлалаа. Есүс ээ, миний амьдралыг Өөрийнхөөсөө дээгүүр үнэлээд, миний өмнөөс шийтгүүлсэнд баярлалаа. Ариун Сүнс ээ, Та намайг яаж үнэлж, хайрладгаа зүрхэнд минь бат ухааруулж, бөх суулгаж өгөөч. Бусдад ч бас. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би бусдыгаа Бурхан намайг хайрлаж, үнэлдэг шиг л хайрлаж, үнэлэх болно.

*Бурханы хайрын тухай номлохдоо,
Библи эхлээд Бурханы хайрыг бус, харин
Бурханы хайрыг бүслүүрдсэн Бурханы
дүрэлзсэн, хурц ариун чанарыг илчилсэн
байдгийг мартагнах нь аюул.*

— Осуалд Чамберс

9 | АЮУЛТАЙ МӨРГӨЛДӨӨН

Бид эхнийхээ хэсгээр Бурханы алдрын тухай ярилцсан буюу сэдвийнхээ өрмийг хамсан гэж хэлж болно. Тэгвэл энэ бүлгээрээ Бурханы оршихуйн төрөл төрлийн хүчдэл дээр төвлөрөх болно. Бүгдээрээ Аугаа хүчирхэг Бурхан Израиль үндэстнийг цөлд оршин сууж байх үеэр майханд оршихыг хүссэн тэр үе дээр очигцооё.

Цаг авсан, хүч зарцуулсан, хүнд хүчир ажлын дараа бүлэг ажилчдын хүчээр майхан сүм боссон. Тэнгэрийн майхан сүмийн ерөнхий загвараар баригдсан (Еврей 8:1-5) майхан сүм нь уулан дээр Бурханы Мосед өгсөн төлөвлөгөөг яс баримталсан байгууламж байлаа. Ажил дууссаны дараа Бурхан яруу алдраа гайхуулан харуулсан.

Тэгтэл уулзалтын майхныг үүл бүрхэн ЭЗЭНий цог жавхлан асрыг дүүргэлээ. ЭЗЭНий цог жавхлан асрыг дүүргэж, дээр нь үүл багшран суусан тул Мосе уулзалтын майханд орж чадахгүй байв. (Гэтлэл 40:34-35)

Бурхан мөн л Өөрийнхөө алдраас Израилийг бараан үүлсээр нөмөрлөн хамгаалжээ. Бурхан алдраа хайртай хүмүүстээ дааж чадах хэмжээнд нь л тааруулж харуулсан. Гагцхүү тэргүүн тахилч л жилд ганц удаа амьтны цусаар Онцгой ариун газарт нэвтрэх зөвшөөрөлтэй байв. Тэнгэрээс сонгон тогтоож өгсөн энэ байр сууринд анх Мосегийн ах Аарон сонгогджээ.

Нэгэн өдөр мөн тахилч болох Аароны хоёр хүү майхан сүмд нэвтрээд “...өөрсдөд нь ЭЗЭНий тушаагаагүй ёс бус галыг Түүний өмнө өргөв” (Леви 10:1). Яг юу болсон талаар янз бүрийн санаа явдаг

Бурханаас эмээхүй

ч, гол шугамаа алдахгүйн үүднээс тэдний үйлдлийг нь алгасаад, сэдэл дээр нь төвлөрье. *Ёс бус* гэдэг үгийг нэг янзаар “Ариун зүйлд хүндэтгэлгүй хандах” хэмээн тодорхойлдог. Энэ нь ариун зүйлд байдаг л, жирийн зүйл шиг хандах гэсэн утгатай. Үндсэндээ, Аароны хөвгүүд Бурханы яруу алдар руу ямар ч хүндэтгэлгүй нэвтэрчээ. Үүний дараа цочирдмоор ч гэхэд багадам үйл явдал болсон.

ЭЗЭНээс гал гарч ирэн тэднийг залгиж, тэд ЭЗЭНий өмнө үхэцгээв. (Леви 10:2)

Бурханы оршихуйд нэвтрэх эрх бүхий хоёр эр хүндэтгэлгүй явдлаасаа болоод газар дээрээ үхжээ. Бурхан тэдэн рүү харгислан дайрсан уу? Үгүй ээ, тэд өөрсдөө л аминд халтай зам дээр гарцгаасан. Бодоод үзнэ үү: Дэлхий нарнаас 93,000,000 миллийн (149,668,992 км) зайтай. Далайн эрэг дээр биеэ шарах шиг жаргал үгүй хэдий ч, нөгөө л наранд 10,000 миллийн (16093.44 км) зайд ойртож очсон хүн шууд үхнэ.

Тэр хоёр хүн Бурханы ариун, алдарт оршихуйд хэнэггүй хандаж, өөр дээрээ гай авчирчээ. Хөвгүүдийг нь үхээд удаагүй байхад Мосе Ааронд юу гэж хэлснийг үзнэ үү:

Надад ойртон ирэгсдээр дамжин Би Өөрийгөө ариун хэмээн үзүүлж, бүх ард олны өмнө Би алдаршуулагдах болно” гэж ЭЗЭНий айлдсан зүйл нь энэ юм. (Леви 10:3)

Мосегийн мэдэгдэл нь даяар ертөнцөд хамаа бүхий, мөнхийн тунхаг юм. *Ертөнцийн* гэдэг нь хүн байна уу, тэнгэрлэг байна уу - бүх бүтээлд хамаатай гэсэн үг. *Мөнхийн* гэдэг нь байсан бөгөөд хэзээд байх - хэзээ ч өөрчлөгдөшгүй гэсэн утгатай. Та Бурханы оршихуйн өмнө хүндэтгэл бүхий зүрх, хандлагаар л ирнэ.

Бүгдээрээ нөгөө Бразилд болсон үйл явдал руу эргэж очицгооё. Бурханы гайхамшигт оршихуй дотор салхи исгэрэх хугацаанд би ариун эмээхүйд бүрэн автсан байлаа. Толгойд “*Жон Бивэр, чи ганц буруу хөдөлгөөн хийхэд л, ганц буруу үг хэлэхэд л үхдэл болно!*” гэсэн бодол лугшиж байлаа.

Яг үхчих байсан эсэхийг сайн мэдэхгүй. Гэхдээ Шинэ Гэрээнээ

яг тийм уур амьсгал дор нэгэн эр, эм хоёр буруу нүүдэл хийгээд, үхдэл болсон түүх байдгийг харин сайн мэднэ. Тийм ээ, “Үхдэл болсон” гэдэг нь газарт хоёр метрийн гүнд булуулсан гэсэн үг (Үйлс 5:1-10). Тэр эр, эм хоёр чуулганыхаа удирдагч нар, итгэл нэгт нөхдийнхөө өмнө өргөл авчирчээ. Гэх атлаа тэр л өдрөө хоёулаа үхэж, оршуулагдсан. Үүнийг үзсэн бусад итгэгч нар яасан бол?

Чуулган даяар, энэ бүхнийг сонссон бүгд дээр үлэмжийн айдас ноёлов. (Үйлс 5:11)

Эндээс тэмдэглүүштэй хэд хэдэн зүйл байна. Энд “Хотод үлэмжийн айдас буув” гэж хэлээгүй, харин “Чуулган даяар үлэмжийн айдас буув” гэжээ. Хоёрдугаарт - зүгээр нэг “Айдас” бус, харин “Үлэмжийн айдас” гэсэн байгааг тэмдэглээрэй. Еврей номын бичээч нар манай Барууны соёл шиг хэтрүүлэг хэрэглэдэггүй. Тиймээс Бичээс “Үлэмжийн” гэсэн л бол, энэ нь маш өндөр хүчний ариун эмээхүй мөн болой.

Үйлс 2 дээр Бурханы Сүнс Пентекост өдөр анх илэрхийлэгдэхэд, тэнд байсан зарим хүн дагалдагч нарыг өглөөний 9 цаг гэхэд согтчихож гэж үзсэн. Тэгэхээр, согтуу хүн яаж авирладгийг эргэцүүлнэ үү. Ер нь бол, дуугаа аядахаасаа илүүтэй улам чангарч, учиргүй их инээж ханиадаг. Тэгэхээр, тухайн өдөр ийм л уур амьсгал ноёрхож байж. Хайртай Бурханы маань оршихуй үнэхээрийн сэргээмээр, цэнгээмээр байжээ. Гэтэл тэр л Бурханы гайхамшигт бөгөөд аймшигт оршихуй шүүх буулгахаар тэр л хүмүүсийн дунд буухад, чуулган үлэмжийн айдас, бишрэлд автсан байна. Энэ үйл явдал Бурханы ариунд нэвтрэх ухаарлыг даган ер бусаар өсчээ.

Хүмүүс “Тэгвэл өнөө цагт хүмүүс яагаад газар дээрээ үхчихдэггүй юм бэ?” гэж их асуудаг л даа. Энэ нь ч үнэ цэнэтэй, сайн асуулт. Дээрх хос Петрт тэгээд эцсийн дүнд Ариун Сүнсэнд худал ярьжээ. Тэгвэл Хорин нэгдүгээр зуунд худлаа ярьчихаад үхээгүй явж байгаа олон пасторууд байгаа. Тэгэхээр, мөнөөх хосыг үхсэний яг дараа юу болсныг харцгаая:

Тэр ч байтугай ард олон Петрийг ирэхэд ядаж түүний сүүдэр нь тэдний хэн нэгэн дээр тусаасай гэж өвчтэй хүмүүсийг гудамжинд

авчран, дамнуурга болон дэвсгэр дээр тавьдаг байлаа. Мөн Иерусалим орчмын хотуудаас олноороо өвчтөн, бузар сүнсэнд баригдагсдыг авчирч байв. Тэд бүгд эдгэж байлаа. (Үйлс 5:15-16)

Үүнийг бодохлоор ер ухаанд багтамгүй. Гудмууд хэмээн (Олон тоон дээр) байгааг тэмдэглэнэ үү! Мөн “Зарим” нь бус, харин “Бүгд” эдгэрсэн! Одоогийнхоор бол, элч Петр улсын томоохон эмнэлэгийн корридороор зүгээр л алхахдаа, бүх өвчтөнийг нь эдгээгээд, хамаг орыг нь хоосолчихсон гэсэн үг л дээ. Тэгэхээр, гагцхүү Эзний алдрын уур амьсгалд л ийм ер бусын хүч оршино.

Бичээсийн энэ жишээгээ цааш нь задлая. Аароны хоёр хүүгийн явдлаас хэдэн зуун жилийн дараа мөн л тахилчийн ажил хийдэг Хофни, Финехас гэдэг ах, дүү хоёр мөнөөх майхан сүмийн үүдэнд хүүхнүүдтэй садарладаг байжээ. Аароны хоёр хүүгийн үхэхийн унасан цэгээс гучаадхан метрийн зайнд! Үүгээр зогсохгүй Хофни, Финехас хоёр хүмүүсийг сүрээр далайлган, өргөлийг нь дээрэмддэг байж. Үнэндээ тэд “үл бүтэх хүмүүс байсан бөгөөд тэд ЭЗЭНийг мэддэггүй” (1Самуел 2:12-13) байжээ. Бурхан ч тэдний талаар “Түүний хөвгүүд өөрсдөдөө хараал авчирсан бөгөөд тэр тэднийг хазаарлаагүй тул түүний мэдсэн хилэнцийн учир өөрийнх нь гэрийг мөнхөд шийтгэхээр зэхэж байгаа” (1Самуел 3:14) хэмээсэн. Та аугаа хүчирхэг Бурханы амнаас ийм үг сонсохыг хэзээ ч хүсэхгүй!

Тэр хоёр Бурханд хүндэтгэлгүй, гутаан доромжилсон хандлагаараа Аароны хөвгүүдээс долоон дор байсан ч, тэр дорноо майхан сүмд үхээгүй байна. Яагаад тэр вэ? Хариултыг нь дараах үгээс мэдэж болно: “Тэр өдрүүдэд ЭЗЭНий үг ховор, үзэгдлүүд ч цөөн байв” (1Самуел 3:1). Бурханы илчлэгдсэн Үгийн хомсдол нь Бурханы оршихуй үгүй байсныг - нөгөө Бразилийн хүндэтгэлийн цуглаан дээр болсон шиг л бүр огт байгаагүйг хэлнэ. Тэгвэл Мосегийн өдрүүдэд бүрэн байсан.

Эдгээр жишээнээс юу гэж дүгнэх вэ? Бурханы алдрын илчлэл их байх тусам, үл хүндэтгэлийн шүүх нь төдий чинээ хүнд бөгөөд ширүүн байдаг байх нь. Ийм шалтгаанаар л Паул:

Зарим хүмүүсийн нүгэл шүүлтээс нь өмнө илэрхий болжээ. Харин заримынх нь хожим илрэх болно (1Тимот 5:24) гэжээ.

Ямар ч нөхцөлд Бурханд байдаг л, танил зүйл шиг хүндэтгэлгүй хандахгүй байх нь ухаалаг шүү. Бурханы алдар үзэгдэхгүй байх нь үнэндээ үүнээс ч том аюул юм. Яагаад? Яагаад гэвэл, шүүх буухгүй болохоор нь бид болоод байна гэсэн худал итгэлээсээ болоод хүндэтгэлгүй нөхцөл рүү амархан гулсана. Үүнийхээ дараа Бурхан бидний хүндэтгэлгүй байдлыг аньж байна гэдэг итгэл рүү уруудна. Энэ талаар дараагийнхаа бүлгээр үзье.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Надад ойртон ирэгсдээр дамжин Би Өөрийгөө ариун хэмээн үзүүлж, бүх ард олны өмнө Би алдаршуулагдах болно. (Леви 10:3)

Санаа: Бурханы алдрынилчлэлийг байх тусам, үл хүндэтгэлийн шүүх нь төдий чинээ хүнд бөгөөд ширүүн байдаг байх нь. Тиймээс, шийтгэл саатах нь цуцлагдсан гэсэн үг биш.

Эргэцүүлэл: Бид Бурханы Үгийг сонсохдоо, өдөр тутмынхаа жирийн амьдрал дээр залбирахдаа, хүндэтгэхдээ, чуулахдаа Эзэн дээр хэрхэн очих вэ? Хүн яаж яваад Бурханд хаа хамаагүй хандаж эхэлдэг вэ? Бурхан бидний Аав төдийгүй, шатаагч гал болох ариун Бурхан болохыг мартаа юу?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Танд хүндэтгэлгүй, хаа хамаагүй хандсаныг минь уучлаарай. Би Таныг хэн болохыг мартаад, мэдэмхийрдэг болжээ. Гэмээ улайгаад, цаашид Таны мөрийг алгадаж хандах бус, харин ариун Бурхан гэдэг утгаар тань мэхийн хүндэтгэхийг хүсч байна. Миний хүндэтгэлгүй байдлыг уучилж, өршөөл, энэрлээ үзүүлдэгт баярлалаа.

Шийдвэр: Бурханы оршихуй хүчирхэг байсан ч, бүдэг байсан ч, би Түүнийг мэхийн хүндэтгэх болно.

*Хүмүүний замнал ЭЗЭНий мэлмийн
өмнө ил ажгуу. Хамаг жимийг нь
Тэр дэнсэлюү.*

— Сургаалт үгс 5:21

10 | БУРХАН ХАРАХГҮЙ

Бурханы алдрыг ухаарахуйг дагаж ариун эмээхүй өсдгийг өмнө хэлсэн. Тэгвэл эсрэг нь ч бас үнэн: Бурханаас аль бага эмээх тусам, Бурханы аугаа чанарыг хүний хэм хэмжээнд тулгана.

Энэ дэлхийн системийг хүнийг Бурханы алдраас сарниулах зорилгоор сэтгэл зүйтэй юутай хийтэй нь хуйлан хамагч, хүчирхэг мөрөнтэй адилтгаж болох. Тэр мөрөн Бүтээгчийн маань аугаа чанарыг бууруулах өртгөөр мөнх бус хүнийг өргөмжлөхийн төлөө ашиглаж болох үг, бодол, дүр төрх, видео тэргүүтэй зуучлагчаас бүрдэнэ.

Ариун эмээхүйгээр дутмаг хүн тэр хүчирхэг мөрөнд хялбар автаад, тэднийг юу ч хийсэн Бурхан үнэндээ анзаарах ч үгүй, тоох ч үгүй гэдэг итгэл үнэмшилд автана. Тэгээд *Би тусгай, онцгой, би бусадтайгаа л адил, Бурхан миний сэдэл, үйлдлийг анзаарахгүй* гэх зэрэг бодлоос авахуулаад *Бурхан бөөн ажилтай, надтай зууралдах сөхөөгүй байгаа* гэж бодохдоо тулна.

Тэгээд зүрхэндээ “Бурхан мартсан билээ. Нүүрээ Тэр нуусан, хэзээ ч үүнийг харахгүй” гэдэг. (Дуулал 10:11)

Энэхүү алдаатай, аюултай сэтгэлгээ нь олон янзын хувилбартай ч, үндсэндээ бүгдээрээ л Бурханы чадварыг дутуудуулах үнэр ханхлуулдаг. Ер нь бол аав ээж, дарга, багш, дасгалжуулагч тэргүүтэн нь манийхаа зан авирыг анзаарахгүй, өнгөрөөчихнө гэж үзэхтэй л ижил. Ийм урхинд орсон хүн “түүний үйл хэргийн нарийн ширийнийг нягтлаад байх зав” Бурханд байхгүй гэж итгэхээс гадна дээрээс нь нэмээд Бурханы чадварыг доош хийдэг.

Бурханаас эмээхүй

Арай дэлгэрүүлэе л дээ. Ариун эмээхүйгээр дутагдах нь байтугай, зайлсхийж явдаг хүний хувьд энэхүү эгзэгтэй замаараа үргэлжлүүлэн таваргаад байх нь *Бурхан миний сэдэл, үг, үйлдлийг харахгүй* гэдэг адын итгэлийн аюул заналд өртөх хөнөөлтэй. Бурхан харахгүй гэж итгэх нь нэг хэрэг бол, Бурхан харах *чадваргүй* гэх маягаар үл хүндэтгэх нь тэс өөр хэрэг ээ!

Хүнээс сэдэл, үг, үйлдлээ нууж болно. Нууцаар - харанхуйд, сүүдэрт үйлдсэн хэргийг маань хүн анзаарахгүй байж болно. Харин аугаа хүчирхэг Бурханаас арга зам, бодлоо нууж чадна гэж итгэх нь өөрийгөө мэхэлсэн хэрэг юм. Санаатай, санаандгүй - энэхүү алдаатай үнэмшил нь ариун эмээхүй үгүй сэтгэлд л үндэслэнэ. Бичээс:

Өөрсдийн санаагаа ЭЗЭНээс ор тас нууцалж үйлсээ харанхуй газарт хийж хэн биднийг харах юм бэ? Хэн биднийг мэдэх вэ? гэж хэлдэг хүмүүс хөөрхий еэ (Исаиа 29:15) гэдэг.

Эхлээд харахад, Исаиа муу ёрын буюу чуулганд явдаггүй, Бурханыг хүндэтгэхээр цугладаггүй, үл итгэдэг муу ёрын хүмүүсийн талаар яриад байгаа мэт боловч, дээрх үг нь *Бурханд итгэдэг гэдэг* хүмүүст зориулагдсан үгс юм. Тийм ээ, дээрх мэдэгдлийн яг өмнө:

Эзэн “Энэ ард түмэн амаараа ойртон, уруулаараа л Намайг хүндлэвч, зүрх нь Надаас алс хол байдаг. Тэд Намайг эмээн хүндлэхэд хүний тушаалаар суралцжээ” (Исаиа 29:13) гэдэг.

Одоогийнхоор бол, энэ хүмүүс Есүсийн нигүүлслээр аврагдсан болохоороо, өөрсдийгөө Есүстэй харилцаатай гэж мэдэгддэг байх нь. Тэд Есүсийг амаараа айхтар хүндэтгэж, Христчин конференцэд оролцож, Спотифай дээр магтаал сонсдог ч, тархиныхаа нөгөө хэсгээр Бурхан тэдний бодож, хийж байгаа юмсыг *харахгүй* гэж боддог байх нь. Тэдний тархи толгой нь Есүсийг дагадаггүй зарим хүнийхээс долоон дор. Тэд худалд итгэдэг - үүнээс аймшигтай нь тэд энэ байдлаа мэддэг ч үгүй.

“За, арай ч дээ. Юу гэж ийм юм байдаг юм!” гэж үү? Тэгвэл

өнгөрсөн бүлгээрээ үзсэн, Шинэ гэрээний хос - Ананиа, Сапфира хоёрыг (Үйлс 5) дахин санацгаая. Тэр хосын алдаатай үйлдлийг ойлгоход дэвсгэр түүх нь чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэ түүх бүр 4-ээр бүлгээс эхтэй:

Элч нарт Барнаб (орчуулбал «Тайвшралын хүү») гэж нэрлэгддэг, Кипрээс гаралтай Леви овгийн Иосеф өмчилж байсан талбайгаа зараад, мөнгийг нь авчран элч нарын хөлд тавьжээ. (Үйлс 4:36-37)

Тухайн үед Кипр нь үнэт чулуу, зэс, төмөрлөгийн уурхай, модон материалын нөөцөөрөө алдартай, асар чинээлэг арал байжээ. Түүнчлэн цэцэгс, жимс жимсгэнэ, дарс, тосоороо ч алдартай. Кипрт газартай хүн гэдэг их л хөрөнө чинээтэй байх нь гарцаагүй.

Бодоод үз: Киприйн баян Леви овгийн хүн газраа зарсан ихээхэн хэмжээний мөнгөө чуулганы өмнө ил тодоор хүлээлгэн өгчээ. Тэгтэл юу болсон?

Гэтэл Ананиа гэгч эр, эхнэр Сапфиратайгаа хамт хөрөнгөө зарж...
(Үйлс 5:1)

“Гэтэл” гэдэг эхний үгийг тэмдэглээрэй. Энэ нь бодлын хөврөлийг холбож байгаа холбоо үг шүү. Энэ тохиолдолд шинэ бүлэг эхлүүлэх нь түүхийн өрнөлийг дорхноо тасалдуулж мэдэх.

Тэрхүү чинээлэг шинэхэн итгэгч чуулганд явж эхлэхдээ, бүх хүний нүдэн дээр их хэмжээний өргөл авчирж өгсөн нь нөгөө гэр бүлийн хоёрт ихэд нөлөөлжээ. Тийнхүү тэд ч үл хөдлөхөө зараад...

өртгөөс нь өөртөө үлдээж, үлдсэнийг нь элч нарын хөлд тавьжээ.
Энэ тухай эхнэр нь бүрэн мэдэж байв. (Үйлс 5:2)

Юу энэ хариуг өдөөв? Энэ хос өдийг хүртэл чуулганыхаа хамгийн өгөөмөр хос гэдэг нэртэй байв уу? Үүгээрээ удирдагч, хүмүүсийнхээ анхаарлыг татдаг байв уу? Өгөх нь үйлчлэх, номлох, зочлон дайлах, багшлах, удирдах, өгөөмрөөр өгөх тэргүүтэй бусад бүх төрлийн бэлэгтэй л адил сайхан бэлэг юм (2Коринт 9:12-13). Энэ хос хүлээж авсан хүндэтгэл, анхааралдаа хэт автаад байв уу? Шинэ

гарч ирсэн залуугийн үйлдэл тэдний сул талд аюул занал болов уу? Тэр хүний их хэмжээний мөнгө сайнмэдээ үйлс, ядуусыг асран халамжлахад хичнээн их нэмэртэйг шагшин магтах хүмүүс хараагаа анхаарлын төвд явдаг Ананиа, Сапфира хоёроос салгав уу?

Тэр хос алдагдсан анхааралдаа хорогдсондоо магадгүй хамгийн том хөрөнгө болох газраа зарчихсан ч байж мэдэх. Тэгээд “Бүгдийг нь өгчихөд дэндүү хайран. Гэхдээ л бүрэн өгсөн болоод *харагдчихмаар* байдаг. Тэгэхээр, тодорхой хувийг нь өгөөд, “Бүгдийг нь өгсөн” гээд л хэлчихье” гэсэн шийдэлд хүрсэн байх. Тэгээд “Энэ үйлдэл маань ч бусдыг том том өгөөмөр бэлэг өгөхөд хүргэнэ” гэсэн төөрүү бодолдоо мэхлэгджээ.

Үзэмж нь үнэнээс илүү чухал байсан бөгөөд үүнчлэн мэхлэлд хүргэсэн байна. Тэд Бурханыг харахгүй хэмээн яаж бодож чадав аа?

Тэд урьдаас санаатайгаар тунгаагаад, энэ үйлдэл дээрээ зөвшилцсөн. Тийнхүү төлөвлөгөөгөө Эзэнээс нууж чадна хэмээн итгэсэн хос харанхуйд хар үйлээ үйлдсэн! *Тэдэнд болж буй үйл явдлыг Эзэн мэдэхгүй!* (Исаиа 29:15-аар эшлэл бараг л дүрээрээ байна) гэсэн атгаг бодол байсан л байх. Гэхдээ тэд энэ хэргээ амиараа төлөөд, нэг өдөр нэгэн зэрэг оршуулагдав!

Өмнөх бүлгүүд дээр тэнгэрийн салхи үлээж, хот даяарын анхаарлыг ховх сорж, зарлагдаагүй цугларалтууд дээр хүмүүс мянга мянгаараа аврагдаж, суунги нь гайхамшгаар алхалж, Бурханы хүч байшин барилгыг чичрээхийг нүдээр үзсэн, өөрсдийгөө итгэгч гэдэг тэр хүмүүс ийм Аугаа хүчирхэг Бурханаас бодол сэдлээ нууж чадна гэдэгт яаж итгэж чадав аа?

Эсвэл цэцэрлэг дотор Бурхантай зугаалдаг байсан Адам, Ева хоёр нүгэл үйлдсэнийхээ дараа Бурханаас нуугдаж чадна гэж яаж бодож чадав аа? (Эхлэл 3:8)

Израильчууд “Эзэн харахгүй!” (Езекиел 9:9) гэж яаж хэлж чадав аа?

Эсвэл “Тэр надад,—Хүний хүү чи, Израилийн гэрийн ахмадууд харанхуйд, хүн бүр сийлмэл хөргийнхөө өрөөнд юу үйлдэж буйг харав уу? Учир нь тэд “ЭЗЭН биднийг хардаггүй” хэмээдэг гэв” (Езекиел 8:12) гэдэг үгийг яанам?

Бид ч хөндийрсөн зүрхээ Эзэнээс нуучихна хэмээн мунхагаар боддоггүй билүү?

Товчхондоо, энэ бүх нөхцөл нь бүгдээрээ ариун эмээхүй байхгүй гэсэн ганц л аймшигт алдаанаас үндэстэй. Ариун эмээхүйгээр дутахаар барахгүй, толгой дотроо Бурханы чадварыг доош хийхээс гадна хамгийн аймшигтай нь ялгах ухаан маань бүдгэрч бадагран, нөхцөл байдлаа мартаж санадаг болно. Бүгдээрээ яг энэ нөхцлийг талаар дараагийнхаа хэдэн бүлгээр авч хэлэлцэнэ.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Оюун санаа хийгээд зүрхийг Нягтлагч нь Би байгаа юм гэдгийг бүх чуулган мэдэх болно. Би та нарын хүн бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө. (Илчлэл 2:23)

Санаа: Бурхан бидний үйл хэргийг төдийгүй, үүний цаад сэдэл, санааг ч мэднэ.

Эргэцүүлэл: Бурхан миний гүний гүн бодол, сэдэл, санааг мэддэг болохыг би цаг үргэлж санаж байна уу? Энэ үнэний сэрэмжийг яаж ахиулах вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, миний санаа сэдэл Есүсийн санаа сэдэл шиг л ариун байх болтугай. Миний арга замыг Та цаг үргэлж нягталж байдаг гэдэг ойлголтоор бодол, хүсэл, үг, үйлдэл маань тунгаагдаж гарах болтугай. Таныг хүнийхээ үзэл бодлоор тунгаагаад, энэ үнэнийг дорд үзэх нь бүү байг. Есүсийн нэрээр залбирч байна. Амень.

Шийдвэр: Би Бурхан миний сэдэл, бодол, үг, үйлдлийг нэгт нэгэнгүй мэднэ гэдгийг санаж амьдарна.

*Тэгвэл яагаад Иерусалимын энэ хүмүүс,
үргэлжийн төөрөгдөлдөө
эргээж буцна вэ?*

— Иеремиа 8:5

11 | АЙДАС БӨГӨӨД ЧИЧРЭЛ

Бурханы гайхамшигт оршихуйгаас үүдэн Ананиа, Сапфира хоёр дээр буусан шүүх нь чуулган дээр “Үлэмжийн айдас” буулгажээ. Энд *хот* бус, харин *чуулган* буюу ариун хүмүүсийн цуглаан гэдэг үгийг хэрэглэснийг дахин цохон тэмдэглэх хэрэгтэй. *Үлэмжийн айдас* гэдэг Грек үгийг нягтлах аваас, бидэнд хэлэх гэсэн санаа нь улам л хүчжинэ.

Юун түрүүнд *үлэмжийн* гэхийг Грек дээрээ *мегас* гэдэг бөгөөд энэ нь “Дээд зэргийн ... хурц, аймшигтай, тулсан хэм хэмжээ”¹ гэсэн утгатай болно. Үүнээс ч Англи хэлний *мега* гэдэг үг гаралтай. Үүнд утгын ямар ч эндүүрэл байхгүй. Өөрөөр хэлбэл, “Мега айдас” хэмээн хөрвүүлж ойлгож болно. Бичээсийн бичээч нар юуг ч давсалж, хачирладаггүйг санаарай.

Айдас хэмээх хоёр дахь үг нь *фообос* гэдэг Грек үг бөгөөд үүгээр Шинэ Гэрээн дээр ариун эмээхүйг илэрхийлдэг. Үүнийг “Айдас, аюумшиг, аюуж бишрэх, хүндэтгэх, өргөмжлөх” хэмээн тодорхойлно. Өөр нэгэн сурвалж дээр “Шүтээнд үзүүлэх гүнээ хүндэтгэл, бишрэл - хүндэтгэл, эмээхүй”² хэмээн тодорхойлсон байдаг. Мөн л дээд зэргийн айдсыг илэрхийлсэн *бишрэл*, *аймшиг* гэсэн үгс гарч байна. Паул дараахыг бичихдээ мөн л үгсийг хэрэглэжээ:

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг *айдас* ба *чичрэлээр* гүйцээ. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын

аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм.
(Филиппой 2:12-13)

Бидний аврал *хайр*, *зелдэг* чанараар бус, харин *айдас*, *чичрэлээр* гүйцэлдэх бөгөөд бүгдээрээ энэ талаар хожим ярьцгаана. Тэгэхээр, энд бидэнд ойлгуулах гэсэн санааны хүчийг нэг шат ахиулсан *чичрэх* гэдэг үг гарч байна. *Троомос* гэдэг энэхүү Грек үг нь “Айдас, аймшгаас болж чичрэхүй ... юмуу гүн бишрэхүй, хүндэтгэхүй, аюухуй” гэсэн утгатай болно. Энэ хоёр үгийг Шинэ Гэрээнд элч Паул хамтад нь дөрвөн удаа хэрэглэсэн учраас, дээрх хэрэглээ нь тохиолдол биш ажээ.

Ариун айдсын талаарх судалгаа маань талдаа ч ороогүй байна. Гэхдээ яг одоо Бурханы Үгийг заадаг хүмүүс энэ үгийг яагаад “биширсэн хүндэтгэл мөргөл” гэсэн ойлголт төдийхнөөр хязгаарлаж ухуулдагт нь гайхшрах ёстой юм болов уу. Тухай нь, бид дан ганц энэ бүлгийн хэдхэн тооны эшлэл дээр л айхтар чанга үгсийн сантай тулгарлаа: мега буюу үлэмжийн айдас, бишрэл, аймшиг, гүн хүндэтгэл, чичрэл, сүрдэж айх.

Эдгээр нь Христ доторх бидний амьдралын багахан хэсгийг дүрсэлсэн үгс гэхээсээ илүү бидний *аврал хэрхэн гүйцэлддэгийг* тодорхойлсон үгс юм. Тодруулбал, бидний хүчин зүтгэл нь Ариун Сүнсээр хүчжин, Түүнтэй хүч хавсран ажиллахдаа, Есүсийн бидэнд ямар ч үнэ төлбөргүй хангаж өгсөн зүйлсийг бүрэн төлөвшилд хүргэдэг байна. Үүнийг цаашид: *Бидний аврал нь айдас, чичрэлээр төлөвшилд хүрдэг* хэмээн тодорхойлж болно.

Ийм атал яагаад ариун эмээхүйг чуулган, жижиг бүлэг, Библийн сургуульд тэргүүн эгнээнд заадаг үнэний нэг болгохгүй байна? Үүнээс болж Барууны ертөнцөд үр нөлөөгүй, үй олон царцуу итгэгч бий болно уу? Иймээс л Библи эцсийн өдрүүдэд үй олноороо итгэлээсээ “няцах” талаар анхааруулаа юм болов уу? “Учир нь эхлээд урвалт гарч, сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн илчлэгдэхээс нааш хэн ч та нарыг ямар ч аргаар бүү мэхлэг” (2Тесалоник 2:3) хэмээн Паул бичсэн. Тэгэхээр, ариун эмээхүйг хаягдуулснаас болж, ийнхүү олноороо няцахад хүрэх юм болов уу? Миний бие өнгөрсөн дөчин жилийн хугацаанд Америкаар болоод дэлхийн жараад улсаар үйлчилж, зааж, залбирсаар ирсэн хүнийхээ хувьд ингэж л итгэж байна.

За, цаашаа хөдөлцгөөе. “Мөнхийн шүүх” нь чуулганы хамгийн үндсэн, суурь сургаалын нэг юм. Дараах үгийг анхааралтай уншина уу:

Тиймээс Христийн тухай балчир ойлголтыг орхиж, төлөвшилд тэмүүлцгээе. Түүнчлэн үхлийн үйлсээсээ гэмших, Бурханд итгэх, баптисмын тухай заавар, гар тавих тухай, үхэгсдээс амилуулагдах болон мөнх шийтгэлийн тухай сургаалуудын суурийг дахин дахин тавихгүй байя. (Еврей 6:1-2)

Бид хэрхэн амьдарсныхаа тайлан тооцоог хийх нь бодит үнэн юм. Энэ шүүхээр гарах тогтоол нь мөнхөд хүчинтэй! Итгэгч хүмүүсийн орох энэ шүүхийг “Христийн шүүх сэнтий” гэнэ.

Тэгэхээр, дараах хоёр тодруулсан үгийг авч үзье. Нэгдүгээрт - Үндсэн. Хүүхэд бага ангидаа юу сурдаг билээ? Унших, бичих, нэмэх, хасах зэрэг үндсэн чадвараа. Үндсэндээ, цаашид олж авах боловсролоо өрөх тоосготой болно. Унших, бичих, нэмэх, хасах чадваргүйгээр ахлах сургуульд юмуу коллежид сурна гэж байх уу? Боломжгүй!

Гэтэл олон итгэгч тэрхүү шүүхийн талаар юу ч мэдэхгүй явах юмуу за мэдлээ гэхэд нарийн судлаагүй, онолоос хэтрэхгүй явдаг. Энэ нь яг л нөгөө ерөнхий боловсрол чухал гэдгийг мэдэхээс биш, хэзээ ч эзэмшээгүй хүнээс ялгаагүй. Тэгэхээр, итгэгч нар энэхүү үндсэн үнэнгүйгээр Христ дотор амьдралаа хэрхэн барьж байгуулж байгаа нь аминд тулсан асуудал болоод байна.

За дараагийн чухал үгээ авч үзье: Суурь. Суурьгүй байшин барина гэхээр төсөөлөгдөж байна уу? Цаг агаар тогтуун байхад ч барилга яах ч үгүй, сайхнаараа л байна. Гэвч шуурга дэгдбэл, байшин нурна! Үүнийг итгэлээсээ няцах явдлаар төлөөлүүлж болно. 2000 - 2020 оны хооронд дөч гаруй сая Америк хүн итгэлээсээ няцсан тухай Барна Груп мэдээлсэн!³ Эдүгээ тэдний тал хувь нь өөрийгөө атеист юмуу агностик гэдэг. Гэтэл суурь сургаалын хомсдол нь энэ аюултай тоо баримтад хүргэсэн байж болох уу?

Тэгэхээр, бидний шүүхийг юу дагалдахыг товч үзэцгээе:

Бид урамтай байдаг бөгөөд биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг. (2Коринт 5:8)

Бурханаас эмээхүй

Паул итгэгч хүмүүст хандаж байгааг мэдэж цөхөх юм алга. Итгэгч бус хүмүүс биеэсээ гарахдаа, Бурханы оршихуйд байхгүй.

Тиймд ойр ч, хол ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ.
(2Коринт 5:9)

Лиза, бид хоёр шилжилтийн насан дээр яваа хөвгүүдээ бурханлаг байдалд сургах боломж бүрийг хайдаг байсан сан. Сургалтын маань нэгэн чухал хэсэг нь хөвгүүдээ буруу эрхлэхээс хамгаалах явдал байлаа. Нэгэн орой би хөвгүүддээ “Хөвгүүд ээ, та нар юу ч хийсэн бай эсвэл хийгээгүй бай, ээж, аав хоёр нь та нарыг хайрладгаараа л хайрлана” гэж хэлсэн юм.

Ийнхүү хөвгүүд маань аав, ээжийнхээ болзолгүй хайрыг тогтоож авав. Үүний дараа би “Гэхдээ аав, ээжийнхээ таалалд нийцтэй амьдрах нь та нарын үүрэг” гэж хэлсэн юм. Тэдний нэгийг ухаарав.

Тэгэхээр, ийм байна. Үйлдэл маань биднийг хайрлах Бурханы хайрыг өөрчлөхгүй боловч, Түүний таалалд нийцтэй амьдрах нь бидний үүрэг юм. Тиймээс л Паул Эзэнд “таалагдах” нь түүний зорилго гэжээ. Яагаад?

Учир нь хүн бүр (итгэгч нар) мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. Иймээс бид *Эзэнээс эмээхийг* мэдэж, хүмүүсийг ятгадаг. Бид Бурханд ил болсон. Мөн та нарын мөс чанарын дотор ч бид ил болсон гэж би найддаг. (2Коринт 5:10-11)

Энэ шүүх дээр бид гэмшсэн нүглээсээ болж шүүгдэхгүй. Тэдгээр нь Есүсийн цусаар хэдийнээ арчигдсан. Бурхан “Өрнө нь дорноос хол байдаг адил, гэмт үйлдлийг маань биднээс тийн холдуулсан” (Дуулал 103:12), “Би тэдний гэм бурууд өршөөнгүй хандана. Би цаашид нүглийг нь дахин эс санана” (Еврейн 8:12) гэдэг.

Тэгвэл, бид юуныхаа төлөө шүүгдэх вэ? Бид итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарснаа - *сайнтай, муутай нь* шалгуулна.

Энэ сэдвээр Паул “Эзэнээс айж эмээхийг” итгэгч хүмүүсийн шүүхтэй холбогдуулан яриад байгааг л тогтоож авна уу. Айдас нь

фообос гэдэг Грек үг бөгөөд яг энэ үгээр Ананиа, Сапфира хоёрын шүүхд хандсан чуулганы хариу үйлдлийг дүрсэлсэн: Тэр хосод тохиолдсон явдал нь итгэгч хүмүүсийн шүүхийн урьдчилсан тойм байж болох уу? Үүнийг дараа дараагийнхаа бүлгээр судалцгаая.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Мөн та нар Эзэнд зохистойгоор явж (биеэ авч яван, амьдарч) бүх талаар Түүнд *таалагдаасай*, аливаа сайн үйлсэд үр жимс гарган, Бурханы мэдлэгээр өсөж... (Колоссай 1:10)

Санаа: Үйлдэл маань биднийг хайрлах Бурханы хайрыг өөрчлөхгүй боловч, Түүнд таалалд нийцтэй амьдрах нь бидний үүрэг.

Эргэцүүлэл: Би Бурханд таалагдахаар амьдарч байна уу? Бурхан юуг таалах, юуг эс таалахыг хэрхэн мэдэх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Танд юу таалагддаг, юу эс таалагддагийг Үгээрээ болоод Сүнсээрээ илэрхийлээч. Танд таалагдах юмсыг дагаж, эдгээрт юу юунаас илүү хайрлан дурлах зүрх, оюуныг хайрлаач. Ингэснээрээ би Таны зүрхийг мэдэж, Таныг хүндэтгэдэг замаар амьдарна. Хожмын өдөр итгэгч хүмүүсийн шүүхээр нэр төртэй орж, Таны надад өгөхийг хүсч буй мөнхийн шагналыг хүлээж авахад бэлтгэлтэй байхад минь туслаач.

Шийдвэр: Бурханд таалагдах нь миний оройн дээд зорилго. Түүний хүсдгийг хүсч, сайн тааллыг нь гүйцэлдүүлдэг байлгахын төлөө Бурхан миний дотор ажиллаж байгаа.

*Бурханд хамааралтай нэгэн онцгой зүйл
нь Бурханаас айдаг хүн өөр юунаас ч
айдаггүй бол, Бурханаас айдаггүй хүн
юм бүхнээс айж явдаг.*

— Освальд Чамберс

12 | ХОЁР НҮҮРЛЭХ НЬ ХАЛДВАРТАЙ БӨГӨӨД ХАЛТАЙ

Үйлс ном дээр үхэж дууссан хосод хамаатай нэгэн амин зүйлийг тодруулах ёстой. Ананиа, Сапфира хоёрын үйлдэлд ямар ч асуудал байсангүй; тэд зүгээр л цуглаандаа өргөл өргөсөн. Бурханы үйл хэрэгт санхүүгийн бэлэг өгөх нь бурханлаг, ариун, сайхан зүйл. Гол асуудал нь тэдний сэдэл байж. Энэ хүслийг тодорхой хэмжээнд гэрэл тусгаж байж л мэдэх боломжтой.

Эндээс нэгэн чухал асуулт ургаж байна: Сэнтийн шүүхээр бидний дан үг, үйлс шалгагдах уу эсвэл бодол, сэдэл маань ч шалгагдах уу?

Есүсийн дагалдагч нартаа хэлсэн анхааруулгаас эхэлье л дээ:

Тэр хооронд хүмүүс үй түмээрээ хуран цуглаж, нэг нэгнээ гишгэчин байв. Тэр эхлээд шавь нартаа, —Фарисайчуудын хөрөнгөнөөс болгоомжлогтун. Энэ нь тэдний хоёр нүүрт байдал юм. Гэвч илчлэгдэхгүй байхаар далдлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. (Лук 12:1-2)

Хоёрхон эшлэл дээр өчнөөн зүйлийг өгүүлжээ. Та сайнмэдээний номлогч байгаад, таныг “тоолошгүй” олон хүн сонсохоор цуглажээ гээд төсөөлөөд үзнэ үү. Энэ чинь номлогч хүний “мөрөөдөл” байхгүй юу! Гэтэл Есүс юу хийв? Есүс багийнхандаа “Залуус аа, энэ чинь Миний ирсний хамаг зорилго. Зорилгоо биелүүлэхэд

Бурханаас эмээхүй

минь саад бололгүй, зам тавь!” гэж шивэвгнээгүй. Үгүй ээ, Есүс, гурван зүйлийг хийсэн:

Нэгдүгээрт - Есүс боломжийг ашиглан *тухайн эгшиндээ автахгүй байхыг* үзүүлэнтэйгээр зааж өгчээ. Есүс тэдгээр ирээдүйн удирдагч нарт хоёр нүүртэй байдлыг сургаалаараа ч, үлгэр жишгээрээ ч анхааруулжээ. Үүнийг Грекээр *хупокризис* гэх бөгөөд “цаанаа тэс өөр зорилготой юмуу сэдэлтэй атлаа наанаа нэр бүхий зорилготой юмуу сэдэлтэй мэт сэтгэгдэл төрүүлэх”¹ гэж тодорхойлж болно.

Фарисайчууд хоёр нүүрлэхийн мастерууд байв. Яаж үзүүлбэр үзүүлж, дүр исгэхийг яруу тодоор харуулна. Харин Есүс сэдлээ цэврээр хадгалснаараа энэ урхинд унахгүй байхыг анхааруулжээ. Үндсэндээ, Есүс алдаршихын төлөө юмуу хүнд таалагдахын төлөө амьдралгүй, Ариун Сүнсээр хөтлүүлэн, амьдрахдаа ч, сургахдаа ч үнэн дотроо бат зогсохыг зааж өгчээ.

Хоёрдугаарт - Есүс хоёр нүүрлэх явдал ямар хурдан тархадгийг цохов. Есүс үүнийг зуурсан гурилаар үтэр түргэн тархаж, бүхлээр нь хөөлгөдөг хөрөнгөтэй жишжээ. Хоёр нүүрлэх явдал нь халдвартай бөгөөд бидний сайн сайханд учруулах хор уршгаараа исгэгч хөрөнгөөс ялгардгийг Есүсийн дүрсэлсэн.

Гуравдугаарт - Есүс хоёр нүүрлэх явдал нь нууц чигээрээ мөнхрөхгүйг цохсон. Хүний үг, үйлдлийн цаад санаа адагтаа заавал тэсрэх. Тэгвэл ийм цэвэр бус сэдлээс юу биднийг хамгаалдгийг Есүс дараагийнхаа мэдэгдлээр илчилжээ:

Би та нарт хэлье. Андууд минь, махбодыг хөнөөгчдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. Харин хэнээс айж эмээвэл зохихыг та нарт сануулъя. Хөнөөсний дараа тамд хаях эрх мэдэлтэй Нэгэнээс эмээгтүн. Тийм ээ, Би та нарт хэлье, Түүнээс эмээгтүн. (Лук 12:4-5)

Есүс дахиад л *айх* гэдэг хүчирхэг үгийг хэрэглэсэн байна. Энэ нь *фобео* гэдэг үг бөгөөд бидний өмнөх бүлэг дээр үзсэн *фообос* гэдэг үг нь үүнтэй язгуур нэг юм. *Фобео* нь “Айдаст автуулах, аймшигт автуулах, айлгах” гэсэн утгатай. Есүс ариун эмээхүйг үл тоох явдлыг “Тамд хаягдахтай” холбожээ. Ийм зүйлд хөнгөн

хандаж болдоггүй юм. Ариун эмээхүй амин чухал бөгөөд энэ нь зүгээр нэг хүндэтгэлийн ёслолоос том зүйл болохыг бид эндээс дахиад л харж байна.

Есүс бидэнд хүнээс бус, *Бурханаас эмээхийг заасан. Товчхондоо, Бурханаас айх айдас нь биднийг хүнээс айх айдсаас чөлөөлдөг бол, хүнээс айх айдас нь бидний Бурханаас айх айдсыг зайлуулан, боолчилдог байна.* Бүү эндүүр. Бид хүнээс айбал, сэдэл маань автагдах болно. “Хүнээс айх айдсыг” “Бурханаас айх айдастай” харьцуулан эргэцүүлнэ үү. Тэгэхээр, энэ нь хүмүүсээс зугтах явдал гэхээсээ илүү хувийнхаа ханамж, хамгаалалт, олз ашгийг бодолцсон тооцоолол дээрээ үндэслэн, өмнөх хүмүүстээ таалагдахад автагдах явдал гэвэл таарна.

Ананиа, Сапфира хоёрын үйлдэлд асуудал байгаагүй ч, нийгэмдээ нэгэн төрлийн сэтгэгдэл төрүүлэх сэдлээр хөдөлсөн явдал нь тэднийг шороодуулжээ. Хүмүүс янз бүрийн үйлдэл хийж, бурханлаг үг ярьдаг ч, ариун эмээхүйгүй сэдлээсээ болоод нүглийн нүхэнд унадаг.

Миний бие 1980-аад онд нутгийн чуулганд үйлчилж байхдаа, хүнээс ухаан жолоогүй айдаг байж билээ. Ариун Сүнс сэдлийг минь илчилж өгөх хүртэл ингэж л амьдрал. Тухайн үед би мега чуулганд өндөр албан тушаал хашдаг байлаа. Тэгээд харилцдаг, хамтран ажилладаг хүмүүстээ учиргүй эелдэг хандаж, үнэний ул үндэсгүй байсан ч хамаагүй, гоё ганган үгээр булдаг байв. Би хүмүүстэй нүүр тулахыг яс магнаасаа үздэггүй, үүнээс гай барцад мэт зугтдаг байлаа. Үүнийхээ улмаас чуулганыхаа хамгийн хайраар дүүрэн залуу гэдэг алдрыг хүртээд, үүндээ хөл газар хүрэхгүй баярладаг байж билээ.

Нэгэн өдөр залбирч байтал, Эзэн надад: “Миний хүү, хүмүүс чамайг хайраар дүүрэн, эелдэг залуу гэдэг гэв үү?” гэх нь тэр. Ариун Сүнс зүрхэнд минь ийнхүү тод айлдах үед би Түүнийг намайг зөвшөөрхөн тулд ингэж хэлээгүйг нь шууд мэдрэв.

Тиймээс болгоомжлон байж: “Тийм ээ, тэгдэг” л гэлээ.

Ариун Сүнс: “Чи яагаад худлаа байсан ч хамаагүй, хүмүүст гоё гоё магтаалын үг хэлдгээ мэдэх үү?” л гэж байна.

- “Яагаад?”

- “Яагаад гэвэл, чи хүмүүст гологдохоос айдаг. Тиймээс, чиний хайрын төв нь хүмүүс байна уу, чи байна уу? Хэрэв чи хүмүүст

үнэхээр хайртай байсан бол, ад үзэгдэж байсан ч хамаагүй, худлыг биш, үнэнийг л хэлэх байсан.” Би мэл гайхаж, цэл хөхрөв. Хүмүүс бүгдээрээ л намайг хайраар дүүрэн хүн гэж сайшааж байсан ч, суурь үнэн нь тэс өөр байжээ.

Үүнтэй адил, анхны чуулганыхан бүгдээрээ л чуулганы нүдэн дээр пасторгаа жинтэй бэлэг авч ирсэн Ананиа, Сапфира хоёрыг бурханлаг хүмүүс хэмээн шаагилдсан байх. Гэтэл тэдний жинхэнэ сэдэл ил болжээ. Үүнтэй адил, би ч өөрийгөө л дөвийлгөсөн, хамгаалсан, шагнасан сэдэлтэй байжээ. Миний зан авирын цаад жинхэнэ түүх нь хоёр нүүрлэх явдал байж.

Аминч сэдлээ нууж байгаад, дэлхий нийтийн нүдэн дээр бурханлаг, ач тустай ажил хийх амархан л даа. Аминч сэдэл өвөрлөсөн атлаа Сайн мэдээний аугаа үгээр цэнгэлдэх дүүрэн хүнийг намируулж ч болох (Филиппой 1:15-16). Огт хайрлахгүйгээр ядарсан зүдэрсэн хүмүүст их хэмжээний бэлэг өгч ч болох (1Коринт 13:3). Алдар нэрийг л санаалах атлаа хүмүүсийг магтаал хүндэтгэлд удирдаж ч болох. Гаднаа хүмүүст хачин эелдэг загнах атлаа дотроо байнга шүүмжилж, гоочилж байж болох. Ёс суртахууны алдаа доголдол гаргасныхаа урхагаар ажлаасаа халагдаж байгаа пасторыг наанаа ихэд хөөрхийлөх атлаа дотроо: “Болж!” хэмээн гуяа алгадаж байж болох. Даруу царайлан: “Бүх алдрыг Есүст!” гэх атлаа дотроо хүмүүсийн магтаал, сайшаалд дурлаж байж ч болох. Энэ мэтчилэн тоочоод л байвал, тоочоод л байна.

Тэгэхээр ийм байна: Нэгдүгээрт - эдгээр сэдлийн нэг нь ч Бурханаас нууцлагдахгүй. Хоёрдугаарт - бүгд эцэстээ ил болно. Тэгэхээр: “Бидэнд нууц байна уу?” л гэж асуух хэрэгтэй. Эзэнээс эмээхүй нь биднийг амьдралын амин чухал зүйл болох зүрхний минь сэдэлтэй уяж өгдөг. Учир нь Эзэнээс эмээхүйгээр гачигдбал, хоёр нүүрлэхийн урхинд унах эрсдэлтэй.

Ананиа дээр буусан шүүх чуулганыг гүнээ цочирдуулсан ч, эхлээд Ананиа, дараа нь Сапфира нар өөрсдөө хамгийн их цочирдсон болов уу. Тэд ариун эмээхүйгээр дутагдсандаа, хүмүүний сэдлийн ёрын чанартаа сохорчээ. Тэдний түүхээр Христийн сэнтийн шүүхийг төлөөлөн дүрсэлсэн эсэхийг бид дахиад бодох хэрэгтэй. Харин энэ тухайд дараагийнхаа бүлгээр үзье.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм. (Еврей 4:12)

Санаа: Эзэнээс эмээхүй нь биднийг амьдралын амин чухал зүйл болох зүрхний минь сэдэлтэй уяж өгдөг. Учир нь Эзэнээс эмээхүйгээр гачигдбал, хоёр нүүрлэхийн урхинд унах эрсдэлтэй.

Эргэцүүлэл: Өөрөөсөө асуу. Би яаж яваад өөрийгөө л дөвийлгөсөн, хамгаалсан, шагнасан сэдэл дээр дөрөөлсөн, хоёр нүүрлэх явдалд уначихав? Дарамтан дор миний зэс цухуйдаг тал юу вэ? Үүнээсээ болоод би аль тал дээрээ шударга бус авирласан бэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, өөрийнхөө төлөө, бусдад таалагдахын төлөө явсныг минь уучлаарай. Ариун Сүнс минь ээ, дарамтанд амархан тэсэрдэг талыг минь илчилж өгөөч. Есүсээс аз жаргалаа хайх ёстой байтал, хүнийг баяр хөөр, аз жаргалынхаа эх үүсвэр болгож байсныг минь өршөөгөөрэй. Хүмүүсийг үнэн хайраар тууштай хайрлаж, хоёр нүүрлэхийг цээрлэхийн төлөө зүрхийг минь ариун эмээхүйгээр дүүргээч. Есүсийн нэрээр залбирч байна. Амень.

Шийдвэр: Би хүмүүсийг хайрлаж, тэдний эрх ашгаас дээгүүр өөрийнхөө эрх ашгийг тавина.

*Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу
үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа
авахаар бид бүгдээрээ Христийн шүүх
суудлын өмнө гарч ирэх ёстой.*

— 2Коринт 5:10

13 | ГУРВАН ДҮР

Эсрэг талын нүүрэн дээрх “Юу үйлдсэнийхээ төлөө” гэдэг үгийг анхаарна уу. Хүн бүрт: *Бусдын нүдээрх* дүр, *бусдын төсөөллөөрх* дүр, *бодит дүр* гэсэн гурван дүр бий.

Бусдын нүдээрх дүр гэдэг нь хүмүүс биднийг хэрхэн хардаг дүр юм. *Бусдын төсөөллөөрх* дүр гэдэг нь хүмүүсийн зүгээс биднийг харахыг хүсдэг дүр болно. *Бодит дүр* гэдэг нь бидний байгаа, жинхэнэ дүр бөгөөд энэ маань хүмүүст анзаарагдамгүй, нүднээс нь далд байлаа ч, Бурханы мэлмийд ил байж байдаг. Шүүх сэнтийн өмнө бидний яг энэ дүр ил болох нь байна.

Тухай нь Есүсийг л аваад үз. Түүнийг хүмүүс ташаа тайлбарлаж, буруугаар яллаж, согтуу, ховдгоор нь дуудаж, буруу номтон бүү хэл чөтгөр шүгэлсэн гэж байсан. Түүнийг шашны мяндагтан тэргүүтэй олон түмэн ад үзсэн. Есүсийн бусдын нүдээрх дүр нь олонд - нэн ялангуяа алдартай хүмүүст таалагдаагүй.

Нэг эхээс төрсөн дүү нар нь ч Есүст байнга эргэлзэж, юм л бол *хүмүүсийн төсөөллөөр* амьдрахыг шаардаж байв. Бүр: “Эндээс хөдөлж, Иудей уруу яв. Тэгвэл дагалдагчид тань хийж байгаа үйлсийг тань мөн харна ... Та эдгээрийг үйлддэг бол Өөрийгөө ертөнцөд харуул л даа” (Иохан 7:3-4) хэмээн даапаалсан ч удаатай. Тэд хүмүүсийн үзэлд захирагдан, хүнээс айх айдсын боолчлол дороо Есүсийг ч оруулах гэж оролджээ.

Гэвч Есүс “... үл үзэгдэгч Бурханы дүр бөгөөд бүх бүтээлийн Түрүүнд гарсан нь мөн” (Колоссай 1:15) байсан тул Түүний дүр төрх нь *хүмүүсийн нүдээрх* дүр төрхөөс ангид байжээ. Хүмүүс олноороо Есүсийг эсэргүүцэж байхад Аугаа хүчирхэг Бурхан Өөрөө Түүнийг: “Үзэгтүн, хайрт Хүү минь энэ билээ. Таалал

минь Түүнд оршдог” (Матай 3:17) хэмээн батлан хамгаалсан байдаг. Есүсийн *бусдын нүдээрх* дүр нь бус, харин *бодит* дүр нь мөнхөрсөн болой.

Есүс газар дээр байхдаа Өөртөө нэр олох, Өөрийгөө тодруулах юу ч хийгээгүй. Тэрбээр хүнийг эдгээхдээ ч: “Энэ тухай бүү ярь” (Матай 9:30) хэмээн байнга анхааруулна. Есүс алдарших, нэрд гарах, хүнд хүлээн зөвшөөрөгдөхөөс зайлсхийдэг байв.¹ Хүмүүс Түүнийг хаанаар өргөмжлөх гэтэл, Есүс бултан зайлсан. Түүнд ямар ч өнгөлөн далдлал, хиймэл дүр, заль мэх байгаагүй. Тэрбээр Аваасаа дуртайяа эмээж, Аав дээрээ л төвлөрдөг байжээ.

Бид ч бас Есүсийн шууд дүр байх ёстой. Өөрийгөө дөвийлгөн тодруулах, биеэ өмөөрөхөөс зайлсхийж, дотроо үнэний дагуу амьдрахад л эрх чөлөө утгаараа оршино. Өөр дээрээ төвлөрөхийн эх үндсийг Адам, Ева хоёр тавьсан байдаг. Тэд бүдэрмэгцээ “нүд (нь) нээгдэн, ... нүцгэн байгаагаа мэдсэн... (ичгүүр мэдэрсэн) (Эхлэл 3:7) гэдэг. Тэд хараагаа Бурханаас нүүлгээд, өөрсөд дээрээ буулгахдаа, дөнгөж сая илрүүлсэн сул талаа нөхөх эрэлд гарчээ. Анхны хос нүцгэнээ *нуухаар* оролджээ. Тэгвэл бидний хувьд, илэрхийлэх арга нь л хувьссанаас бус, ялгаагүй л санаалдаг. Би өөр дээрээ төвлөрөөд байх юм бол, ил дутагдлыг минь өнгөлөн далдлах дүр төрхийн эрэлд гарна. Есүс биднийг боолчлолоос чөлөөлөхийн төлөө амиа тавьсан. Паул: “Учир нь бид өөрсдийгөө магтдаг хүмүүсийн тоонд орохыг, тэдэнтэй өөрсдийгөө харьцуулахыг эс зүрхэлнэ. Тэд өөрсдөө өөрсдийгөө хэмжиж, өөрсдийгөө өөрсөдтэйгөө харьцуулдаг нь ухаангүй аж” (2Коринт 10:12) гэсэн.

Бид харьцуулахын дарамтанд унаад өгөх юм бол, дутагдлаа л тодосгож хараад, эргээд өөрийгөө дөвийлгөх юмуу биеэ өмөөрөх бөгөөд энэ бүхэн нь бидний санаа сэдлээс л эхэлнэ. Өнөөгийн ертөнцөд *хүний нүдээрх* дүр нь *бодит* дүрээс хавьгүй жинтэй болжээ. Товчхондоо, бид нэр төрөө л улайран хамгаалах. Бид гадаад төрх, байр суурь, хэргэм зэрэг, алдар нэр, хүлээн зөвшөөрөл, нэр төр гэх мэт юмст л анхаарч, эдгээр нь бидний сул талыг *өнгөлөн далдлах* болно.

Гэвч Шүүх сэнтийн өмнө эдгээр нь бус, харин бидний санаа, сэдлийг бүслүүрдэн орших бодит дүр маань илчлэгдэх юм.

Иймд цагаас өмнө, Эзэнийг иртэл юуг ч бүү шүүгтүн. Эзэн *харанхүйд нуугдсан юмсыг (хар нууцыг)* гэрэлд гаргах бөгөөд *зүрхний санааг (амин сэдлийг)* илрүүлнэ. Тэгээд Бурханаас хүн бүрд магтаал ирэх болно. (1Коринт 4:5)

Олон хүн энэ Бичээсийг үл итгэгч хүмүүст хамаатуулан, хамар доогуураа өнгөрөөдөг. Гэвч үгүй юм аа. Учир нь үл итгэгч хүн шүүхээр орохдоо, магтуулна гэсэн ойлголт байхгүй. Тиймээс энэ нь зөвхөн итгэгч хүмүүсийн талаарх яриа болно.

“Хар нууц”, “Амин сэдэл” чинь тэнгэрийн чуулганы өмнө дэлгэгдэнэ гэхээр танд эрүүл айдас төрж байгаа биз ээ. Магадгүй иймээс л Паул итгэгч хүмүүсийн шүүхийг “Эзэнээс аюуж, бишрэхүй” хэмээгээ юм болов уу. Бодитоор айсуу энэ шүүхийг ухаарахуй нь хүнд ариун айдсыг төрүүлэх бөгөөд энэ нь биднийг *бодит* дүрээрээ амьдрах чадвартай болгож мөн үүнийхээ дагуу амьдарч буй эсэхээ нягтлахад хүргэнэ. Тэгвэл үүний эсрэг тал нь ч ялгаагүй үнэн юм: Хүн Эзэнээс үл эмээх тусмаа, бусдын *төсөөллөөрх* дүрдээ улам л орно.

Ананиа, Сапфира хоёр яг энэ үхлийн занганд унажээ. Тэд өрсөлдөгч, найз, чуулганы гишүүд, удирдагч нарынхаа *нүдэнд* юу гэж *үзэгдэх* дээрээ л анхаарчээ. Чуулган мэндлээд хэдхэн л сар болж байв. Хэн ямар салбар дээр сугаран манлайлахыг элч нар ч, чуулганы гишүүд ч анхааралтай ажиглаж байж.

Мөнөөх хосын хувьд аз жаргалтайгаар Есүст итгэж, нүглээ уучлуулсан. Тэд Бурханы ч, итгэл нэгт нөхдийнхөө ч хайранд автсан.

Гэвч энэ хараа нь яваандаа шилжжээ. Гэхдээ байна шүү - өргөл өргөх юмуу ятган сэнхрүүлэх, магтаалын багт дуулах зэрэг урсган тоочиж болох энэ бүх боломж нь голдуу Бурханаас эхлэлтэй байдаг нь хамгийн сонирхолтой. Үйлчлэлийнх нь хариуд ирж буй сайшаал урамшуулалд дээрх хоёр тун хангалуун байж. Эндорфин нь олгойдож, аз жаргал, сэтгэл ханамжийн мэдрэмж нь садарч байв.

Энэ талархал нь улам л дэлгэрч байв. Гэхдээ тэр хоёр шинээр бүтээсэн нэр төрөө хадгалахын төлөө зарим нэг асуудалтай зан авираа нэг их гэм хоргүй гэмээр үг, үйлдлээр *өнгөлөн далдлах* шаардлагатай болжээ. Магадгүй, тэд гэр дотроо нилээд олон

жил тар тур хийсээр ирсэн байхыг хэн мэдлээ. Дотоодын хагарал самуун нь улам л улангасан даамжирсаар байсан ч, тэд итгэгч нарын дунд орох үедээ сул талаа тэс өөр ааль байдлаар өнгөлөн далдалдаг болов. Зөрчил, хагарлаараа бусдын *нүдээрх* дүрээ баллахыг хүсээгүй хоёр маань бусдын *төсөөлөлд* хоёр биенээ гэх хайр, халамжаар халгисан хосын дүрд оржээ.

Инстаграм, ТикТок дээр нэг л их тэврэлдэж, инээлдэж, зугаацсан зураг, видео тавьсан улс. Доор нь мэдээж “Мөрөөдлөө дага”, “Хувь заяат хосын зорилго”, “Түүнтэйгээ л байх сайхан!” гэх мэт үг өгүүлбэр бичнэ. Амжилттай (нэндээ зөрчилтэй яваа) амьдрал, цэцэглэж байгаа (үнэндээ алдагдалтай яваа) бизнес, сайхан (үнэндээ амиа бодсон, буруу эрхэлсэн, авиргүй) хүүхдүүд зэрэг ололт амжилтаа алаг эрээн зургаар дөвийлгөнө. Энэ арга нь ч бүтэж, олон нийтийн сүлжээний дагагч нар нь ч зогсоо зайгүй өссөөр.

Ананиа, Сапфира хоёр бусдын төсөөллөөрх дүрээ тун сайн батлан хамгаалж байжээ. Энэ бүхэн нь ч гэм хоргүй харагдав ч, хоёр нүүр гаргах бүрий, тэдний бурханлаг эмээхүй нь саарсаар байв. Одоо тэд хоёр дүрд тоглож байгаадаа ч эмзэглэхээ больжээ. Бүх юм сайн сайхан, нэр төр нь ч өндөр яваагийн дунд нөгөө “Чуулганы хамгийн өгөөмөр гэр бүл” гэдэг өргөмжлөл ч багтана.

Тэгтэл тэр нэгэн өдөр Барнаб чуулганд өргөл өргөөдөхөв. Хүмүүсийн анхаарал ч шууд Барнаб руу шилжив. Ананиа, Сапфира хоёр ул болж, *хүмүүсийн нүдэн дээрх* дүр нь аюулд оров. Хамгийн харамсалтай нь, тухайн үед тэдний бүтээсэн дүр нь тунчиг бэхжээд байжээ. Тэгээд юу болсныг бүгд мэднэ.

Бусдад сэтгэгдэл төрүүлсэн тэдний амьдрал гэм хоргүй мэт боловч, үүнээсээ болж тэд өөрсдөө бодитоор аюулд орж, сүйрсэн. Шүүх сэнтий хичнээн ноцтой болохыг Бичээс дээрх энэ хосын түүхээр Ариун Сүнс бидэнд анхааруулга өгөө юм болов уу? Паул:

Зарим хүмүүсийн нүгэл шүүлтээс нь өмнө илэрхий болжээ. Харин заримынх нь хожим илрэх болно (1Тимот 5:24) гэж бичсэн.

Мартагдашгүй түүхт Ананиа, Сапфира хоёрын нүгэл ил тод байсан. Тэд шүүхээр урьдчилан оржээ. Гэвч дийлэнх хүмүүсийн

нүгэл хожим ил болно гэхээс сэрэмж авах ёстой. Бурхан тэр хоёр хүний үйлдлийг бус, далд сэдлийг нь шүүснийг санаарай.

Гэхдээ сайн мэдээ нь: Хар буруу сэдлээ гэмшбэл, Бурхан хэзээд уучлах хэдий ч, ариун эмээхүйн төлөө, Бичээсээр оюун санаагаа шинэчлүүлэхийн төлөө хашхирбал, Бурхан биднийг цэвэр сэдлээр ерөөнө.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Илчлэгдэхгүй байхаар халхлагдсан, мэдэгдэхгүй байхаар нууцлагдсан юм гэж огт үгүй билээ. (Лук 8:17)

Санаа: Хүн бүрт: *Бусдын нүдээрх дүр, бусдын төсөөллөөрх дүр, бодит дүр* гэсэн гурван дүр бий.

Эргэцүүлэл: Би аль дүр рүү нь тэмүүлэх вэ? Би үнэнээр амьдарч байна уу эсвэл худлаа хэлж, нэр төрөө хамгаалахын тулд хуурамч мэдэгдэл хийдэг үү? Би харилцаж байгаа хүмүүстээ шулуун шударгаар ханддаг уу?

Залбирал: Би бодит дүр дээрээ бус, харин бусдын нүдээрх, бусдын төсөөллөөрх дүр дээрээ анхаарснаа гэмшиж байна. Үнэн зөвийг орхигдуулсандаа, Танаас уучлал гуйж байна. Миний сэдэл, санааг цэвэршүүлээч. Би өөр дээрээ бус, ерөөл дээр, Есүс дээр төвлөрмөөр байна.

Шийдвэр: Би Бурханы Үгийн хоёр талдаа ирт сэлмээр зүрхнийхээ санаа, сэдлийг илчлүүлнэ.

*Бурханаас айх айдас орж ирэхэд,
үхэл, шүүхээс айх айдас гарч,
айдас нь тамлал бус, биднийг
ядраадаг бус, харин ч амраах
сэтгэлд амар,
хөнгөн буулга болно.*

— Эй. Даблью. Тозер, Харри Верплоех

14 | МӨНХИЙН ШИЙДВЭР

Өнө мөнхлөлтэй харьцуулахад, хүний амьдрал уур манан мэт. Үнэндээ юу ч биш гэвэл голыг нь онох байх. Учир нь тооны ухаан дээр хязгааргүй тоог хязгааргүй тоогоор хуваахад, тэг гардаг. Тиймээс үсрээд үсрээд, зуу насаллаа ч, энэ нь өнө мөнхлөлтэй харьцуулахад, юу ч биш дэг ээ. Энэ цочирдмоор үнэнийг нэгэнт ухаарсан бол, өдгөөгөөс үүрд мөнхдөө бэлтгэж эхлэх нь ухаалаг бус уу.

Шүүх сэнтийгээр бидний хүн нэг бүрт хандаж гаргах Есүсийн шийдвэр нь *мөнхийн* чанартай (Еврей 6:1-2). Товчхондоо, Есүсийн шийдвэрт аль нэгэн өөрчлөлт хийгдэх, ахин шүүн хэлэлцэх юмуу өөр хувилбар гарахгүй. Тиймээс, хүн загалмайг хэрхэхээсээ шалгаалж *хаана* өнө мөнхийг өнгөрөөхөө шийдэх бол, итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарснаараа, өнө мөнхийн амьдралаа *хэрхэн* өнгөрүүлэхээ шийдвэрлэнэ.

Дэндүү олон хүн тэнгэрийг ямар ч зовлон шаналангүй, бөөн хайр, халамж, амар амгаланд автсан, биет бус, хийсвэр оршлоор л төсөөлдөг. Ариун хүмүүсийг үүлсээр хөвж, босоо ятга тоглож, усан үзэм амталсан, хийн биетэй оршигсад байна гэж боддог болтой. Гэтэл нөгөө хэсэг нь тэнгэрийг мөнхийн мөнхөд тасралтгүй үргэлжлэх хүндэтгэлийн цуглаанархуу юм гэж ойлгодог юм шиг байгаа юм. Ийм үзэлтэй хүн өнө мөнхлөл гэдэг ойлголтод баярлахгүй байх нь аргагүй л дээ.

Гэхдээ иймэрхүү юмс нь Бичээс дээр байдаггүй, домог юм. Энэ ертөнц дээрх амьдралын хамгийн л өнгөтэй өөдтэй гэгдэх бүхэн нь өнө мөнхийн амьдралын сүүдэртэй л дүйцнэ байх. Тэнд чинь нийгмээ төлөвлөх, хотуудыг барьж байгуулах, улс орныг захирах, галактикуудыг нээж хөгжүүлэх гээд л бидний үйлдэхээр бүтээгдсэн үй олон үйл хэрэг бий. Эзэний мөнхийн хотод үүрэг хариуцлагын байр суурь гэж бий. Тиймээс, шүүх сэнтий нь таныг

Бурханаас эмээхүй

шинэ тэнгэр, шинэ газар дахь Эзэний нийслэл хотод өнө мөнхөд ямар байр суурь эзэлж амьдрахыг шийдвэрлэх ажлын ярилцлага, дүгнэлт гэвэл, таарах байх.

Үүнийг тогтоонгоо, бидний одоогийн бөгөөд эндхийн амьдрал хожим шүүхээр хэрхэн шалгагдах талаар үргэлжлүүлэн ярьцгаая.

Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө (ямар зорилго, сэдэл агуулав, ололт амжилт нь юу байв, юуг гүйцэтгэхийн төлөө цаг заваа зориулан, өөрийгөө бөгөөд анхаарлаа өгснөө харгалзан үзүүлээд) биеэрээ хариугаа (цалин хөлсөө) авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. (2Коринт 5:10 Хаалтанд ЭйЭмПиСи Библийн орчуулгыг хавсаргав)

Итгэгч хүний хувьд - тамын ялд унагах байсан нүгэл нь Есүсийн цусаар хэдийнээ арчигдаад, мөнхөд мартагдсан (Еврей 8:12). Тийм боловч итгэгч - бид амьд ахуйдаа гаргасан адын юмуу муу зан үйлдлийнхээ төлөө итгэгч хүмүүсийн шүүхээр орж, шүүгдэнэ. Үүнийг анхаараарай.

Адын гэхийг Грекээр *какоос* гэдэг бөгөөд “хортой, хорон чанартай муугаараа байсаар байх”, “тулаанд няцах, дундаас нь гарах, ухрах” гэсэн утга илэрхийлэх. Өөрөөр хэлбэл, энэ үг нь дан ганц үйлдсэнээрээ бус мөн няцах юмуу хөсөрдүүлснээрээ буюу товчхондоо *эс үйлдсэнээрээ* учруулдаг хор хөнөөлийг илэрхийлж байна. Тиймээс, бидний зөвхөн үйлдсэнийг бус мөн хөсөрдүүлсэн боломжийг ч илтгэх. Ариун айдас нь биднийг хаанчлалын үүрэг хариуцлагад сэргэг байлгадаг төдийгүй, Бурханы хайртай хүмүүсийн амьдралыг хорлож хохироох дайсагналт сэдэл, үйлдлээс ч сээрэмжтэй байлгана.

Бичээс биднийг “Барилгачидтай” зүйрлэх нь олонтаа. Үүнийг нь Бурханы өнийн мөнхөд оршин суух захиалгын байшинг барилцаж байгаа туслах барилгачид хэмээн ойлгож болно. Бурханы гэрийг *Цион* гэдэг (Дуулал 132:13-14) бөгөөд материал нь амьд чулуу - Бурханы ариун хүмүүс (2Петр 2:5) бол, Есүс булангийн тэргүүн чулуу нь болой (Исаиа 28:16).

Паул “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор *яваасай* гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ” (Ефес 2:10) хэмээн бичсэн.

Паул биднийг эдгээр даалгаврыг биелүүлэхийн төлөө *явна* гэсэн бус, харин *яваасай* гэснийг тэмдэглэнэ үү. Түрхэн зуурын амин хувийнхаа ашгийн төлөө амьдрах сэдлээр жолоодуулсан замыг сонгоод байх нь “адын” зан үйлд тооцогдоно.

Паул түүнчлэн “Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун” (1Коринт 3:10) гэсэн. Хэрхэн барих нь ялгаагүй чухал болохыг тун тодорхой хэлжээ. Бид Бурханы мөнхийн Үгээр барьж байгуулж байна уу эсвэл энэ цагийн сүнсийг сонсож байна уу? Бурханы Сүнсээр барьж байна уу эсвэл амин хувиа эрэлхийлсэн хүсэлдээ үйлчилж байна уу? Паул цааш нь ийн бичив:

Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. (1Коринт 3:12-13)

Бурханаас олгогдсон цагийг өнгөрөөх олон төрлийн сонголт байдаг байх нь. Амин хувийнхаа эрх ашгийг барьж байгуулахын төлөө амьдарбал - энэ нь богино настай, шатамхай материалд тооцогдоно. Харин амин хувиа үл тоон, Бурханы мөнхийн хаанчлалыг байгуулахын төлөө амьдарбал, эдгээр нь шаташгүй, харин цэвэрших материалын тоонд орно. Амьдралыг маань шалгах гал нь Бурханы Үг мөн буюу. Өөрөөр хэлбэл сэдэл, үг, зан үйлдлээрээ Бурханы Үгтэй аль хэр зэрэгцснээ л галаар шалгуулна.

Паул цааш нь “Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна” (14-ээр эшлэл) гэжээ. Зан үйлдэл, хүчин зүтгэл маань бидний амьдралд хандсан Бурханы Үг, хүсэлд дуулгавартай явах байдлаас ундрэн гарсан бол, ололт амжилт маань өнө мөнхөд тогтоно. Эндээс хоёр зүйлийг тэмдэглэх хэрэгтэй: Нэгдүгээрт - ололт амжилт маань өрөөлд хэрхэн нөлөөлж амьдарсан мөн Бурханы хаанчлалыг байгуулахын төлөө Түүнээс өгөгдсөн бэлэг авьяасыг хэрхэн хэрэглэсэн гэдэг хоёр хүчин зүйлийг хамаарна. Хоёрдугаарт - мөнхийн шагнал нь бид Бурханы хаанчлалд өнө мөнхөд ямар байр суурь эзлэхийг шийдвэрлэнэ.

Үүнийхээ араас Паул үнэхээрийн цочирдуулмаар үг хэлжээ:

Бурханаас эмээхүй

Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр (үлэмж) хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч *аврагдана*. (1Коринт 3:15)

Энэ эшлэл маш ихийг өгүүлрүүн. Нэгдүгээрт - барилгачин *аврагдаж* байгааг тэмдэглэнэ үү. Энэ чинь галт нууранд хаягдах ялтай үл итгэгч хүн бус, харин Бурханы хаанчлалд мөнхөд оршин суух хүн шүү дээ.

Хоёрдугаарт - хохирол нь үлэмж их байх нь. Энд шийтгэл юмуу гарз хохирлыг илтгэсэн утга бүхий Грек үгийг хэрэглэжээ. Гэхдээ шийтгэлийн тухай өгүүлсэн гэдэгт дийлэнх эрдэмтэд - тэр дундаа би ч итгэдэггүй. Илүүтэй хүнд гарз хохирлыг илтгэсэн болов уу. Энэ том алдагдал нь шүүх дээр ил болохоос гадна биднийг өнийн мөнхөд ямар янзтай амьдрахыг ч шийдвэрлэх нь байна.

Гуравдугаарт - галан хана дундуур амь мөлтөс аврагдаж буйгаар жишжээ. Одоогийнхоор бол дараах жишээрхүү юм болох нь байна. Манай Барууныхан тэтгэврийн насандаа бэлтгэдэг. (Тэтгэвэр буюу “Ретайрмент” гэдэг Англи үг нь “Даалгавраасаа ухрах” гэсэн утга санаагаараа “Какоос” буюу “Адын” гэдэг үгийн тодорхойлолттой эвсдэг учраас, би л хувьдаа тэтгэврийн сэтгэлгээг дэмждэггүй. Гэхдээ яахав, жишээгээ тайлбарлах үүднээс энэ энэ дүрслэлийг ашиглая.)

Тухай нь, нэгэн хүний яг тэтгэвэртээ гардаг өдөр нь банк нь дампуурчихжээ. Нөгөө хүн тэтгэврээ бүхлээр нь алдаад, түрүүвчиндээ хэдхэн доллартай л үлдэж. Гэтэл бас яг тэр өдөр нь Нийгмийн даатгал нь ч, хөрөнгө оруулсан хэд хэдэн компани нь ч бүгд дампуурчихаж. Дээрээс нь нөгөө хүний байшин нь бүрэн шатаад, өмсөж явсан өмдтэйгээ л үлдэв гэнэ. Тэрбээр юу ч үгүй хоцров. Ийм явдлыг жинхэнэ гай гамшиг гэхээс өөр юу гэх билээ. Гэтэл зарим итгэгч мөнхийн улсын босгоор нэг иймэрхүү янзтай л орохыг Паул дүрслэн хэлжээ. Тэгээд энэ байдал нь хорин жил үргэлжлэлгүй (энэ нь хүний тэтгэвтээ гарснаас хойш амьдардаг дундаж хугацаа), харин өнө мөнхөд үргэлжилнэ.

Итгэгч хүн аврагдах хэдий ч, хамаг байдгаа шатаалгаад, мөнхөд алдагдал хүлээхийг Паул хэлсэн. Энэ чинь мөнхийн шүүх (шийдвэр) болохыг санаарай. Буруу ташаа ойлгуузай. Мэдээж аврагдах нь гал нууранд хаягдахаас тэнгэр газар шиг ялгаатай, хамгийн том ололт мөнөөс мөн. Мэдээж бид цэнгэлийн дээдээр баярлах боловч, нөгөөтэйгүүр өөрөөр байж болох байсан гэдэг харуусал хэзээ ч арилахгүй юм.

Паул дараа нь “Иймээс бид *Эзэнээс эмээхүйг* мэдэж, хүмүүсийг ятгадаг” (2Коринт 5:11) гэж хэлсэн нь ч санаандгүй үг биш. Паулын яриад буй ариун эмээхүй таныг цагаа ашиггүй юмс дээр юмуу хүний нүд, төсөөллөөрх дүр дээрээ гарздахгүй байхад хүргээсэй гэдгийг л үнэн голоосоо хүсэх минь. Танд бэлэг болж ирсэн цаг хугацаа нь Бурханы Үг, Сүнсэнд дуулгавартай байхад л зориулагдах болтугай.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой. Иймээс бид *Эзэнээс эмээхүйг* мэдэж, хүмүүсийг ятгадаг. Бид Бурханд ил болсон. Мөн та нарын мөс чанарын дотор ч бид ил болсон гэж би найддаг. (2Коринт 5:10-11)

Санаа: Хүн загалмайг хэрхэхээсээ шалгаалж хаана өнө мөнхийг өнгөрөөхөө шийдэх бол, итгэгч хүнийхээ хувьд хэрхэн амьдарснаараа, өнө мөнхийн амьдралаа хэрхэн өнгөрүүлэхээ шийдвэрлэнэ.

Эргэцүүлэл: Би өдөр болгоныг өнө мөнхийн төлөө, хүмүүсийн амьдралыг хайр, үнэн дотор байгуулахын төлөө зориулж байна уу? Эсвэл хүч тэнхээ, эрч хүч, цаг заваа амин хувийнхаа төлөө л зориулж байна уу?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, анхаарал, эрч хүч, хүч тэнхээ, цаг заваа цаг зуурын юмс дээр төвлөрүүлснийг уучлаарай. Есүсийн хаанчлалын төлөө өдөр бүр хэрхэн барьж байгуулахыг зааж өгөөч. Намайг хүмүүсийн амьдралд өнө мөнхийн нөлөө авчрах хүчтэй болгооч. Есүсийн нэрээр талархаж байна. Амень.

Шийдвэр: Би дан ганц энэ амьдралаар эцэс болох боломжинд төдийгүй, өнө мөнхийн боломжинд ч оролцохыг эрмэлзэж амьдарна.

ТЭСВЭРЛЭШГҮЙ АРИУН ЧАНАР

Гуравдугаар долоо хоног

*Махан биеийн хүн нь
Бурханаас бус, хүнээс айдаг.
Хүчтэй итгэгч хүнээс бус,
Бурханаас айдаг. Сул итгэгч
Бурханаас дэндүү бага,
хүнээс дэндүү их айдаг.*

— Жон Флавел

15 | ХҮНЭЭС АЙХ НЬ

Жинхэнэ ариун байдал нь бүхлээрээ Бурханых л байх гэсэн үг. Гол тодорхойлолт нь ч “Бурхан руу тусгаарлагдах”¹ л гэсэн утгатай. Дэндүү өргөн дэлгэр утга бүхий энэ үгийн талаар хэдэн ботиор ч бичиж болно. Энэ бүлгээрээ бүгдээрээ гол гол утгыг нь авч үзнэ. Яагаад гэвэл бурханлаг айдас нь ариун байдлын амин чухал тал мөн. Гэхдээ цааш хөдлөхөөсөө өмнө: Жинхэнэ ариун байдал нь хүлээс бус, жинхэнэ эрх чөлөө гэдгийг мэдэгдмээр байна.

Ананиа, Сапфира хоёрын шүүх нь хожим хүн болгоны үзэх зүйлийг буюу шүүхийг төлөөлсөн байх бүрэн боломжтой. Тэгэхээр, энэ хос тэнгэрт “Үлэмжийн алдагдал” хүлээх хүмүүсийн юмуу Хайдаст орох хүмүүсийн жишээ биш гэдэгт л хамаг учир оршино.

Энэ хосын мөнхийн хараал сайнмэдээний ном дээр Есүсийн Өөрийнх нь хэлсэн үгэнд байдгийг Бичээс олонтаа тайлбарласан байдаг: “Ариун Сүнсийг доромжлогч хэн ч хэзээ ч уучлагдахгүй бөгөөд мөнх нүглийн гэмтэн болно” (Марк 3:29). Энэ сэтгэлгээний гол алдаа нь “Хэн нэгний эсрэг нэр төрийг нь хохироож, сэвтүүлэх арга замаар ярих”² гэсэн утга бүхий “Доромжлох” гэдэг үгд оршино. Дээрх хос Ариун Сүнсэнд *худлаа* хэлсэн хэдий ч, дээрх тодорхойлолтын дагуу авч үзэх юм бол, Ариун Сүнсийг *доромжлоогүй* байна. Үүгээрээ л хувь заяагаа эрсдүүлжээ. Хэн ч ямар ч нөхцөлд ийм үр дагаврыг хүсэлтгүй.

Тэгэхээр, бид тэнгэрт орох хэдий ч, үлэмжийн алдагдал хүлээх хүний жишээг харав уу? Би л хувьдаа тийм гэж итгэж байна. Үүнийгээ Паулын үгтэй эгнээе:

Бурханаас эмээхүй

Учир нь эдүгээ би хүмүүсийн тааллыг эрж байна уу? Эсвэл Бурханыхыг уу? Эсвэл би хүмүүст таацуулах уу? Хэрэв би эдүгээ хүртэл хүмүүст таацуулсаар байсан бол би Христийн зарц биш байх байсан. (Галат 1:10)

Ямар хүчтэй мэдэгдэл бэ? Бид алдар нэрийн татлагад автчихбал, Христийн зарц байх завшаанаа хөсөрдүүлнэ. Үүнээсээ болоод бусдад тааламжтайгаар үзэгдэхийн төлөө ямар л дүр гаргах ёстой - түүнийгээ гаргадаг болоход хүргэнэ. Тэгвэл Паул үүнийг юмын чинээ тоогоогүй бөгөөд бид ч тэгэх ёстой юм.

Асар өндөр төвшний эмээхүй дотор амьдарсан Паул: “Өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ” (Филиппой 2:12) гэж бичсэн. Паул *бусдын төсөөлөлөөрх дүр* дээр бус, харин шүүх дээр илчлэгдэх *бодит* дүр дээрээ төвлөрчээ. Энэ нь л Паулыг тэр их гутрал, үл зөвшөөрөл, эсэргүүцэл дунд жинхэнээсээ ариун байж, Христэд дуулгавартай байх байр суурин дээр нь тогтоосон юм.

Хүн айдаг нэгэндээ үйлчлэх! Энэ үнэнийг үргэлжид өмнөө байлга. Бурханаас айдаг бол, Бурханыг дагана. Хүнээс айдаг бол, эцэстээ хүний хүслийг л дагана. Хүн ер нь биетээр үзэгдэхгүй Нэгэнээс илүүтэй нүдэн дээр ил байгаа хүнийг гомдоохоосоо айдаг л даа. Ялангуяа тэр хүнээс хайр юмуу нөхөрлөл горьдохдоо. Ийм учраас л бидэнд “Хүнээс айх айдас занга тавих” (Сургаалт үгс 29:25) хэмээн анхааруулсан бөгөөд Ананиа, Сапфира хоёр энэ л урхинд унасан буюу.

Яасан болоод Паул итгэл нэгт удирдагч нартайгаа уулзаад дүрэлзэж, захидлынхаа сүүлээр доорх улайдсан үгийг бичихдээ тулаа юм бол хэмээн төсөөлөх юм:

Харин Кефийг Антиохт ирэхэд би түүнийг нүүрэн дээр нь эсэргүүцэв. Учир нь тэр буруутан болоод байлаа. Иаковын хэдэн хүнийг ирэхээс өмнө харийнхантай хооллодог байсан атлаа тэднийг ирэхэд тэр хозлуулагсдаас цэрвэж, харийнхнаас холдон зай барьсан юм. Бусад иудейчүүд ч түүний хамт хоёр нүүр гаргацгаасан. Түүнчлэн Барнаб хүртэл хоёр нүүрт байдалд нь автсан юм. Харин би сайнмэдээний үнэнээр цэх шулуун явахгүй байгаа тэднийг

хараад, бүгдийн өмнө Кефт “Чи иудей байж, иудей шиг биш, харин харьтан шиг амьдардаг атлаа яагаад харийнхныг иудейн маягаар амьдар гэж албадна вэ?” гэж хэлсэн. (Галат 2:11-14)

Петр, Барнаб тэргүүтэй Еврей итгэгч нар хүндэт хүмүүсийн дургүйцлээс айдаг байжээ. Ийнхүү таалагдах гэсэн эрмэлзэл нь эхлээд Петрийг, дараа нь бусдыг нь хоёр нүүрлэхэд хүргэжээ. Бусдын *төсөөлөлөөрх дүрдээ* орсон тэд ёст чанараа уландаа гишгэлээд, ариун бус зан авир гаргахдаа тулжээ. Өөр нэгэн Библийн орчуулга дээр Сургаалт үгс 29:25-ыг “Чиний талаарх ерөөлийн бодолд зовних нь аюултай буюу” гэдэг (ЖиЭнТи Библи).

Гэтэл ёст чанараа хадгалсан Паул эхлээд хүний дарамтаас айсан Петрийг, араас нь Барнаб тэргүүтэй бусдыг нь нүүрэн дээр нь зэмлэжээ. Консерватив Иүдей удирдагч нар байгаагүй бол, Петр ба түүний нөхөд яг л байгаагаараа буюу *бодит* дүрээрээ л амьдрах байсныг Паул даруй цохон тэмдэглэжээ. Тэд харь итгэгч хүмүүсийг хүлээн авч, хайрлаж, нөхөрлөдөг Есүс Христийн жинхэнэ төлөөлөгч нар байхаар хүчижсэн байв. Гэтэл хүрээллийнх нь динамик өөрчлөгдмөгц, Петр тэргүүтэй нөхөд тухайн нөхцөлдөө нийцэх гэсэндээ *бусдын төсөөлөлөөрх* дүрдээ оржээ. Гэтэл энэ зан авир нь боловсруулах бус, харин ч хохироох үр дагавар авчиржээ.

Петр бол эдүгээ тэнгэрт буй, ариунтан. Гэхдээ дээрх адын буюу хортой сэдэл, үг, үйлдэл нь шүүх сэнтийн өмнө шүүгдэхийн бас нэгэн жишээ болно. Бид цаг үргэлж Есүст л таалагдахын төлөө амьдарбал, хүмүүс биднийг юу гэж *үзэж байна* гэдэг айдаст жолоодуулалгүй, харин ч үнэн дотор алхална. Энэ нь жинхэнэ ариун амьдралын чухал тал мөн. Дараахыг анхааралтай уншина уу:

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм. Түүний хараанаас нуугдах нэг ч бүтээл үгүй. Харин Түүний мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил болой. Түүнд бид тооцоотой. (Еврей 4:12-13)

Энэ үгээс нэгийг ойлгож байна уу? Танил эшлэл учраас, жирийлгээд жирийлгээд өнгөрсөн бол, дахиад тогтож уншаад, мэдэгдэл бүрийг тогтуунаар тунгаана уу.

Бурханы Үг нь гүний гүн сэдэл, хүсэлд ч хүртэл исгэдэг гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Энэ нь бидний ордог дүрийг бус, харин жинхэнэ төрхийг илчилдэг гэсэн үг. Сонсоод, дагах аваас, Бурханы Үг биднийг *Эзэн харахгүй ээ... (за харсан байсан ч өдий зэргийн юмыг тоохгүй)* хэмээн бурханлаг бус, ариун бус явдалд хүргэгч, өөрийгөө хуурах үйлдлээс сэргийлнэ.

Бурханы Үгийг анхаарбаас, Бурханы Үг бидний дотор Эзэнээс эмээхүйг идэвхижүүлнэ. Энэ нь биднийг “Түүний хараанаас нуугдах нэг ч бүтээл үгүй. Харин Түүний мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил болой” (Еврей 4:13) гэдэгт үргэлжид сэрэмжтэй байлгана. Ийнхүү юуны учир Ариун Сүнс бидэнд:

Хүү минь, үгсийг минь хүлээн авч, Тушаалуудыг минь дотроо нандигнаваас, Мэргэн ухаанд чих тавьж, Ухаан бодролд зүрхээ зүглүүлвээс, Ухаарлыг чи чангаар дуудаж, Ухаарал ойлголтын төлөө дуугаа өндөрсгөвөөс, Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж, Нууц эрдэнэ мэт түүнийг хайваас, ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно, Бурханы мэдлэгийг олж авна (Сургаалт үгс 2:1-5) хэмээн зөвлөснийг эдүгээ бид ойлгож авсан байх аа.

Бурханы Үгийг дотор хэсэгтээ буюу сэдэл, санааг маань засагладаг газартаа л мөрддөг байх нь хамгаас зөв. Бид Бурханы Үгийг хамгийн үнэт олз мэт үзэж, илчилсэн үнэнийг нь дагахдаа л *аюулгүйн бүсэд* оршино. Бурханы замыг мэдэхийн төлөө үүнээс дээр шагнал үгүй мэт үнэн голоосоо эрэлхийлэх аваас, бид Эзэнээс эмээхүйг ойлгон мэдэх бөгөөд *бусдад таалагдах* хуурамч дүрд орох залиас зайлна. Бид үнэн бөгөөд ёст чанараараа амьдрах хүчтэй байж, хөл минь ч ариун амьдралын алтан шаргал замаар ямар ч аюул осолгүй зорчино.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Та нарын ариун хэмээн үзэх ёстой нэгэн нь түг түмдийн ЭЗЭН юм. Тэрээр эмээдэс тань байх болно. Тэр та нарыг айлгах болно. Дараа нь Тэр ариун газар болно. Гэхдээ Израилийн хоёр гэрийг цохих чулуу, бүдрүүлгийн хад, Иерусалимын оршин суугчдын урхи ба занга болно. (Исаиа 8:13-14)

Санаа: Хүн айдаг нэгэндээ үйлчлэх. Бурханаас айдаг бол, Бурханыг дагана. Хүнээс айдаг бол, эцэстээ хүний хүслийг л дагана. Та хүний хүслийг дагахыг эрмэлздэг бол, Есүс Христийн жинхэнэ дагалдагч байж чадахгүй.

Эргэцүүлэл: Би яагаад биетээр харагдахгүй Бурханыг гомдоохоосоо илүүтэй нүдэнд харагддаг хүнийг гомдоохгүйг хичээнэ вэ? Яагаад Бурханаас илүүтэй хүнээс хайр, таалал, нөхөрлөлийг хүснэ вэ? Үүнийгээ хэрхэн өөрчлөх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны тааллаас илүү хүмүүсийн тааллыг эрэлхийлснийг минь уучлаарай. Есүс ээ, Таны тааллаас илүү хүмүүст таалагдах гэж чармайснаа гэмшиж байна. Би Тан руу тусгаарлагдаж, ариун байхыг сонгож байна. Яг одооноос эхлэн би зөвхөн Танд л таалагдахын төлөө явна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Христийн зарц. Би хүний тааллаас илүү Христийн тааллыг л эрэлхийлнэ.

*Бурханаас эмээхүй
зүрхийг засаглаж байгаа нөхцөлд
энэ нь сүсгээр ч, үйлдлээр ч илрэх
бөгөөд алийг нь ч хаягдуулахгүй.*

— Мэтью Хенри

16 | ЭРХ

Галат ном нь МЭ 49 оны хавьцаа бичигдсэн болохоор Паулын Петр тэргүүтэй Иүдей удирдагч нарыг зэмлэсэн явдал нь түүнээс өмнө тохиолдсон болж таарах нь. Арав гаруй жилийн дараа МЭ 63 онд Петр анхныхаа захидлыг бичсэн. Петрийг дараах үгийг үзэглэж байхад, Галатын чуулган даяар дэгдсэн мөнөөх явдал Петрийн ой санаанд тодхон байсан гэдэгт эргэлзэх юм алга:

Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл ... Та нар ялгаварлалгүйгээр хүн бүрийг үйлсийнх нь дагуу шүүдэг Нэгэнийг Эцэг гэж дууддаг юм бол, энд байх хугацаандаа *эмээн биеэ авч яв*. (1Петр 1:14, 17)

Петр Есүсийг дагахад бүрэн зориулагдсан, дэлхий рүү цовдлогдсон, өөрсдийгөө няцаасан итгэгч хүмүүст л хандаж бичсэн нь тодорхой. Эдгээрийг үйлдэлгүйгээр Есүсийг дагах боломжгүй тул аль нэгийг нь үйлдээгүй л бол, жинхэнээсээ итгэсэн ч байж таарахгүй (Матай 16:24, Марк 8:34, Лук 9: 23, Галат 6:14). Нэгэнт итгэсэн бол, бидний дотор тэнгэрийн мөн чанар бүрэлдэн тогтоно. Энэ мөн чанарт захирагдсанаараа бид сэтгэл - мэдрэмжийнхээ захиргаанаас чөлөөлөгддөг ба ийн амьдрах хүч нь Ариун Сүнснээс бөгөөд Бурханы илчлэгдсэн Үгээс ирдэг болой (2Петр 1:4).

Элч биднийг хуучин захирагдаж явсан амин хүсэлдээ жолоодуулсан амьдрал руугаа эргэж уруудахгүй байхыг анхааруулжээ. Бидний няцааж, цовдлох ёстой, хүчирхэг дуршлын нэг нь *амиа хамгаалахуй* юм. Энэ нь хүмүүст таалагдахын

төлөө дүрд орох явдлын буюу товчхондоо хүнээс айх айдсын цаана нуугдагч, үндсэн сэдэл юм. Энэ сэдэл л Петрийг ч, Ананиа, Сапфира, Барнаб тэргүүтэй хүмүүсийг ч - бүгдийг нь шороодуулсан.

Эдгээр дуршилд автаад байвал, бид энэ амьдралдаа юмуу эсвэл ирэх амьдралдаа тун таагүй шүүхээр орохыг Петр анхааруулжээ. Тэгвэл эсрэгээрээ - Бурханы хүсэлд хянамгай анхаарсныхаа төлөө шагнуулах болно. Энэ бүх зааврынхаа дундуур Петр тун хатуу анхааруулга хавчуулжээ: *Бурхан алагчилдаггүй.* Энэ үгийн цаана ямар гашуун түүх оршиж байсныг эргэцүүлцгээе.

Энэ элчид Есүс хүчирхэг үйлчлэл даалгасан. Тэрбээр анхны чуулганы тэргүүн удирдагч нарын нэг байсан боловч, олон жилийн өмнө Антиохт хэсэг Иүдей удирдагч нарын хамтаар амиа хамгаалах урхинд унацгаажээ. Магадгүй Паулын нүд нээсэн, халз үг л тэднийг амин хувийнхаа сэдэл, үйлдлийг чин үнэнээр шалгахад хүргээ байх. Үндсэндээ, Петр хоёр нүүрлэх явдлынхаа цаадах “Яагаад” гэдэг шалтгааныг хуулж гаргасан.

Магадгүй, Петр ийнхүү хуулах явц дундаа Саул хаан, Давид хаан зэрэг Библийн удирдагч нарын алдаатай зан үйлдлийг ч тунгаасан байх. Саул цэргүүдийнхээ тааллыг олох гэсэндээ буюу хүнээс айсандаа тэнгэрийн тов тодорхой тушаалыг хөсөрдүүлсэн. Давид завхайрчихаад, нэр төрөө аврах гэсэндээ буюу хүнээс айсандаа нөгөө хүүхнийхээ эр нөхрийг нь хороолгосон. Хэн хэн нь үнэнд гүйцэгдэж, өөр дээрээ ял авчирсан. Саулын хувьд, хаанчлалаа алдсан. Давидын хувьд, удам угсаа дээр нь хэзээ ч авагдахгүй илд буусан. Хэн хэн нь Бурхан өөрсдийг нь өнгөрөөнө гэдэг урхинд ороод, эрүүл хил хязгаараа даваад, адагтаа бурханлаг бус, дуулгаваргүй зан авир руу далийжээ.

Ийм явдал яах ийхийн зуургүй л өрнөдгийг Петр мэднэ. Тиймээс бидэнд “Би Бурханы төлөө хичээнгүй ажилладаг...”, “Би хаанчлалд ихийг өргөсөн...”, “Би өч төчнөөн жил зуучлан залбирсан...”, “Би энэ чуулганы удирдагчийнхаа хувьд ихийг бүтээсэн...”, “Онцгой эрхт” хүн учраас, Бурхан намайг шүүхээс өнгөрөөнө гэдэг бодлоо таягдаж хаяхыг анхааруулжээ. Ийм хуурмаг бодол нь үй олон хувилбартай байдаг ч, бүгд *Намайг зүгээр өнгөрөөнө* гэсэн дүгнэлтэнд л хүрдэг. Ийм сэтгэлгээ ариун эмээхүйг нандигнадаггүй.

Петр “Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн” (Лук 17:10) гэж ярьсан Есүсийн мэдэгдлийн жинг илүү гүнээ ойлгож эхэлжээ. “Тусгүй” гэдэг нь Грек дээрээ “Ямар нэгэн тусгай магтаал, онцгой сайшаал хүлээхээргүй”¹ гэсэн утга бүхий үг. Бид Бурханд хичнээн хичээнгүй үйлчиллээ гээд, хэзээ ч “Онцгой эрхт” хандлага тээх ёсгүй. Энэ нь хэн хүнгүй - нэн ялангуяа удирдагч нарын амархан ойчоод өгдөг, өөрийгөө дэгээддэг урхи юм.

Петр эдүгээ захидлаа туршлагаар ч, илчлэлээр ч үзэглэж буй. Хүнээс айх айдсын хор тайлагч нь Бурханаас эмээх хүндэтгэл бүхий айдас байдгийг тэрбээр мэднэ. Мөн л гүн хүндэтгэл, эмээхүйг өгүүлж байна. Петр бидэнд Бурханаар таагүй шүүлгэх бус, харин шагнуулах байр сууринд байлгах түлхүүрийг өгчээ.

Тэгэхээр, Есүсийн өгүүлсэн “нарийн хаалга, бэрх замын” сургаалыг яг дээрх утгаар нэвтрүүлж шалгах юм бол, гүйлгээд өнгөрөхийн аргагүй, цочирдом үнэн тодорч байна.

Хавчиг хаалгаар ор. Учир нь сүйрэлд хөтөлдөг хаалга нь уужуу, зам нь өргөн юм. Олонх нь түүгээр тийш ордог. Амь өөд хөтөлдөг хаалга нь хавчиг, зам нь нарийн юм. Цөөнх нь түүнийг олдог. (Матай 7:13-14)

Есүс нарийн хаалгын талаар өгүүлсэн бөгөөд үүнийг нь Есүсийн захиргаагаар дамжин мөнх аминд орох орц гэдэгт дийлэнх хүн итгэдэг. Би ч санал нийлнэ.

Гэтэл “Замыг” нь олон хүн сөнөх тавилантай, итгэдэггүй хүмүүсийн зам гэж итгээд байдгийг нь би олж мэдсэн юм. Тэгвэл анхааралтай үзэх юм бол, Есүс замын талаар үүднээс *өмнө* яриагүй, харин үүдээр нэвтэрсний *дараа* өгүүлж байгааг харж болно. Леон Моррис “Бид эхлээд үүдээр нэвтрээд (Христийг дагахын төлөө бүрэн зориулагдаад), дараа нь өмнө маань зурайх замаар замнадаг”² гэсэн. Есүс бидний авралын дараах, Түүн доторх амьдралын талаар өгүүлжээ. Тэрбээр үүнийг бэрх (буюу нарийн) хэмээв.

Өнөө манай Барууны чуулганд машид алдаршсан нигүүлслийн сэдэв нь мөнөөх замыг ихэд өргөтгөжээ. Тэд “Бидний нүгэл, өнгөрсөн, одоо, ирээдүй - бүгд уучлагдсан” гэдэг. Энэ мэдэгдэл нь зөв агуулга дотроо яригдаж байгаа нөхцөлд үнэн хэдий ч, биднийг

замаа алдсан дэлхийгээс ялгагдах юмгүй, өргөн замаараа амьдарсан атлаа Бурхантай харилцаатай амьдраад байж болох юм шиг л суртчилдаг болжээ. Энэ худлаа юм. Учир нь Петр ингэж өгүүллүүн:

Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл. Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм. (1Петр 1:14-16)

Ариун байдал нь “Ёстой” гэдэг тушаал болохоос биш, “Зүгээр шүү” гэдэг зөвлөмж биш юм. Бурханы тушаалд анхаарах нь ухаалаг явдал бол, хөнгөн хандах нь мунхаглал болой. Цаашилбал, Петр Христ доторх бидний байр суурийн талаар бус, харин үйл хэргийн талаар ярьж байна. Ингэж амьдрахын тулд бид *фообос* (ариун айдас) дотор амьдрах ёстой. Бурхан биднийг нарийн замын хоёр талын суваг шуудууны аль алинаас нь сэргийлсэндээ, хоёр төрлийн их хүчийг өгсөн юм. Эхний шуудуу нь *хуульчлал* бөгөөд удаах нь *хуульгүй явдал* юм.

Тэртээ чуулган доторх олон хүн хуульчлалын шуудуунд унаад байлаа. Тэр үед хүний зохиосон, бичээсийн бус амьдралын хэв маягийг бүслүүрдсэн ариун байдлыг их номнодог байлаа. Үйлсээр л хүрч болох авралын худлаа сайн мэдээг номноно. Энэ нь аймшигтай хүлээс байсан бөгөөд олон хүнийг цөхрөөж, заримыг нь итгэлээ хаяж явахад ч хүргэдэг байлаа. Тэгтэл энэ аймшигтай шуудуунаас биднийг *Бурхан чинь сайн Бурхан* гэдэг амин илчлэл гаргав. Бид Тэнгэрийн Аавынхаа *хайрыг* бодитоор харж, хуульчлалын шуудуунаас аврагдсан юм.

Гэвч хүний зан болсон хойно - бид хуульчлалын шуудуунаас аль болох хол явах гэсэндээ, нөгөө тал руу нь хадуураад, *хуульгүй явдлын шуудуунд* уначихав. Энэ шуудуу биднийг нигүүлслээр аврагдсан учраас, дэлхийгээс ялгаагүй л амьдарч болно гэдэг бичээсийн бус итгэл үнэмшлээр урхидан, бидний дотор орших Христийнхээ хүчээр цовдлогдсон амьдралаар амьдрах бус, харин мэдрэмжнээс ургадаг хүслийнхээ дагуу амьдарч болно гэдэгт итгүүлдэг. Энэ худал тээглэсэн олон хүн Бурханы оршихуй, ерөөл, хүчийг үзэж чаддаггүй.

Ариун байдал нь хүлээс бус, харин ч Бурханыг ч, амьдралыг ч эдлэх, жинхэнэ эрх чөлөө болой. Бид чинь биднийг аварсан Нэгэндээ зохистой амьдрахаар дуудагдсан улс. Үүнийг Эзэнээс эмээхүй дотор алхаж амьдарсан хүн л гүйцэлдүүлж чадах бөгөөд энэ тухай дараагийнхаа хэдэн бүлгээр үзэцгээе.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Тэнд нэгэн тэргүүр зам буй болж, Ариун Зам хэмээн нэрлэгдэнэ. Түүгээр бузар нь үл өнгөрнө, тэр нь Бурханы хүмүүсийнх, Түүгээр алхсан ухаан хомс нь ч үл төөрнө. (Исаиа 35:8)

Санаа: Бурханы хайр биднийг хуульлалын шуудуунаас хамгаалах. Мөн Эзэнээс эмээхүй нь биднийг хуульгүй явдлын шуудуунаас хамгаалах. Ариун эмээхүй нь биднийг жинхэнэ ариун байдлын хурдны зам дээрээ үлдэх хүчийг өгнө.

Эргэцүүлэл: Би ямар байдлаар ариун эмээхүйг үл хайхарч, бурханлаг бус зан авирыг амьдралдаа зөвшөөрдөг вэ? Хаанчлалд эзлэх албан үүрэг маань “Бурхантайгаа адил ариун бай” гэдэг тушаалыг үл хайхрахад хүргэж байна уу? Тийм бол, ямар арга байдлаар? “Онцгой эрхтэй” гэдэг ойлголт ямар арга байдлаар намайг алдаанд хүргэж, хуульгүй явдлын шуудуунд унагав?

Залбирал: Эзэн минь ээ, Таны хаанчлалд үйлчилдэг учраас, шүүхээс мултарна гэж санасныг минь уучлаарай. Энэ явдлаа гэмшиж, Таны адил ариун байх тушаалыг тань дагаж байна. Намайг гэх Таны хайрыг ч, Танаас эмээх ариун эмээхүйг ч тээж амьдаруу. Энэ тохиолдолд би амь руу хөтлөх замаасаа гарахгүйг Таны Үг амласан. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Бурхантайгаа адил ариун байхыг сонгож байна!

*Хүүхдүүд ээ, Бурханаас эмээ;
өөрөөр хэлбэл адын зүйлээс
зайлсхийж явахын төлөө оюун
санаандаа ариун эмээхүйг тээж,
сайныг тэвэрч, үйлдэх чанд
баримтлалтай байх.*

— Уиллиам Пенн

17 | ЁРЫН МУУГААС ЗАЙЛ

Эзэнээс эмээхүй нь биднийг Есүсээс холдохоос минь хамгаалагч, тэнгэрийн Аавын минь бэлэг буюу. Есүс - мөнхийн амь, хайр, баяр, амгалан, сайн, найдварын болоод хамаг л гайхамшгийн Эх булаг болой. Түүнээс холдох нь үхэл, харанхуй тэгээд мөнхийн булш руугаа явахтай л адил. “Энэрэл хайр ба үнэнээр хилэнц цагаадна. ЭЗЭНээс эмээвээс ёр муугаас зайлна” (Сургаалт үгс 16:6).

Энэ үнэнийг амьдрал дээр бодитоор үзсэн түүхээ хуваалцъя. 1980-аад оны сүүлээр телевизээр сайнмэдээ дэлгэрүүлдэг нэгэн нэрт хүний завхрал олон нийтэд ил болсон юм. Тэрбээр дэлхий даяар алдаршсан боловч, харамсалтай нь буруу шалтгаанаар тэр. Тухайн үед түүний үйлчлэл цар хүрээгээрээ ч, санхүүгийн хүчин чадлаараа ч дэлхий дээр хамгийн том нь байсан хэдий ч, хэвлэл мэдээллийн томоохон газрууд тэр хүний цуврал гэмт хэрэг, дагалдах шүүх, эцэстээ шоронд хоригдсон түүхийг нь тасралтгүй нэвтрүүлснээр, тэр хүн утгаараа дэлхий даяар алдаршсан билээ.

Тэрбээр анх дөчин таван жил хоригдох ял авсан ч, давж заалдсанаар таван жил болтол бууруулж чадсан юм. Тэрбээр хорионыхоо дөрөв дэхь жилд буюу 1994 онд туслахтай маань холбогдов. Тэр эрхэм намайг танихгүй ч, хэн нэгэн хүн түүнд миний бичсэн *Цөл дэхь ялалт* (буюу эдүгээ *Бурхан минь, Та хаана байна?!* нэртэй болсон) номыг маань бэлэглэсэн юм санж. Тэгээд шоронд уншаад, сэтгэлд нь ихэд хүрчээ. Тиймээс туслахаараа дамжуулан, намайг шоронд ирж уулзаж болох эсэхийг асуулгасан байв.

Би ч очсон бөгөөд тэр уулзалтыг хэзээ ч мартахгүй. Хоригдлын хувцастай нөгөө хүн уулзалтын өрөөнд орж ирэв. Над руу дөхөж ирээд, гараа сунгаад, бараг минутын турш намайг ихэд дотночлон

Бурханаас эмээхүй

тэвэрлээ. Тэгээд мөрнөөс маань атган, нулимс цийлэгнэсэн нүдээр ширтгээд: “Та өөрөө бичсэн үү эсвэл хүнээр бичүүлсэн үү?” гэж асуув.

Би ч “Би өөрөө бичсэн. Амьдралдаа үзсэн зовлон дээрээ тулгуурлаж бичсэн. Гэхдээ таны үзсэн зовлонгийн дэргэд юу ч биш л дээ” л гэлээ.

Тэгтэл тэрбээр “Маш олон зүйл ярьмаар байна. Гэтэл дөнгөж цаг гучин минут л байна” гэв.

Би тэр хүнтэй анх удаагаа л уулзаж байсан тул яльгүй тэвдэж байлаа. Тэр хүний талаар хамгийн адгийн юмсыг л сонсож явснаас биш, чухам хэнтэй ярилцаж байгаагаа үнэндээ мэдэхгүй байв. Гэхдээ биднийг тухлах үед тэрбээр эхнийхээ үгээр л миний бамбай шийдмийг хаяулсан юм. Тэрбээр нүд рүү минь ширтэж байгаад: “Жон, энэ шорон Бурханы надад өгсөн шийтгэл биш, харин өршөөл. Би хуучин замаараа яваад байсан бол, мөнхийн тамд л унаж дуусах байсан” гэж хэлэв.

Би ч түүн рүү байдгаараа анхаарлаа. Тэр хүн ч өөрийгөө ямар адгийн амьтан байсныг, Бурханы энэ чөлөөлөлт ямар аугаа байсныг үргэлжлүүлэн хүүрнэв. Төд удалгүй би нухлагдсан, гэмшсэн, чин үнэн Бурханы хүнтэй ярилцаж байгаагаа мэдэв. Тэрбээр цааш нь хорионх нь эхний жилд Бурхан түүнийг харанхуйгаас чөлөөлсөн тухай ярьсан юм.

Тэгээд өдөр бүр ганцаараа ч, бүлгээрээ ч олон цагаар Библи уншиж, залбирч байгаагаа ч ярив. Тэрбээр шоронгийнхоо чуулганы талаар бас пасторынхаа тухай баяртайгаар өгүүлсэн бөгөөд пастор нь мөн л ялаа эдэлж байгаа хүн байлаа. Би түүнийг өөрийг нь пастор байхад арай тохиромжтой байх гэж санаад, яагаад пастораар үйлчлэхгүй байгааг нь асуулаа. Гэтэл тэрбээр бүрэн гүйцэт өөрчлөгдөх хүртлээ ямар нэгэн удирдах ажил хийхгүйгээ учирласан юм. “Жон, би мастер - манипулятор байсан... тэр зангаа дахиж амилуулахгүй” гэж билээ.

Тэр эрхэм жилийн дараа шоронгоос суллагдаж, Лос Анжелесийн төвд байдаг, нэгэн илгээлтийн байгууллагад ажилд орохдоо, хэлсэн үгээ баталсан юм. Тэгээд хоёр жилийн турш зүгээр л гудамжинд орон гэргүй хүмүүсийг асран халамжилж билээ. Гудамжны хүмүүс энэ улсад түүнийг хэн болохыг нь огт мэдэхгүй, цөөхөн хүмүүсийн нэг байсан болохоор, тэрбээр өөрөө ч энэ ажилдаа хайртай байв.

Түүний яриаг хориод минут сонссоныхоо дараа би биеэ барихаа больж, асуулт ч тавих зориг оров. Тэгээд хүний санаанд орж болох хамгийн л том асуултыг гаргаж тавьсан юм: “Та яг хэзээ Есүст хайргүй болчихсон юм бэ?”

Үйлчлэлээ эхлүүлж байхад нь тэр хүнээс Есүсийг хайрлах хайр цацардаг байсан болохоор л ингэж асуусан учиртай. Тэр хүний гал халуун сэтгэл хэнд ч бэлээхэн харагддаг байж билээ. Гиймээс тэр их хайр хэзээд нь царцаад, ийм байдалд хүргэснийг мэдмээр байв.

Тэгтэл нөгөө хүн миний нүд рүү харж байгаад: “Би Есүст хэзээ ч хайргүй болоогүй!” хэмээн үнэн голоосоо хэлсэн юм.

Би ч энэ үгэнд нь цочирдоод, бүр: “*Яаж ингэж хэлж зүрхэлнэ вэ?*” хэмээн уур ч хүрэх шиг болов. Гиймээс өөдөөс нь шууд л: “Та чинь юу ярина вэ? Та хуурамч захидлын хэргээр энд хоригдохоосоо долоон жилийн өмнө завхайрсан. Тэгээд тэр долоон жилийн хугацаанд та Есүсийг хайрласаар байсан болж таарч байна уу?” гэж ирээд л галлалаа.

Тэгтэл тэр хүн нүд рүү минь харсан чигээрээ: “Жон, би Есүст дандаа хайртай байсан” хэмээн ихэд тайван хэлсэн юм.

Миний цухалдал илт байсан биз. Тэрбээр хэсэг чимээгүй болсноо: “Жон, би Бурханаас эмээдэггүй байсан юм” гэж хэлэв. Тэгээд дахиад амьсгаа авснаа: “Жон, би Есүст хайртай байсан. Гэхдээ Түүнээс эмээдэггүй байсан юм” хэмээн санаагаа бүтнээр нь хэлсэн юм.

Би ч нам болов. Үнэндээ түүний үгийг бишрэв. Өрөөнд арван таван секундын турш нам гүм тогтох хооронд би түүний үгийн ухааныг боловсруулж байлаа. Тэр хүний хэлсэн үг одоо ч миний судсаар гүйдэг юм даа: “Жон, цаана чинь надтай ижил Есүст хайртай атлаа Бурханаас эмээдэггүй сая сая Америкчууд бий!”

Яг л тэр хүний амаар Бурхан Өөрөө айлдах шиг болж билээ. Тэр мэдэгдэл олон асуултыг тагласан юм. Ухаан минь киноны хальс шиг л жирэлзэн гүйж, манай улсын хүмүүс бөөн бөөнөөрөө итгэлээсээ няцаж байгаагийн үндсийг энэ хүний түүх - үгээр дүрслээд өгсөн нь хамгийн том “Оллоо!” болов. Хамгийн харамсалтай нь, тэр цагаас хойш итгэлээсээ няцах үзэгдэл улам л нэмэгдсэн дээ.

Бурханыг дотно таньж мэдэхийн эхлэл нь Эзэнээс эмээхүй болохыг Бичээс тодорхой хэлдэг. Эзэнээс эмээхүй үгүй бол, бид

алдрын Эзэн биш, хулхи Есүстэй хуурамч харилцаа хөгжүүлнэ. Бид бодит бус аврагчид итгэнэ. Энэ талаар номынхоо дараа дараагийн бүлгээр дэлгэрэнгүй өгүүлнэ. Гэхдээ урьдаар товч хоёр жишээгээр нотолмоор байна.

Би яг энэ долоо хоногт хүүхэд ахуйгаас нь мэддэг байсан нэгэн залуу бүсгүйн талаар горьгүй мэдээ сонслоо. Тэрбээр итгэл дотор хүмүүжиж, Есүсийг дагадаг гэгддэг байсан ч, эрэгтэй найзуудынхаа дунд “Хялбархан” гэдэг нэр зүүтлээ задгай амьдарчээ. Тэрбээр саяхан Инстаграм дээрээ “Үр хөндүүлж байх хооронд нь Есүс түүний гарыг атгаж байсан” гэсэн пост тавьсан юм. Тэр ямар Есүсийг яриад байна?

Мөн нэгэн бурханлаг залуутай гэрлэсэн өөр нэгэн залуу бүсгүй улаан нүүр рүү минь харж байснаа “Нөхрөөсөө салах юм бол, Есүс намайг халамжилна гэж амласан” хэмээн пал хийтэл хэлж билээ. Тэгээд салаад, нөхөр, үр хүүхэд, гэр бүл, найз нөхдөө тун хэцүү байдалд оруулсан юм. Салах шалтгаан нь ч сүйдтэй юм биш. Зүгээр л нөхөртөө хайргүй болсон гэнэ. Ямар ч хүчирхийлэл, ёс бус явдал, санхүүгийн асуудал байхгүй, харин ч эр нөхөр нь хайр халамжаар бөмбөрүүлдэг нөхөр, аав гэдгийг өөрөө надад хэлж билээ. Тэгэхээр, тэр эмэгтэй ямар Есүсийг яриад байна?

Есүстэй харилцаатай гэдэг ч, тэс өөрөөр амьдардаг хүмүүсийн үй олон жишээний хоёр нь л энэ. Энэ хоёр бүсгүй тэргүүтэй тэр олон хүн ер нь яаж яваад ингэтлээ мунхардаг байна? Ариун эмээхүй дутагдсанаас л тэр гэж би итгэдэг.

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ.
(Филиппой 2:12)

Паул бидэнд хайр, эелдэг байдлаар аврал дотроо төлөвших ёстой гэж бичээгүй. Дээрх хоёр эмэгтэй хайраар дүүрэн, эелдэг зөөлөн болохыг хэн чиг л батална. Чуулганд тогтмол явсныг нь, Есүст үнэнчийг нь ч батална. Гэтэл яаж яваад ийм хуульгүй явдалд толгойгоо зоочихдог байна? Нөгөө алдарт сайнмэдээ дэлгэрүүлэгчид дутагдсан зүйл тэдэнд ч мөн дутагджээ. Бид ёрын

муугаас Бурханы хайраар бус, харин Эзэнээс эмээхүйгээр л зайлдаг юм. Бурханы хайр биднийг Бурхан руу ойртуулдаг бол, Бурханаас эмээхүй нь биднийг сүйрүүлэх зорилготой, ёрын муугаас сахин хамгаалдаг билээ.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ЭЗЭНээс эмээхүй нь ёрын мууг үзэн ядах явдал юм. Бардамнал, ихэмсэг зан, ёрын муу зам хийгээд гажсан амыг би жигшдэг. (Сургаалт үгс 8:13)

Санаа: Эзэнээс эмээхүй нь тэнгэрийн Аавын маань өгсөн, биднийг Түүнээс хөндийрөхөөс сахин хамгаалагч бэлэг юм. Бид нүглийг жигших бус, зөвшөөрөөд ирэхээрээ л Бурханаас хөндийрч эхэлдэг.

Эргэцүүлэл: Хүн гэрлэлтийн гэрээгүй хүнтэйгээ нэг оронд орохдоо л итгэлээсээ няцдаг юм биш. Хүн ажил олгогчоосоо мөнгө завшиж эхлэхдээ л итгэлээсээ няцаж эхэлдэг юм биш. Харин бүр өмнөөс буюу Есүсийн амиа өгөн байж, биднийг чөлөөлсөн тэр нүгэлд хүлцэнгүй хандаж эхэлсэн цагаасаа л итгэлээсээ няцаж эхэлдэг юм. Есүс намайг ямар нүглээс амиа өгөн байж чөлөөлсөн бэ?

Залбирал: Эзэнтэн минь, өөрийнхөө төдийгүй, итгэл нэгт хүмүүсийнхээ амьдралд байгаа нүглийг хүлээн зөвшөөрсөнд уучлаач. Тэднийг буруу замаас нь гаргахын төлөө хайрын, өр зөөлөн сэтгэлээр нүүрэлдэлгүй, амаа үдэж явсныг минь уучлаач. Би хүлцэнгүй байдлаа улайж байна. Намайг уучилсанд баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Бурхан хүмүүст хайртай учраас, би ч хүмүүсийг хайрлана. Гэхдээ хайрлаж байгаа хүмүүсийг минь сөнөөгч нүглийг үзэн ядна.

Миний алхмууд

Таны замуудад бат холбогдсон.

Хөл минь эс халтирсан.

— Дуулал 17:5

18 | МӨНХӨД ТОГТОХ

1994 онд, нөгөө миний Бурханаас эмээх талаар заасан номлолыг засварласан бас шоронд сайнмэдээ тараагч хүнийг эргэсэн хоёр содон үйл явдлын дараа би ариун айдсыг улам л ухамсарлаж, үүн дотор өсөх гал хүсэл маань улам л бадрав. Эдгээр нь нэг л мессежийг хоёр ондоо талаас харуулсан үйл явдал юм.

Бүс нутагтаа хамгийн л нэр нөлөөтэй, том байсан мөнөөх чуулган эдүгээ байхгүй болсон. Шинэ Гэрээний итгэгчид Бурханаас айж эмээх хэрэггүй гэж зааж байсан тэр пастор эдүгээ үйлчлэхээ больсон. Шоронд уулзсан үйлчлэгч нүсэр үйлчлэлээ алдсан боловч, ариун эмээхүйг олж аван, мөшгих болсноороо, Бурханд болоод хүмүүст итгэмжтэйгээр үйлчлэх зам дээрээ үлдсэн билээ. Эдүгээ тэрбээр олны төлөө өөр нэгэн үйлчлэлийн байгууллагад ажиллаж яваа.

Дээрх уялдаагүй хоёр тохиолдол нь Эзэнээс эмээхүй нь биднийг Христийн үр нөлөөтэй элч төлөөлөгч нар байх үүрэг даалгаврыг маань хорогдуулах, урхидагч ёрын муугаас зайлан зугтахад амин чухал болохыг харуулж байна. Үүнийг бид *мөнхөд тогтох* гэдэг. Саяхан нэгэн нэр хүндтэй пастор - хүн Бичээс дээр Бурханаар дуудагдаж, томилогдсон хувь хүмүүсийг дэлгэрэнгүй судласан нэгэн Библийн сургуулийн профессортой хийсэн ярилцлагынхаа талаар надад өгүүлэв. Тэгтэл сонгогдсон хүмүүсийн 75 хувь нь үр нөлөөгөө хугасалж, олонх нь амьдралаа сайн дуусгаагүй ажээ. Тэр судалгааг өнөө цагийн эмгэнэлт үйл явдалтай хавсрах юм бол, *мөнхөд тогтох* гэдэг ойлголт нь нухацтай авч үзэх шаардлагатай уриалан дуудлага болж байна.

Уртын үйлчлэлд ариун эмээхүй ямар чухал болохыг 1990-ээд оны адгаар тохиолдсон өөр нэгэн томоохон үйл явдал, үүнээс ургасан илчлэл батална. Би Малайзын Куала Лумпурт үйлчилж байлаа.

Миний арав дахь буюу сүүлийн цуглаан байсан бөгөөд танхим тус улсын өнцөг булан бүрээс ирсэн итгэгч нараар пиг дүүрсэн байлаа. Номнолын төгсгөл дээрх үйлчлэлд бүрэн зориулагдах дуудлагад ч олон хүн хариу өгөв. Өргөн тайзны өмнүүр дөрөв таван эгнээ болон давхралдсан олон залбируулахаар багшралдаж байлаа.

Намайг тайзны шатнаас эхлэв үү гүй юу, Бурханы оршихуй юу юугүй маш тодорхой, биет дүрээрээ танхимыг эзэгнэв. Бурханы тэр оршихуй хайр, баяр хөөрөөр онцгойрч байлаа. Өмнүүр минь жагссан хүмүүс мишээж эхэлснээ, дараа нь хөхрөлдөөд, яваандаа урагшаа гарч ирсэн бүх хүнд тархав. Абба - Бурхан Аав маань үр хүүхдээ сэргээхийг хүсч дээ гэмээр л байлаа. Би ч юу ч хийх шаардлагагүйгээ ойлгоод, Бурхан хүүхдүүдээ яаж бэхжүүлж, ерөөж байгааг нь тайзны захаас бахдан харж суув.

Ийнхүү таваас долоон минут үргэлжилсний дараа Бурханы үзэсгэлэнт оршихуй өргөгдөн, уур амьсгалыг нам гүм эзлэв. Бид ч танхимд залрах амар амгаланд чимээгүй мэхийлээ. Тэгтэл нөхцөл эргэж, Бурханы оршихуй тэс өөр чанараар буюу миний нөгөө Бразильд үзэнтэй яг ижлээр илэрхийлэгдэв. Би ч өөрчлөлтийг тосон, босч зогслоо. Оршихуй улам хүчирхэгжсээр, энэ удаа салхи исгэрээгүй боловч, Бурханы эрх мэдэл, аюуж бишрэм чанар андуурахын аргагүй бодитой байв. Дөнгөж сая хөхрөлдөж байсан улс ямар ч заавар үг хүлээж аваагүй атлаа нэгэн зэрэг шахуу нир хийтэл уйлж эхэлсэн бөгөөд зарим нь бүр эхэр татуулав.

Оршихуй ч улам бэхэжсээр, хүмүүсийн уйлаан ч эрчижсээр байлаа. Үг дуу цөөтэй тэдгээр Ази хүмүүс Бурханы гал дотор баптисм хүртэв үү гэлтэй л байв. Тэр илрэлийг дүрслэх боломжгүйг би дахин хэлье. Энэ ариун үйл явдлыг хуваалцсаны минь зорилго ч энэ биш. Хамгийн чухал нь Бурханы оршихуйн гайхамшиг юм. Тэр оршихуй зузаарсаар зузаарсаар, сүүлдээ бид ч тэсэхгүйдээ тулав.

Энэ үйл явдлаар би хүн - бидний сэтгэл, сүнсний ялгааг тун тодорхой ухаарч билээ. Библи дээр Бурханы Үг “Сэтгэл, сүнсийг салгадаг” (Еврей 4:12) гэдэг. Миний оюун (сэтгэл) *Би цаашид тэсэхгүй нь! Бурхан минь, арай л хэтэрлээ!* гэж байсан бол, зүрх (сүнс) минь *Бурхан минь ээ, битгий яваач. битгий зогсооч!* гэж хашхирч байсан юм.

Надад дахиад л *Жон Бивэр, чи ганц л буруу хөдлөх юм бол, ганц*

л буруу үг хэлэх юм бол, үхнэ шүү гэсэн бодол төрж байлаа. Гэхдээ мөн л Бразилд байсан шигээ яг үхэх байсан эсэхийг мэдэхгүй ч, ямартаа ч ийм уур амьсгал дунд хүндэтгэлгүй авир гаргах нь зүгээр өнгөрүүлэшгүй үйл явдал болох байсныг л мэдэж байлаа.

Бурханы гайхамшигт оршихуй гурваас дөрвөн минут илэрхийлэгдээд, дээш өргөгдөв. Үүний дараа хэн ч, юу ч хэлээгүй байтал, хүмүүс үг дуугүй нэгэн хүн мэт нэгдсэн байлаа. Миний бие Бурханы оршихуйн үлдээгээд одсон амар амгалан, тайвшрал дунд дахиад хэдэн минут чимээгүй зогсов.

Биднийг тарах үед ч хүндэтгэл төрүүлэм, ёслол төгөлдөр, нам гүм тогтсон хэвээрээ л байлаа. Би Энэтхэгээс ирсэн гэр бүлийн хоёртой уулзахаар зогсов. Тэдний хэн, хэн нь Бурханы оршихуйг гүнээ мэдэрчээ. Бид гурав ч айж гайхсан байдлаасаа гарч чадахгүй, хэсэг бие биенээ чимээгүй харж зогстол, гэргий нь “Жон, миний дотор цэв цэвэрхэн болчихлоо” хэмээн намуухнаар хэлэв. Нөхөр нь ч чимээгүй л толгой дохилоо.

Тэр эмэгтэйг ингэж хэлэхэд нь миний зүрх уйлсан юм. Миний өмнө Бразилд, эдүгээ Малайзид тээж хоцорсон мэдрэмжийг тэр бүсгүй яг оноод хэлчихэв. Би ч түүнд “Миний ч бас” хэмээн биеэ барин хариулав. Бид цааш юм ярьж чадаагүй боловч, тэр бүсгүйн үг оройжин миний дотор цуурайтсан юм.

Маргааш өглөө нь тэр чуулганы хэд хэдэн ажилчин, Библийн сургуулийн залуустай сагс тоглохоор зочид буудлынхаа өрөөнд хүлээж байтал, Ариун Сүнс зүрхэнд минь “Хүү минь, Дуулал 19-ийг унш” хэмээн айлдав.

Би Библиэ барьж аваад, тухайн хэсгийг гаргаад, уншиж эхэллээ. Тэгээд 9-ээр эшлэлд хүрлээ:

ЭЗЭНээс эмээхүй нь цэвэр, мөнхөд оршдог. (Дуулал 19:9)

Би ч өрөөгөөрөө нэг: “Тийм байна! Тийм байна!” хэмээн хашхирч гарлаа. Өчигдөр орой тэр эмэгтэй яг л үүнийг хэлж шүү. Би мэл гайхав. Яг л ийм дүрслэхийн аргагүй цэвэр байдал, гүн гүнзгий ариун чанарыг бид сэтгэлдээ мэдэрсэн.

Тэгтэл “мөнхөд оршино” гэдэг үг хуудсаасаа ховхроод гараад ирэв. Ариун Сүнс ч зүрхэнд минь тэр даруй:

“Хүү минь, Люцифер тослогдсон учир, чухам Миний сэнтийн өмнө магтаж, тэнгэрийн даяар оршигсдыг удирддаг байв. Тэр надтай ойр байж, Миний алдрыг үзсэн ч, Надаас үл эмээж явсан учир, Миний сэнтийн өмнө мөнхөд тогтоогүй юм” (Езекиел 28:13-17).

Тэнгэрийн элч нарын гуравны нэг нь Миний алдрыг үзсэн ч, Люцифертэй нийлсэн. Тэд Надаас айгаагүй, Миний оршихуйд ч тэсээгүй (Илчлэл 12:4,7).

Адам, Ева хоёр оройн сэрүүнд Миний алдрын оршихуй дотор алхалдаг байсан. Тэд надаас эмээгээгүй, тэд Едений цэцэрлэгт ч удаагүй.

Хүү минь, Миний сэнтийг тойрон хүрээлэх бүтээл болгон Эзэнээс эмээхүйн ариун шалгуурыг даван гарсан байх болно” (Эхлэл 3:8) хэмээн айлдав.

Энэ үнэн нүдийг минь онгойлгов. Үйлчлэлийнх нь үр нөлөө тас үсэрсэн юмуу амьдралаа сайн төгсгөж чадаагүй пасторууд санаанд орлоо. Олонх нь их л бадрангуй эхэлж, Есүст ч хайртай, Бурханы хүмүүст ч золиос гарган, дуулгавартай үйлчилж байснаа, яваандаа залхан, увайгүй загнаж, бөөн бөөнөөрөө үйлчлэлээ хаядаг. Тэд тэсвэрлээгүй.

Зарим нь үйлчлэл дээрээ үлдсэн хэдий ч, үүнийгээ ашиг тэргүүтэй амин хувийн зорилгоор л хийх болжээ. Зарим нэг нь сексийн донд автаж, удирдах байр сууриараа далайлган, гэм зэмгүй эмэгтэйчүүдийг идшээ болгодог бол, зарим нь дагагч нараасаа ихээхэн хэмжээний өргөл салгахын тулд элдэв янзаар дарамтлах хорон аргыг үйлчлэгч нарт зааж өгдөг ухуулагч, зөвлөх болцгоодог бол, зарим нь үйлчилж байх ёстой хувь хүмүүсээсээ мэдээлэл олзолчихоод, эргүүлээд үүнийгээ Бурханы илчлэл, зөн үг мэтээр залилан хийдэг. Энэ маягийн завхарсан үйлдлийн бүртгэл нь эцэсгүй хөвөрнө.

Яаж яваад цэвэр тунгалгаар эхэлж байсан тэдгээр хүмүүс ингэтлээ завхрав? Яагаад үр нөлөөлөл нь мөнхөд тогтсонгүй вэ? Хамаг учир нь ариун эмээхүй байхгүйд л бий. Есүсийн таашаадаг юмсыг үл ойшоох юмуу тэр бүү хэл дургүйцэх. Яг л Америкийн зүүн өмнөд нутгийн нөгөө пастортай адил. Бурханы “Нарийлан нандигнадаг” зүйлст өөрийгөө ч, өрөөлийг ч багтаадаггүй. Тэгвэл Бурхан ариун айдас, мөнхөд тогтохын талаар юу өгүүлснийг сонсоно уу:

ЭЗЭНийг магтагун! ЭЗЭНээс эмээдэг, Тушаалуудад нь ихэд баярладаг хүн Юутай ерөөлтэй! ...Гэрт нь хөрөнгө баялгууд байна. Зөвт байдал нь мөнхөд тогтоно. ...Тэрээр хэзээ ч ганхахгүй. Зөвт хүн мөнхөд дурсагдах болно. (Дуулал 112:1, 3, 6)

Заавал зовлон үзэж байж ариун айдсыг ойлгох шаардлага үгүй. Бурханы алдар, өөрийнхөө өнө мөнхийн төлөө ариун айдсыг нандигнаж яваарай.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Харин ЭЗЭНий хайр энэрэл Түүнээс эмээгчдийн дээр мөнхөөс мөнхөд болоод Түүний зөвт байдал хөвгүүдийн хөвгүүдэд байна. (Дуулал 103:17)

Санаа: Бурханаас эмээдэг бүтээлүүд л өнө мөнхөд Бурханы сэнтийг хүрээлнэ.

Эргэцүүлэл: Сайн сайхан амьдралын нэг хэсэг нь сайн төгсгөл юм. Эзэнээс эмээхүй нь мөнхөд тогтох. Яаж ариун эмээхүйг амьдралдаа гагнах вэ? Амьдрал дээр ямар бодитой арга замаар хэлэх үг, хийх үйлдлээ ариун эмээхүйгээр шүүж нэвтрүүлж байх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны үг намайг алдагдахаас сахин хамгаалж, Таны жавхлантай оршихуй руу ширхэг ч алдаа мадаггүй, баяр хөөртэйгээр оруулна гэж хэлсэн. Энэ мөнхийн харилцааг Эзэн Есүсийн маань авралын үйлс, дээрээс нь ариун айдас л баталгаажуулдаг. Таны ариун айдас миний дотор лав сууж, би Таны оршихуйд мөнхөд амьдрах болтугай. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би Эзэний өргөө - Түүний оршихуйд мөнхөд ариунаар эмээж амьдарна.

*Аав тань ариун, ариун, ариун гэдэгт
эс баясах аваас, та сүнсээр үхжээ.
Чуулгандаа явсаар байгаа байж болно.
Христэч сургуульд ч сурдаг байж
болно. Гэхдээ Бурханы ариун чанарт
сэтгэл чинь эс баясах аваас,
та Бурханыг үл мэдэх, Бурханыг үл
хайрлах ажээ. Бурхан, та хоёрын
харилцаа тасарч, та Бурханы зан
чанарт нойрсжээ.*

— Ар. Си. Спроул

19 | ӨӨРСДИЙГӨӨ ЦЭВЭРЛЭХ

ЭЗЭНээс эмээхүй нь *цэвэр, мөнхөд* оршдог (Дуулал 19:9). Магтаалч ариун эмээхүйн хөнгөн хуумгай хандаж, үл ойшоож болохгүй хоёр үр жимсийг тоочжээ: *Цэвэр* бөгөөд *мөнхөд* тогтох чанар. Тэгэхээр, эхлээд цэвэр чанарыг авч үзээд, хоёрдугаар чанарыг нь хожим авч үзье. Паул ингэж бичжээ:

Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохирос *цэвэрлэе*. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё. (2Коринт 7:1)

Паул энд магтаалчтай адил үнэнийг хэлсэн боловч, арай дэлгэрүүлжээ. Тэгэхээр, юуны түрүүнд ариун байдал нь Бурханы хайраар бус, харин Эзэнээс эмээхүйгээр дамжиж байж л өсч боловсордгийг цохон тэмдэглэмээр байна. Есүсийг хайрласаар байх атлаа бурханлаг бусаар амьдарсан сайнмэдээ дэлгэрүүлэгчийг санаарай. Тэрбээр ариун эмээхүйг ойлгосон хойноо л өөрийгөө цэвэрлэж, урьдын булай бузар явдлаасаа чөлөөтэй амьдрах болжээ. Үүнийхээ ч ачаар Есүстэй урьд урьдынхаасаа хавь илүү дотносон, жинхэнэ харилцаа тогтоосон байна. Түүний амьдралаараа сурсан зүйл Бичээс дээр ч бий.

Өнөө цагт ариун амьдрал нь онц сонирхолтой сэдэв биш болохыг өмнө хэлсэн. Энэ нь олон хүний хувьд ямар ч зугаа цэнгээгүй, амьдралд тушаа болсон, амтгүй эд. Үүнийг нэг бол хуульчлалын хүлээс мэт, нөгөө бол хүрэшгүй, хийсвэр чанарт тооцох. Хүмүүсийн үл ойшоох энэ зангийн талаар Си. Эс. Люис “Ариун чанарыг утгагүй хэмээн үздэг хүмүүс юуг ч үл мэдэх хүмүүс ажээ. Гэхдээ

үүнийг бодитоор үзсэн хүн... зүгээр л хөл алдана”¹ хэмээн бичсэн юм. Тиймээс цаашлах тусмаа, хөл алдахад бэлэн байгаарай.

Ариун байдлыг үндсэндээ “Бурхан руу тусгаарлагдахуй” хэмээн тодорхойлдог бөгөөд үүнд мэдээж цэвэр чанар ч багтахыг өмнө хэлсэн. Тухайлах юм бол, сүйт бүсгүйг аваад үзье. Тэрбээр өөрийгөө эр нөхөртөө зориулан тусгаарладаг бөгөөд өөр эрстэй холбоо сүлбээ тогтоох хүслийг цээрлэнэ. Энэ нь ариун байдлын цэвэр чанарыг төлөөлөн харуулж байна. Тийм боловч, өөрсдийгөө цэвэрлэхийг Паул бидэнд заажээ. Тэрбээр “Есүсийн цус биднийг цэвэрлэхинэ” гэж хэлээгүй. Тэгэхдээ, нэгэн зүйлийг тодруулмаар байна: Есүсийн цус үнэхээр биднийг бүхий л нүглээс цэвэрлэдэг. Гэхдээ бид *зөвтгөлийн* үйлсийг *ариусгалын* үйлстэй хольж хутгаад ирэхээрээ л самуурч дуусдаг.

Биднийг гэмээ гэмшиж, Есүс Христийг Эзэнээ болгон хүлээж авах үед нүгэл маань уучлагдсан бөгөөд бид ч цэвийн цэвэр болон угаагдсан. Бурхан ч бидний нүглийг умартлын далайдаа булшилсан. Тэгээд дахиж санахгүй! Энэ үйлс бүрэн төгс гүйцэлдсэн бөгөөд дахиж сөхөгдөхгүй. Бурханаас бэлэг болгож үйлдсэн, энэхүү гайхамшигт үнэнийг бид яаж ч өөрчлөхгүй. Энэ бол *зөвтгөлийн* үйлс.

Гэхдээ зөвтгөлийг хүлээж авсан даруйд *ариусгалын* (ариун байдлын) үйлс эхэлсэн буюу. Энэ нь бидэн дотор үйлдэгдсэн зүйл *гаднаа гүйцэлдэж*, шинэ мөн чанар маань бидний амьдарч буй арга байдлаар гаднаа гүйцэлдэх явдал юм. Чухам энэ л талаар Паул:

...өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр *гүйцээ* (*гүйцэлдүүл*). Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын *хүсэх, ажиллахын* аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм (Филиппой 2:12-13) хэмээн бичжээ.

Тэгэхээр, үүний цаана нөгөө л Бурханы нигүүлсэл ажиллаж байгаа хэдий ч, бидний талаас хүсэх бөгөөд үйлдэх хүчээр хангадаг Бурханы хүчтэй гар нийлж ажиллах ёстой ажээ. Айдас, чичрэхүйт нь Бразилчуудыг Бурханы оршихуйд нэвтэрч, Түүгээр ерөөгдөх бэлэн байдалд хүргэсэн шигээ биднийг ч дуулгавартай байхын төлөө Бурханы нигүүлслээр хүчжих байр сууринд гаргана.

Ариусгах үйлс, зөвтгөлийн үйлсийг нэг л ижил зүйл мэтээр заадаг нь Барууны чуулганы багш нарын гаргадаг түгээмэл алдаа юм. Өөрөөр

хэлбэл, бид юу ч хийх шаардлагагүй, Есүс бүгдийг хийгээд өгсөн гэнэ. Тэгвэл, бид зүсэн зүйлийн тачаалдаа автан, энэ дэлхийгээс дээрдэх юмгүй амьдарсан ч, Есүс бидний ариун байдал учраас, бид ариунаараа л байх нь гэсэн аргумент үүснэ. Дээрээс нь тэдний мэдэгдлийг дэмжээд байх шиг харагддаг бичээс Шинэ гэрээнд үнэхээр байдаг нь байдлыг бүр адармаатай болгодог. Гэвч энэ алдаа нь тэд *байр суурийн* ариун байдлыг, *зан авирын* ариун байдалтай хольж хутгаад байгаагаас л бий болоод байгаа хэрэг. Тайлбарлахыг минь болгооно уу.

Байр суурийн ариун байдал гэдэг нь цэвэр бидний төлөөх Есүсийн үйлсийн гавъяа; бидний Христ доторх байр суурийн асуудал; Христийн зөвтгөлийн үйлсийн нэгэн ерөөл мөн: “Түүний өмнө биднийг хайр дор *ариун* бөгөөд гэм зэмгүй *байхын* төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм” (Ефес 1:4). Бид өөрийнхөө хүчээр энэ байр сууринд хэзээ ч хүрэхгүй байх байсан. Паул мөн: “Түүний үйлдсэнээр та нар Христ Есүс дотор байгаа бөгөөд Тэрээр бидэнд Бурханаас ирсэн мэргэн ухаан, зөвт байдал, ариусал ба зөвлөлт болсон юм” (1Коринт 1:30) гэж ч бичсэн.

1982 оны 10-аар сарын 2-нд Лиза Тоскано, бид хоёр гэрлэлтийн гэрээ байгуулж, тэрбээр Лиза Бивэр болсон юм. Тэр өдөр Лиза *байр суурийн* талаасаа миний гэргий болсон. Тэр өдрөөс хойш өнөөдрийг хүртэл мөн өнөөдрөөс дөчин жилийн дараа ч миний гэргий байх Лизагийн байр суурь нь илүү чангарах ч үгүй, сулрах ч үгүй, хүчин төгөлдөр хэвээрээ л байна. Байр суурийн талаасаа Лиза хуримынхаа өдөр миний гэргий болсон бөгөөд тэр үйл явдал төгс гүйцэлдсэн юм. Үүнтэй адил бид аврагдсан өдрөө Христийн дотор ариун бөгөөд цэвэр болгогдсон бөгөөд түүнээс илүү ариусна гэж үгүй.

Гэхдээ байна шүү, миний гэргий болуутаа л Лизагийн *зан үйлдэл* нь *байр суурьтай* нь эгнэж эхэлсэн юм. Тэрбээр надтай гэрлэхээсээ өмнө өөр залуустай болзож, тэдэнд утсаа өгч, өөрийнхөө дураар амьдарч - ер нь ганц бие бүсгүйчүүдийн хийдэг бүхнийг хийдэг байсан бол, эдүгээ эдгээрийг хийхээ больсон. Түүний үйлдэл нь бидний хооронд байгуулсан гэрээтэй эгнэх болсон юм. Тэгээд жил өнгөрөх тусам, Лизагийн зан үйлдэл нь бидний хооронд байгуулсан гэрээтэйгээ эгнэхийн төлөө улам л төлөвшсөөр ирсэн билээ. Элч Петрийн бичсэнийг үзнэ үү:

Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл. Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм. (1Петр 1:14-16)

Петр байр суурийн ариун байдлын талаар бус, харин зан үйлдлийн ариун байдлын талаар өгүүлсэн бөгөөд Паул ч биднийг бүхий л бохироосоо өөрсдийгөө цэвэрлэх талаар ярихдаа, чухам энэ талаар л өгүүлсэн юм. Энэ нь зөвтгөгдсөн хэмээгдэх үнэ төлбөргүй ирсэн байр суурийн бэлэг бус, харин ариусгалын үйл явц болой.

Зан үйлдлийн ариун байдлын талаар өгүүлдэг өөр бичээс Шинэ Гэрээнд байдаг уу? Тийм ээ, байдаг. Би ганцыг л дурьдъя. Угаасаа бүгдийг нь тоочих ч боломжгүй:

Бурханы хүсэл нь та нарын ариусал бөгөөд тэр нь юу гэвэл, та нар садар самууныг цээрлэж, хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн *биеэ хэрхэн хянахаа мэдэж*, Бурханыг мэддэггүй харийнхан мэт тачаангуй хүсэлд эс байх нь юм. (1Тесалоник 4:3-5)

Саяхан Бүтэн сайны өглөөний цуглааны дараа нэгэн залуу надад: “Би ганц бие итгэгч хүн. Биеэ сахиж дийлэхгүй учраас, эмэгтэйчүүдтэй унтдаг. Яахав хэдэн сараар тэвчиж чаддаг ч, эргээд л бэлгийн харилцаанд ордог. Гэхдээ энэ миний ярих гэсэн гол асуудал биш ээ. Би хамгийн гол нь миний бизнес яагаад бүтэлгүйтээд байгааг л асуумаар байна” гэж ярьж билээ.

Энэ үг намайг таглаж орхив. Нигүүлслийн талаарх тэнцвэргүй сургаал маань хүмүүсийг нүглээ үйлдсэн чигээрээ Бурханы оршихуй, ерөөл дор амьдарч болно гэдэгт итгэж үнэмшихэд хүргээ юу? Эмэгтэйчүүдийн конференцийн асуулт хариултын цаг дээр нэгэн эмэгтэй Лизагаас “Би нөхөртөө тун хайртай. Гэхдээ тэр маш их аялдаг болохоор би араар нь олон эрчүүдтэй унтахаас өөр аргагүйд хүрдэг. Би яах ёстой вэ? Нөхөртөө хэлэх ёстой юу?” гэж асуусан байв.

Дээрх хоёр хүн өөрийгөө Есүстэй холбоотой гэдэгт үнэн голоосоо итгээд байгаа хэдий ч, тэр Есүс нь Бурханы баруун гарт залран суугаа Есүс үү эсвэл *хулхи* Есүс үү? Иймэрхүү асуудал нь мөсөн уулын зулай

л юм. Иймэрхүү тохиолдолтой ой тоймгүй олон удаа тулгарч л явлаа. Ариун амьдрах дуудлагыг нам болгосны улмаас ариун амьдрах итгэл үнэмшил ч бас таг болоо юу? Гэтэл Паул “Үүнийг эсэргүүцэгч нь хүнийг бус, харин та нарт Ариун Сүнсээ өгдөг Бурханыг эсэргүүцэж байна” (1Тесалоник 4:8) хэмээн бичсэн байх юм.

Ариун байдал нь салахын аргагүй чанарлаг бөгөөд үүнийг ч цааш цаашдын судалгаа маань улам тод харуулна.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: “Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга. (1Иохан 2:4)

Санаа: Ариусгалын (ариун байдлын) үйлс нь бидний дотор үйлдэгдсэн юмс гаднаа илэрхийлэгдэх явдал юм. Шинэ мөн чанар маань бидний амьдрах арга байдлаар дамжин, гаднаа бодитоор бий болно.

Эргэцүүлэл: Ариун байдал нь Бурханы нигүүлслийн ажил мөн хэдий ч, би Бурханы надад хүсэх хийгээд үйлдэхэд өгдөг хүчтэй гар нийлж ажиллах ёстой. Би үүнд итгэдэг үү? Би байр суурийн ариун байдал, зан үйлдлийн ариун байдлыг хольж хутгаснаасаа болоод, энэ үнэнийг бөгөөд Бурханы ариунаар амьдрах тушаалыг үл тооно уу? Эсвэл өнгөрснийхөө алдаагаар бамбайлан, миний дотор хийж чадах Бурханы хүчирхэг ажилд итгэх итгэлээ бөхөөж байна уу? Үүнийг амьдрал дээрээ бодитой болгох итгэлээ хэрхэн дахиж сэргээх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны сайн тааллыг хүсэхийн төлөө хийгээд гүйцэлдүүлэхийн төлөө миний дотор ажиллаач. Миний дотор Таны аль хэдийн хийсэн үйлсийг гаднаа харуулж амьдрахыг хүсч байна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би авралаа ариун эмээхүй, чичрэлээр гүйцэлдүүлнэ.

Доголон нь замаасаа хазайхгүй...

ариуслыг мөшгөгтүн.

— Еврей 12:13-14

20 | АРИУН БАЙДЛЫГ МӨШГИХҮЙ

Ариун байдал нь өөрөө хүрэх цэг бус, харин илүү чухал зүйл рүү аваачих зам гэж хэлж болно. Тэгэхээр, эхэлбэр эшлэлээ өөр нэгэн орчуулгаас нягтлах байдлаар ариун байдлын амтат чанарыг үргэлжлүүлэн үзэцгээе.

Ариун байдлыг ... мөшги, үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй.
(Еврей 12:14)

“Мөшгихийг” Грекээр *диоко* гэдэг бөгөөд “аливаа юмыг чанд мэрийлтээр болоод тодорхой зорго, зорилгоор хийх”¹ хэмээн тодорхойлдог. Дээрх хоёр орчуулга дээр *диокогийн* тодорхойлолтыг нэмбэл, энд ариун байдлыг ойлгож ухаарахуйн төлөө араас нь улайран хөөцөлдөх тухай мэдэгдэж байгаад эргэлзэх юм алга.

Тэгэхээр, юуны түрүүнд энд *байр суурийн ариун байдлын* талаар өгүүлж байна уу, *зан үйлдлийн ариун байдлын* талаар өгүүлж байна уу гэж асуух ёстой. Бүгдээрээ нөгөө Лиза, бид хоёрын гэрлэлтийн жишээ рүү эргэцгээе. Тухай нь, Лиза хамгийнхаа дотны найзад “Би Жоны гэргий байхын төлөө чанд мэрийж, улайран хөөцөлдөж байна!” гэж ярих болов уу?

Найз нь инээд алдаад: “Чи чинь хэдийнээ гэргий нь шүү дээ! Хуримынхаа өдөр л болчихсон!” гэж хэлнэ байх.

Хүний гэргий болчихсон эмэгтэй хүн “Гэргийн” *байр суурьтай* хөөцөлдөх шаардлагагүй ч, “Гэргий” хүний *зан үйлдлийг* мөшгиж болно. Тэгэхээр, ариун байдал ч ялгаагүй юм. Бид хэдийнээ олж

авсан *байр суурьтайгаа* бус, харин “Эзэнд зохистой байхын” (Колоссай 1:10) төлөө *зан үйлдэлтэйгээ* хөөцөлдөх хэрэгтэй.

Энэ тушаалыг үл ойшоосон хүн *Эзэнийг үзэхгүйг* хатуу хэлжээ. Үнэн сэрдхиймээр үг! Хэдийгээр энэ үр дагавар биднийг өнө мөнхийн амьдралд минь сүүдэр мэт дагах нь үнэн боловч, энэ удаа бүгдээрээ энэ талаар ярилгүй, харин одоогийн энэ амьдралд минь хэрхэн нөлөөлөх талаар ярилцъя.

Би Америкийн иргэн хүнийхээ хувьд улсынхаа ерөнхийлөгчтэй “Холбоотой” гэж хэлж болно. Миний бие бусад 332 сая Америк хүний хамт түүний удирдлага дор байж, гаргасан шийдвэрийнх нь үр нөлөөг эдэлж амьдардаг. Ерөнхийлөгч, бид хоёр нэг иймэрхүү маягийн харилцаатай нь үнэн боловч, миний бие өнөөг хүртэл нэг ч ерөнхийлөгчтэй биечлэн уулзаж үзээгүй.

Гэтэл нөгөөтэйгүүр, ерөнхийлөгчтэй өдөр бүр *уулздаг* Америкчууд бий. Тэд ерөнхийлөгчийн найз нөхөд юмуу хамтран зүтгэгч нар нь. Тэд Цагаан ордонд амьдардаг тэр эрхмийг надаас хавьгүй сайн мэднэ. Тэд ерөнхийлөгчийг дотно таньдаг бол, миний хувьд манай улсын ерөнхийлөгч гэдгээр нь л мэдэх төдий.

Үүнтэй адил, Есүс Христийн захиргаан дор сая сая итгэгч бий. Есүс тэднийг хамгаалдаг, хайрладаг, хангадаг, хүсэлтэд нь хариулдаг. Гэхдээ тэд Есүсийг *хардаг* болов уу? Өөрөөр хэлбэл, Есүсийн оршихуй тэдэнд *илэрхийлэгддэг* үү?

Бразилийн мөнөөх олон мянган итгэгч авир үйлдлийнхээ урхагаар Эзэний оршихуйд нэвтэрч чадаагүй боловч, үүнийгээ гэмшсэнийхээ дараа Хааныхаа оршихуйд орох эрхтэй болсон. Энэ үнэн өдөр тутмын, жирийн амьдрал дээр ч хүчинтэй. Бид бурханлаг эмээхүйгээр гачигдахаараа, Есүсийн ил оршихуйд нэвтрэх эрх олгодог ариун зан үйлдлийг мөшгих хүсэлгүй байна. Есүс “Миний тушаалуудыг хүлээн авч сахигчийг.. Би хайрлаж, Өөрийгөө түүнд илэрхийлнэ” (Иохан 14:21) хэмээн айлдсан буюу.

Зан үйлдлээрээ ариун бус хүн Эзэнийг үзэхгүй гэдэг үгийг давтаж хэлбэл зохилтой. Энэ яагаад тийм чухал гэж? Нэгдүгээрт - бид Эзэнийг үзэлгүй, Түүний ил оршихуйгаар гачигдбал, Түүнийг дотно таньж мэдэж чадахгүй. Яахав, миний нөгөө Америкийн ерөнхийлөгчийг мэддэгтэй л адил, их бага хэмжээгээр Эзэний *тухай* мэдэж болох л доо. Эсвэл бүр дордоод, өөртөө зориулж

хулхи Есүсийг бүтээгээд, өөрийгөө мэхэлж ч болох. Гэхдээ ийм хийсвэр итгэлтэй хүн “Танихгүй Хүнээ танина” хэмээн итгэж явдаг нь хамгийн аюултай. Иаков бидэнд “Өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бай” (Иаков 1:22) гэсэн. Ийнхүү мунхарсан хүн нь “Хэн нэгнийг танина, мэднэ” гэж итгэдэг ч, үнэндээ таньдаг ч үгүй, мэддэг ч үгүй юм.

Хоёр дахь шалтгаан нь дутахгүй чухал юм. Эзэнийг үзэхгүй, Түүний оршихуйд байхгүй бол, бид Түүний дүр төрх рүү хувиран өөрчлөгдөж чадахгүй. Эзэнийг хардаг хүмүүс “Эзэний алдрын тусгалыг тольдох мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг” (2Коринт 3:18) хэмээн Паул хэлжээ. Энэ өөрчлөлт нь дотроос эхлээд, эцэстээ бусдад харагдахуйцаар гаднаа гүйцэлддэг байна.

Бид Фарисай маягаар цэвэр байж болохгүй. Есүс тэднийг “хүмүүсийн өмнө гаднаа зөвт мэт харагдавч, дотроо хоёр нүүр болон ёс бус явдлаар дүүрэн” (Матай 23:28) гэсэн. Тэд яг л үхдэл мэт бохир, бузар сэдэлтэй байжээ. Тэд Эзэнээс эмээхгүйнхээ улмаас, гагцхүү бусдын төсөөллөөрх дүр дээрээ л анхаарч, гадаад үйлдэл дээр л дэвсгэрлэсэн зөвтгөлийг мөшгидөг байв. Тиймээс ч зохих гадаад зан үйлдлийг төрүүлдэг дотоод өөрчлөлтөд хүрээгүй байна. Тэд Бүтээгчээ танина гэдэгтээ итгэлтэй байсан ч, өмнө нь биеэр зогсож буй Бүтээгчээ таниагүйгээр үл барам, Түүний хүсэлтэй ч тэрсэлдсэн юм. Тэд өөрсдийгөө л залилжээ.

Тэгвэл өнөөдөр ч бид зүрхнээс - бодол, сэдэл, санаанаас маань төрсөн ариун байдлыг л мөшгих ёстой. Энэ маань яваандаа бидний гадаад зан үйлдлийг жолоодно. Тиймээс ч Есүс “Зүрхэндээ цэвэр ариун байгсад ерөөлтэй еэ! Тэд Бурханыг харна” (Матай 5:8) хэмээн айлджээ. Эзэнийг үздэггүй хүн дотроо өөрчлөгдөлгүй, жинхэнэ ариун байдлаар гачигдсаар - эцэстээ ч Түүнийг үзэхгүй. Тойруулгаараа л гүйгээд байна.

Гаднаа жигтэйхэн бурханлаг дүртэй атлаа дотор хүслийг минь өөрчлөгч хүчийг няцааж амьдрах нь ч худлаа амьдрал юм. Дотроо (санаа, сэдэлдээ) үнэнийг хүсэн тэмүүлж, үүнтэй хөөцөлдөх хэрэгтэй. Элч Иаков ариун байдлыг хөнгөн авч үздэг хүмүүст хатуу анхааруулжээ:

Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн

Бурханаас эмээхүй

тааламжид зарцуулъя хэмээн буруугаар гуйдаг байна. Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. (Иаков 4:3-4)

Амин хувийн ашиг, ололт амжилт чинь энэ дэлхийн цээжний өвчин учир, бусдын төсөөлөл, нүдээрх дүр дээрээ л анхаарна. Бид ариун байдлыг ойшоолгүй, дэлхийн хүсэлтэй хэлхэлдэхдээ, садарлагч болдог. Үүгээрээ Нөхөр болох Бурхан Эзэнээ гутаан доромжилж, үнэндээ Түүний дайсан болцгоодог. Тиймээс Иаков цааш нь “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга” (Иаков 4:8) хэмээжээ. Бид Эзэнээс эмээхүйг өвлөснөөрөө л зүрхээ цэвэршүүлдэг бөгөөд энэ маань эргээд биднийг жинхэнэ цэвэр ариун байдал руу жолоодно!

Лиза, бид хоёр дөчөөд жил ханилсан бөгөөд би хэд хэдэн хүчтэй шалтгааны улмаас түүнээсээ урвахгүй. Нэн түрүүнд - би Бурханаас айж байна. Би Лизагийн хариу үйлдэл, зан авираас үл шалтгаалан, тэр бүсгүйг хайрлан халамжлахаа Бурханы өмнө гэрээлэн байж, амласан.

Хоёрдугаарт - би энэ гайхамшигтай бүсгүйтэй тогтоосон дотнолоо алдмааргүй байна. Лиза надтай хамаг л нарийн нандин нууц, зүрхнийхээ хүслийг хуваалцаж, даатгадагт нь буюу бидний дотно харилцаанд би хайртай.

Тэгвэл Есүсийн хувьд ч ялгаагүй юм. Би Түүнтэй тогтоосон дотно харилцаагаа алдмааргүй учраас, Түүнээс урваж зүрхлэхгүй. Би Түүний танил дотно оршихуй, надтай өрнүүлдэг дотно ярианд хайртай. Миний мэдэхгүй нууцыг надтай аминчлан ярилцдагт нь би хайртай. Магадгүй иймээс л бидэнд:

ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ (Дуулал 25:14) хэмээн айлдсан буй за.

Ариун байдлын салшгүй чанарыг одоо зах зухаас нь үзэж эхлэв үү? Энэ гоо үзэсгэлэнг удаах бүлгээрээ ч үргэлжлүүлэн харцгаая.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Цэвэр зүрхийг хайрлагч, нигүүлсэнгүй уруулт хүнтэй хаан хүртэл анд нөхөр болох. (Дуулал 22:11)

Санаа: Зан үйлдлээрээ ариун байхын мөн чанарыг ойлголгүйгээр, дан хэлбэрийг нь хөөснөөрөө Эзэний оршихуйд орохгүй. Ариун байдлыг ариусалд хүрэх гэхээсээ илүү зүрхээрээ ариуслыг мөшгих явдал гэж ойлгобол, зохино.

Эргэцүүлэл: Намайг ариун зан үйлдлийг мөшгиж байна уу, хайр, хүлцлээр шалтаглан дэлхийн хүсэл, бардамнал, ололт амжилттай хөөцөлдөж байна уу гэдгийг Бурхан мэднэ. Би оюунаараа ч, зүрхээрээ ч цэвэр байхыг эрмэлзсээр, үүнийгээ даган үйлдлээрээ өөрчлөгдөх үү? Эргэн тойрныхон маань хийхгүй байсан ч, би үүнийг хийх үү?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, ариун байдлыг мөшгөөгүйд уучлаарай. Би үүнийг тоохгүй явж. Гэхдээ ариун байдал нь намайг Таны оршихуйд нэвтрүүлэх үүд болохыг ойлгосон тул яг одооноос ариун байдлыг л мөшгиж амьдарна. Газрын юмсыг мөрдөж, дэлхийн хүн шиг авирлаж байсныг минь уучлаарай. Намайг Есүсийн цусаар цэвэрлээрэй. Ариун байдалд хамаагүй хандсанаа гэмшиж байна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би ариун байдлыг ойлгохын төлөө хамаг л санаа сэдлээрээ явна. Бурхантайгаа адил ариун байхыг би зорино.

*Зөв шударгын зам нь
чигч шулуун ажээ. Аяа Зөвт Нэгэн ээ,
Зөвт хүний замыг тэгшихэн тавиач.*

— Исаиа 26:7

21 | ДУР ХҮСЭЛ БА ЭРХ ХҮЧ

Яг одоо та ариун амьдрахын төлөө *хичээгээд хичээгээд*, бүтэлгүйтэж явсан түүхээ гашуудан санаж байна уу? Үнэндээ, бүтэхээсээ илүү бүтэлгүйтсэн нь олон биз. Та Бурхантай ойр дотно байхыг хүсэв ч, дуулгавартай байх гэж үйлээ үзсэн л байгаа. Гэхдээ “Та Бурханыг хүсэхээс чинь илүүтэйгээр Бурхан таныг хүсдгийг” урьдаас хэлмээр байна. Бурхан таны төлөө учраас, баяртай байгаарай! Энэ үнэн таны дотоод зөрчлийг намжааж, тайтгаруулах болтугай.

Хамаг асуудал нь “*Оролдож үзсэн*” явдалд л байгаа юм. Хүн Бурханы тушаалыг дагаж чадахгүй бөгөөд хүнд тэнгэрийн тусламж хэрэгтэйг Мосегийн хууль батлан харуулсан. Энэ түргэн тусламж нь Бурханы нигүүлсэл болой. Есүс Христийн нигүүлсэл биднийг хуулийн шаардлагаас чөлөөлснийг Христэд итгэдэг ихэнх хүн мэднэ. Гэхдээ үүгээр зогсохгүй, энэ л нигүүлсэл нь биднийг шинэ мөн чанараар хангаж, бидэнд нүглээс эрх чөлөөтэй амьдрах хүчин чадал өгдгийг (Ром 6:6-7) ихэнх нь мэдэхгүй.

Өөрсдийгөө махан бие, сүнсний бохироос цэвэрлэх Паулын тушаал үгийн өмнө бидний анзааралгүй өнгөрдөг нэгэн мэдэгдэл бий. Хэдхэн параграфийн өмнө Паул:

Бурхантай хамтран ажиллагч бид та нараас хичээнгүйлэн гуйя. Бурханы нигүүлслийг дэмий хоосноор бүү аваарай. Учир нь Тэр “Тааламжтай цагт Би чамайг сонссон. Авралын өдөр Би чамд тусалсан” гэж айлддаг” (2Коринт 6:1-2) хэмээн бичжээ.

Тааламжтай цаг нь ирсэн бөгөөд бид Бурханыхаа тусламжтайгаар ариун амьдрах чадалтай болсон. Харамсалтай нь, Бурханы нигүүлслийг бүрэн эхээр нь заахгүй юм даа. Нигүүлслийг мөнхийн аврал, нүглийн уучлал, нүглийн шийтгэлээс чөлөөлсөн чөлөөлөлт, зохисгүй бидэнд хайрласан үнэ төлбөргүй бэлэг гэх зэргээр заадаг. Эдгээр нь бүгд үнэн. Гэхдээ нигүүлсэл нь мөн хүч оруулах чанартайг л тэр бүр заадаггүй нь бидний хамгийн том алдаа юм. Элч Паулд Бурхан: “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөсдөлд [Миний] хүч бүрэн төгс болдог” (2Коринт 12:9) хэмээн айлдсан. Товчхондоо “Паул аа, чи хүнийхээ чадвараар хийж чадахгүйгээ эдүгээ Миний нигүүлслийн хүчээр хийж чадна” гэжээ.

Энэ үнэнийг Петр ч бататгасан: “...та нарт нигүүлсэл ... арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч (нигүүлсэл) нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон” (2Петр 1:2-3) ЭнЭлТи. Библи дээр “Тэнгэрийн хүчээр (нигүүлслээр) Бурхан бидэнд бурханлаг амьдрахад хэрэгтэй бүхнийг өгсөн” хэмээн түс тас хэлсэн байна. Нигүүлсэл бидэнд ариун амьдрах хүчийг өгнө!

Энэ үнэн яагаад тийм чухал юм бэ? Христэд итгэх итгэл нь итгэлийн амьдрал юм. Энэ сургаалыг бүхэлд нь “итгэлийн үг” (Ром 10:8) гэдэг. Өөрөөр хэлбэл, итгэхээс нааш бид Бурханаас юу ч хүлээж авахгүй бөгөөд харин мэдэхгүй зүйлдээ итгэж чадахгүй. Тиймээс нигүүлслийн хүчирхэгжүүлэгч чанарыг мэдэхгүй хүн өөрийнхөө чадлаар Бурханд таалагдах гэж зүдэрсээр явна. Харин энэ нь түүнийг үр жимсгүй, уй зовлонтой байдалд хүргэнэ.

Шинээр төрөх үйл явдлаар жишээ татъя л даа. Аврагдаагүй үй олон хүн Бурхан аварч чадна гэдэгт итгэж явдгаа хэлдэг. Гэхдээ тэд нүглээ гэмшиж, сайн мэдээнд итгэхээс нааш, авралд хүргэгч нигүүлслийг хүртэхгүй. Тэгвэл ариун байдлыг мөшгих нь ч үүнтэй л адил юм. Христэд итгэдэг олон хүн Бурхан ариун амьдрах чадварыг өгч чадна гэдэгт итгэдэг хэдий ч, *нигүүлсэл* нь *хүчжүүлдэг* гэдэгт чин зүрхээрээ итгэхээс нааш, ач тусыг нь хүртэхгүй.

Паул Коринтын итгэгч нарыг “Бурхантай хамтран ажиллагч бид та нараас хичээнгүйлэн гуйя. Бурханы нигүүлслийг дэмий хоосноор бүү аваарай” (2Коринт 6:1) хэмээн хичээнгүйлэн ятгасан. Дэмий хоосноор авах гэж юу гэсэн үг вэ? Хүчин чадлаар нь ашиглахгүй байх

л гэсэн утгатай. Нэгэн хүнд хоол хүнсээ ургуулж, амьдрал ахуйгаа босгоорой хэмээн суулгах үр, дээрээс нь газар тариалангийн багаж хэрэгсэл бэлэглэжээ. Гэтэл тэр этгээд өгсөн зүйлийг нь хэрэглэхгүй бол, өлсөж үхнэ биз дээ. Үхсэнийх нь дараа хөршүүд нь “Хайран ч үр, хайран ч багаж. Бүгд талаар болов.” хэмээн халаглах бус уу?

Паул ч яг л энэ тухай хэлжээ. Бурхан таныг хүнийхээ хүчээр барахгүй амьдралаар амьдруулах гэж нигүүлслээ өгсөн. Нигүүлсэл таныг ариун амьдралыг мөшгиж, сахих хүчтэй болгоно. Энэ хүчийг итгэлгүй байдлаараа унтраах бий.

Барууны чуулган Бурхан нигүүлслийг аврал, уучлал, тэнгэрт нэвтрүүлэх тасалбар төдийхнөөр сургаад байх юм бол, халаглах юм ч үгүй хоцорно. Талаар болох юм угаасаа байхгүй учраас, Паулын үг ч утгаа алдана.

Элч Паулын бодлын хэлхээг мөшгих юм бол, бүх зүйл тодорхой болно. Коринтын чуулган ариун амьдралд хойрог, дэлхийн явдалтай чуулган байжээ. Паул мөн л захидлынхаа адгаар “Мөн дахин очиход минь миний Бурхан намайг та нарын өмнө гутааж, урьд нь нүгэл үйлдэн, ариун бус байдал, садар самуун, тачаангуй байдалдаа үл гэмшсэн эдгээр олноос болж би харуусах вий гэхээс айж байна” (2Коринт 12:21) гэж бичсэн нь дээрх санааг бататгаж байна. Зургадугаар бүлгийг Паул Бурханы нигүүлслийг үрлэгдэхгүй байх ятгалгаар эхлүүлээд, араас нь тэр хүмүүсийг хайрлаж явдгаа учирлан хэлээд, яагаад хайрыг нь хайраар хариулахгүй байгааг лавлажээ. Тэгээд дараа нь тэдний Бурханы нигүүлслийг үл ойшоосон байдал нь тэдэнд нөлөөлж байгаа бурханлаг бус хүмүүст ч илэрхий байгаа гэдэг үндсэн санаагаа дахин давтжээ:

Үл итгэгчидтэй буруу буулганд бүү ор. Зөвт байдал ба ёс бусын түншлэл гэж юу байх? Гэрэл ба харанхуйн нөхөрлөл гэж юу байх юм? (2Коринт 6:14)

Итгэдэггүй хүмүүст туслахын төлөө дэлхий рүү хандах болоод итгэдэггүй хүмүүстэй зэрэгцэн хэлхэлдэх нь ялгаатай болохыг мэдээрэй. Хоёр дахь харилцаа нь биднийг амийн замаас гаргаж ч мэднэ шүү. Үүнийг сүнсний завхайрал ч гэдэг.

Дараа нь Паул махан биеийн явдалтай тэр итгэгч хүмүүсийг Бурханы оршихуйн газар бөгөөд Бурхан тэдэнд юу хүсдгийг хэлжээ:

Би тэдний дотор амьдарч, дунд алхалж, тэдний Бурхан болж, тэд Миний хүмүүс болно. Тиймээс үл итгэгч нарын дундаас гарч, тэднээс өөрийгөө тусгаарла хэмээн Эзэн айлдруун. Тэдний бохир юмст бүү хүр. Тийнхүү Би *та нарыг угтаж авна* (2Коринт 6:16-17).

Энд мөн л Бурханы ил оршихуйг амласан байх боловч, энэ удаа хавьгүй өндөр төвшинд амлажээ. Бурхан хааяа нэг айчлах бус, харин бидний дотор бөгөөд бидэнтэй хамт оршино гэв! *Бурханыг үзэх* (Бурханы ил оршихуй) нь болзолтой амлалт болох нь мөн л харагдаж байна. Бид аминч, бардам хүслээсээ чөлөөтэй явбал, Хаан “Би та нарыг угтаж авна” хэмээн мөнхийн оршихуйгаа амлажээ. Гэхдээ үүний нөгөө тал нь ч үнэн юм: Өөрийгөө дэлхийгээр бохирлож бузарлаад байвал, Бурханы оршихуйг үзэхгүй. Эцэст нь Паул ийн дүгнэжээ:

Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохиросоо цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё. (2Коринт 7:1)

Одоо та “... авралаа айдас ба чичрэлээр гүйцээ. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, *ажиллахын* аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм” (Филиппой 2:12-13) гэсэн Паулын үгийг ойлгохтойгоо болсон байх аа. Эзэнээс эмээхүй нь биднийг *хүсэлд* хөтөлж (хүсэл өгч), Эзэн Есүс Христийн нигүүлсэл биднийг *үйлдэх* чадвартай болгодог (хүчжүүлдэг) байна.

Түүнчлэн (ариун эмээхүй дутагдсаны улмаас) хүсэл дутагдсан газарт хүчийг чухалчилж үзэхгүй учраас, хэрэглэлгүй орхиод, гарзадна! Тиймээс л урт настай, үр нөлөөтэй байхад ариун эмээхүй амин чухал ажээ.

Цэвэр байдал нь ариун байдлын жинтэй бүтэц мөн боловч, бүрэн илэрхийлэл нь биш юм. Ариун байдлыг үндсэндээ *бүрэн бүтнээрээ Бурханых байхаар Бурханд ариунаар зориулагдах* хэмээн тодорхойлж болно. Тэгэхээр, ариун байдлын энэхүү үндсэн тодорхойлолтыг цааш нь дэлгэрүүлэн дүрсэлцгээх үү? Сүйт хүүхэн сүйт хархүүтэйгээ гэрлэх үедээ өөрийгөө бүрэн эхээр нь нөхөртөө зориулдаг. Үүн дотор нь байр суурийн талаасаа ч, зан үйлдлийн ч талаасаа ч ариун байх шаардлага багтана. Энэ зориулалтын туйлын зорилго нь зүгээр л цэвэр байгаад байх явдал

бус, харин сүйт хархүүдээ ариунаар зориулагдах явдал бөгөөд үүнийх нь дотор цэвэр байдал ч багтана.

Тиймээс, жинхэнэ ариун байдал нь Бурхантай дотносох үүдийг нээдэг, ариун зориулалттай, ер бусын цэвэр байдал ажээ. Бүгдээрээ энэ *хөл алдмаар явдлын* талаар номоо дуусгахаасаа өмнө үргэлжлүүлэн ярилцана. Харин одоо амьдрал дээр Сүйт хархүүдээ хэрхэн ариунаар зориулагдах талаар ярьцгаая. Хариулт нь *дуулгавартай байдал* гэдэг ганц үгд оршино.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Иймд хүү минь, Христ Есүст буй нигүүлслээр зоригтой бай. (2Тимот 2:1)

Сургамж: Нигүүлслийн хүчирхэгжүүлэгч чанарыг үл мэдэгч хүн Бурханд өөрийнхөө хүчээр таалагдаж гэж мэрийсээр, тийнхүү өөрт өгөгдсөн Бурханы нигүүлслийг гарздах.

Санаа: Би ариунаар амьдрах гэж оролдоод, бүтэхээсээ бүтэхгүй нь олон байлуу? Өөрийнхөө хүчээр хийх гэж оролдсон уу? Намайг ариунаар амьдрах хүчтэй болгодог Бурханы нигүүлсэлд найдсан уу? Найдаагүй бол, үүнийг хэрхэн өөрчлөх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, биТаны нигүүлслийн хүчээр л Таны жавхлант оршихуйд нэвтрэх эрх бүхий, бурханлаг амьдралаар амьдарч чадахаа ойлголоо. Өөрийнхөө хүчээр зүтгэснийг минь уучлаарай. Одооноос эхлэн би Есүсийг алдаршуулах, тусгаарлагдсан амьдралаар амьдрахын төлөө Таны нигүүлсэл дотор хүчтэй байна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би ариун эмээхүйгээр хөтлүүлэн, Бурханы нигүүлслийн хүчээр ариунаар амьдарна.

БУРХАНЫ ҮГД ХАРИУЛАХУЙ

Дөрөвдүгээр долоо хоног

*Тушаалуудынхаа жимээр
намайг алхуулаач!
Түүнд би баярладаг билээ.*

— Дуулал 119:35

22 | БУРХАНЫ ҮГД ЧИЧРЭХҮЙ

Эзэнээс эмээхүйг 1) Бурханы оршихуйд чичрэх, 2) Бурханы Үгд чичрэх хэмээн хоёр хувааж болохыг эхний хэсэг дээрээ хэлсэн. Бурханы жавхлантай оршихуй нь өнийн мөнхөд биднийг зогсоо зайгүй бишрүүлэх яндашгүй, оройгүй зүйл болохыг ч ярьсан.

Тэгэхээр, Бурханы хүмүүс Бурхантайгаа тогтоосон жинхэнэ харилцаанаасаа хөндийрөөд, зүгээр л хэлбэрдэж явсан үеийн нэгэн түүхээр судлалаа нээюү. “Тэнгэр болбоос Миний сэнтий, Газар болбоос Миний хөлийн гишгүүр билээ. Надад зориулж та нар ямар сууц барих юм бэ? Миний амрах газар гэж юу байх вэ?” (Исаиа 66:1)

Дээрх хэсгийн эхний таван эшлэлийг бүрэн эхээр нь унших юм бол, Аугаа хүчирхэг Бурхан Өөртэй нь өөрийнхөө нөхцлөөр харилцаа тогтоож, хөгжүүлэхийг санаалсан хүмүүстээ хандан Үгээ айлдруун. Хүмүүс нь Бурханы замд хагас дутуу анхаарах маягаар Түүнийг аргалах гэж оролджээ. Гэвч энэ замнал нь үнэндээ гутамшигтай байсан бөгөөд жинхэнэ харилцаа тогтооход ямар шаардлагатайг Бурхан шууд айлджээ:

Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй, *Үгэнд минь чичирдэг* нэгнийг л Би анхаарна (ерөөнө). (Исаиа 66:2)

“Ерөөнө” гэдэг нь “анхаарах, харгалзах, харж хандах, хүндэтгэх. Аливаа зүйлийг төвлөрөлтэй, эрчимтэй өнгө аясаар ажиглах” гэсэн утга бүхий “*набат*” гэдэг Еврей үг болно. Тэгэхээр, Бурхан үндсэндээ “Тэр хүнд би нарийн анхаарна” л гэжээ. Тиймээс энэ хичээлээрээ бүгдээрээ даруу байдал, гэмшсэн зүрх, “Миний үгэнд чичирдэг хүмүүс” гэсэн гурван чанар дээр төвлөрнө.

Бурханы Үгд чичирдэг хүн нь Бурханы айлдвар - Үгийг хэзээд юу юунаас дээгүүр тавина. Түүнд үүнээс чухал нь үгүй. Энэ нь ч ариун эмээхүйн жинхэнэ нотолгоо юм. Ийм л хүн хамгийн ерөөлтэй. Паул ч үүнийг хэлсэн:

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг *байхад ч* биш, харин эдүгээ *байхгүй байхад* минь *бүр илүүгээр* өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ. (Филиппой 2:12)

Энэ үгийг Филиппойчуудад хандсан Паулын үг бус, харин бидэнд хандсан Бурханы Үг гэж үзээрэй. Мөн “Үргэлж дуулгавартай байсан шигээ” гэдэг үгийг анхаарна уу. Энэ нь болзолгүй л гэсэн үг. Бурханы оршихуйг мэдэрсэн ч, мэдрээгүй ч, Таны төлөө үйлдэхийг нь харсан ч, хараагүй ч, залбиралд чинь таны хүссэн цагт, хүссэн аргаар чинь хариулсан ч, хариулаагүй ч - хамаагүй.

Эргэн тойрон эелдэг хүмүүс дүүрэн, Бурханы хүчирхэг оршихуйтай конференцийн халуунд Бурханыг дуулгавартай дагах ч амархан л даа. Харин багийн чинь итгэлт нөхөр таныг гүтгээд, ажлаас чинь халуулчихсан үед яах уу? Та Үгийн дагуу уучлах уу эсвэл нэгийгээ үзэлцэх үү?

Эсвэл бизнесийн томилолтоор яваад, өрөөндөө ганцаархнаа байж байтал, хань ижлийн чинь хатуу ширүүн үг санаанд чинь орж ирнэ. Гэтэл танд жигтэйхэн сайн хандаж, үргэлж сайшаал магтаал хайрладаг, багийн чинь нэгэн хөөрхөн бүсгүй юмуу залуу үдшийг хамт өнгөрөөө гэвэл, яах уу? Хэн ч мэдэхгүй. Энэ санаанаас зугтах уу, хүлээж авах уу?

Шөнө дүл болтол компьютер дээрээ ажлаа хийж байсан чинь гэнэт порно сайт гараад ирбэл, яах уу? Сонирхох болов уу?

Эдгээр нь Бурханы оршихуйгаас далдуур үйлдэгддэг юмс юм. Гэхдээ Бурханы Үгд чичирдэг хүн ямар ч нөхцөлд Үгийг л дуулгавартай дагана. “ЭЗЭНээс эмээвээс ёр муугаас зайлах” (Сургаалт үгс 16:6) учраас, ёрын муугаас зайлах нь ариун эмээхүй дотор амьдарч буйг илтгэнэ.

Магтаалч “ЭЗЭНийг магтагтун! ЭЗЭНээс эмээдэг, Тушаалуудад нь ихэд баярладаг хүн Юутай ерөөлтэй!” (Дуулал 112:1) гэдэг.

Бурханаас эмээдэг эрчүүд, эмэгтэйчүүд нь зүгээр нэг дуулгавартай улс бус, дуулгавартай байхдаа ч дуртай улс ажээ. Дуулгавартай байдал нь зовлон бус, жаргал болдог байна. Тэд Бурхан - бидний Бүтээгч гэдгийг мэддэг учраас, биднийг юу бүтээдэг, юу сөнөөдгийг ч мэднэ.

Дөрвөн хүү маань жаалхан байсныг санаж байна. Христмасын баяр нь үндсэндээ ажлын өдөр л гэсэн үг. Жаахан хүүхдүүдтэй аавууд үүнийг ойлгож байгаа байх аа. Бэлэг задарсны дараа тоглоом угсрах том ажил аавд л оноогддог. Би ч яахав, дийлэнх аавуудтай л адил хайрцгийг нь задлаад, тоглоомын хэсгийг шалаар нэг цацаад, хайрцаг, зааврыг нь зайчилж байгаад л, үзэж тарна. Ийнхүү гол төлөв цагийн дараа дуусах боловч, шалан дээр ганц хоёр эд анги үлдэж намайг гайхшруулдаг байлаа. Тэгээд асаах товчин дээр нь дарсан ч, асахгүй. Би яах уу? Гарын авлагыг нь хайж олоод, тоглоомоо дахиад л салгаж байгаад, зааврынх нь дагуу шинээр угсарна. Тэгээд мэдээж ажиллана!

Бурханаас эмээдэг хүн ямагт дагадаг. Тэрбээр дараах суурь үнэнийг яс махнаасаа багтай ч мэддэг, багтай ч дагадаг:

1. Надад юу нь зөв болохыг Бурхан л мэднэ.
2. Бурхан цэвэр хайр бөгөөд Түүний хайрын төвлөрөл нь би.
3. Бурхан хэзээ ч надаар хор хөнөөлтэй юм хийлгэхгүй. Түүний хэлсэн нь үргэлж хамгийн зөв байдаг.
4. Тиймээс Бурханыг юу ч айлдсан, би баяртайгаар дагахыг л сонгоно.

Израилийн хүүхдүүд зогсоо зайгүй гомдоллосон. Туулах замдаа, тулгарах үйл явдалдаа дургүйцсэн. Тэд тав тухгүй нөхцөл, гачигдал, за ер нь таагүй бүхэндээ Бурханыг буруутгасан. Тэдэнд ямар ч ариун эмээхүй байгаагүй, Бурханы Үгд ч чичрээгүй. Тэгээд Бурхан айлдруун:

Чи алив бүхнээр элбэг дэлбэг байсан ч ЭЗЭН Бурхандаа баяр хөөртэй зүрхээр зарагдаагүй учраас ЭЗЭНээс чиний эсрэг илгээх дайснуудад чи өлсөж цанган, нүцгэрч, алив бүхнээр дутагдан байж зарагдана. Тэр чамайг устгах хүрглээ хүзүүнд чинь төмөр дөнгө углана. (Дэд хууль 28:47-48)

Бурханы Үгд чичрэхүй нь дотроос хөөр баяр, цэнгэл жаргалыг төрүүлдэг. Эс бөгөөс эрт орой хэзээ нэгэн цагт урвагнаж, уур хилэн бадрах л болно. Израилийг хувь тавиландаа хүрэхэд нь хориг болсон таван төрлийн нүглийг би мартажгүй. Тэдгээр нь: Ёрын мууд дурлах, шүтээнд мөргөх, бэлгийн ёс бус явдал, Бурханыг шалгах бөгөөд гомдол гаргах (1Коринт 10:6-10). Тэгээд “Гомдоллох” гэдэг үгийг уншихдаа, тааз мөргөнгөө алдаад: “Юу? Гомдоллох оо! Яахаараа гомдоллохыг ийм *том том* нүгэлтэй зэрэгцүүлдэг билээ?” хэмээн гайхаж билээ.

Тэгтэл Ариун Сүнс: “Хүү минь, гомдоллох нь Миний мэлмийд ноцтой нүгэл буюу” хэмээх нь дуулдлаа. Тэгээд гомдоллох нь “Бурхан минь, миний амьдралд хийж байгаа юмс чинь таалагдахгүй байна. Би л Таны оронд байсан бол, өөрөөр хийх байсан” хэмээн эсэргүүцлээ илэрхийлэхтэй л ижил болохыг харуулав.

Дараа нь: “Энэ нь Миний зан чанарыг гутаан доромжилсон явдал, Миний хүсэлтэй тэрсэлдсэн явдал, үндсэндээ огтоос айж эмээх сэтгэлгүйн тэмдэг” хэмээв.

Би ч энэ тухай Лизад хэлээд, бид хоёр гомдоллох нь тэрсэлэл гэдэг ойлголтоор үр хүүхдээ хүмүүжүүлж байхаар санаа нэгдсэн юм. Би ч үүнд тун нухацтай хандлаа. Тэгээд үглэх, бувтнахыг - ер нь гомдлын чанартай ширхэг ч үг хэлэхийг цээрлэв. Гэвч хожим дөрвөн өдөр мацаг барихдаа, Ариун Сүнс: “Хүү чинь, чи зүрхэндээ гомдоллож байна” хэмээн айлдахыг нь сонсов.

Би ч тэр даруй сөгдөөд, гэмшсэн юм. Эзэндээ *баяр, цэнгэлтэй зурхээр* үйлчлэхгүй байгааг минь, дайснууд миний дээр гарсныг хожим Бурхан надад харуулав. Паулын үгийг ахин үзнэ үү:

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм. Бүхнийг гомдол маргаан үгүйгээр хийцгээ. (Филиппой 2:12-14)

Тэр дөрвөн өдрийн мацгийн дараагаас л би дээрх бичээсийн нарийн ухааныг олж мэдэж билээ. Энэ Бичээс л гомдоллох нь

Бурханы Үгд чичрэх байтугай, харин ч бүр ариун эмээхүйн эсрэг үйлдэл гэдэг үнэнийг харах нүдийг минь тайлж өгсөн юм.

Бурханаас эмээдэг хүмүүс дуулгавартай байдлаас илүү тустай, чухал зүйл байхгүйг багтай мэднэ. Тэд ямар ч үнээр хамаагүй дуулгавартай дагадаг бөгөөд Бурханы Үгийг орчин цагийн нийгмийн соёл, трэндээр нэвтрүүлж шүүдэггүй. Түүнчлэн бусад итгэгч нарын зан үйлдлээс хамаарч байж Бурханы Үгийг дуулгавартай дагах эсэхээ ч шийддэггүй. Тэд зүгээр л дагадаг.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Уриалгахнаар (хүсэлтэй бөгөөд дуулгавартай) дагах аваас Уул газрын сайныг иднэ. (Исаиа 1:19)

Санаа: Нөхцөл байдлаасаа үл хамааран, зөв хандлага, зохих үйлдэл хоёрыг дагуулдаг дуулгавартай байдал л ариун эмээхүйн нотолгоо болно.

Эргэцүүлэл: Би яагаад зөвхөн таатай нөхцөлд л дуулгавартай дагадаг вэ? Миний санаагаар болохгүй үед би гомдол гаргадаг уу? Яаж үргэлж баяр, талархалтай хандлагаа хадгалах вэ? Яавал ямар ч нөхцөлд дуулгавартай дагадаг болох вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны Үгд чичрэхийг мэдэхгүй явсанд уучлаарай. Миний дуулгавартай байдал болзолтой, миний хандлага тийм ч баяр, талархалтай байгаагүй. Цаг үргэлж баяртай хандлагаар дуулгавартай дагах хүчийг хайрлаач. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Бурханаас эмээдэг тул Түүний сайн тааллыг хүсдэг ч, үйлддэг ч болгохын төлөө Бурхан миний дотор ажиллаж байгаа.

*Хоолойгоо сөөтөл бархирч байснаас,
Эзэний Үгд чичирч, тэнгэрлэг хайрын
энгүй сүр жавхланд мөргөх нь дээр.*

— Си. Эйч. Спержен

23 | ҮТЭР ТҮРГЭН

Бурханлаг эмээхүйн амин хүчин зүйл нь амьдралд минь гайхаш төрүүлмээр ач тус авчрагч, Бурханы Үгд болзолгүй хандах дуулгавартай байдал юм. Бурханы Үгд чичрэх таван онцгой тал байдаг бөгөөд тэдгээрийг бүгдээрээ ирэх таван өдрийн турш нэг бүрчлэн авч үзнэ.

1. Бурханыг үтэр түргэн дагах.

Бурханаас эмээдэг хүмүүст дуулгавартай чанар зайлшгүй юм. Тэд амин хувийнхаа ашиг сонирхлоос дээгүүр Бурханы хийгээрэй гэсэн юмсыг тавих. Ариун эмээхүй нь зүрхэнд маань *Бурханд чухал юмс нь - надад амин чухал* хэмээн сийлдэг байна.

Жишээлж болох үй олон эшлэл дундаас Есүсийн айлдсан хоёр үгийг эш татъя:

Иймээс чи тахилын ширээнд өргөл өргөх гэж байхдаа чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь байгааг санавал, өргөлөө тахилын ширээний өмнө орхиод (*даруй*) замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө.

Даруй буюу *үтэр түргэн* гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Мөн Исаиа 66 дээр Есүс “Бид Бурханы хийгээрэй хэмээн айлдсан зүйлийг нь хөсөрдүүлчихээд, “Бурханы төлөө сайн дураараа гавьяа байгуулах” ёсгүйг цохон тэмдэглэсэн. Хэдийгээр Есүс өс хонзон тээх талаар онцгойлж ярьсан боловч, ерөнхий зарчим нь бүхий л нөхцөл байдалд хэрэгжинэ.

Нөгөө садар самуун явдалтай атлаа залбиралд нь хариу ирэхгүй, бизнес нь хүссэнээр нь хөгжин цэцэглэхгүй байгаад гайхширч байсан бизнесмэнийг санаж байна уу? Түр зогсоод, үүнийг эргэцүүлбэ. Тэрбээр бэлгийн ёс бус байдлаас зугтаарай гэсэн Бурханы үгийг нэн тэргүүнд тавихгүй атлаа яахаараа Бурхан түүний бизнесийг нэн тэргүүнд тавьж, ерөөх ёстой гэж бодоо юм бол оо?

Израилийн Тэргүүн тахилч Елигийн хоёр хүү нь мөн л аавынхаа удирдлага дор тахилчийн албан үүрэг гүйцэтгэж байсан боловч, адын муу хүмүүс байв. Тэд завхайрч, хүмүүсийн тахилыг булаадаг байж. Ели ч хөвгүүдийнхээ энэ увайгүй явдлыг зохих ёсоор шийдвэрлэхгүй, *хойш тавьсаар* явжээ. Үүнийх нь талаар ч Эзэн “Юуны учир чи Намайг хүндэтгэхээсээ илүү хөвгүүдээ хүндэтгэнэ вэ?” (1Самуел 2:29) хэмээсэн.

Хэн нэгэн хүнээс юмуу ямар нэгэн зорилгоос болоод Бурханыг дагаж өгөхгүй байгаа нь тэр хүнийг юмуу юмыг Бурханаас дээгүүр өргөмжилж байгаагийн л шинж. Ариун эмээхүй алга. Дараа нь Бурхан:

Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг *үл тоомсорлогсдыг* Би үл хайхарна (1Самуел 2:30) хэмээн айлдсан.

Үнэхээрийн сэрдхиймээр үг. Бурханы Үгийг дагахаасаа хойш сууж, тоомжиргүй хандах нь Бурханыг л *үл тоож* байгаа хэрэг болно. Үндсэндээ “Бурхан миний нэн тэргүүний зорилго биш ээ” л гэж буй хэрэг. Гэтэл Бурхан Өөрийг нь *үл тоогсдыг жигшинэ* гэх. Үнэндээ *жигших* нь ч тийм ч оновчтой хөрвүүлэг биш юм. Энэ нь “Юмын чинээ үзэхгүй” гэсэн утга бүхий *каалал* гэдэг Еврей үг болно. *Юмын чинээ бодохгүй* гэхээр шууд орой руу орж байгаа байх аа. Тэгэхээр, Бурханы Үгд хөнгөн хуумгай ханддаг хүмүүсийн аминчлан хүсдэг юмсыг Бурхан *юмын чинээ үздэггүй* байх нь. Эрүүл ухаантай хэнбугай нь ч үүнийг хүсэхгүй биз ээ.

Бизнесмэн хүн бэлгийн харилцааны тал дээр цэвэр амьдрахыг заасан Бурханы Үгийг хүндэтгэсэн бол, Бурхан түүний бизнесийг чухалчилж үзэх байсан ч юм билүү. Гэтэл оронд нь юмын чинээ үзээгүй байна.

Үтэр түргэн дагахын чухал чанарыг дүрсэлсэн өөр нэгэн хэсэг нь Ефесийн чуулганд хэлсэн Есүсийн үг болой:

Тиймээс чи хаанаас унаснаа сана бас гэмш. Анхны үйлсээ үйлд.
 Чи эс гэмшвээс, Би чам дээр (*даруй*) очиж, дэнг чинь байрнаас нь зайлуулах болно. (Илчлэл 2:5)

Гэмших гэдэг нь Бурханы Үгтэй зэрэгцэхийн тулд сэтгэлгээ - тэгээд үүнийхээ дагуу үйлдлээ өөрчлөхийг хэлнэ. Чуулган дуулгавартай дагалгүй, хойш суух аваас, ерөөгдсөн чигээрээ орших боломжийнхоо цонхыг хаалгуулах байв. Есүс *даруйхан* ирээд, тэдний нөлөөллийг зайлуулна. Мөн л сэрдхийм үг байна.

Цаг хугацаа, чухал юм, чухал бус юмсаа ялгаж салгаагүйнхээ гайгаар алтан боломжоо алдсан тухай нэгэн түүх Лук ном дээр бий. Есүс “Тэр түүнд —Нэгэн хүн их зоог бэлдэж, олон хүн урьжээ. Тэгээд зоог барих цаг болоход уригдсан хүмүүст боолоо илгээн «Зоог бэлэн болов. Морилон ирцгээнэ үү» гэж хэлүүлжээ” (Лук 14:16-17) хэмээн айлдруун. Эзэний Үг маш тодорхой байна: Найрын ширээ бэлэн болов! Тэгэхээр, цаг гэдэг амин чухал аж.

Гэтэл уригдсан зочдын хариуг үзнэ үү: “... уригдсан хүмүүс бүгдээрээ л шалтаг тоочив. (18-аар эшлэл) Ирээгүй учрыг нь ч хүндэтгэх шалтгаанд тооцмоор. Нэг нь газар авсан бол, нөгөө нь ажил хэргээ явуулах шаардлагатай, гурав дахь нь гэргийдээ анхаарах хэрэгтэй юмсанж. Тэд чинь явж завхайрлаа, хулгайллаа, аллаа гэж хэлээгүй шүү дээ. Гэхдээ байна шүү, *нүгэлгүй зүйл ч Эзэний Үгээс дээгүүр залраад ирэхээрээ, нүгэл болж хувирдаг.*

Зарц нь эргэж ирээд, уригдсан зочдын хариуг дуулгатаг “Эзэн нь хилэгнэв” (21-ээр эшлэл). Гонсойгоогүй, харин хилэгнэсэн. Яагаад? Яагаад гэвэл хүмүүс урилгыг нь чухалчлаагүй, тоогоогүй.

Тэгээд эзэн яасан? Анх уриагүй хүмүүсээ урьсан. Эцэст нь Есүс “Би та нарт хэлье, уригдсан байсан нөгөө хүмүүсээс нэг нь ч миний зоогноос амсахгүй” (24-ээр эшлэл) хэмээн дүгнэжээ. Тэд боломжийнхоо цонхыг хаалгуулсан. Тоочсон шалтаг нь гэм хоргүй мэт боловч, гэмгүй зүйл ч биднийг Бурханы хүслийг гүйцэлдүүлэхээс төөрөлдүүлж чаддагийг сана. Бурханаас эмээх зүрхгүй хүн амархан ч төөрнө.

Дуулгавартай дагалгүй, саатсаныхаа урхагаар боломжоо хаалгасан түүх Бичээсээр нэг бий. Үнэндээ тоочихын аргагүй олон учраас, би дахиад ганц л гол гогдмоор түүх ярьж өгье. Лук 9

дээр Есүс хоёр хүнд “Намайг дага” гэсэн. Хамаг бүтээлийн Эзэн Өөрөө таныг хамт алхъя хэмээн урив! Эхний хүн зөвшөөрсөн атлаа: “Эзэн минь, эхлээд хариад, аавыгаа оршуулаадхья!” (59-ээр эшлэл) гэсэн болзол тавьжээ.

Тэр хүн Есүсийг дагахыг *зөвшөөрсөн* боловч, хувийнхаа сонирхлыг дээгүүр тавьснаараа Есүсийн урилгыг *хойшлуулжээ*. Тэр үед ууган хүү нь аавыгаа нутаглуулахдаа, хоёр дахин их өв хүлээж авдаг байсан бол, бусад хөвгүүд нь өөрт ноогдсон ганц хувиа л авдаг байсныг судлаач нар хэлдэг. Харин үүргээ биелүүлэхгүй бол, хувь нь удаах хүү рүү нь шилждэг байж. Есүсийн урилгыг хойш тавьсан тэр хүний шалтгаан хууль ёсны л асуудал бөгөөд нүгэлд тооцогдохгүй. Гэвч Есүсийг орхиж яваад, боломжоо алдсан нь тун харамсалтай.

Яг адилхан урилга хүлээж авсан хоёр дахь хүн нь: “Тэгье, Эзэн минь, би Таныг дагая. Гэхдээ *эхлээд* гэр бүлдээ баяртай гэж хэлээдхье” (61-ээр эшлэл) гэжээ. Мөн л *эхлээд* (буюу *нэгдүгээрт*) гэжээ. Түүний саатах шалтгааныг ч бас нүгэлд тооцохгүй. Гэвч энэ хүн ч мөн тэнгэр, газрын Бүтээгчтэй ойр байх боломжийнхоо цонхыг хаалгажээ.

Хожим “Эзэн өөр далан хүнийг томилж Өөрийн очихоор яваа хот, газар бүрд тэднийг хоёр хоёроор нь урьдчилан илгээв” (Лук 10:1) гэдэг. Дээрх хоёр хүн энэ далын дунд байж болох байсан ч, Бурханаас эмээх сэтгэлгүй учраас, дуулгаваргүй загнан, алтан боломжоо тавиад туучихжээ.

Миний бие өдий олон жил Бурханы хүмүүст үйлчилж явахдаа “Бурхан надад ингэ, тэг гэж айлдаад олон сар болж байна” хэмээн хэнэг ч үгүй ярих итгэгч хүнтэй таарахдаа, биширсээр л явна (муу утгаараа шүү). Тэгээд бүр хөөрхөн юм ярьчихсан аятай маасайхыг нь, заримдаа бүр инээд алдахыг нь яана. Угтаа ямар ч ариун эмээхүйгүй байдлаа л гайхуулж байгаагаа ухаарбал, инээхтэй манатай л болох байх.

Мосе шатаж байгаа бутны гайхамшигт үзэгдлийг харахаар хажуу руу эргэхээс хойш сууж, сүрэгтэйгээ зууралдаад үлдсэн бол, яах байсан бол? (Гэтлэл 3)

Ноа хөвдөг авдар барихаас хойш суусан бол, яах байсан бол?

Абрам Канаан явахаас хойш суусан бол, яах байсан бол? Гэтэл аав нь анх Канаан руу явах дуудлага хүлээж авсан атлаа

саатсан байдаг. Аавынхаа хойш сууж, саатуулсан зүйлийг Абрам биелүүлжээ (Гэтлэл 11:31).

Нехемиа Санбаллат, Гешем гэдэг хоёр удирдагчийн “Ажлаа зогсоогоод, хүрч ирээд уулз” гэсэн шаардлагыг хүлээж аваад, хана босгох ажлаа хойш тавьсан бол, яах байсан бол? Гэтэл Нехемиа “Би агуу үйл хэрэг хийж байгаа бөгөөд очиж чадахгүй. Би үүнийг орхиж та нар уруу очих хооронд энэ ажлыг зогсоох хэрэг юу байна вэ?” (Нехемиа 6:3) гэсэн байдаг.

Ийм жишээ олон. Гол дүгнэлт нь: Бурханы Үгд чичирдэг хүн Бурханыг шууд л дагана.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ. Харин Намайг үл тоомсорлогсдыг Би үл хайхарна. (1Самуел 2:30)

Санаа: Амин хувийн шалтгаанаар Бурханы Үгийг дагахаас хойш суух нь Түүний Үгийг хоёрдугаарт тавьж байгааг л илтгэнэ.

Эргэцүүлэл: Гэм хоргүй мэт юмс ч биднийг Бурханы хүслээс төөрөлдүүлж чадна. Нүгэл бус зүйл ч Эзэний Үгээс дээгүүр залраад ирэхээрээ, нүгэл болно. Би амин хувийнхаа сонирхолд сатаараад, дуулгавартай байхаас хойш суусан уу?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны Үгийг сонголт мэт үзэж, хамгаас чухалчлаагүйд уучлаарай. Ингэснээрээ би өөрөө ч мэдэлгүйгээр Танд чухал юмсыг юмын чинээ үзээгүй ажээ. Одоо гэмшиж, Танаас уучлал гуйж байна. Тэгээд Таны хүслийг хамгаас чухалчилж байна. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би Бурханы Үгийг мэдсэн даруйдаа шууд дагана.

*Бид хүний учир зүйгээр
амьдрахаар дуудагдаагүй.*

*Хамгийн чухал нь Бурханы Үгд болоод
жолоодлогод л дуулгавартай байх.*

*Түүний хүсэл дотор байгаа цагтаа бид
энэ дэлхийн хамгийн
аюулгүй газарт байна.*

— Итгэлийн ах Юн

24 | ЯМАР Ч УТГАГҮЙ ГЭМЭЭР

Өмнө Ариун Сүнс таныг ямар ч утгагүй гэмээр юм рүү хөтөлж байсан уу? Бурхантай тодорхой хугацаанд алхсан хүмүүс “Тийм” л гэж хариулна. Тэгвэл би өөр нэг асуулт асууя: Харин Бурханы Үгэнд орж, тэр утгагүй зүйлийг нь биелүүлснийхээ дараа, эрт юмуу орой утга учрыг нь ойлгосон уу? Хариулт нь бараг л дандаа “Тийм” гэж гардаг (Зарим нэг ховор тохиолдолд тэр зүйл нь шүүх сэнтийн өмнө зогсохоос өмнө тайлагдахгүй байх явдал байдаг учраас, бараг гэж хэллээ). Бурханы Үгд чичрэх гэдэг үгийн утгыг үргэлжлүүлэн судлангаа, жинхэнээсээ ариунаар эмээдэг хүн дараах зүйлийг хийдгийг мэдээрэй:

1. Бурханыг үтэр түргэн дагана.
2. **Ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханыг дагана.**

Бурхан юм л бол биднээс хүний ухаанаар ойлгошгүй зүйл хийхийг шаардаад байдаггүй ч, ийм явдал тохиолддог. Тухай нь, нэг зүйлийг асууя.

Шороо руу нулимаад, түүнийгээ сохор хүний нүдэн дээр түрхээд, явж угаа гэх нь аль хэр утгатай санагдаж байна? Тухайн үедээ утгагүй санагдсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь нүдгүй хүнд нүд хайрласан юм.

Хурим найр ид халаад, илүү их дарс шаардагдах үед дарсны савыг усаар дүүргэх нь аль хэр утгатай вэ? Тухайн үедээ утгагүй байсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь тэр хуриман дээрх хамгийн чанартай дарсыг бий болгосон юм.

Туршлагатай далайчин хүний хувьд аврах хантааз байсаар байтал, зөн совин, дасгал сургуулийнхаа эсрэг нүүдэл хийж, хөлөг дээрээ үлдэх нь аль зэрэг утгатай вэ? Тухайн үедээ утгагүй байсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь нэг ч хүнийг үхэлд хүргэлгүй, 276 хүний бүгдийнх нь амийг аварсан байдаг (Үйлс 27:27-36).

Бурханы тушаалаар хотыг хамарсан сэргэлтийн цуглаан эхлүүлчихээд, дараа нь энэ бүхнээ орхиод, цөлийн гүн рүү яваад өгөх нь аль хэр утгатай вэ? Тухайн үедээ утгагүй байсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь Етиопийн дээрээсээ гурав дахь албан тушаалтныг авралд хүргэсэн юм.

Зургаан өдрийн турш хэрмэн ханатай нүсэр хотыг чив чимээгүй бүслүүрдэн тойроод, долоо дахь өдрөө долоон удаа тойроод, эцэст нь бүрээ үлээж, хашхирцгаах нь хэр утгатай вэ? Тухайн үедээ утгагүй байсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь дайсны ханыг зүгээр л үйрүүлсэн юм.

Хортой шөлөнд гурил хийгээд, Бурханы зарц нарт идүүлэх нь хэр утгатай байв? Тухайн үедээ утгагүй байсан ч, энэ зөвлөгөө (цэц ухаан) нь хүн бүрт шим тэжээлтэй хоол болж, хэн ч үхэж, өвдөөгүй билээ.

Таныг, гэр бүл, дотны хүнийг чинь шархлуулсан хүмүүсийг уучлах нь аль хэр утгатай вэ? Тэд хариугаа хүртэх ёсгүй гэж үү?

Таныг үзэн яддаг хүмүүсийг хайрлах нь ямар утгатай вэ? Адилхан л хандах ёсгүй гэж үү?

Танд муу муухай хандсан хүмүүст сайн хандах нь утгатай гэж үү? Адилхан л хандах ёсгүй гэж үү?

Хорон муу үйл хэрэгтэй эрх баригчдыг хүндэтгэх нь утгатай гэж үү? Муулж, шүүмжлэх ёсгүй гэж үү?

Танд хүндэтгэлгүй хандаж байгаа хүмүүсийг хүндэтгэнэ гэдэг чинь юу гэсэн хэл вэ? Зүгээр л зайл гэх ёстой бус уу?

Ингээд л Бичээс дээрх ямар ч утгагүй мэт харагддаг ч, эцсийн дүндээ Бурханы цэц ухаан болох нь батлагддаг тушаалыг үргэлжлүүлээд л байвал, бүлгээ, за бүр номоо дуустал ч тоочиж болох юм. Тэгэхээр, Бурханы зааварт чичирч, Түүний үгэнд орсон хүмүүс ерөөгдсөн бол, ариун эмээхүй байхгүйн улмаас, тушаалыг үл хэрэгссэн юмуу дуулгаваргүй хандсан хүмүүс нь таагүй үр дүнд хүрсэн байдаг. Эзэнээс эмээхүй нь үнэхээр цэц ухааны эхлэл (Дуулал 111:10) болохыг та одоо илүү тод харж байгаа байх аа.

Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Бүү түшиглэ, өөрийнхөө ойлголтод. Түүнийг мэдэхэд зам бүхэн чинь байг Тэрээр зам харгуйг чинь шулуутгана. (Сургаалт үгс 3:5-6)

Бидний ухаан Эзэний цэц ухаанд чирэгдэх учраас, хүнийхээ ойлголтод түшиглэх хэрэггүй. Бурханаас учир зүйгүй мэт харагдах тушаал хүлээж авах үед төрөлх ойлголт чинь таныг дуулгавартай загнаж, ашиг тусыг нь хүртэхэд чинь тээг болно. Гэлээ ч ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханаас эмээгч хүн Бурханыг л дуулгавартай л дагадаг юм.

Хэдэн жилийн өмнө нэгэн саятантай уулзаж байлаа. Түүний ажил карьер эхэн дээрээ тун явцгүй байж л дээ. Тэгээд амжилттай бизнес босгохыг сургадаг бүхий л бестселлер номыг уншиж, олсон цэц ухаанаа ажил хэрэг болгосон гэнэ. Гэвч бүтэлгүйтсэн хэвээрээ л.

Нэг өдөр чуулган дээрээ пасторынхаа номлолыг сонсоод сууж байтал сайнмэдээг номлохоор дуудагдсан энэ хүн тэр үүрэг даалгавраа Ариун Сүнснээс бүрэн хамааралтай гүйцэтгэдэг байхад, зах зээлийн талбарт дуудагдсан би яагаад Ариун Сүнснээс хамаарахгүй ажиллаж амьдарч байна? гэсэн бодол харван орж иржээ.

Тэгээд өглөө бүр сэрээд, Эзэнээс тухайн өдөртөө чиглүүлэг, зааварчилгаа гуйгаад, төрсөн санаа бүрээ дэвтэртээ бичдэг болжээ. Үүнээс гадна өдрийнхөө турш - бүр чухал хурал дээр байсан ч, Ариун Сүнсний зааварчилгаа - үгд нэг чихээ хэзээд бэлэн байлгаж байхаар шийджээ.

Тэгээд үүнийгээ тодруулж ярив. Тухайлбал, нэг өдөр хөрөнгө оруулалтын чухал уулзалт товлосон байж. Өглөө нь Ариун Сүнс түүнд нэг их ач холбогдолгүй гэмээр юм хийхийг сануулах шиг болжээ. Ямар ч утгагүй боловч, тэрбээр үгийг нь дагасан байна.

Ариун Сүнс түүнд яг нэг зүйлээ удаа дараалан хийхийг зааварчилсаар байж. Тухай нь, эш үзүүлэгч Элишагаас сумаараа газар цохих заавар хүлээж авсан хааны түүх санаанаас нь гарахгүй байж л дээ. Сумаараа гурван удаа газар цохисон хаан илүү олон удаа цохисонгүй хэмээн эш үзүүлэгчээр зэмлүүлсэн байдаг (2Хаад 13:14-19). Тэгээд тэр бизнесмэн нэг үйлдлийг хорин удаа гүйцэтгэжээ. Хожим тэрбээр надад: “Тэр өдөр манай компани Вьетнамд хорин эмнэлэг худалдаж авсан” гэж хэлсэн юм.

Дараа нь Европийн хамгийн томдоо тооцогдогдох нэгэн банкийг худалдаж авсан түүхээ ч ярив. Энэ үйл явц нь нөгөө эмнэлгийн хөрөнгө оруулалтаас ч илүү ер бусын явдал байжээ. Би бүр ангайж билээ. Товчхондоо тэр бизнесмэн залбирлынх нь хариу учир зүйтэй санагдсан ч, санагдаагүй ч, Бурханыг л дагахыг сонгожээ. Үр жимс нь ч ил тод байна - эдүгээ бизнес нь бүтэлгүйтэхээ больж!

Би нэг хүүдээ өсвөр наснаас насанд хүрэгч рүү шилжих насанд дээр нь ямар ч утгагүй гэмээр хүсэлт тавьсан юм. Хүү минь ч миний шал утгагүй зааврыг эсэргүүцэн, надтай нүүр тулсан боловч, би хөдөлсөнгүй. Сүүлдээ хүү маань аргаа бараад: “Аав аа, би чинь шинэ мянганы хүн. Тиймээс ямар ч юмыг хийхдээ “Яагаад” гэдэг шалтгааныг нь мэдэх хэрэгтэй байна” хэмээн учирлаж билээ.

Би хүүдээ “Тэгвэл хоёулаа тохирьё. Би чамд нэгэн бодит түүх ярьж өгье. Бурхан Иудагийн нэгэн залуу эш үзүүлэгчид “Бетел рүү яваад, Израилийн хаанд эш үзүүлээд, Иуда руу харихдаа очсон замаараа явахгүй байх, дээрээс нь замынхаа турш юу ч идэхгүй байхыг” тушаасан. Гэтэл залуу эш үзүүлэгч Ариун Сүнсний зааврыг дагаагүй бөгөөд үүнийхээ хохирлыг ч үзээд, замдаа арсланд алуулсан байдаг (1Хаад 13:16, 23-26). Иймд хүү минь, хоёулаа ингэж тохиролцъё. Чи тэр залуу эш үзүүлэгчид өгсөн онцгой зааврын цаад “Яагаад” гэдэг учрыг надад тайлбарласан өдөр чинь би чамд өөрийнхөө зааврын цаад “Яагаад” гэдэг учрыг тайлбарлаж өгье” гэж хэлсэн юм.

Хүү минь өнөөдрийг хүртэл тайлбарлаагүй л явна. Үнэндээ тэр учрыг би өөрөө ч гайхдаг. Заримдаа Бурхан бидний хувьд ямар ч утга илэрхийлэхгүй зүйл хийхийг тушаадаг. Гэхдээ Бурханы цэц ухаан нь ямагт үр дүнгээрээ баталгааждаг юм. Тиймээс л Есүс “мэргэн ухаан үйлсээрээ зөвтгөгддөг” (Матай 11:19) гэжээ.

Бид бүгдээрээ шөнөжин загасчлаад, загасчлаад юу ч бариагүй хэдий ч, буцаад далайд гараад, тороо дахиад хая гэсэн Есүсийн дуу хоолойг сонссон Петр шиг байх болтугай. Хэдийнээ эцэж цуцталаа оролдсон хүмүүсийн хувьд энэ тушаал нь дэмий хүчин зүтгэл мэт. Гэтэл Петр ямар сайхан хариу хэлсэн гээч? “Эзэнтэн, бид шөнөжингөө зүдэж зүтгээд юу ч бариагүй, гэхдээ хэлснээр тань тороо доошлуулья” (Лук 5:5). Тэгээд хоёр онгоц дүүрэн загас!

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Мунхаг хүн болбоос зүрхэндээ итгэдэг мэргэн хүн харин аюулаас зайлдаг. (Сургаалт үг 28:26)

Санаа: Бидний ухаан Эзэний цэц ухаанд чирэгдэх учраас, хүнийхээ ойлголтод түшиглэх хэрэггүй. Бурханаас учир зүйгүй мэт харагдах тушаал хүлээж авах үед төрөлх ойлголт чинь таныг дуулгавартай загнаж, ашиг тусыг нь хүртэхэд чинь тээг болно. Гэлээ ч ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханаас эмээгч хүн Бурханыг л дуулгавартай л дагадаг юм.

Эргэцүүлэл: Би Бурханы цэц ухаанд итгэх гэж зүдэрдэг үү? Надад Бурханы санааг хойш тавиад, өөрийнхөө учир зүйд найдах тохиолдол байсан уу? Тэгээд юу болсон? Бурханыг харж, Бурханд найдсан бол, яах байсан бол? Одоо би ингэж чадах уу?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таныхаас илүү өөрийнхөө мэргэн ухаанд найдсанд уучлаарай. Таны Үгийг уншихдаа мөн Танаас эмээдэг хүмүүсээс бурханлаг ухаан сонсохдоо, Таны цэц ухааныг хүлээж авах итгэл хайрлаач. Ямар ч утгагүй санагдаж байсан ч, итгэж, дуулгавартай дагах хүч хайрлаач. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Бурханы чадвараас илүүтэй хүний чадварт найддаг хүмүүсийн дуу хоолой, өөрийнхөө дуу хоолойноос илүү Бурханыхаа цэц ухааныг дагахыг сонгож байна.

*Шагнуулна гэсэн найдвар, шийтгүүлнэ
гэсэн айдас байхгүй байсан ч, Бурханыг
хайрлаж, Түүнээс эмээж амьдрах нь
хүмүүний үүрэг.*

— Маймонидэс

25 | ИЛ ХАРАГДАХ АШИГ БАЙХГҮЙ ҮЕД Ч

Оюутан болсон хүү, охин нь зөвхөн мөнгө хэрэгтэй болохоороо л холбоо барьдаг талаар аав, ээжүүд гомдолтой өгүүлэхийг та сонсоо л байх. Тэгээд энэ ховор тохиолдлынхоо үеэр хүүхэд нь аав, ээжтэйгээ утсаар ярихдаа, хайлсан тугалга шиг л зантай байх хэдий ч, цаана нь мөнгө салгах гэсэн гол санаа л хорогдоостой. Тэгвэл ариун эмээхүй л биднийг тэнгэрийн Аавдаа ингэж хандахаас сэргийлж, Бурханы Үгд чичрэх дараагийн төвшин өөд гаргадаг. Тэгэхээр шинэ хүчин зүйл орж ирж байна. Бид:

1. Бурханыг үтэр түргэн дагах.
2. Ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханыг дагах.
3. **Амин хувийн ашиг харагдахгүй байсан ч, Бурханыг дагах ёстой.**

Миний бие дөчөөд жил үйлчлэхдээ, ялангуяа Барууны чуулганаас нэгэн харамсалтай дүр төрхийг ажиглав. Юу гэхээр, итгэгчд нарыг дуулгавартай амьдралд уриалахын тулд ашиг тусыг нь л цохоод байдаг. Бодоод үз л дээ. Бид ариун амьдралд уриалсан номлол сонсохын төлөө аль болох урагшаа суухын тулд цуглаан эхлэхээс гучин минутын өмнө ирэх болов уу? Дуулгавартай амьдрахыг заадаг ном бестселлер болох болов уу? Хөгжлийн чигтэй хөл нийлүүлэхийн тулд удирдлага маань үнэнтэй нүүрэлдэхээс зайлсхийдэг болсон уу? Өөрөөр хэлбэл, үйлчлэгч нарын тодорхой хувь нь Бурханы хүмүүсийг өөрсдийгөө

няцаагаад, Есүсийг дагахад уриалан дуудахын оронд, сэтгэл гижигдэм түүхээр хөгжөөх дарамт үүрч явна уу?

Энэ чиг яагаад гашуудмаар үнэн болчихов? Бид Бурханы цэц ухаанаас зайлсхийснээрээ, үнэндээ өөрийгөө л хорлодог. Түүний тушаал, зөвлөгөө, цэц ухаан нь эцэстээ энэ амьдралд ч, ирэх амьдралд ч хамгийн аугаа ерөөл авчирна. Бурханы Үгийг “дагасан хүмүүс аугаа шагналтай” (Дуулал 19:11) гэдэг. Бурханаас давж өгнө гэж байхгүй. Ашиг тус нь ч Бурханы төлөө таны хийж чадах бүхнээс чинь хол давна.

Нөгөөтэйгүүр, шан харамжийн сэдлээр хөдлөх нь тун аюултай. Яагаад? Ил ашиг тус харагдахгүй үед бид Бурханы зааврыг ялгаагүй л эрс шийдэмгий дагах болов уу? Хувийнхаа ашиг сонирхолд л дийлдэх болов уу. Тиймээс л Эзэнээс эмээх нь амин чухал бөгөөд шагнуулах эсэхээсээ үл хамааран, дуулгавартай дагахад хүргэдэг юм.

Бусад хаанчлалыг бут цохисон Персийн эзэнт гүрнийг энэ дэлхийн хамгийн хүчирхэг хаан - Ксеркес (мөн Ахашверош ч гэдэг) захирч байв. Тэрбээр Естер гэдэг Еврей гэргийтэй байлаа.

Хааны нэгэн тэргүүн тушаалтныг Хаман хэмээх. Гэтэл тэрбээр Естериин садны хүн, мөн л хааны албат - Мордихайд хорсжээ. Тэгээд уурандаа ганц Мордихайг бус, Еврейчүүдийг үндсээр нь устгахыг санаархав. Гэвч Хаман ч, хүмүүс ч Естер хатныг Еврей хүн байсныг нь мэдсэнгүй.

Хаман хаанд Еврейчүүдийг хайр найргүй гүтгэх ажлаа эхлүүлж, тэднийг ганц өдрийн дотор л хүйс тэмтрэхийг санал болгожээ. Тэгээд санаандаа ч хүрэв. Хаан зөвшөөрч, зарлиг гаргаад, бэлзгээрээ тамгалжээ.

Энэ зарлигийг олж мэдсэн Мордихай садныхаа охин Естерт хэл хүргүүлээд, хаанаас Еврейчүүдийн амийг хэлтрүүлэхийг гуйхыг хүсэв.

Гэтэл Естер Мордихайд: “Дуудагдаагүй байж хааны дотоод ордонд орох эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн үхэх ёстой гэсэн ганц хууль байдаг бөгөөд хаан алтан очирт таягаа түүн уруу сунгавал л тэр хүн амьд үлддэг гэдгийг хааны бүх зарц, хааны аймгуудын ард түмэн мэднэ. Тэгтэл би энэ гуч хоногийн турш хаан дээр дуудагдаагүй байна” (Естер 4:11) гэж хариулжээ.

Естер хэдий Ксеркес хааны хатан байсан ч, хааныг дуудаагүй байхад сэнтийн өрөөнд нь дураараа явж орбол, гарцаагүй цаазлуулах байв.

Бодоод үз: Естер чинь хатан хүн. Түүнд санаалсан бүхнээ эдлэх тансаг амьдрал байна. Бурханы хүмүүсийн төлөө амиа эрсдэлд оруулан байж хаан дээрээ явж орох нь Естерт ширхэг ч ашиггүйгээр барахгүй, байгаа бүхнээ - тэр тусмаа толгойгоо алдах ч гарзтай хэрэг болно. Тийм байтал Естер Мордахайд юу гэж хариулсныг үзнэ үү:

Явж, Сусад байгаа бүх иудейчүүдийг цуглуулж, миний төлөө мацаг барьж, шөнө ч, өдөр ч гурван хоногийн турш бүү ид, бүү уу! Би болон миний шивэгчингүүд ч мөн ийнхүү мацаг барина. Хуулийн дагуу биш ч гэсэн би хаан дээр орно. Хэрэв *би үхэх ёстой бол үхнэ.* (Естер 4:15-16)

Ариун эмээхүй нь л Естерийг Бурханы хаанчлалыг хувийнхаа жаргалаас дээдлэхэд хүргэжээ. Естер дуулгавартай байдлаасаа болж тав тух, аюулгүй байдал, баялаг, байр сууриа эрсдэлд оруулсан. Энэ бүхэн нь Естерт ширхэг ч ашиггүй боловч, тэрбээр Бурханы чухалчилдаг ширхэг зүйлийг ч чухалчилдаг байжээ. Естер Бурханы Үгд чичирдэг, Бурханаас эмээдэг бүсгүй байв.

2015 онд Лиза, бид хоёр Армений Ереван хотод 3,500 удирдагчид үйлчилсэн юм. Зүүн Европ, Ойрх Дорнодын зүг бүрээс хүрэлцэн ирсэн пасторуудын дунд Иранаас (Ереван хот нь Ираны хилээс 50 гаруй километрийн зайтай) ирсэн удирдагч олон байв. Тэр үед Ираны иргэд Армени руу нэвтрэх эрхтэй байсан болохоор нууц чуулганы олон удирдагч ирж оролцсон юм. Цуглаан ч сүр жавхлантай байлаа.

Сүүлчийн цуглаанаа дуусгаад, Лиза, бид хоёр агаар амьсгалахаар Ереваны төв гудмаар зугаалав. Тэгж явтал, хорин тав орчим насны хоёр бүсгүй гүйхээрээ гарч ирээд, бидэнтэй мэндлэх нь тэр. Тэд Иранаас ирсэн удирдагч нар байв. Тэд нүд унагам үзэсгэлэнтэй, дээрээс нь гал дөлөөр бадарсан бүсгүйчүүд байсан болохоор, би ч бүр барьц алдаад *Энэ хоёрыг гурван хүүгийнхээ хэнтэй нь танилцуулъя даа?* гэж хүртэл бодоод амжсанаа ний нуулгүй л хэлье.

Лиза, бид хоёр тэдэнтэй хориод минут ярилцав. Шашны цагдаа нар тэднийг мөрдөж мөшгидөг бөгөөд конференцийн үеэр Ираны эрх баригчид залгаад, хаана байгааг нь шалгаажээ. Тэгээд нэг бүсгүй нь утсан дээр нь ирсэн сэрдхийм мессежийг ч үзүүлэв.

Тэгэхэд нь би дөчин жил үйлчлэхдээ гаргаж үзээгүй, хамгийн тэнэг алдаагаа гаргаж билээ. Би: “Чи буцаж яваад яах юм бэ? Зугтчихбал яадаг юм?” гэхихсэн юм.

Нөгөө бүсгүй над руу өр зөөлөн атлаа шийдмэг нүдээр үнэн голоосоо ширтээд: “Бид буцаж очихгүй бол, Перс хүмүүст хэн Есүсийн тухай хэлж өгөх юм бэ?” гэж хариулж билээ.

Тэр хариулт намайг нам болгов. Хоёр залуу бүсгүйн амиа аврах зөн совин нь улс үндэстнийхээ дотор хаанчлалыг дэлгэрүүлэх гал хүсэл тэмүүлэлд нь цохигдон, хоёрдугаар зэргийн асуудал болж хувирчээ. Тэд Естертэй л адил ариун эмээхүй дор амьдарч байв. Тэд Бурханыг амин хувийн ашиг тооцохгүйгээр үл барам, амь насаа ч аюул заналд тушаан байж дагажээ. Би тэднээс сургамж ч, урам ч авч билээ.

Тэр хоёр залуу бүсгүйнх шиг шийдмэг зан чанар нь ганц удаагийн тэрс үйлдэл бус, харин хөгжүүлдэг бас амьдруулдаг зүрхний хандлага юм. Бид жижиг гэлтгүй зүйл дээр ч Бурханы Үгийг, Ариун Сүнсний удирдамжийг дагахыг сонгох хэрэгтэй. Ид ажилтай байхад, Ариун Сүнс хэн нэгэн рүү ярихыг сануулж болох. Үнэндээ ярих ч шалтгаан байхгүй, ярилаа гээд ашиг ч байхгүй байсан ч, зүгээр л ярина. Харин “Учир” нь голдуу хожим л тайлагдана.

Эсвэл нэг хүн бидний талаар цуурхал дэгдээгээд байж болох. Түүнийг уучилж, эвлэрч, ерөөгөөд байх шалтгаан үгүй атал бид “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнээ энэрч аядуу зөөлөн сэтгэлээр ханд... та нарыг хараагсдыг ерөө” (Ефес 4:32, Лук 6:28) гэдэг тушаалыг шууд дагахыг сонгоно.

Магадгүй хэн нэг хүн биднийг үзэн ядаж, шударга бус хандаж болох. Есүсийн “Дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир” (Матай 5:44) гэдэг үгийг дагасны илт ашиг юу вэ? Эсвэл: Хавчлагатай улс оронд амьдарч байгаа итгэгч нар өөрсдийг нь хавчиж, тамлаж, түүгээр барахгүй хайртай хүмүүсийг нь алж хядаж байгаа хүмүүсийг ерөөх нь ямар ашигтайг бодоод үз. Гэтэл

Лиза, бид хоёр яг ийм нөхцөлд амьдарч байгаа атлаа амьдрал, баяр хөөрөөр гийж яваа пасторуудтай уулзаж явсан.

Өөр улс үндэстэнд байгаа хүмүүсийн төлөө залбирах нь ямар ашигтай гэж? Эсвэл танд эргүүлж төлөхгүй, өөр улсын хүмүүст зориулж өргөх нь ямар ашигтай гэж? Гээд л тоочоод л байвал, тоочоод л байна. Тэгэхээр, та Бурханыг зүрхэнд чинь асаатай ариун эмээхүйгээр тууштай дагаж чадах уу? Эсвэл хувьд чинь ямар ашиг тусахыг харзнаж байж дагах уу?

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно. (Матай 16:25)

Санаа: Хувьд маань ашиггүй харагдах Бурханы цэц ухаанаас зайлсхийснээрээ, хамгийн том ерөөлөө алдах нь олонтаа. Энэ нь үнэндээ уртын замд хохирол авчирна. Бурханаас давж өгнө гэж байдаггүй юм.

Эргэцүүлэл: “Амиасаа зуурах” хэмээн Есүс юун тухай хэлсэн бэ? Энэ үгийг итгэлийнхээ төлөө алуулах зэрэг эрс тэс явдлаар л төсөөлж ойлгож байв уу? Үүнийг өдөр тутмын жирийн, жижиг шийдвэр дээрээ хэрэгжүүлж байсан уу? Хэрэгжүүлсэн бол, яах байсан бол? Амьдрал минь хэрхэн өөрчлөгдөх байсан бол?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, надад ашиггүй санагдсан үед Таны цэц ухаанаар өлсөөгүй, дагаагүйг минь уучил. Энэ сэтгэлгээгээ улайж, уучлал гуйж байна. Одооноос эхлэн амьтайгаа зууралдалгүй, Есүсийн төлөө зориулмаар байна. Тийнхүү түргэн ашиг харагдахгүй байсан ч, би Таны цэц ухаанаар өлсөж, цангах болно. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би алхам тутмаа Эзэн Есүсийнхээ хүсэл, цэц ухаанд амь амьдралаа зориулна.

*Дуулгавартай байдлаас ангид
аврал үгүй. Учир нь дуулгавартай
байдалгүй аврал нь өөрөө өөрийгөө
няцаасан, худлаа зүйл болно.*

— Эй. Даблью. Тозер

26 | АШИГТАЙ ЗОВИУР

Бүсгүй хүн амаржих таатай бус, тун хэцүү, маш зовиуртай. Гэхдээ үр дүнд нь тэр айл шинэ хүнээ угтаж авна. Эмэгтэй хүн жирэмсний үеийн хямрал, амаржихын зовиурыг заавал давж байж л, тэр хөөрхөн шинэ амь мэндэлнэ. Энэ жишээ бидэнд Бурханы Үгд чичрэхийн удаах талыг зэрвэс харуулж байна. Тэгэхээр өмнөх гурван хүчин зүйл дээрээ шинэ хүчин зүйлээ нэмье:

1. Бурханы Үгийг үтэр түргэн дагах.
2. Ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханыг дагах.
3. Амин хувийн ашиг харагдахгүй байсан ч, Бурханыг дагах.
4. **Зовиуртай байсан ч, Бурханыг дагах.**

Судлалын маань суурь болсон Филиппой 2:12-13-аар эшлэл дээр бидэнд авралаа айдас, чичрэлээр гүйцэлдүүлэхийг сануулдаг. Энэ үгийнхээ өмнө Паул биднийг *дуулгавартай байхад* уриалан дуудахдаа, Есүсийг үлгэрлэн дагаарай гэсэн. Эзэн маань тэнгэрийн эрх ямбаасаа татгалзаад, “өөрийгөө мөхөс болгож, Үхэлд, загалмайн үхэлд хүргэл *дуулгавартай байв*” (Филиппой 2:8). Есүс аймшигтай зовлон туулах шаардлагатай байсан ч, Аавынхаа хүсэлтийг дуулгавартайяа дагажээ.

Цовдлуулахынхаа урьд орой, Гетсемен цэцэрлэгт байхдаа Есүс: “Аав минь ээ! Болдог бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таныхаар болог” (Матай 26:39) хэмээн тарчлан дуу алдсан байдаг. Есүсийг дуулгавартай дагах, амиа бодохын хооронд амь тэмцэн тарчлах үед хөлс нь цусан дусал болон дусалсан гэдэг. Есүс “Нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн” (Еврей 4:5) гэдгийг санаарай. Есүс айсуй, аймшигт зовлонг урьдаас үзээд, үүнийг гүйцэтгэх өөр нэгэн замыг

Бурханаас эмээхүй

Аваасаа гуйсан боловч, ямар ч боломжгүй байв. Ийм зэрэглэлийн дуулгавартай байдалд юу түлхэц болдог вэ?

Тэрээр махбодынхоо өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах Нэгэнд чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөсөн.
Тэр эмээдэг байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ. (Еврей 5:7)

Гүн гүнзгий ариун эмээхүй л Есүсийг ямар ч хүний зугтах байсан зүйлтэй нүүр тулах хүчтэй болгожээ. Үүнтэй адил бидэнд ч:

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар *өөрсдийгөө зэвсэглэ*. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан (1Петр 4:1) гэжээ.

Цааш явахаасаа өмнө нэгэн чухал санааг дамжуулмаар байна. Аливаа шашинд бурхан шүтээнээ хөгжөөхийн төлөө өргөл барьцыг эрэлхийдэг бол, Христэд итгэх жинхэнэ итгэлд Бурханд дуулгавартай байхыг л эрэлхийлдэг бөгөөд ингэх явцдаа гэмт дэлхийн эсэргүүцэлтэй тулгарч, зовж зүдрэх нь олонтаа. Бурхан бэрхшээл зовлонг эрэлхийлэхдээ дуртай бус, харин дуулгавартай байдалд л дуртай. Хүн биеийн юмуу оюун сэтгэлийн зовлон үзэж болох бөгөөд аль аль зовиур нь маш бодитой юм.

Петр *өөрсдийгөө зэвсэглэ* гэжээ. Цэргүүд онгоц, усан онгоц, танк, буу, сум, хутга - ер нь зэвсэггүй байлдах уу? Инээдтэй биз дээ? Үүнтэй адил Христэд итгэдэг хүн зовлонд бэлтгэлгүй байх нь солиотой хэрэг боловч, үнэндээ олон итгэгч хүн ямар ч бэлтгэлгүй явдаг. Тэгээд зэвсэггүй итгэгч хүн амиа хамгаалахын тулд зовлонгоос даруй бултдаг. Тэгвэл Эзэнээс эмээхүй нь биднийг зэвсэглэдэг бөгөөд ямар ч зовлон ирлээ, Бурханыг дагах шийдмэг хүслийг маань бэхжүүлдэг.

Би энэ номыг дүүргэх чинээний олон зовлонгийн түүх ярьж өгч чадна. Гэхдээ тэр дундаас 1990 оны эхээр гэр бүлээ аваад, үйлчлэлийн аянд гарахдаа, пастор нь том чуулганд үйлчлэхээр яваад өгсөн учраас, пасторгүй болоод удаагүй байгаа, газрын мухрын нэгэн чуулганд очиж үйлчилсэн түүхээ ярьмаар байна.

Эхний хэдэн цуглаан маш хүнд байв. Чуулганы дийлэнх хувь нь огт анхаарахгүй, араар нэг марзагнаж, хөхрөлдсөн залуус. Гэтэл гурав дахь цуглаан дээр байдал эргэв. Бурхан хүмүүст хүчтэй

хүрэлцэж, нөгөө залуус чинь эхний эгнээг эзлэхийн тулд эртлэн ирж эхлэв. Ирц ч нэмэгдэж, цуглаан нь ч хэдэн долоо хоногоор үргэлжлэв. Тэр жижиг чуулганы байшин орой болгон пиг дүүрч, хэд хэдэн хүмүүс аврагдаж, бараг л хүн болгон сэргэв.

Нилээд залбирсны эцэст тэр чуулганыг шинэ пастортай болох хүртэл биднийг хэдэн сараар үлдэж, үйлчлээч гэсэн санал тавив. Гэвч чуулганы үйл ажиллагаа, амьдрал дээр тогтоосон эрх мэдэл, тооцоололд нь өөрчлөлт орох учраас, энэ санаа чуулганы зөвлөлд таалагдсангүй. Хамгийн почирдмоор нь тэд залуусыг эрт ирж, эхний эгнээг эзэлж байгаад гомдоллож билээ. Энэ мэтчилэн өмнөөс нь ч улаймаар олон хөгийн гомдол гаргав. Товчхондоо, тэд эцэстээ биднийг явуулахыг л хүссэн юм.

Санал хураасан тэр орой нь би чуулганд маргааш сүүлчийн удаа үйлчлэх болсноо зарласан юм. Танхим доторх хүмүүсийн дийлэнх хувь нь энэ шийдвэрт дургүй байгаагаа нууж хаалгүй, чангаар илэрхийлж, байдал ч түгшмээр, хурц, эвгүй байв.

Маргааш нь тэр цуглааны нэгэн гишүүн эмэгтэйн хилэгнэсэн нөхөр нь цуглаан руу залгаад, бидний сүүлийн цуглаан дээр чуулганы байрыг дэлбэлнэ хэмээн заналхийлэв. Би ч энэ талаар цагдаагийн албан хаагчтай утсаар ярих хүртлээ энэ асуудлыг инээдэм л гэж бодож байлаа.

Тэгээд итгэж ядсандаа: “Яалаа гэж ийм зүйл болох вэ дээ?” гэлээ.

Тэгтэл цагдаагийн албан хаагч: “Эрхэм ээ, би тэр хүнийг мэднэ. Тэр чинь хар тамхины томоохон наймаанд сэжиглэгдэж байсан... Ер нь хэд татчихсан явж байвал, би л лав ойртохгүй хүн” хэмээн хариулсан юм.

Тиймээс жаахан түгшээд: “Цагдаагийн газар чуулганыг хамгаалалтад авч болох уу?” л гэлээ.

Гэвч цагдаагийн албан хаагч надад үнэмшмээргүй хариулт өгөв: “Танай жижиг хоттой хамгийн ойр байдаг манай цагдаагийн цэг наанаас чинь бараг 60 километр. Би өнөө орой 18 цагт ээлжээсээ бууна. Хүн хүч байхгүй учраас, хэн ч тэр холоос наад руу чинь очиж чадахгүй.”

Би харилцуураа таслахдаа, сонссон зүйлдээ итгэж ядаж байсан ч, үүнээс илүүтэй сэтгэл минь хачин их түгшиж байлаа. Толгой дотроо “Бушуухан юм хумаа аваад, энэ хотоос арилах минь” гэж хашхирч байв.

Манай гэр бүл цуглааны нэгэн гишүүний нилээд өргөн чиргүүлийг хүнгүй шахам газарт тавиад, тэндээ амьдарч байсан болохоор, ямар ч дайралтад хялбар өртөж болохоор байлаа. Бид гадуурхагдаж, аюултай байдалд оров. “Ер нь тэр орой цуглаанд очих хэрэг байгаа ч юм уу? Зөвлөл биднийг бараг л хөөсөн болохоор, зүгээр л яваад өгчихье!”

Энэ бол амиа бодсон бодол гэдгийг би мэдэж байлаа. Хий заналхийллээс болоод чимээгүй хаяад явчихбал, эхний хэдэн долоо хоног бидний хийсэн цуглаанаар амьдрал нь өөрчлөгдсөн олон хүн удирдагчдаа гологдсон мэдрэмжтэй хоцорно. Зугтбал, насан турш давтагдаж мэдэх, няцдаг үлгэр загварыг өөртөө тогтооно гэдгийг мэдэж байлаа. “Хөлсний хүн (цалин хөлсөөр л ажилладаг хүн)... чоно ирэхийг хараад хоньдыг орхин зугтдаг” (Иохан 10:12) гэж хэлсэн Есүсийн үг л бодогдоод байв.

Бид зогсоо зайгүй залбирч байлаа. Зүрхэнд минь “Эзэний оршихуйд амьдардаг хүмүүс”... өөрөө хохирсон ч андгайлснаасаа үл няцна” (Дуулал 15:4) гэдэг бичээс ахин дахин цуурайтсаар. Эцэстээ бидний зүрх амар тайвнаар дүүрч, бид аюулгүй байхаа мэдэв. Тэр оройн цуглаан ч маш хүчтэй байлаа. Бөмбөг ч дэлбэрсэнгүй. Бид ч цуглаанд зохих ёсоор баяртай гэж хэлэв.

Бид Бурханы арга замтай зөрчилддөг, тэр бүү хэл бүр дайсагнадаг нүгэлт дэлхий дээр аж төрдөг улс. Тиймээс л бидэнд “Учир нь Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус, Түүний төлөө бас зовох нь та нарт соёрхогдсоныг” (Филиппой 1:29) мэдүүлсэн. Ганц Паул бус, Петр ч хэлсэн:

Учир нь та нар үүнд дуудагдсан билээ. Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн. Тэр нүгэл үйлдээгүй, аманд нь мэх худал байгаагүй. Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа. (1Петр 2:21-23)

Бид шударга бусыг үзэх тоолондоо өс хонзон авах бус, харин Бурханы мутарт даатгах ёстой. Яагаа ч үгүй дүр эсгэх бус, харин залбирлаараа Бурханд өргөх ёстой. Бурхан Өөрийнхөө цагт, Өөрийнхөө арга замаар бидний өс хонзонг авна.

Хаанчлалын баатрууд итгэлээрээ аугаа ялалт байгуулсан нь олон чиг, Бурханд дуулгавартай явсныхаа төлөө “гоочлуулж, гинжлүүлж, тамлуулж, хүчирхийлүүлж, хоригдож, цөлөөр тэнүүчлэх, агуйд хорогдох гэх зэрэг зүсэн зүйлийн тав тухгүй, зовиуртай нөхцөлд амьдарч байсан (Еврей 11:36-39). Тэд бүгдээрээ Бурханаас эмээдэг учраас, зовиуртай нөхцөлөөс няцалгүй, дуулгавартай дагасан гэдгээрээ хоорондоо адилхан. Тэгэхдээ тэд “Нулимс дуслуулан үр суулгагчид уухайн дуутай ургац хураана... Багцалсан тариагаа үүрэн Баяр хөөрийн дуутай гэртээ ирнэ” (Дуулал 125:5-6) гэдэг амлалтад итгэсэн юм.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ЭЗЭНээс эмээгчдэд бат итгэл. Энэ нь хүүхдүүдэд нь хоргодох газар. (Сургаалт үгс 14:26)

Санаа: Эзэнээс эмээхүй нь биднийг дайсагналын улаан нүүрэн дээр ч Бурханыг бат дагах шийдвэрээ хадгалах хүчтэй болгодог.

Эргэцүүлэл: Би амиа аврахын төлөө Бурханы Үгд дуулгаваргүй авирлаж байсан уу? Надад гэмшээд, Эзэнээс эмээж амьдрах хүсэл байна уу? Санхүүгийн, нийгмийн тэгээд бүр биеийн гарз хохирол үзсэн ч, би хайрласаар, дуулгавартай байсаар байж чадах уу?

Залбирал: Эзэн минь ээ, амиа хамгаалахын төлөө Таны Үгд удаа дараалан дуулгаваргүй байсныг минь уучлаарай. Би мунхаг сонголт хийснээ ойлголоо. Миний хамгаалах арга түр зуурынх бол, Таны хамгаалалт хэзээ ч хөсөрдүүлэшгүй, мөнхийн чанартай. Одооноос эхлэн би Эзэнээс эмээж амьдрахыг сонгож байна. Ямар ч үнээр хамаагүй Таныг л дагадаг, шийдмэг байхад минь туслаарай. Энэ хүч чадалд тань баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Эцэстээ зовсон ч хамаагүй, би Бурханыг л дуулгавартай дагах ариун эмээхүйгээр зэвсэглэгдсэн. Би шударгаар шүүдэг Бурхандаа сэтгэлээ даатгана.

*Хөл доорх замаа дэнсэл.
Зам бүхэн чинь дайвшгүй байг.*

— Сургаалт үгс 4:26

27 | ГҮЙЦЭЭ

Бүлгээ эхлүүлэхээсээ өмнө нэг юм асуухыг минь зөвшөөрнө үү: Гүйцээхгүйгээр аливаа төслийг хүчин чадалд нь тулгах боломжтой юу? Хариулт нь мэдээж үгүй. Эзэн маань хаанчлалаа байгуулах нүсэр төслөө эхлүүлээд, ид дундаа явж байна. Эзэнээс бидний хүн нэг бүрт хариуцуулж өгсөн дэд төслүүд бүрэн гүйцэлдэхийн цагт Түүний жавхланта хаанчлалын ажил дуусна.

Үүнийг тогтоонгоо, Бурханы Үгд чичрэхүйн хамгийн сүүлийн хүчин зүйлийг үзэцгээе. Тэгээд өмнөх дөрөвтэй нь нэгтгэбэл, ийм жагсаалт үүсэх нь байна:

1. Бурханы Үгийг үтэр түргэн дагах.
2. Ямар ч утгагүй санагдаж байсан ч, Бурханыг дагах.
3. Амин хувийн ашиг харагдахгүй байсан ч, Бурханыг дагах.
4. Зовиуртай байсан ч, Бурханыг дагах.
5. **Гүйцээн гүйцээтлээ Бурханыг дагах.**

Израилийн анхны хаан Саул болбоос Бурханы Үгд чичирдэггүй хүний сонгодог жишээ мөн. Утгагүй санагдбал, ил харагдах ашиггүй бол, өөрийнх нь зорилготой авцалдахгүй бол, тэрбээр шууд л дуулгаваргүй авирлана. Тэр хүний Бурханаас эмээхийг мэддэггүй чанар нь өрөөлд байнгын гай зовлон, хор хөнөөл авчирдаг байсан бөгөөд энэ нь ийм зан авирын зайлшгүй үр дагавар билээ.

Гэхдээ анхнаасаа ийм байсан уу гэвэл, үгүй юм. Саул анх хаан болж байхдаа Бурханаас эмээдэг, даруухан залуу байв. Бурханаас эмээхүй, даруу зан хоёр нь байнга хөтлөлцөж явдаг, ихэр чанар юм. Алдарт эш үзүүлэгч Самуел эрэл сурал болсоор Саултай уулзах үед, Саул: “Та миний юунд болов? Би чинь Израилийн хамгийн жижиг овгоос гаралтай, гэр бүл минь ч овгийнхоо хамгийн дорой

нь” (1Самуел 9:21-ийг утгачлан буулгав) хэмээн хариулсан. Хожим улсынхаа анхны хааныг тодруулахаар Израиль хуран цуглав. Тийнхүү урт удаан үйл өрнөлийн эцэст тэнгэр Саулыг таалж, удирдагч нар Саулыг дуудтал, тэрбээр алга болоод, далд газраас нуугдаатай олджээ. Саул алдаршихыг хүсээгүй (1Самуел 10:20-24).

Гэвч Саул ариун эмээхүйг нандигнаагүй. Соломон ч ялгаагүй адагтаа удирдагч хүний амжилт, алдар, ашгийг хүртмэгцээ, Бурханаас айж эмээхээ больжээ. Саул хаан тэргүүтэй хүмүүсийн хувьд ариун эмээхүйгээ алдаж яваа нь анхандаа эс мэдэгдэх. Энэ явдал нь жижиг сажиг зүйл дээр итгэл үнэмшлээ үл хайхрах байдлаар эхлээд, яваандаа улам мэдрэмжгүй болдог. Тэгээд адагтаа том асуудалтай тулгарахын цагт хэдийнээ дуулгаваргүй авирлаад дадсанаа өөрөө ч мэдэхгүй.

Саул хаан ч ингэсэн. Ариун эмээхүйгээ алдаж яваагийн шинж нь илэрч эхэлсэн боловч (1Самуел 13:5-14), яг тэр үеэр Саул ид гялалзаж явсан нь нөхцөл байдлыг бүр адармаатай болгожээ (1Самуел 14:47).

Тодорхой хугацааны дараа Саул хаан “амалекчуудыг бут цохиод тэдний хамаг юмсыг бүрмөсөн сүйрүүлж, бүү өршөөгтүн. Эр, эм, нялхас хүүхэд, үхэр хонь, тэмээ илжиг бүгдийг нь алах” (1Самуел 15:3) тушаал хүлээн авчээ. Эзэн тэр ёрын үйл хэрэгтэй үндэстнээс өс хонзонгоо авахаар зэхэж байлаа.

Саул 210,000 цэрэг цуглуулав. Тэгээд дайсныг хүн, малгүй бүгдийг нь хядсан атлаа Амелекийн хаан Агагийг амь хэлтрүүлж, тарга тэвээрэг сайтай сүргийг нь авч үлджээ (1Самуел 15:7-9).

Бодоод үзье. Саул ийм олон тооны цэрэг цуглуулсан болохоор, тэнд ойролцоогоор саяын дөрөвний нэгтэй тэнцэх тооны Амалекчууд байжээ гэж тооцоход, Саул үндсэндээ 249,999 хүнийг хороосон байх нь. Тэгвэл Саулын бараг л төгс дуулгавартай гэж дүгнэж болмоор 99 хувийн шахуу гүйцэтгэлийг Бурхан юу гэж үзсэнийг уншина уу:

Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас *буцан эргэж (татгалзаж)*, Миний үг зарлигийг үл сахив. (1Самуел 15:11)

Эш үзүүлэгч Самуел Бурханы энэ үгийг Саул хаанд айлтгаад, гаргасан зан үйлдлийг нь *тэрслүү явдал* хэмээв (1Самуел 15:23). Саул *нүгэл үйлдсэн* нь тодорхой. Одоо түр зогсоод, нүглийг авч

үзье. Нүгэл нь хуульгүй явдал болохыг элч Иохан хэлдэг (1Иохан 3:4). Үүнээс үүдэн: *Нүгэл нь Бурханы эрх мэдэлд захирагдахгүй байх явдал* гэж хэлж болно. Тэгэхээр, яг энэ өнцгөөс нүглийг харъя: Адам цэцэрлэг дотор янхан хүүхэнтэй унтаж хэвтээгүй, хүн алаагүй, хүрээ талаагүй. Зүгээр л Бурханы үгийг үл дагасан. Яг үүнтэй ижил Саул Бурханы зааврыг *бүрэн* дагахаас татгалзсан.

Цааш нь үзье. Амалектай байлд гэх үед Саул газар дэвслээд “Чадахгүй! Би байлдахгүй!” гэж хэлээгүй. Ихэнх хүн ийм үйлдлийг шууд л урван тэрслэл гэж үзнэ. Саул амин хувийнхаа юмыг хийж, Бурханы тушаалыг үл хайхрах зан ч гаргаагүй. Тэгсэн бол, ихэнх хүн: “Дуулгавартай байдлыг нэн тэргүүн тавиагүй нь Саулын алдаа байж” гэж л дүгнэхээс биш, Саул “Тэрсэлжээ” гэх байсан нь юу л бол.

Мөн олон хүн Саулыг даалгавраа 99.99 хувь гүйцэтгэсэн “Сайн хүү” гэхээс биш, тэрслүү явдалтан гэж үзэх нь юу л бол. Саулын оронд байгаад, ингэж зэмлүүлсэн бол, дийлэнх маань: “За боль доо! Яагаад миний хийгээгүй жаахан юм дээр дөрөөлөөд, хийсэн бүхнийг минь сайшаахгүй байгаа юм бэ!” гэж эсэргүүцэхгүй байсан гэж үү? Тиймээс: *Бүрэн шахуу* дуулгавартай байдал нь дуулгавартай байдал ерөөсөө биш гэдгийг хэлмээр байна.

Яагаад ингэтэл хатуурхаж байгааг одоо мэдэцгээе. Нэгдүгээрт - тухайн үед бусад улсыг булаан эзэлсэн хаан хүн эзлэгдсэн улсынхаа хааныг амьдаар нь барьж авчраад, ордондоо байлгах нь сүр хүчээ өөртөө төдийгүй, ордны зочид гийчдэд гайхуулах амьд цом болдог байжээ.

Хоёрдугаарт - яагаад шилдэг малыг үлдээв? Хариулахаасаа өмнө энэ асуудлыг бүр ээдрээтэй болгоё. Саул үүнийгээ Эзэнд бэлэглэх зорилгоор үйлджээ. Тэрбээр эш үзүүлэгчид юу гэж хэлснийг үзнэ үү: “Эдгээрийг тэд амалекчуудаас авчирсан юм. Учир нь таны Бурхан ЭЗЭНд нядалж тахихын тулд хамгийн сайн хонь, үхрийг ард олон хэлтрүүлсэн юм. Гэвч бусдыг нь бид бүрмөсөн сүйрүүлэв” (1Самуел 15:15). Саул яах гэж ингэв? Хүмүүстээ таалагдахын төлөө хийсэн юм биш байгаа? Тэд чинь Эзэнд мөргөдөг улс. Цэргүүд, “Тахилч нар”, ард түмэн юу гэж бодох байсныг бодоод үз. Тэд өөр хоорондоо: “Хаан маань юутай бурханлаг хаан бэ. Эзэнийг оройлон дээдэлдэг. Шилдэг сайхнаа Бурханд л барьдаг” хэмээн ам булаалдах байсан биз. Тэд чинь Бурхан анх Саулд юу гэж тушаасныг ч мэдэхгүй. Тэгэхээр, Саул

үндсэндээ нэр төрөө л баталгаажуулахыг санаархжээ. Цаад сэдэл нь хүнээс айх айдас байв. Саул өөртөө итгэл муутай хүн байжээ.

Өнөөгийн манай нийгэм өөртөө итгэлгүй хүмүүсийг хөөрхийлдэг. Гэвч итгэл муутай зангийн цаана дуулгавартай чанараа хөсөрдүүлж байгаад ч хамаагүй, бусдад таалагдах гэсэн, хайрлуулах, хүндлүүлэх гэсэн хүсэл л явж байдаг. Тэдэнд Бүтээгч маань биднийг хичнээн гүн хайрлаж, хүлээн авдгийг ойлгох ухаан дутах. Итгэл муутай занг зүгээр л “Аюулт урхи” гэдэг жинхэнэ нэрээр нь л дуудах хэрэгтэй.

Саул ариунаар эмээдэггүй учраас, тушаалыг бүрэн гүйцэтгээгүй. Бүгдээрээ дахиад л Есүсээр жишээ татъя. Есүсийг ад үзсэн, шившиглэсэн, Түүнээс урвасан, нүд үзүүрлэсэн, харгис хатуу эсэргүүцсэн, авах юмгүй болтол нь зодсон тэгээд хэрцгийлэн цовдолж алсан. Сүмийн харуулууд Есүсийг баривчлахаар ирэх үед дагалдагч нар нь болиулж, Есүсийг хамгаалах гэж үзсэн ч, Есүс:

Арван хоёр легионоос олон тэнгэрэлчийг одоо Надад илгээхийг Би Эцэгээсээ гуйж чадахгүй гэж чи бодож байна уу? Энэ нь болох ёстой гэсэн Бичвэр тэгвэл яаж биелэгдэх билээ? (Матай 26:53-54) хэмээн хариулсан.

Есүсийн хувьд эцсээ хүртэл дуулгавартай байх нь аминаас нь чухал байжээ.

Би ахлах сургуульд байхдаа буюу Есүст итгээгүй байхдаа, хувцас солих өрөөнд хадаатай нэгэн зурагт хуудсыг байнга үздэг байлаа. Үдээс хойш сагсны бэлтгэлээ тарах бүрийдээ уншина. Тэр зурагт хуудас дээр “Би бууж өглөө!” гээд, толгойгоо унжуулж суугаа тамирчны зураг байна. Харин доор нь “Би бууж өгөөгүй!” гэсэн үг бүхий Есүсийн загалмай дээр хадаастай зураг байдаг байж билээ.

Тэр зураг Есүст итгэдэггүй хөвгүүн - надад хэзээ ч мартахааргүй сэтгэгдэл үлдээсэн юм. Есүс тэр их харгислал, аймшигт үхлээс зайлж чадах байсан атлаа “Түйцээ!” гэж хэлэх хүрлээ дуулгавартай байхыг сонгосныг эдүгээ би ойлгосон болохоор, тэр утга бүр ч жинтэй тусах болсон юм. Есүс бидэнд бүрэн дуулгавартай байж, Бурханы даалгасан зүйлийг гүйцээхийн үлгэр жишээг тогтоож өгчээ.

Ийнхүү бид итгэлийг минь өсгөж өгөөч хэмээн дуу алдсан дагалдагч нартаа өгсөн Есүсийн зааврыг илүү нарийн ойлгож авлаа:

Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд “Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн” гэж хэл. (Лук 17:10)

“Бүхнийг гүйцэтгээд” гэдэг үг цоо шинэ утга илэрхийлж байна. Ямагт бүрэн гүйцэт дуулгавартай байцгаая.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд Төгсгөгч болох Есүс өөд харцгаая. Тэрээр өмнө нь тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм. Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн Түүнийг санагтун. (Еврей 12:2-3)

Санаа: Бүрэн шахуу дуулгавартай байдал нь дуулгавартай байдал ерөөсөө биш. Бурханы бидэнд даалгасан зүйлийг гүйцээн гүйцээтлээ бүрэн дуулгавартай байхын үлгэр жишээг Есүс Өөрөө бидэнд тогтоож өгсөн.

Эргэцүүлэл: Би Бурханы Үгийг дагаж эхэлсэн боловч, сатаарал, таашаал, эсэргүүцэл, бусдын дургүйцэл зэрэг дайсагналаас болоод дуусгалгүй, зогсоочихсон уу? Үүнийг хэрхэн өөрчлөх вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, Таны хийгээрэй гэснийг дуулгавартай хийж байснаа, бие дааж гүйцээх ёстойгоо ойлгоогүйгээсээ болоод, хайхрамжгүй зангаасаа болоод, санаагаа хувиргаснаасаа болоод дуусгаж чадаагүйг уучлаарай. Ариунаар эмээдэггүй зангаа гэмшиж, уучлал гуйж байна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Эзэнийг бүрэн гүйцэт дуулгавартай дагана.

*Хүмүүс Бурханаас эмээхээ
болиод ирэхээрээ хуулийг нь
ямар ч айдасгүй зөрчдөг.*

*Бурханаас айх айдас арилах үед
үр дүнгээс айх айдас
хориг байхаа болино.*

— Эй. Даблью. Тозер

28 | МӨС ЧАНАРАА ХУЙХЛУУЛАХ?

Өмнөх бүлэг дээр хэлсэнчлэн, хүн ариунаар эмээх сэтгэлгүй болж байгаа нь анхандаа мэдэгдэх юмгүй учраас, энэ чухал хэсгийг арай дэлгэрүүлж задлах хэрэгтэй. Ямар нэгэн эргэлзээтэй юм хийх боломж гарч ирэх үед хэвлийд чинь анхааруулах дохио улалзаж байсан уу? Тэгэхээр, энэ нь *мөс чанар* маань биднийг хамгаалж байгааг ихэнх хүн мэдэх байх. Харин гэхдээ мөс чанарын хурц хараа, хүч чадлыг ч тожийлгож болдгийг тэр бүр мэдэхгүй биз.

Бурханаас бидэнд бэлэглэсэн мөс чанар гэдэг зүйлд хэзээ ч хөнгөн хандаж болохгүй. Энэ нь *зурхний* маань амин бүтэц бөгөөд хүний мөс маань ариун эмээхүйгээр хурцлагдаж, айж эмээхийг мэдэхгүй зангаар тожийдог. Тиймээс л бидэнд “Зүрх юугаан урьтан хамгаал Амийн булгууд түүнээс ундарюу” (Сургаалт үгс 4:23) хэмээн анхааруулжээ.

Намайг гуч гарч явахад, нэгэн алдартай номлогч өдрийн зоогт урьж билээ. Зоогийн дундуур тэрбээр надаас: “Жон, би явал бусад удирдагч нар шиг хөл алдахаас сэргийлэх вэ?” гэж асуусан юм.

Би ч золтой л хахчихсангүй. Яагаад надаас ийм том юм асууна вэ? Би чинь залуу хүн, дээрээс нь тэр эрхэм миний аврагдсан хугацаанаас ч урт удаан хугацаанд үйлчилж яваа. Гэхдээ барьц алдахаасаа өмнө би дотогш өнгийгөөд, *Ариун Сүнс ээ, би юу гэж хариулах вэ?* гэж асуулаа.

Тэгтэл тэр даруй *мөс чанараа хамгаас үнэт эрдэнэс мэт сахин хамгаал* гэж хэл гэхийг сонсов.

Тэгээд сонссон үгээ хэлснээ, араас нь дараах үгийг бараг л гулгиад гаргачихав: “Танд асар ашигтай санал тавина. Гэхдээ

Бурханаас эмээхүй

энэ нь үнэнч чанарыг чинь зөрчсөн, жишгийн хил хязгаарт чинь халдсан, асуудалтай бөгөөд бусдыг хохироох зүйл гэдгийг та дотроо мэдэх болно. Мөс чанараа сонс, анхааруулгыг нь бүү үл хайхар. Үл хайхрах аваас, Бурханд мэдрэг чанар чинь суларна.”

Дараагийн хэдэн өдөр нь би Бичээс “Мөс чанарын” талаар маш их өгүүлдэг бөгөөд энэ талаар ямар ч ойлголтгүй явснаа олж мэдэж билээ. Зөвхөн Шинэ Гэрээнд л гэхэд ойролцоогоор гучаад удаа гарч байна. Паул Тимотод:

Ингэхдээ итгэл, сайн *мөс чанараа сахь*. Зарим нь үүнийг үл ойшоосноос итгэл нь, сүйрсэн хөлөг онгоц мэт болжээ (1Тимот 1:19) гэж бичсэн.

Итгэл сүйрэх нь тоглоом биш.

Алдартай ахмад үйлчлэгчтэй барьсан зоог надад Паулын үгийн жинг ойлгуулсан юм. Энэ үг надад яагаад олон хүн сайн төгсгөж чаддаггүйг баталж билээ.

Бичээс бидэнд “Мөс чанараа” сахин хамгаалахыг анхааруулсан нь мөс чанар маань анх цэмбэгэрээрээ байдгийг илтгэх. Есүсийн цус бидний мөс чанарыг цэвэрлэж, ариутгадаг (1Тимот 3:9, Еврей 9:9, 14). Энэ нь шинээр төрөхүйн хамгийн том нэгэн ашиг мөн. Мөс чанарын талаар эш үзүүлэгч Иеремиагийн хэлсэн мэдэгдлийг бид голдуу буруугаар хэрэгжүүлчих гээд байдаг. Тэрбээр “Зүрх гэдэг бүхнээс илүү хуурамч, эдгэршгүй өвчтэй. Хэн үүнийг ойлгож чадах билээ?” (17:9) гэсэн. Иеремиа Есүсийг дууриан дахин бүтээгдсэн, шинэ мөн чанартай, дахин төрсөн хүмүүсийн талаар яриагүй. Хуучин Гэрээний хүмүүст шинэ зүрх байгаагүй. Гэхдээ Бурхан тэдэнд “Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг өгнө” (Езекиел 36:26) хэмээн амласан. Есүс бидний мөн чанарыг аваад, оронд нь Өөрийнхөө мөн чанарыг өгөх үед энэ амлалт биелсэн юм.

Христийн дотор цоо шинэ хүн болох гайхамшгийн ачаар л бид найдвартай мөс чанартай болсон билээ. Харин үүнийгээ цэврээр нь хадгалах л хамгийн гол ажил. Тиймээс мөс чанарыг хэрхэн бохирлодгийг асуух ёстой. Завхрал нь ганц удаагийн явдлаар бус, ихэвчлэн аахар шаахар юмсаар эхлээд, эцэстээ бүрэн сүйрэлд хүргэдэг. Энэ талаар Иаков:

Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг. (Иаков 1:22)

Ийнхүү бид дуулгавартай байдалтай улаан нүүрээрээ тулж байна. Ямар ч утга илэрхийлэхгүй байсан ч, илт ашиггүй байсан ч, зовиуртай байсан ч, тэр даруй бүрэн гүйцэт дуулгавартай дагадаг чанар л ариунаар эмээдгийн баталгаа мөн болохыг бид дэлгэрүүлж ярьсан. Зохих замаараа явж байгаа хүн өөрийгөө хуурч чадахгүй.

Тэгэхээр, түр зогсоод, гол санаагаа баталгаажуулъя. Танил, дотны хүмүүс, гэр бүлээ дөнгөчих боломжтой ч, өөрийгөө дөнгөх нь тэс өөр асуудал болоод явчихна. Үнэндээ, бид дуулгаваргүй байхдаа, *өөрийгөө л мэхэлж* байгаа юм. Үнэний хамгаалалтаа сулруулахад л ёс суртахууны баримжааны мэдэрхүй маань суларна. Тийнхүү бид аюулт зам дээр гарснаа ч мэдэхгүй.

Энэ үйл явцыг дүрслэх жишээ татъя. Та хэзээ нэгэн цагт хэн нэгнийг муулж байсан уу? Тэр үед хэвлий рүү чинь хутгалчих шиг мэдрэмж төрсөн бол, тэр чинь мөс чанар чинь. Тэгээд та сонсоод, гэмшээд, хэлсэн зүйлээ тэр даруй зассан байх гэж найдаж байна. Гэвч хүн гол төлөв зан авираа зөвтгөдөг. Учир зүй нь: Би зөв л юм хэлсэн! Ийнхүү тун харамсалтайгаар бидний ташаа зөвтгөл ялж, бид дотоод анхааруулгаа тоолгүй, өөрийнхөө зөв дээр тогтдог. Ингээд завхрах үйл явц эхэлж, мөс чанарын маань мэдрэмж бүрэлзэж эхэлнэ.

Дараагийн удаа хэн нэгнийг муулах үед хэвлий рүү хутгалах шиг бус, харин элэгдүүлчих шиг л санагдана. Энэ ч бас мөс чанарын л ажил мөн боловч, энэ удаа дуу нь суларчээ. Дотроо ч тэгтэл хүчтэй зөрчилдөхгүй учраас, та тэр анхааруулгыг үл хэрэгсэн, бүр ч ядах юмгүй биеэ зөвтгөнө. Ингэж зүрх маань улам л бохирдож, мөс чанар маань улам суларна.

Дараа нь дахиад хүн муулах үед хутга ч, цохилт ч мэдрэгдэхгүй, үл ялиг час хийх байх. Мөс чанарынхаа амыг барьчихсан учраас, одоо биеэ зөвтгөөд байх шаардлага ч байхгүй. Зүгээр л угаасаа л миний зөв гэж бодно.

Ингэж явсаар, адаг сүүлдээ юуг ч мэдрэхээ болино. Мөс чанар маань хуйхлагдаж дуусчээ. Нүдээ бүрэлзэж байгааг ч мэдэхээ больж, ялгах салгах мэдрэмж маань тагларчээ. Бид ёс суртахууны

Бурханаас эмээхүй

зүг чигээ бүрэн алдаж, итгэл маань ч гарцаагүй сүйрэхээр болжээ. Өөрийгөө мэхэлсэн нь энэ!

Гэтэл энэ бүхнээс энгийн гэмшлээр буюу оюун бодол, зүрхний бүрэн өөрчлөлтөөр сэргийлж болох л байсан. Бидний мэргэн ухаан ашиггүй болохыг үг дуугүй хүлээн зөвшөөрсөн цагтаа бид Бурханы цэц ухааныг хүлээж авдаг. “Гэмт үйлдлээ далдлагч хэзээ ч үл дэвжюү. Гэвч улайгаад, орхигч хайр энэрлийг хүртюү” (Сургаалт үгс 28:13).

Өршөөл, сэргэлт нь үйл явцсын дундуур хэзээд ирэх боломжтой ч, хамгийн гол нь хүн өөрөө ариунаар эмээхгүй бол, энэ байдал нь хариуг саатуулдаг. Зүрх нь мөс чанарынхаа итгэл үнэмшлийг мэдрэхээ байчихсан учраас, хүн бооцоотой тоглож эхэлдэг. Мэргэн хүн мөс чанарынхаа анхааруулгад тэр даруй гэмшлээр хариулдаг. Саатах нь аюултай гэдгийг тэр мэднэ.

Мөс чанараа сонсохоос цааргалсан хүн Бичээс дээр ч олон, амьдрал дээр ч олон. Орос рулет тоглохтой л ижил юм даа. Яахав, энэ удаа сүйрлээс мултарлаа ч, мэдрэмжээ алдсан хүн юугаа мэдэх вэ? Угаасаа “Чи намайг дахиад ганц л үл тоох юм бол, Би дахиад ярихгүй” хэмээн анхааруулаад байх дуу хоолой ч байхгүй.

Харин хожмын цагт зарим нь итгэлээ орхин, мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн сургаалд анхаарал хандуулна гэж Сүнс тодорхой хэлдэг. Тэд *мөс чанараа хуйхлуулаад* хоёр нүүр гарган худал ярьж... (1Тимот 4:1-2)

Халуун индүүнд түлэгдсэн хүний арьс мэдрэмжээ алддаг. Мөс чанар ч ялгаагүй. Хуйхлуулсан хүн ямар ч итгэл үнэмшил тээлгүй, бодит байдлаасаа тэс өөр дүрээр амьдарна. Ананиа, Сапфира, Саул хаан, тэргүүтэй хүмүүс тэгээгүй гэж үү?

Хуйхлуулах нь өөр нэгэн үр дагавартай: Түлэгдсэн хэсэг нь өөртөө бүгдийг түгждэг. Мах шарах үед мах дотроо шүүсээ түгждэг. Паул “Би худал яриагүй, Христ дор үнэнийг хэлж байна. Миний мөс чанар Ариун Сүнсээр гэрчилж байна...” (Ром 9:1-2) гэсэн. Итгэгч хүний мөс чанар хуйхлагдбал, Ариун Сүнс тэй харилцах чадваргүй болно. Махнаас ялгарч чадахгүй шүүстэй адил Ариун Сүнсний гэрчлэл бидний сэтгэлд хүрэхгүй. Бид амьдралын зүг чигийн системгүй болоод, адагтаа сүйрнэ.

Эцэст нь Паулын хэлсэн хэдэн үгийг сонсоно уу: “Эрчүүд ахан дүүс ээ! Энэ өдрийг хүртэл би Бурханы өмнө сайн мөс чанартай амьдарч ирлээ” (Үйлс 23:1). Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө сайн мөс чанартай байхыг үргэлж хичээдэг билээ (Үйлс 24:16). За ингээд, зүрхээ хичээнгүйлэн хамгаалцгаая гэдэг үгээр бүлгээ төгсгөө.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: “хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, итгэлийн дүүрэн баталгаатай, үнэн зүрхээр ойртон очицгооё.” (Еврей 10:22)

Санаа: Мөс чанарын хурц хараа, хүч чадлыг ч тожийлгож болдог.

Эргэцүүлэл: Бидний мөс чанар Есүс Христийн цусаар цэвэр болсон. Мөс чанараа тунгалгаар нь сахихын тулд сүнсний ямар сахилга батыг баримталж болох вэ?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, мөс чанараа үл тоож, сөрж явсныг минь уучлаарай. Мөс чанараа хичээнгүйлэн хамгаалаагүйг уучлаарай. Би гэмшиж, уучлал гуйж байна. Есүсийн цусаар намайг цэвэрлээч. Миний дотор Таны дуу хоолой, чиглүүлэгт мэдрэг, цэвэр мөс чанарыг сэргээж өгөөч. Би Таныг дагахдаа түргэн байя. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би зүрхээ хичээнгүйлэн хамгаалж, мөс чанарынхаа удирдамж, дуу хоолойд мэдрэг байх болно.

БУРХАНТАЙ ДОТНО БАЙХ

Тавдугаар долоо хоног

*Бурханы дуу хоолойг
хоёрдагч этгээдээс сонсоод ханаж
байснаас, ямар ч бэрх нөхцөл байдал
дунд Бурханаас Өөрөөс нь хувьчлан
сонсох тэр үнийг төлөхөд би бэлэн.*

— Жой Даусон

29 | ДОТНОСОЛ ЭНДЭЭС Л ЭХЭЛНЭ

Ариунаар эмээхүй нь Бурханы алдрыг ойлгох ойлголтыг маань дагаж өсөхийн зэрэгцээ бидний сэдлийг цэвэршүүлж, хүнээс айх айдсаас чөлөөлж, амьдралд маань жинхэнэ ариун байдлыг бүтээдэг. Хүн ариунаар эмээж байгаа эсэх нь шалтгаан, ашиг харсан хараагүй, зовлон зовиур эдэлсэн эдлээгүй - Бурханыг тэр даруй, бүрэн төгс дуулгавартай дагаж буй эсэхээр нь л илэрхийлэгдэнэ.

Үүнийг мэдсэн болохоор, одооноос эхлэн бүгдээрээ энэ хосгүй бэлгийн ашиг тусыг авч үзэх бөгөөд энэ удаа үүний няцаахын аргагүй том ашиг болох Бурхантай тогтоох дотно харилцаан дээр төвлөрч ярилцъя.

Дотно гэдэг үг нь Латин хэлний “Дотор” гэсэн утга бүхий *интус*, “Амин нууц” гэсэн утга бүхий *интимус* гэдэг хоёр үгээр гаралтай.¹ Энэ хоёрыг холбох аваас “Далдын далд амин нууц” гэсэн утга төрнө. *Дотнослыг* үнэхээр гоё дүрсэлжээ. Дотносол гэдэг үг нь хоёр дотно найзын нэг нэгнээ гэсэн холбоог дөнгөж танилцсан, сайн мэдэхгүй, зүс таних төдий хүнтэй тогтоосон харилцаанаас хол гүн төвшинд дүрсэлж байна.

Дотносол нь хоёр талаас угталцсан, хоёр урсгалтай гудамж бөгөөд хэн хэн нь нэг нэгнийхээ далдын далд хүсэл, бодлыг мэддэг байх хэрэгтэй. Бурхантай тогтоох дотно харилцааны тухайд, Бурханы ч, бидний ч үзэл бодлыг харах хэрэгтэй. Давидын бичвэрээс эхэлцгээе:

Аяа ЭЗЭН, Та намайг судлан намайг мэдлээ (Өө Эзэн минь, Та миний зүрхийг *нягталсан* бөгөөд миний талаар бүгдийг *мэднэ*).
(Дуулал 139:1)

Нягтлах гэдэг үг нь “Судлах, хайгуул хийх, эрэлхийлэх” гэсэн дутга бүхий *хаакар* гэдэг үг болно. Энэ үг хэн нэгэнтэй дотно харилцаанд ороход юу шаардлагатай болохыг маш тодорхой дүрсэлж байна. Нөгөө хүнийхээ гүний гүн бодол, арга замыг таньж мэдэхийн төлөө зарцуулах цаг, хүчин зүтгэл нь ачаа дарамт бус, харин ч жаргал юм.

Лиза, бид хоёр ч ингэсэн. Лизатай анх гэрлэхдээ би түүний санаашрал, таашаал, дуртай юмс, дургүй юмс, тэр байтугай юуг жигшдгийг нь ч мэддэггүй байлаа. Түүнийхээ нарийн нандин бодол, арга замыг таньж мэдэх нь цаг авсан үйл явц байсан ч, би үүнийгээ ёстой жаргаж хийсэн шүү. Товчхондоо хань ижилтэйгээ дотносоход оюуны ч, сэтгэл мэдрэмжийн ч, биеийн ч төвлөрөл бүхий хичээл зүтгэл шаардлагатай.

Сонирхол татах дараагийн үг нь Еврей хэлний *яада* буюу *мэднэ* гэдэг үг юм. Хуучин Гэрээнд энэ үгээр голчлон дотнослыг өгүүлсэн байдаг. Эхлэл 4:1 дээр “Адам Еватайгаа *унтаж* (*Евагаа мэдэж* буюу *яада*), эхнэр нь жирэмслэн Каиныг төрүүлээд —ЭЗЭНий ерөөлөөр би хүүтэй боллоо гэж хэлэв” гэдэг. Энэ амьдралд хоёр хүний дотносож болох дээд туйлыг Ариун Сүнс *яада* гэдэг үгээр дүрсэлжээ. Тэгэхээр, дээрх хэсэг дээр Давид “Эзэн минь, Та намайг гүн гүнзгий мэднэ” гэж л хэлжээ.

Давид бидний гүний гүн хүслэн, Өөртэй нь дотносохын хүслэн болж явдаг хүмүүсийнхээ замыг Бурхан яаж эрж, хайдгийг яруу тодоор харуулахын төлөө *хаакар*, *яада* гэдэг үгсийг хавсран хэрэглэжээ. Лиза, бид хоёрын харилцаан дээр ч ялгаагүй - миний бие гэргийтэйгээ олон жилийг хамт өнгөрүүлснийхээ ачаар л түүнийхээ талаар өдий зэрэг мэддэг болсон билээ. Би Лизагийн дотоод хүслийг мэдээд зогсохгүй, түүний дадал хэвшил, тодорхой нөхцөл байдалд үзүүлдэг хариу үйлдэл, чөлөөт цагаараа юу хийх, ямар ажил хийх дуртайг нь ч мэддэг болсон. Үүнтэй адил Давид ч:

Миний сууж, босохыг Та мэддэг бөгөөд Хаа холоос санаа бодлуудыг минь ойлгодог. Та миний зам мөр хийгээд Хэвтэхийг минь ч нарийвчлан үзэж, Замнал бүрийг минь сайн мэддэг. Хэлэн дээр минь ганц үг ч байхаас өмнө, Харагтун, ЭЗЭН Та бүгдийг мэддэг (Дуулал 139:2-4) хэмээн дуу алджээ.

Бурхан биднийг дотор гадаргүй, нэвт шувт мэддэг. Бурхан Давидыг судалж, эрж, хайсан шигээ буюу хаакардсан шигээ бидний хүн нэг бүрийг өнгөрсөн дөчийн жилийн турш би Лизагаа танин мэдсэнтэй адил боловч, хавьгүй өндөр төвшинд судладаг байна. Үнэндээ, хэдхэн эшлэлийн дараа бидний хүн нэг бүрт хандсан Бурханы бодол нь энэ дэлхий дээрх бүх элсэн ширхэгийн нийлбэрээс ч олон (18-аар эшлэл) гэдэг цочирдмоор үгтэй мөргөлдөнө. Миний бие өнгөрөгч дөчин жилийн турш 12 секунд тутам гэргийнхээ дуртай юм, зан аяг, тэмүүлэл, дургүй юмсыг нь бодоод, бодол болгоноо нэг элсэн ширхэгээр төлөөллөө ч, гутлын хайрцаг ч дүүрэхгүй байх! Гэтэл Бурхан бидний хүн нэг бүрийг энэ *гариг дээрх* бүх элсэн ширхэгээс ч олон боддог гэсэн бөгөөд Бурхан худлаа ярьж чаддаггүй учраас, давслаагүйг нь мэдээрэй. Ухаан ч хүрэмгүй! Биднийг танин мэдэх гэсэн Бурханы хүсэл тэмүүллийг төсөөлж эхэлж байна уу?

Бурхан бидний хүн нэг бүртэй дотно байхыг зүрхнээсээ хүсдэг. Гэхдээ жинхэнэ дотносол нь ганц талаас бус, харин хоёр талаас *нэгэн зэрэг* төрдөг, бие биеэ мэдэх гэсэн тэмүүлэл гэдгийг дахин хэлмээр байна. Бурхан бидний гүний гүн бодлууд дунд хайгуул хийдэг шиг бид ч жинхэнэ дотносолд тэмүүлж, бүтээхийг зорих ёстой юм. Мосе ийм төвшний дотнослыг эрэлхийлэхдээ, ийн дуу алджээ:

Би чамайг нэрээр чинь мэднэ (*яада*). Мөн чи Миний мэлмийд тааллыг олсон” гэж Та айлдсан. Одоо тэгэхлээр гуйж байна, хэрэв би Таны мэлмийд тааллыг олсон бол замуудаа надад мэдүүлээч. Тэгвэл би Таныг мэдэж (*яада*), Таны мэлмийд тааллыг олох юм. (Гэтлэл 33:12-13)

Бурхан биднийг түмний дундах нэгэн гэдэг утгаар нь *мэддэг* бус, харин хувьчлан, ганцаарчлан, нэрээр минь мэднэ. Үүнд нь ч Мосе адилтай хандаж, Бурханыг илүү гүн гүнзгий мэдэхийг хүссэнийг нь бид дээрх эшлэлээс үзлээ. Мосе зөвхөн Бурхан л түүнийг мэддэг бус, тэр өөрөө ч Бурханыг мэддэг, тийм л дотно харилцааг хүсчээ. Тэгвэл, бидний хувьд? Иаков “Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно” (Иаков 4:8) гэсэн.

Саяын яриан дээр үндэслэн, эдүгээ та Бурханы зүрхээс гарах дуудлагыг - үгүй ээ, хашхирааг сонсдог болоо байх аа. Цаг явах

Бурханаас эмээхүй

тусам: “Надтай дотно байж болох байсаар байтал, юунд чи Надаас дөлнө вэ?” гэдэг хашхираа улам л чангарсаар байна. Тэгэхээр, үндсэндээ *Бурханы тогтоох дотнослын зэргийг бид өөрсдөө тогтоодгийг* энд хэлжээ. Арай ойртуулж хэлье л дээ: Бурхантай аль зэрэг дотно байхыг чинь Бурхан бус, та л шийднэ! Тэгэхээр, Эзэнээс эмээхүй энд ямар үүрэгтэй вэ? Библи:

ЭЗЭНээс эмээхүй нь мэдлэгийн эхэн юм (Сургаалт үгс 1:7) гэдэг.

Юуны мэдлэг? Бичээч эмнэлгийн, шинжлэх ухааны, түүхэн зэрэг аль нэг эрдмийн мэдлэгийг хэлээ юү? Их сургуулиуд эдгээр мэдлэгээр дүүрэн ч, тэд Бурханаас эмээдэг нь юу бол. Эсвэл бичээч нийгэм, улс төрийн мэдлэгийг хэлэв үү? Үгүй ээ, дэлхийн арга зам нь Бурханд мунхаг. Тэгвэл Библийн мэдлэгийг хэлээ юү? Яалаа гэж. Учир нь Фарисайчууд Библийн мэргэжилтнүүд байсан ч, Бурханаас эмээдэггүй, Бурханд огт таалагддаггүй байв. Хариулт нь дараах бичээс дээр байна:

ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно Бурханы мэдлэгийг олж авна.
(Сургаалт үгс 2:5)

Мэдлэг гэдэг үгийг *Библийн хэлний толь бичиг* дээр “Харилцаа тогтоохын хүслэн болж явдаг хүнийхээ талаар мэдэх мэдлэг” хэмээн тодорхойлсон бол, *Вайны бүрэн тайлбар толь* дээр “Түүний (Бурханы) талаар дотно, бодитой мэдлэгтэй байхуй” гэжээ. Тэгэхээр, энэ амлалтыг: *Эзэнээс эмээхүй нь Бурханыг дотно мэдэхийн эхлэл болой* хэмээн энгийнээр тодорхойлж болох юм.

Үнэндээ, Бурханаас эмээдэггүй бол, Түүнийг дотночлон таньж мэдэх талаар ямар ч яриа байхгүй. Эмээхүй бол эхлэл цэг. Эхлэл цэгээс гадуур сэдсэн аливаа зүйлийг гүйцэлдүүлэх боломжгүй. Зуун метрийн гүйлтэд оролцох хүн гарааныхаа цэгээс тавин метр гарантай түрүүлж эхэлбэл, уралдаандаа оролцох ч, уралдаанаа дуусгах ч боломжгүй. Тэгвэл Бурхантай тогтоох харилцаа ч ялгаагүй. Ариун эмээхүй байхгүй бол, Бурханыг дотно таньж мэдэх огт боломжгүй. Бурхан бидэнд Өөртэй нь дотно байх замыг гаргаж өгсөн нь талархалтай явдал боловч, үүнийг нь бид хүлээж авах уу?

Эзэнээс эмээхүй л биднийг адын муу, *хуульгүй явдлаас*

сэргийлдгийг санаарай. Үүнийг санангаа шүүх өдөр Есүсийн үй олон хүнд хэлэх үгийг бодолцоорой. Тэдгээр эрчүүд, эмэгтэйчүүд Есүсийг Эзэн хэмээн дуудав ч, Есүсээс “Би та нарыг *танихгүй* (*мэдэхгүй*). *Ёс бусыг үйлдэгч* та нар Надаас зайл” (Матай 7:23) гэдэг үгийг дуулна. *Танихгүй* гэдэг нь *яада* гэдэг үгийн Грек хувилбар болох *гиноско* гэдэг үг юм. Есүс ариунаар эмээдэггүй хүмүүст “Би та нарыг хэзээ ч дотно мэддэггүй байсан” хэмээнэ. Энэ үг нь бидний үзэх дараагийн том сэдэв болно.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: “Миний царайг эрэн хайцгаа!” гэхэд зүрх минь Танд “ЭЗЭН, царайг тань би эрж хайюу” гэв. (Дуулал 27:8)

Санаа: Жинхэнэ дотносол нь ганц талаас бус, харин хоёр талаас нэгэн зэрэг төрдөг, бие биеэ мэдэх гэсэн тэмүүлэл юм.

Эргэцүүлэл: Хамт байх хамгийн дуртай хүнээ бод. Та түүнийхээ юу бодож, мэдэрч байгааг нь асуулгүйгээр аль зэрэг мэдэх вэ? Янз бүрийн нөхцөл байдалд ямар хариу үзүүлэхийг нь аль зэрэг гадарлах вэ? Та энэ асуултад зог тусч байна уу эвсэл дотно найз нөхрөө таньж мэдэхийн төлөө зориуд цаг гаргадаг уу? Тэгвэл таны талаарх Бурханы бодлыг тоолохын аргагүй гээд л бод. Энэ танд юу хэлж байна? Тэгвэл та дотно найзаа таньж мэдэхээсээ ч илүү Бурханы зүрх, арга замыг эрэн хайж, эргэцүүлбэл, юу болох бол?

Залбирал: Эзэн минь ээ, Тантай дотносох - хамгийн аугаа урилгыг тань тоогоогүйд уучлаарай. Би Тантай дотносоход цаг гаргахын оронд хэрэгтэй, хэрэггүй олон зүйлд анхаарч явжээ. Тэгвэл одооноос өөрчлөгдмөөр байна. Библиэ уншиж, залбирч, тунгаахдаа Таныг л ойр дотно таньж мэдмээр байна. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Есүс намайг таньж мэдэхийг сонгосон шиг би ч бас Есүсийг мэдэхийн төлөө хичээнгүйлэн амьдрахыг сонгож байна.

*Хүнд өөрт нь зөв мэт зам
Харин эцэс нь үхлийн зам.*

— Сургаалт үгс 16:25

30 | ӨӨР ЕСҮС

Заримдаа аливаа зүйлийг ойлгохын тулд эсрэг утгыг нь мэдэх хэрэгтэй байдаг. Тиймээс, Бурхантай дотносох талаар цааш ярихаасаа өмнө үүний эсрэг хувилбар нь юу болохыг дараах түүхээр жишээлэн үзэцгээе.

Миний бие удирдлагын конференц дээр номлохоор Хавайд дөнгөж буюгаад байв. Зочид буудлын өрөө маань хараахан бэлэн болоогүй байсан болохоор, би усан сангийн дэргэдэх сүүдрэвч дор жаал тухлахаар суулаа. Тэгтэл өөр нэг конференцэд оролцохоор ирсэн нэгэн бизнес хатагтай бас өрөөгөө хүлээж байхтай таарав. Бид хоёр яриа дэлгээд, бүсгүй намайг Христийн номлогч, зохиолч гэдгийг маань мэдүүтээ, Есүстэй тогтоох харилцааны талаар урсгаж гарах нь тэр.

Тэгээд ганц хоёр минутын дараа би тэр бүсгүй Есүсийг огт мэддэггүйг ойлгосон юм. Бүсгүй юунд *итгэдгээ* ахин дахин итгэл дүүрэн мэдэгдэж байсан ч, тэр нь Бичээсийн илчлэлтэй авцалдахгүй байв. Би ч дотроо Ариун Сүнснээс цэц ухаан гуйтал, Ариун Сүнс ч юу хэлэхийг минь тэр даруй зааж өгсөн юм.

Бүсгүйг ярьж дууссаны дараа би түүнээс “Та усан сангийн цаана сууж байгаа тэр залууг харж байна уу?” гэж асуув.

Бүсгүй гайхсан янзтай: (Ярианыхаа сэдвийг огцом өөрчилсөнд минь гайхаа байх.) “Харж байна, юу гэж?” хэмээн хариуллаа.

Би баяртай нь аргагүй: “Түүнийг Жийм гэдэг. Калифорнийн Фресногийн хүн. Цэвэр цагаан хоолтон. Америкийн Олимпын усан пөлийн багт тоглохыг хүсдэг. Өдөрт гурван цаг усан санд бас спорт заалд ажилладаг. Мөн пиклбоол тоглох, шүхрээр буух, зураг зурах хоббитой. Тэр халуун устай онгоцонд хэвтэж байгаа бүсгүй бол эхнэр нь. Бет гэдэг. Жиймээс арав дүү” гээд л авч өглөө.

Тэр залууг ингэтэл мэдэж байгааг минь гайхсан бүсгүй: “Тэр хүн тантай хамт конференцэд ирсэн юм уу?” гэж асуув.

Би ч шууд л: “Үгүй ээ, хатагтай” л гэлээ.

Сониуч зандаа улам автсан бүсгүй: “Тэгээд, та яаж ийм сайн мэдэж байгаа юм?” гэв.

Тэгэхээр нь би эргээд, бүсгүй рүү харж байгаад: “Би түүнтэй нэг ч удаа ярьж үзээгүй” гэлээ.

Бүсгүйн царай энэ удаа болгоомжлолоор - за магадгүй бүр айдсаар солигдов. Намайг мөшигч, хувийн мөрдөгч эсвэл бүр засгийн газрын агент гэж бодсон ч байж мэдэх.

Би хэсэг сууж байснаа: “Би зүгээр л тэр залуугийн талаар ингэж итгэж байна” хэмээн итгэл дүүрэн хэлэв.

Эмэгтэй таг.

Тэгэхээр нь би: “Та дөнгөж сая Есүсийн талаар юу гэж итгэж явдгаа яг ингэж итгэл дүүрэн ярьсан. Гэхдээ ярьсан бүхэн чинь Библийн сургаалыг сөрж байна. Үнэн биш байна. Би Есүсийг мэддэг учраас, үүнийг мэдэж байна” гэж хэллээ. Ингээд бүсгүйн хүсэлтээр бидний яриа дууссан бөгөөд түүний хамаг бие салганаж байгааг би харж билээ.

Элч Паул чин зүрхний хайрт чуулгандаа зог тусмаар мэдэгдэл хийсэн: “Хэн нэг нь очоод, бидний тунхагласнаас өөр Есүсийг тунхаглахад эсвэл хүлээн авсан та нар...” (2Коринт 11:4). Паул өөр бурхныг гэж хэлээгүй, өөр Есүсийг гэж хэлжээ. Тэгэхээр тэр хүмүүс Есүст *итгэдэг* атлаа Түүнийгээ сайн мэддэггүй нь илэрхий байна. Яагаад? Яагаад гэвэл, тэд таалагдсан зүйлдээ л итгэсээр, эцэстээ жинхэнэ Есүсээс хөндийрчээ. Энэ тийм хэцүү биш. Эзэн харагдахгүй учраас, Түүний мөн чанарыг хүн дураараа өөрчилж чадна.

Израилийн хүүхдүүд яг л ингэсэн. Тэдний Египетээс чөлөөлөгдсөн үйл явдал нь бидний дэлхийгээс аврагдах үйл явдалтай агаар нэг юм. “... бүгд адилхан сүнслэг ундааг ууж, тэднийг дагаж байсан сүнслэг хаднаас ундаалсан ба тэр хад нь Христ байв. Гэсэн ч тэдний олонх нь Бурханы таалалд нийцээгүй тул цөлд хиарсан юм” (1Коринт 10:4-5). Бурхан тэдэнд олон шалтгаанаар хилэгнэсэн ч, тэдгээр нь бүгд ганц л дэвсгэр шалтгаантай байв: Тэд Бурханы Үгд дуулгаваргүй буюу *ариунаар эмээдэггүй* байжээ.

Мосег дөч хоног ууланд байх хойгуур Израилийн хуаранг даргалж байсан удирдагч - Аарон нь алтан тугал бүтээлгэв. Бид ч энэ явдлыг нь шууд л “Шүтээн мөргөл!” гэнэ. Энэ үнэн. Гэхдээ Аарон ба Израилийн ард түмэн мөнөөх алтан тугалаа *Елохим* гэж өргөмжилснийг нь олон хүн анзаардаггүй. Елохим гэдэг үг нь Хуучин Гэрээнд 2,606 удаа гардаг. Үүгээр худал бурхдыг дуудах явдал байсан ч, арван удаагийн ес дээр нь цорын ганц жинхэнэ Бурхан - *Иеховаг* дуудсан байдаг. Тухай нь, Эхлэл номын эхний бүлэг ганц бүлэг дээр энэ нэр 32 удаа гарна. Библийн нэгдүгээр эшлэл дээр “Эхэнд Елохим тэнгэр ба газрыг бүтээжээ” (Эхлэл 1:1) гэдэг.

Тэгэхээр, Израиль алтан тугалаа Аугаа хүчирхэг Бурхан - *Елохим* гэсэн утгаар дуудсан уу, худал бурхан - *Елохим* гэдэг утгаар дуудсан үү гэдгийг хялбархан оношилж болохоор байна. Хариулт нь Аарон тугалаа *Иавэ* хэмээн дуудсанд оршино (Гэтлэл 32:5). *Иавэ* нь цорын ганц жинхэнэ Бурханы ариун дархан нэр бөгөөд тус нэрээр энэ ганц тохиолдлоос өөр худал бурхдыг дуудсан удаа Библид байхгүй. Аарон ба ард түмэн тугалаа *осирис*, *баал*, *айсис* зэрэг худал бурхдын нэрээр дуудаагүй. Харин “Биднийг Египетээс гаргаж авчирсан *Иавэ* энэ байна” (Гэтлэл 32:4) хэмээн тунхаглажээ.

Тэд яаж ийм эргүү байж чадав аа? Яахаараа жинхэнэ, амьд Бурханаа Мосе шиг таньж мэддэггүй байна аа? Гайхамшигийг нь үзэж, үүл, галан баганаар нь хөтлүүлээ биз дээ? Үүнд хариулах амархан. Хэдэн сарын өмнө Бурхан Өөрийгөө танилцуулахаар уулан дээр морилох үед хүмүүс гэдрэг унаад, Мосе рүү: “Та өөрөө очиж, манай Бурхан ЭЗЭНий айлдах бүхнийг сонсоод, ЭЗЭН Бурханыхаа танд айлдсан бүгдийг бидэнд хэлж өг. Бид үүнийг сонсоод даган мөрдье” (Дэд хууль 5:27) хэмээн хашхирцгаасан юм.

Мосегийн гашуудлыг төсөөлж байна. Бурханы оршихуйд байх дургүй хүсэлгүй тэднийг яалтай? Яахаараа ийм байдаг байна аа? Мосе энэ зовнилоо Эзэн дээр авчраад, хариулт авах гэтэл Эзэний хариулт Мосег мэл гайхуулав: “Энэ ард түмний чамд хэлсэн үгийг Би сонслоо. Тэдний хэлсэн бүхэн зөв зүйтэй” (Дэд хууль 5:28).

Мосе зог тусав. *Байзаарай. Тэдний зөв өө? Ганц удаа ч болов зөв байдаг байна шүү!* л гэж бодогдсон байх. Мосе Бурханд: “Тэд яагаад Таны оршихуйд нэвтэрч, надтай адил Тантай дотносож

Бурханаас эмээхүй

чадахгүй байгаа юм бэ?” гэж хариулаа болов уу. Үүнд нь Бурхан элэг эмтэлмээр үг хэлжээ:

Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээж, Миний бүх тушаалыг сахин... . (Дэд хууль 5:29)

Тэр хүмүүс ариунаар эмээдэг байсан бол, Бурханы оршихуйд нэвтэрч, дотнослыг эдлэхгүй юу. Энэ нь эргээд тэдний дуулгавартай чанарыг бэхжүүлж, тэд өөрсдөө ч, үр хүүхэд нь ч жаргах байлаа хэмээн Бурхан гашууджээ. Дараа нь Бурхан Мосед ийм заавар өгчээ:

Чи очоод, тэдэнд «*Майхан уруугаа буцацгаа!*» гэж хэл. Харин *чи энд Миний дэргэд зогс!* ...Би чамтай ярья.” (Дэд хууль 5:30-31)

Нэгэн зэрэг зүрх зүсч бас догдлуулмаар үг байна. Эхлээд гашуудмаар. Израилийн хамгийн хар бараан түүхэн цаг нь тугал бүтээсэн юмуу амлагдсан газрыг эзлэх боломжгүй гэдэг мэдээг авчирсан үе бус, чухам энэ үе л байв. Бурхан Израилийг Өөр дээрээ авчирч, Өөрийгөө тэдэнд мэдүүлж, Өөрөө тэднийг мэдэж, дотносох зорилгоор Египетээс (дэлхийгээс) гаргаж авчирсан. Гэтэл *ариунаар эмээх сэтгэлээр* сох дутсан тэр хүмүүс бүгдийг алджээ. Энэ бол эмгэнэл!

Нөгөөтэйгүүр, Бурханы дэргэд зогсож, Түүний Үгийг амнаас нь сонсох урилга хүлээж авсан Мосе хувьтай яа. Бурхан Мосег Өөрийнхөө дотно нөхөрлөлдөө уриад, харин бусдыг нь буцаажээ.

Усан сангийн дэргэд танилцсан хатагтай *өөр* Есүсийг ярьсан, коринтчууд *өөр* Есүст үйлчилсэн, Израиль *өөр* Аугаа хүчирхэг Бурханыг дагасан. Загварыг нь харж байна уу? Тэгэхээр, бид ч бас Есүс гэдэг нэртэй шүтээн бүтээчихээд, Бурханы баруун гарт залран суугаа *жинхэнэ* Есүсийг мэдэхгүй явж байх боломжтой. Хамгийн цочирдмоор нь Израиль ч, Коринт чуулган ч залбирлынхаа хариуг хүлээн авахдаа, Эзний эрх хүч, гайхамшигийг нүдээр үзсэн улс.

Одоо бүгдээрээ Есүсийг Эзэн хэмээн дуудсаар амьдарсан ч, шүүхийн өдөр Бурханаас Израильд хэлсэнтэй ижил үгийг буюу “Надаас зайл” гэдэг үгийг сонсох, нөгөө хүмүүс рүүгээ дахиж

эргэе. Тэр хүмүүст яг юу тохиолдохыг зөгнөсөн Есүсийн үгийг бид илүү дэлгэрүүлж шалгах ёстой. Чингэвээс бид Эзэнтэйгээ дотно харилцаа тогтооход ариун эмээхүй ямар чухал болохыг улам гүнээ ухамсарлана. За, энэ болбоос бидний удаах бүлгийн сэдэв.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Хэрэв миний тунхагласан үгийг та нар баримталж бас дэмий хоосон итгээгүй л бол, та нар түүгээр мөн аврагдсан. (1Коринт 15:2)

Санаа: Худлаа хүнд, худлаа юманд чин зүрхээрээ итгэх боломжтой.

Эргэцүүлэл: Жинхэнэ Есүст итгэдгээ хэрхэн бат мэдэх вэ? Удирдагч нарынхаа сургаалаар уу? Гэхдээ Аарон Израилийг сургаж, удирдаж байгаагүй билүү? Библи уншдаг болохоороо, бат мэдэх үү? Гэхдээ Фарисайчууд үүнийг хийдэггүй байсан гэж үү? Яг яаж мэдэх вэ?

Залбирал: Аав аа, Есүсийн нэрээр үнэнийг мэдээд зогсохгүй, хайрлахад минь туслаач. Ойлгосон ч, ойлгоогүй ч, Таны амьд Үгийг туйлын эрх мэдлээ болгомоор байна. Ингэвэл мэхлэгдэхгүй гэдгийг Та амласан. Таны Үгийг уншиж, дагах үед Таны Үг намайг уншиж, намайг хэн болохыг, Эзэн Есүс хэн болохыг илчлэх болтугай. Есүсийн нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би ойлгосон ч, ойлгоогүй ч, Бурханы Үгд итгэнэ.

*Бодлоо дагаж, сайн бус замаар явагч,
тэрслүү ард түмэнд хандан
Би бүхэл өдөржин гараа сунгав.*

— Исаиа 65:2

31 | ЧАМАЙГ МЭДЭХГҮЙ

Бурхантай дотносохын нөгөө талыг ойлгож байж л *Бурхантай дотносохыг* илүү ухамсарлаж, үнэлнэ байх. Өнгөрсөн бүлгээс эхлээд, энэ бүлэг дээр үргэлжилж буй сэдэв хатуу эд шүү. Гэхдээ энэ сэдвээр өгүүлсэн Бичээсийн бүх анхааруулга нь үнэндээ Аавын маань хайр, халамжийн бэлэг, хамгаалалт болой. Есүсийн үг биднийг Амьдруулагчтай минь ойр байлгах ариун эмээхүйг бидний дотор суулгана.

Хожмын өдрүүдэд Эзэнд захирагдахуйг халж, хуурамч авралын сайнмэдээнд олноороо сүсэглэн хөгжих явдал газар авахыг Бичээс маш тодорхой анхааруулдаг. Товчхондоо, Есүсийн Үгэнд оролгүйгээр, Түүнтэй зүгээр л сайхан анд нөхрийн харилцаатай байж болох юм гэнэ. Энэ нь ариун эмээхүйн өөдөөс тухирсан өдөөн хатгалга мөнөөс мөн бөгөөд Паулд зэмлүүлсэн Коринтчуудад тохиолдсон явдалтай адил *хийвэр Есүсийг* бүтээнэ.

Паул тэр Грек “Итгэгч” нарт *өөр Есүсийг* дагасан хэргийг нь тулгасан хойноо төсөөллийн аврагчийг бүтээхэд хүргэсэн зүрхнийх нь нөхцлийг тулгажээ. “Урьд нь нүгэл үйлдэн, ариун бус байдал, садар самуун, тачаангуй байдалдаа үл гэмшсэн эдгээр олноос болж би харуусах вий гэхээс айж байна” (2Коринт 12:21). Тэд аман дээрээ Есүст итгэдэг гэх боловч, ачир дээрээ Үгийг нь сөрж амьдарчээ.

Ийм явдал анхан үеийн чуулганд ховор байсан бол, өнөө цагийн Барууны чуулганд битүү тархжээ. Ийм сургаалын гороор “Эзэн” хүмүүсийн амьдралын эрх мэдэл бүхий байр суурь бус, хоосон шошго төдий л болно. Есүс:

Бурханаас эмээхүй

Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно (Матай 7:21) хэмээн зөгнөсөн.

Есүсийг Эзэн хэмээн дуудаж буй хүмүүс нь манай эрин зууны Мухамед, Иосеф Смит, Будда, Харе Кришна, Күнз тэргүүтэй хэн нэг хуурамч эш үзүүлэгчид мөргөдөг хүмүүс биш болохыг Есүс хүлээн зөвшөөрсөн. *Эзэн* гэдэг үг нь энэ эшлэл дээр хэдэнтээ давтагдаж байна. Бичээс дээр аль нэг үг юмуу хэллэг давтагдах нь санамсаргүй тохиолдол биш болохыг давтан хэлье. Бичээч үүнийг зориуд цохон тэмдэглэж байгаа хэрэг л дээ. Гэхдээ энэ тохиолдолд цохолт гэхээсээ илүү сэтгэл мэдрэмжийг хүчитгэн илэрхийлж байна. Жишээ нь 2Самуел 19:4-ээр эшлэл дээр хүү нь Иоабын цэргүүдэд алуулсан гэдэг мэдээг сонссон Давид: “Абсалом минь, Абсалом минь, хөвүүн минь, үр минь!” (орчуулагчийн хувилбар) хэмээн *орь дуу тавин* уйлсан байдаг. Бичээч “Хүү минь, үр минь!” гэдэг үгийн давтамжаар Давидын үгээр илэрхийлэшгүй гашуудлыг илэрхийлжээ.

Яг үүнтэй ижил аргаар Эзэн тэр үй олон хүн Өөрийнх нь араас яаж үхэлдэхийг илэрхийлжээ. Тэд Есүс бол Бурханы Хүү гэдэг сургаалыг үг дуугүй хүлээн зөвшөөрөхөөр барахгүй, үүндээ үнэн голоосоо сүсэглэх. Тэгэхээр энд “Христэд итгэгч” гэдгээрээ баясан бахархдаг, итгэлийнхээ тухай догдлон ярьдаг, магадгүй бүр хүндэтгэлийн цуглаан дээр асгартал уйлдаг хүмүүсийн талаар ярьж байна.

Тэд Христийн үйл хэрэгт ингэтэл сэтгэл гаргаад зогсохгүй, Түүний төлөө үйлчилдэг байна:

Эцсийн Шүүх дээр мянга мянган хүн амаа барин, Над дээр ирээд: “Эзэнтэн минь, бид Үгийг номлосон, бид чөтгөрүүдийг жанчсан, супер - сүнслэг төслүүд маань хүмүүсийн амны уншлага болсон гэж хэлэхийг нь Би одоо ч харж байна. (Матай 7:22, Мессеж Библийн орчуулга)

Тэр хүмүүс хөндлөнгийн үзэгч биш болохыг нь хамгийн тод дүрсэлсэн учраас, *Мессеж Библиэс* эш татлаа. Тэд чуулганыхаа

ажилд шууд оролцож, дэмждэг. “Бид Үгийг номлосон” гэдэг нь тэд итгэлээ чангаар илэрхийлдэг аж. Үндсэндээ, тэд хүмүүсийн амьдралыг сайнаар өөрчлөхөд гар бие оролцдог байна.

Мессеж Библийн эшлэл дээр *мянга мянган* гэсэн боловч, бусад бараг бүх орчуулга дээр *олон* гэдэг. Энэ нь “Олон тоо, тоо хэмжээ, нийлбэр хэмжээ” гэсэн утга бүхий *полус* гэдэг Грек үг бөгөөд “Ихэнх, дийлэнх” гэсэн утгаар хэрэглэгдэх нь олонтаа. Ямартаа ч, Есүс жижиг бүлэг хүмүүсийн талаар яриагүй, харин сайнмэдээний сургаалд итгэдэг томоохон бүлгийн талаар өгүүлжээ. Тэд Есүсийг “Эзэнтэн” хэмээн дуудаж, сэтгэл зүрхээ зориулж, Үгийг нь ярьж, үйлчлэлд нь идэвхитэй зүтгэнэ. Бид ч тэднийг жинхэнэ итгэгч л гэнэ. Тэгвэл тусгаарлагч хүчин зүйл нь юу вэ? Тэд жинхэнэ итгэгчээс юугаараа ялгаатай вэ?

Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг *танихгүй*. *Ёс бусыг үйлдэгч* та нар Надаас зайл” гэж хэлнэ. (Матай 7:23)

Түлхүүр мэдэгдэл нь “Ёс бусыг буюу хууль бусыг үйлдэгч” гэдэг үгд бий. Хуульгүй явдал нь Бурханы Үгийн эрх мэдлийг ойшоодоггүй нь эндээс дахин харагдаж байна. Тэр эрчүүд, эмэгтэйчүүд *хааяа нэг* бүдэрчихдэг бус, харин өөрт нь ашигтай л бол, Бурханы Үгийг үл тоож, үл ойшоож, дуулгаваргүй авирлаад бүр дадчихсан улс ажээ.

Есүс “Би та нарыг танихгүй (мэдэхгүй)” гэж мэдэгдсэн нь ч тун сонирхолтой. Мэдэхгүй гэхийг Еврейгээр *яада*, Грекээр *гиноско* гэдэг бөгөөд “Хэн нэгнийг дотно мэдэх” гэсэн утгатайг өмнөх бүлэг дээр хэлсэн. Тэр хүмүүс Есүстэй хэзээ ч жинхэнэ дотно харилцаа тогтоогоогүй аж. Хэдийгээр тэд Есүсийг Эзэнтэн, Эзэн хэмээн өргөмжлөв ч, үүнийгээ нэр төдий л үйлдэл болгоод, харин тушаалуудыг нь дагадаггүй байжээ. Иохан:

Бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа (гиноско) мэднэ. “Түүнийг би мэднэ” (гиноско) гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга (1Иохан 2:3-4) гэжээ.

Энэ үг нь Есүсийн: “Тэгэхээр та нар тэднийг үр жимсээр нь танина” (Матай 7:20) гэсэнтэй яг цав таарч байна. Үр жимс буюу үйл хэрэг гэж цуглаанд үйлчлэх, Үгийг тунхаглах, чуулганд явахыг хэлэхгүй. Учир нь тэр хүмүүс эдгээрийг үйлддэг байсан.

Ингэж хэлье: Мэдээж жинхэнэ итгэгч хүнд эдгээрх чанар заавал байна. Үнэндээ эдгээр чанаргүй хүн нь жинхэнэ итгэгч ч байх боломжгүй. Гэхдээ эдгээрийг эзэмшсэнээрээ, Бурханы жинхэнэ хүүхэд болчихгүй. Тиймээс “Та Бурханы Үгэнд ордог уу?” гэдэг л хамгийн гол шийдвэрлэх хүчин зүйл болно.

Есүс алдарт Уулан дээрх сургаалиа ч энэ л яриагаар өндөрлөсөн. Тэгээд цочир сургаалаа дараах үгээр дүгнэжээ:

Тиймд эдгээр үгсийг минь сонсоод үүний дагуу *үйлдэгч* бүр хадан дээр байшингаа барьсан ухаалаг эртэй зүйрлэгдэнэ. Бороо асгаж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу *эс үйлддэг нь* элсэн дээр байшингаа барьсан мунхаг эртэй зүйрлэгдэнэ. Бороо асгаж, үер буун салхи салхилж, байшинг нүдсэнд тэр нь нурав. Эвдрэл нь асар их байлаа. (Матай 7:24-27)

Дээрх хоёр төрлийн хүн ганц л энгийн зүйлээр ялгарч байна. Хэн, хэн нь Есүсийн Үгийг сонссон ч, эхний бүлэг нь *гүйцэтгэсэн* бол, хоёрдугаар бүлэг нь *гүйцэтгээгүй* буюу өөрөөр хэлбэл эхний бүлэг нь Бурханы *Үгд чичирсэн* (Бурханаас эмээсэн) бол, хоёрдугаар бүлэг нь Бурханы *Үгд чичрээгүй* (Бурханаас эмээгээгүй) байна.

Энэ хоёр бүлэг гаднаасаа бараг л ялгарах юмгүйг Есүс хэлсэн. Бат суурьгүй бүлгийн хувьд Христэд итгэх итгэлийн доктринд итгэдэг, Есүст үнэн сэтгэлээсээ Эзэн хэмээн сүсэглэдэг бөгөөд Христийн төлөөх идэвхитэй үйлчлэлээрээ амьдралаа буюу байшингаа хэрхэн барьснаа харуулдаг. Тэгвэл бат суурьтай бүлэг нь тэднээс ганц л юмаараа ялгарна. Тэд Есүсийн Үгийг өөрийнхөө хүсэл мэт дуулгавартай дагасан. Хоёр байшин хоёулаа ижил материалаар, ижил заавраар баригдсан. Гаднаас нь харахад, хэн, хэн нь хүндэтгэлдээ ч, үйлчлэлдээ ч нэг ижил байжээ. Гол ялгаа нь далд хэсэгтээ буюу сууриндаа байв. Нэг бүлэг нь Бурхантай хувьчлан дотно нөхөрлөдөг байсан бол, нөгөө нь нөхөрлөдөггүй байжээ.

Бурхан ариунаар эмээж амьдардаг хүмүүстэй л дотносохоо амласан. Дараагийнхаа хэдэн бүлгээр та, бидэнд соёрхогдсон ер бусын хувь завшааныг авч үзэцгээе.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ...та нарт нигүүлсэл ... улам арвижиг. ... бурхан хүч (нигүүлсэл) нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон. Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанарыг хуваалцагч болох юм. (2Петр 1:2-4)

Санаа: Хүн Есүстэй харилцаатай үгүйг нэг л зүйл илчилнэ: Тэд Есүсийн Үгийг сахих нигүүлслээр цэнэглэгдсэн байдаг бөгөөд нигүүлсэл нь тэдэнд хүний хүчнээс давсан хүч хайрладаг.

Эргэцүүлэл: Би Есүсийн Үгийг өөрийнхөө хүчээр дагах гэж оролдож байна уу эсвэл Түүний нигүүлсэл, амлалт, тэнгэрийн мөн чанарт найдаж байна уу? Явал өөрийнхөө бус, Бурханы хүчинд илүү найддаг болох вэ?

Залбирал: Аав аа, Таны Үгийг өөрийнхөө хүчээр дагах гэж оролдож байсныг минь уучлаарай. Одооноос эхлэн Есүс миний амьдралын Тэргүүн дээд Эзэн. Би гагцхүү Таны тэнгэрийн замаар явах хүчжүүлэгч нигүүлсэлд болоод дамжуулсан тэнгэрийн мөн чанарт найдна. Энэ замаар би Тантай нөхөрлөж алхална. Намайг ийм ер бусын амьдралд урьсанд баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Бурханы чадвар дотор итгэлээр явна. Би өөрийнхөө хүчинд найдалгүй, Түүний хүчжүүлэгч нигүүлсэлтэй гар нийлж ажиллана.

*Өөрийн маань бодол
биднийг хэзээ ч гэгээрүүлж,
гайхриуулж байгаагүй.
Харин Бурхан айлдах үед
заавал ч үгүй гайхаж, бишрэх.*

— Жой Даусон

32 | ЭЗЭНИЙ НУУЦ

Сүүлийн хоёр бүлэг бас л нэгийг бодож, хоёрыг сэнхрэм, хүнд бүлэг байлаа. Есүсээс “Эзэнийхээ баяр жаргалд ор” гэдэг үгийг дуулна хэмээн санасан олон хүн “Надаас зайл” гэдэг үгийг сонсоно гэхээр үнэхээрийн гол зурагдаж, зүрх зүсэгдмээр. Бурхантай ямар ч харилцаагүй атлаа харилцаатай гэж бодож явах шиг төөрөгдөл үгүй. Тэр эрчүүд, эмэгтэйчүүд “Бурхантай нэгдэх” бус, харин “Бурханыг ашиглах” сэдэл нь ямар явуургүй мунхаг санаа байсан гэдэг илчлэлийг аюудаст автан ухаарна. Бурханы Үгийг дагах үед илчлэгдэх ер бусын хайрыг нь эдлэхийн оронд амин ашгийнхаа төлөө Бурханы Үгийг ашигладаг байжээ тэд. Есүс биднийг ийм царцуу, хуурмаг нөхцлөөс хамгаалчих юмсан гэсэн аугаа хайрынхаа улмаас л энэ аймшигт байдлыг урьдчилан анхааруулжээ.

Ийнхүү бид дотнослын эсрэг талыг ойлгосон болохоор, эдүгээ Бүтээгчтэйгээ жинхэнээсээ дотносохын гоо үзэсгэлэнг дараа дараагийнхаа хэдэн бүлгээр авч үзье.

Яриандаа орохоосоо өмнө нэг зүйлийг асуумаар байна: (“Надаас зайл” гэдэг үгийг сонсохгүй ч) Бурхантай тийм ч дотно биш, зүгээр л хаанчлалын эгэл нэгэн иргэн байх боломжтой юу? Хариулт нь: Боломжтой. Энэ талаар Бичээсээс үзэхдээ, өөрийнхөө дуртай нэгэн түүхээр эхлүүлмээр байна.

ЭЗЭНий *андлал (нууц)* Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ. (Дуулал 25:14)

Нууцыг Еврейгээр *соод* гэх бөгөөд зөвлөгөө гэсэн утгатай

болно. Грек толь бичиг дээр мөн “Энэ нэр томъёоны цөмд нууцлал оршино” гэдэг. Тэгэхээр, үндсэндээ магтаалч нэгэн нууцын талаар хэлсэн гэхээсээ илүү Бурханы *нууц зөвлөгөөний* талаар өгүүлсэн бөгөөд зорилготойгоо нийцүүлэх үүднээс *нууцууд* гээд олон тоон дээр яриад явъя. Тэгэхээр дээрх Бичээсийг “Өөрөөс нь эмээдэг хүмүүстэй Бурхан нууцуудаа хуваалцах” гэж уншиж болно.

Нэгэн зүйл: Та нарийн нандин нууцаа танилтайгаа хуваалцах уу, дотно нөхөртэйгээ хуваалцах уу? Мэдээж дотно хүнтэйгээ л хуваалцана. Тэгвэл Бурхан ч ялгаагүй юм. Бурхан нууцуудаа ойр, дотны нөхөдтэйгээ хуваалцдаг бөгөөд ариунаар эмээж явдаг хүмүүстэй л дотно нөхөрлөдөг. ИйЭсВи Библи дээр: “Өөрөөс нь эмээдэг хүмүүстэй Эзэн нөхөрлөдөг” гэдэг.

Бурхан дурын хүнтэй нөхөрлөхгүй. Тодруулбал: *Бурхан чуулганд явдаг болгонтой найзлаад байдаггүй.* Энэ талаар Хуучин Гэрээнээс эхлэн дэлгэрүүлж ярья л даа. Хуучин Гэрээн дээр Бурханы найз гэдэг нэрийг авсан хоёр хүн байдаг нь Абрахам, Мосе хоёр юм. Өөр хүмүүс бий юу? Мэдээж бий - Ноа, Даниел, Естер, Иосеф, Давид, Иоб, Енох, Исаиа тэргүүтэй хүмүүс Бурхантай дотно явсан. Тийм боловч, эхний хоёр хүн Эзэнтэй найз нөхрийн харилцаанд хөтөлдөг замыг амьдралаараа үлгэрлэн харуулсан юм.

Абрахамаар эхэлье. Бурхан яагаад түүнийг найз хэмээх болов? Абрахамыг далан тавтай байхад нь Бурхан түүнд зүрхнийх нь хүслийг биелүүлэхээ тангарагласан нь хүү заяах амлалт байв. Гэхдээ энэ амлалт нь түргэн биелээгүй. Абрахамыг дахин хорин таван жил хүлээлгэж байж, гэргий Сарах нь гайхамшгаар Исаакийг төрүүлж өгчээ. Ингэтэл хүлээлгэн хүлээлгэн ирсэн амлалт ямар үнэ цэнэ, ямар амттай байсныг төсөөлж байна уу?

Жил ирэх тусам аав - хүүгийн харилцаа улам л бэхжиж байсан нь эргэлзээгүй. Хараад ханашгүй хүүгийнх нь дэргэд хамаг эд хөрөнгө нь юу ч биш байсан биз. Абрахамд хүүгээс нь үнэтэй юм байгаагүй байх аа. Бүр амь наснаас нь ч үнэтэй байсан биз.

Гэтэл нэгэн өдөр гэв гэнэт Бурхан Абрахамыг залбирч байтал нь “Чи цорын ганц хайртай хүү Исаакаа аваад Мориа гэдэг газар уруу яв. Тэнд түүнийг шатаалт тахил болгон Миний чамд зааж өгөх тэр нэг уулан дээр тахин шатаагтун” (Эхлэл 22:2) хэмээн айлдав.

Юу? Бурханаас ямар ч тайлбар ирээгүй байхад, зүгээр л Бурханы тушаал гэдэг шалтгаанаар үр хүүхдээ хөнөөх хэрэг үү? Тоглож байгаа байлгүй дээ! Ийм үг сонссон хүний цочролыг төсөөлөх үү? “Яасан хэцүү юм дуулгадаг хүүхэд вэ?” гэдэг шиг л. Үүнийхээ оронд Абрахамын амийг шаардсан бол, арай л учиртай байх сан. Ямар ч утгагүй юм.

Тэгэхээр, нэг зүйлийг хэлэх хэрэгтэй. Энэ нь зүгээр л шалгалт байсныг өнөөдөр *бид* мэднэ. Үнэндээ Бичээс ч тодорхой хэлдэг: “Хэсэг хугацааны дараа Бурхан Абрахамын итгэлийг шалгав” (1-ээр эшлэл). Гэхдээ төгсгөлийг нь мэдэх нь хэдийнээ болоод өнгөрсөн түүхэн үйл явдлыг уншихын сул тал юм. Абрахамын түүхийг итгэгч нар бүгдээрээ л наснаасаа олон сонссон юмуу уншсан. Гэхдээ Абрахам шалгалт байсныг мэдээгүйг бүү март! Бурхан шалгасныг нөгөө эрэг дээр гаран гартлаа хүн мэддэггүй. Ахлах сургуулийн шалгалт дээр арга заль хэрэглэж болох ч, Бурханы шалгалт дээр бүтэхгүй. Зүрхээ ариусгахын төлөө Бурханы Үг дотор амьдрах даалгавраа хийгээгүй хүн толгойтой байлаа, байлаа гээд шалгалт дээрээ бяц шахуулахдаа л шахуулна!

Абрахамын үр сад цөлд Бурханаар шалгуулж байгаагаа мэдсэн бол, арай өөрөөр үйлдэх байсан буй за. Гэхдээ тэдэнд байгаагүй зүйл нь Абрахамд байсан нь ариун эмээхүй болой.

Бурханы дэндүү гэмээр хүнд тушаалд Абрахам хэрхэн хариу үйлдсэн нь намайг бишрүүлэх: “Абрахам өглөө эртлэн босоод...” (Эхлэл 22:3). Абрахам шууд үйлдсэн! Хэдэн өдөр, долоо хоногоор тунгаагаагүй, найз нөхдөө дуудаж, санал бодлыг нь ч сонсоогүй. Бурханы тушаалыг эсэргүүцээ ч үгүй, үл хайхраа ч үгүй. Абрахам өглөө эртлэн ойр зуурын юмаа ачиж аваад, хоёр зарц, хүүгийнхээ хамт замд гарчээ.

Яахав, Бурханаас үг авмагцаа, зүрхнийхээ хийгээр хөдөлж болох л доо. Гэхдээ хоёр өдөр хагас явсаар, болзоот газраа тулж ирчихээд байхад, тэнгэрээс таг чиг байгаа нөхцөлд Бурхан тушаасан гэдэг ганц шалтгаанаар үр хүүхдээ хөнөөх нь байж болох хэрэг үү?

Абрахам уулын бэлд тулаад, зарц нараа үлдээгээд, Исаактай дээшээ гараад, тахилын ширээ босгов. Ингэх зуур Абрахамын дотор сэтгэлийн хат, оюуны хүч - хамаг бүхэн нь хуу шавхагдан,

Бурханаас эмээхүй

хөмөрсөн л байх. Ингээд цаг болов. Бурхан ч таг. Юм хэлэх ч үгүй биз. Абрахам амьсгаагаа залгиад, Исаакийг хүлээд, хүүгийнхээ зүрхэнд зоохоор хутгаа далайхад бэлэн. Бурхан л ингэ гэсэн. Яагаад гэдгийг нь хэлээгүй.

Тэгтэл гэнэт Бурханы тэнгэрэлч ил гаран: “Хөвгүүний эсрэг гар бүү далай! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй тул *чамайг Бурханаас эмээдгийг* одоо Би мэдлээ” (Эхлэл 22:12) гэв.

Абрахамыг Бурханаас эмээдгийг тэнгэрэлч хэрхэн мэдэв? Учир нь Абрахам *ямар ч утгагүй, ямар ч ашиггүй, зовиуртай* үед Бурханыг *даруй* бөгөөд *бүрэн гүйцэт* дагажээ.

Абрахам хутгаа тавиад, хүүгийнхээ хүлээсийг тайлаад, дээшээ хартал, бутан дундаас нэгэн хуц үзэгдэв. Абрахам өөрийн эрхгүй “Иавэ - Ире” буюу “Хангагч - Бурхан” (Эхлэл 22:14) хэмээн дуу алдав. Энэ юу вэ? Энэ эгшинд Бурхан Абрахамд өмнө хэзээ ч, хэнд ч мэдүүлээгүй чанараа илчилжээ. Яагаад? Яагаад гэвэл Абрахам Бурханы анд болжээ.

Нэг зүйлийг тодруулъя. Та нар намайг зохиолч гэдгээр минь мэддэг учраас, энэ номыг уншиж байгаа. Зарим чинь намайг конференц дээр номлохыг хараад, номлогч гэдгээр минь мэдэх байх. Гэвч Лиза бүсгүй намайг нөхөр, аав, өвөө, хамгийн дотно найз, амраг гэдгээр минь мэднэ. Гагцхүү миний дотны, цөөн хэдэн хүн л миний дээрх чанарыг мэддэг бөгөөд хамгийн сүүлчийн чанарыг бол зөвхөн Лиза л мэднэ.

Тэр өдөр Бурхан Абрахамтай андлалцсан бөгөөд тэдний ер бусын харилцааг бүгдээрээ цааш цаашдаа илүү дэлгэрүүлж үзээд, явал бид ч бас тийм харилцаатай болж чадахыг сурна.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ЭЗЭНий андлал (сэтгэл дүүрэн, сайхан нөхөрлөлийн (нууц)) Өөрөөс нь эмээгчидтэй (хүндэтгэж, мөргөдөг хүмүүстэй) хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ. (мэдүүлэх бөгөөд үүний (гүн, дотоод) утгыг нь тэдэнд илчилнэ (Дуулал 25:14).

Санаа: Бурхан нууцуудаа дотныхоо нөхөдтэй хуваалцдаг бөгөөд ариунаар эмээдэг хүмүүс л Бурханы дотны нөхөд мөн.

Эргэцүүлэл: Найз гэж хэн бэ? Найзууд хэрхэн сайхан нөхөрлөдөг вэ? Нөхөрлөлийг юу гүн гүнзгий болгодог вэ? Би Бурханы найз байхыг хүсч байна уу? Бурхан найзыг эрэлхийлдэг гэхээр юу бодогдож байна? Би Бурханы сайн найз байсан уу? Байгаагүй бол, юуг өөрчлөх хэрэгтэй вэ? Би Бурханд яг ямархуу найз баймаар байна?

Залбирал: Эзэн минь ээ, би Таны дотно найз баймаар байна. Та ч үүнийг хүсдэг. Бодох нь ээ, би итгэмжтэй найз байж чадаагүй. Таны хүслийг бүхнээс дээгүүр тавиагүй, харилцаагаа амьдралаараа ч, үйлдлээрээ ч хамгаалж чадаагүйг уучлаарай. Мөнхөд Таны найз байх нигүүлслийг өгөөч. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Бурханы л найз байхыг байхыг хүснэ.

*Бурханаас эмээхүй нь сэтгэлийг
гийгүүлж, ёрын мууг сөнөөж, дур
хүслийг номхотгож, сэтгэлээс
харанхуйг хөөн, цэвэршүүлдэг.*

*Бурханаас эмээхүй нь цэц ухааны оргил.
Бурханаас эмээдэггүй газар ямар ч сайн
сайхан байхгүй. Бурханаас эмээдэггүй
хүн Диаволын хөнөөлд нээлттэй.*

— Ефрем Дэ Сириан

33 | ОЙРЫН ХҮРЭЭЛЭЛ

Бурхан, Абрахам хоёрын нөхөрлөл хэрхэн бий болсныг бид үзлээ. Энэ түүх Бурхантай дотно харилцаа байгуулахын үлгэр жишээ болой. Энэ тухай яриагаа Абрахамаас л эхлүүлье.

Бидний эцэг Абрахам тахилын ширээн дээр хүү Исаакаа өргөхдөө *үйлсээрээ* зөвтгөгдсөн биш үү? “Бурханд Абрахам итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон юм” гэж өгүүлдэг Бичвэр биелэгдсэн бөгөөд *Бурханы анд нөхөр* гэж Абрахам *дуудагдах* болсон. (Иаков 2:21, 23)

Абрахам, Бурхан хоёрын нөхөрлөлийн талаар ярьсан үгийг элч Иаковын үгийг тэнгэрэлч нар ч баталдаг нь тохиолдол биш юм. Абрахам Бурханаас ариунаар эмээж явдаг нь *шуурхай* бөгөөд *бүрэн дуулгавартай байдлаар* (үйлдлээр) нь батлагдсан бөгөөд ариун эмээхүй л түүнийг Бурхантай дотносоход хүргэжээ. Бурхан ямар ч утгагүй, ямар ч ашиггүй, зовиуртай зүйл тушаагаад байхад л Абрахам Бурханы Үгд чичирсэн. Бурханаас эмээдэг хүн л Бурханы хүссэнийг хүсч, хийхэд хүрдэг.

Нэгэн өдөр Бурхан Мамрегийн царс модны дэргэд Абрахамтай уулзахаар явахдаа бараа болж явсан хоёр тэнгэрэлчээсээ асуусан: “Би хийх гэж буй юмаа Абрахамаас нууна гэж үү?” (Эхлэл 18:17)

Дараа нь Эзэн Абрахамтай санаа бодлоо хуваалцахаар үлдсэн бөгөөд хоёр тэнгэрэлч нь Содом, Гоморра хотыг зорьжээ. Агуулгаа алдагдуулахгүйн тулд дараа нь юу болсныг утгачилж ярья. Эзэн: “Абрахам аа, Би нүглээр улих тэр хоёр хотыг сөнөөлөө. Чи юу бодном?” гэжээ.

Бүтээгчээсээ ийм үг дуулахыг төсөөлж байна уу? Абрахам ч:

Бурханаас эмээхүй

“Содом ий?” гээд л цочоо байх.

Эзэн: “Тийм ээ. Бас Гоморра. Чи юу бодном?” хэмээн хариулав.

Балмагдсан Абрахам дотроо: *“Абрахам аа, бод, бод. Садан дүү Лот маань тэнд байх. Тиймээс түүний төлөө бас өөр олон гэм зэмгүй хүний төлөө чи л зуучлах ёстой”* гэж бодоод, нэгийг сэдээ болов:

Та зөвтийг буруутгай хамт устгах уу? Тэр хотод зөвт тавин хүн байж болох биш үү? Та ийм газрыг устгах уу? Тэрхүү тавин зөвт хүний төлөө тэр газрыг өршөөх үү? Зөвтийг буруутгай хамт устгах ийм хэрэг Танаас хол байг! Буруут нь зөвтэй бүү зэрэгцэг! Газар дэлхийн Шүүгч Та шударга шийдвэр эс гаргана гэж үү? гэв. (Эхлэл 18:23-25)

Абрахамын энэ үг Бурханы бахыг хангаа байх: “Зөв хө! За, Би тэр хоёр хотод тавин зөвт хүн байвал, устгахгүй. Абрахам андтайгаа зөвлөлдсөн нь зөв болов” хэмээн хариулаа байх.

Гэвч Абрахам тайвширсангүй. Тавин хүн хүрэхгүй бол, яанам? Тиймээс хүнийх нь тоог дөчин тав болгож бууруулаад мөн л хүсэлтээ тавьжээ.

Эзэн ч: “Бас л зөв! Тэгэхээр, дөчин таван зөвт хүн байвал, Би тэр хоёр хотыг сөнөөхгүй. Абрахам андтайгаа зөвлөлдсөн нь зөв болж” хэмээн хариулж.

Абрахам ханасангүй. Тэгээд асуудлыг улам л нарийсгасаар, дөчин таваасаа гуч, хорь, эцэстээ арван зөвт хүн дээр тогтов. Тэр дотроо: *“Арвын зэрэг хүн байх л ёстой. Нэг нь манай Лот. Цаана нь есхэн хүн л хэрэгтэй”* гэж бодоо болов уу.

Цааз гаргах эрх мэдэлтэй хаантай анд нь л ингэж ярилцаж зүрхэлнэ. Зарц хүн ингэж ярьбал, бараг өөрөө цаазлуулах биз. Гэтэл Эзэн Абрахамын хүсэлт болгоныг болгоожээ: “ЭЗЭН, Абрахамтай ярьж дуусаад одсон бөгөөд Абрахам ч өөрийн газарт буцжээ” (Эхлэл 18:33).

Бурханаас эмээхүй нь Бурханы хайртай зүйлийг хайрлаж, жигшдгийг нь жигших явдал юм. Нэг удаа надад муухай хандсан хүнд хайраар хандсаны минь дараа Бурхан: “Хүү минь, чи Миний санаа тавьдаг хүмүүст санаа тавьбал, Би чамтай төлөвлөгөөгөө

хэлэлцэнэ” хэмээн айлдаж билээ. Ариун эмээхүй нь Бурханыг төдийгүй, хүмүүсийг ч илүү чин сэтгэлээсээ, гүн гүнзгий хайрлах чадвартай болгодог.

Библи Содом, Гоморрагийн хүмүүсийг “Тэд идэж ууцгааж, худалдаж худалдан авч, тариалж, барьж байгуулцгааж байлаа” (Лук 17:28) гэдэг. Энгийнээр хэлбэл “Амьдрал сайхан байна, эдийн засаг буцалж байна. Бурхан байлаа гээд, бидний амьдарч байгаа байдлыг яах ч үгүй. Ер нь яасан ч яадаг юм” гэсэн янзтай л амьдарч байж. Хот нь хоног хүрэхгүй хугацааны дараа сөнөх гэж байхад, тэр хүмүүс юу ч мэдэхгүй байсан. Гэхдээ хамгийн аймаар нь энэ биш.

Хамгийн аймшигтай нь Библийн “Зөвт хүн” (2Петр 2:7) хэмээн дууддаг Лот гуай бурханлаг бус хүмүүстэй яг адил юу айсуйг мэдээгүй явсан! Абрахамын гуйлтын ачаар л нигүүлслийн хоёр тэнгэрэлч түүнийг болоод гэр бүлийг нь гаргаж аварсан юм (Эхлэл 19:29).

Илүү сайн ойлгохын тулд энэ үйл явдлыг өнөө цаг дээр буулгаж үзье. Аврагдсан, дахин төрсөн, Христэд итгэдэг хоёр *зөвт* хүн амьдарч байжээ. Нэг зөвт хүн нь Бурхан юу үйлдэх гэж байгааг мэддэг бөгөөд үүнийгээ хэрхэн гүйцэлдүүлэх тал дээр нь Бурханд тусалдаг. Гэтэл нөгөө зөвт хүн нь ёрын хүмүүстэй адил айсуй шүүхийн талаар таамаг ч үгүй. Яагаад? Эхний зөвт хүн нь Бурханаас эмээдэг бөгөөд Бурханы анд нөхөр учраас, эргээд Бурханы нууцуудыг мэддэг. Хоёр дахь зөвт хүн нь Бурханаас эмээдэггүй учраас, Бурхантай нөхөрлөдөггүй бөгөөд нууцуудыг нь мэддэггүй.

Лот зөвт байсан ч, дэлхийн явдалтай хүн байж. Тэрбээр ацан шалаанд орохоороо, яг л Коринтын чуулган шиг, яг л өнөөгийн Барууны олон чуулган шиг эхлээд өөрийнхөө ашиг сонирхлыг хайдаг итгэгчийг төлөөлнө. Энэ “Зөвт” эрчүүд, эмэгтэйчүүдийн бүлэг нь Бурхантай Америкийн ерөнхийлөгч, бид хоёрын харилцаанаас дээрдэх юмгүй харилцаатай байдаг. Би ерөнхийлөгчийнхөө шийдвэр, удирдлагын ашиг тусыг хүртдэг байж болох ч, ойрын хүрээлэлд нь нэвтрэхгүй, төлөвлөгөө, сэтгэл зүрхийг нь мэдэхгүй, шийдвэрийг нь ч гаргасан хойно нь л мэддэг.

Лотын амьдрах газар, ханилах хань, цус ойртож төрүүлсэн Моаб, Аммон хүүхдүүдээс нь л Лот ямаршүү хүн байсныг хялбархан таньж болно. Лот анхнаасаа л өөрт ашигтай гэснээ л сонгосон. Абрахам, Лот хоёр зам салах болоход, Абрахам Лотод түрүүлж газар нутгаа сонгох боломжийг олгоод, өөрөө эсрэг тийш явахаа амласан. Бичээс “Лот хараагаа өргөн, Зоар хүртэлх Иорданы талыг бүх газартаа элбэг устай, ЭЗЭНий цэцэрлэг шиг мөн Египетийн нутаг шиг байхыг харав (*баахан ширтэв*)” (Эхлэл 13:10) гэдэг. Яагаад баахан ширтэв? Тэр газрын хотууд нь ямар бузар булай болохыг Лот мэдэж байсан. Тэгэхээр, Лот дэлхийн системд шингэчилгүйгээр яаж ашиг тусыг нь эдлэхээ л шийдсэн байх. Төлөвлөгөөгөө боловсруулаа байх. Тэгээд “Лот талын хотуудын дунд сууж, майхнаа нүүлгэн Содомын ойролцоо босгожээ (Тэрбээр ёрын муугийн төвөөс аюулгүй зайд, хээр талд суурьшихийг” (Эхлэл 13:12) сонгосон ч, энэ арга нь бүтээгүй. Хожим Лот тэдэнд татагдаж, гэр бүлээ аваад, хотын хаалган дотор амьдрах болсон юм.

Ариун эмээхүйгээр дутагдаад ирэхээрээ бид толгойгоо дүрчилгүй, дэлхийтэй аль болох ойр байхыг эрэлхийлэх замыг хайдаг. Гэхдээ ийм сэдэлтэй хүн дэлхийд сорогдох нь цаг хугацааны л асуудал. Бид төөрсөн хүмүүст хүрэх дуудлагатай болохоос биш, тэдний нэг байхаар дуудагдаагүй.

Лотын амьдрал бидэнд сургамж болог. Абрахам зуучлан гуйгаагүй бол, Лот дээр шүүх шөнөөр ирэх хулгайч шиг л буух байж. Тэр хүний дэлхийн явдал аймшигтай үр дагавар дагуулсан. Лотын үр удам нь бурханлаг бус хүмүүс болсон. Гэргий нь Содомд хорогдсондоо, тэнгэрэлч нарын эргэж бүү хар гэсэн тушаалыг зөрчөөд, газар дээрээ давсан багана болж хувирсан. Есүс ч биднийг хайрласандаа л: “Лотын гэргийд юу тохиосныг санаарай!” (Лук 17:32) хэмээн анхааруулжээ.

Тэгэхээр, Бурхан хүүхдүүдтэйгээ ч яг ийм нөхцлөөр нөхөрлөдөг үү гэж асуух нь зүйтэй. Энэ талаар удахгүй ярина. Урьдаар Хуучин Гэрээнээс Бурханы өөр нэгэн найзыг авч үзье.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга. (Иаков 4:8)

Санаа: Бурхан Өөрөөс нь эмээдэг хүмүүстэй төлөвлөгөөгөө хуваалцдаг бол, нэг Түүн рүү, нэг дэлхий рүү гүйдэг хүмүүсээс төлөвлөгөөгөө нуудаг.

Эргэцүүлэл: Есүс “Харин үнэний Сүнс ирэхдээ...Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ” (Иохан 16:13) хэмээн мэдэгдсэн. Энэ нь Бурхан, Абрахам хоёрын харилцаатай хэрхэн уялдаж байна? Бурхан надтай нууцуудаа хуваалцдаг байгаасай гэж би хүсч байна уу?

Залбирал: Эзэн минь ээ, би Таны нууц зөвлөгөөг сонсмоор байна. Би ч бас Лоттой адил дэлхийтэй сээтэгнэсэн. Таны дотно зөвлөгөөнөөс холдсон. Үүнийгээ гэмшиж байна. Намайг Эзэн Есүсийн цусаар бүрэн угаагаач. Намайг зөвлөгөөгөө хуваалцдаг дотны хүнээ болгооч. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би дэлхийг бус, Эзэнийг сонгоно.

*Бурханы оршихуй дотор
хүндэтгэл, эмээхүйн жинд
автахдаа л Бурханд сүнсээр бөгөөд
үнэнээр мөргөж эхэлнэ.*

— Алистэйр Бегг

34 | НҮҮР НҮҮРЭЭРЭЭ

Тэгэхээр, Хуучин Гэрээнд Бурханы “Анд нөхөр” хэмээн дуудуулсан өөр нэгэн хүнийг үзье.

Ийнхүү хүн *анд нөхөртэйгөө* ярьж байгаа мэт ЭЗЭН, Мосетэй *нүүр нүүрээрээ* тулан ярьдаг байлаа. (Гэтлэл 33:11)

Бичээс Бурхан, Мосе хоёрын тогтоосон харилцааг “Нүүр нүүрээрээ” хэмээн дүрсэлсэн нь ухаанд багтамгүй. Энэ чинь гудманд яваа хүн юумуу тэр байтугай алдартай дуучин биш, харин Аугаа хүчирхэг Бурхан шүү дээ. Тиймээс энэ мэдэгдлийн хүч төсөөлөгдөж байна уу? Дотнослын энэ нэр томъёог ганц удаа хэрэглээгүй; хоёр дахь удаадаа Аарон, Мириам хоёр Мосег шүүмжилсэнд нь Эзэн уурлах үед мөн хэрэглэсэн байна. Бурхан:

Миний зарц Мосегийн хувьд тийм биш бөгөөд тэр Миний бүхий л гэрт итгэмжит билээ. Би түүнтэй оньсого таавраар бус... ам амаараа ярьдаг (Тооллого 12:7-8) хэмээн хатуу мэдэгджээ.

Учир нь Бурханаас “Би чамд итгэдэг” гэдэг үгийг сонсох нь хүний хүлээж авах хамгийн том сайшаал болой. Энэ нь ч итгэлцлийн суурь болох Бурхантай тогтоох нөхөрлөл рүү улам татаж байна. Тэгэхээр, Бурханы итгэлийг юу байгуулдаг вэ?

Болзолгүй дуулгавартай байдал - хүссэнийг нь үргэлж гүйцэтгэх. Туйлын үнэн байдал - хэлсэндээ ямагт хүрэх.

Бурханыг хэзээд тэргүүнд тавих - Түүний хүслийг үргэлж нэгдүгээрт тавих.

Бурханаас эмээхүй

Бурханы зүрхийг мэдэх - Шийдвэр гаргахдаа, үргэлж Бурханы хүслийг сонгох.

Бүх дөрвөн зүйл дээр тууштай байдал яригдаж байна. Нэг тал нь зөрчигдсөн бол, чин сэтгэлийн шуурхай гэмшил нь таныг дахин итгэлцлийн зам дээр эргүүлж тавина. Ариун эмээхүй л энэ дөрвөн ангилал дээр найдвартай байхад хөдөлгөдөг бөгөөд энэ тал дээр Мосе өндөр үзүүлэлтээрээ онцгойрдог байв. Энэ бүлгээрээ бүгдээрээ Бурханы зүрхийг л ямагт мэдэж сонгох дээр буюу гурав, дөрөвдүгээр ангилал дээр төвлөрөе.

Мосегийн амьдралыг үзбэл, эхний дөчин жил аугаа баялаг, тансаг хоол, ганган хувцас, эд, хүслийн дээд дунд умбаж, энэ дэлхийн хамгийн эрх хүчтэй, баян өвөөгийнхөө орд харшид амьдарч өнгөрөөжээ. Гэтэл:

... Бурханы хүмүүсийн хамт ад үзэгдэхийг.. Христийн төлөө буруутгагдахыг ... тэр *сонгосон* ... тэр (*аугаа*) *шагналыг* харж байлаа (Еврей 11:25-26) гэдэг.

Мосе тэр бүхнээ орхихыг *сонгосон*. Мосе ордондоо үлдсэн чигээрээ үйлчлэх арга чаргыг хайж болох байсан ч, Египетээс олж чадахгүй *шагналыг* эрэлхийлжээ. Тэр шагнал нь амлалтын газар байв уу? Биш ээ. Учир нь тэр газарт Мосед байхгүй юу л байв гэж?

Мосегийн эрэн хайгаад байсан зүйлийг илрүүлэхийн тулд ордноос хойшхи амьдралыг нь авч үзье. Энэ бүхнийг орхиж явах нь ухаалаг сонголт байв уу? Амьдралынх нь нөхцөл Египетийн ханхүү байсан үеийнхээс нь дээр байв уу? Мосе дэлхийн тэргүүн улсыг жолоодох эрхээ дөчин жил цөлийн гүнд хонь хариулах ажлаар сольсон! Хонь хариулахад үнэхээрийн урт хугацаа шүү! Дараа нь Мосе Бурханы хүмүүсийг Фараоноос чөлөөлөх урт удаан, зовлонтой үеийг туулсан. Энэ зовлон багадсан юм шиг, дараа нь үлэмжийн бэрхшээлээр дүүрэн, хувхай цөлд майханд амьдарсан. Удирдаж байгаа хүмүүс нь гэж удирдлагыг нь тувтан шүүмжилдэг, байнгын сэтгэл дундуур, эсэргүү улс.

Ингэж байтал Бурхан Мосед энэ их дарамт, зовлонг нь үлэмж ихээр хөнгөлөөд өгөх, догь санал тавив. Бурхан түүнд хүмүүсээ цуглуулаад амлагдсан газар руу орох заавар өгсөн. Үүгээр тогтохгүй тэнгэрэлчээрээ тэднийг эсэргүүцэх бүх улс үндэстнийг замаас нь

зайлуулж, замчлах сонголтыг тавьсан. Тэр газар нь үржил шимтэй, баян тансаг нутаг байхыг сануулаад, эцэст нь “Харин Би та нартай явахгүй” (Гэтлэл 33:3) хэмээн айлджээ.

Тэгэхээр, Мосе болоод Израиль ямархуу байдалтай амьдарч байсныг бодолцъё. Тэдэнд сонголт байгаагүй - гоё сайхан хээр тал, гол ус, ой хөвч, үржил шимтэй газар, цэцэрлэгт хүрээлэн, жимсний цэцэрлэг, бэлчээр - юу ч байхгүй. Халуун усанд орох, тухтай оронд унтах, цэвэрхэн хувцас өмсөх, дэлгүүр хоршоо хэсэх тухай бодоод ч хэрэггүй. Хоолны ч сонголт байхгүй - шинэ жимс ногоо, загас, үхрийн мах, амттан - юу ч байхгүй. Ямар ч цөцгийн тос, жимсний чанамал, хүйтэн зуушгүй... өглөө болгон өвсөн дээр унадаг хоосон талхнаас өөр юмгүй!

Египетийн боолчлол аймшигтай хэдий ч, хувхай хуурай цөлөөр тэнэх нь дээрдэх юмгүй байв. Аль аль нь өөр боловч, ялгаагүй аймшигтай зовлонтой байжээ. Гэхдээ цөлд Израильд найдвар байв: Үржил шимтэй, баян тансаг, өөрийн гэсэн нутагтай болох амлалт. Энэ нутгийг хэдэн үеэрээ ч хүлээв!

Тиймээс Бурхан ийм сайхан боломж гаргаж өгнө гэдэг юу болохыг төсөөлж байна уу? Мэдээж Мосе хүлээж аваад, уулнаас өнхрөх нь холгүй харайж буугаад, энэ мэдээг ард түмэндээ хүргэнэ. Хүмүүс ч уулгалан, түүнийг аугаа их удирдагчаараа өргөмжлөөд, бүгдээрээ хэдэн үеэрээ нүдээ ширгэтэл хүлээсэн амлалтын газартаа очих хүсэн хүлээсэн аялалдаа аз жаргалтайяа гарна. Гэхдээ Мосе Бурханд юу гэж хариулсныг үзнэ үү:

Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач.
(Гэтлэл 33:15)

“Эндээс” гэдэг нь ямар газар билээ? Бөөн хор хөнөөл, зовлон, бэрхшээлийн газар. Мэдэхгүй хүмүүсийн хувьд Мосе зог тусмаар, гонсоймоор хариулт хэлжээ. Мосе үндсэндээ “Би Таны оршихуй, ерөөл хоёроос сонгох ёстой болбол, Таны оршихуйг л сонгоно!” гэжээ. Яагаад? Эзгүй хүний тухай ерөнхийлөн мэдэхээс биш, дотносох боломжгүй. Тиймээс Бурхантай дотно явах нь л Мосегийн хүслэнт шагнал нь байжээ.

Бурхан яахаараа Өөрийнх нь зааврыг дагахаас татгалзсан Мосед баярлах билээ гэж үү? Мосе Бурханы зүрхийг мэддэг байжээ. Бодоод

Бурханаас эмээхүй

үз: Та хэн нэг хүнээс яваад, өөрийнхөө дуртай, өөртөө л ашигтай юмаа хийгээрэй хэмээн сэтгэлээсээ хүстэл, нөгөөх чинь: “Үгүй ээ, би таны дэргэд байж байна. Би тантай байх дуртай” гэж хэлбэл, баярлахгүй юу? Ийм үгэнд баярлахаар барахгүй, цочирдож догдолно.

Мосе Бурханаас эмээдэг, Бурханд чухал зүйлийг ямагт чухалчилдаг, Бурханы зүрхийг тээдэг болохоор, итгэлийг нь ч даадаг байжээ. Харин Израиль өөр байв.

Өөрийн замыг (*зан чанарыг*) Мосед, *үйлсээ* Израилийн хөвгүүдэд Тэрээр мэдүүлсэн. (Дуулал 103:7)

Бурхан Абрахамд илчилсэн шигээ *зан чанараа* Мосед ч илчилжээ. Дэ Гүүд Ньус Транслэйшн оф дэ Библи хувилбар дээр Бурхан Мосед *төлөвлөгөөгөө* илчилсэн гэдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан хувийнхаа нууцыг Израилиас нуугаад, Мосед илчилжээ. Израиль Бурханыг залбиралд нь хариулдгаар нь буюу *үйлсээр* нь л мэддэг байв.

Өнөөдөр хичнээн олон итгэгч Бурханыг залбиралд хариулагч Бурхан гэдгээр нь л мэддэг билээ? Бурхантай тогтоосон харилцаа нь ч дотны гэхээсээ, арилжааны чанартай. Тэд Бурханы Үгийг мэддэг ч, зүрхийг нь мэдэхгүй. Бичээсийг дүрэм юмуу түүх шиг эсвэл ердөө л сэтгэл засах урмын үг болгох маягаар л хэрэглэнэ. Үүгээр зогсохгүй, Бурханы зүрхийг илчилсэн, амьдрал өөрчлөгч үнэнийг нь хүлээж авахын оронд хууль бус зан авираа хэрэгжүүлэх зөвшөөрөл болгохоор гуйвуулдаг.

Абрахам, Лот хоёртой л адил Мосе, Израилийн хэн хэн нь зөвт байсан. Гэхдээ Бурханаас эмээдэг нь л Бурханы зүрх, зан чанар, нууц, төлөвлөгөөг мэдэх эрхийг олж авна. Бурхан яагаад хүмүүст бус, Мосед итгэж байв? Яагаад гэвэл Мосе өөрт ашигтайгаа бус, ямагт Өөрийнх нь зүрхийг сонгохыг Бурхан мэдэж байсан. Энэ чинь л ариун эмээхүй.

Гэтлэл ном дээр Израильчууд тугал бүтээхэд Бурхан:

“Одоо Би уур хилэнгээ тэдний эсрэг шагааж, тэднийг устгахын тулд Намайг орхи. Харин чамайг Би агуу үндэстэн болгоно”
(Гэтлэл 32:10) хэмээн хилэгнэсэн.

Мөн л Мосегоор аугаа үндэстнийг бий болгох ер бусын санал тавьжээ. Үүнд Мосе хэрхэн хариулав? Мосе мөн л өөрт бус, Бурханд

сайныг л сонгосон. Мосе Бурханд “Египет болоод дэлхий Бурханы нэр хүндийн талаар хүмүүстээ итгэмжгүй байлаа” хэмээн ярилцахыг нь сануулаад, энэ саналаас зоригтой татгалзсан. Тэдний яриа ч гал авалцаж, сүүлдээ Мосе “Санаагаа өөрчил” (12-аар эшлэл) хэмээн түс тас хэлжээ. Мосе хилэгнэсэн Бурханаас санаагаа өөрчлөхийг шаардах зүрхтэй байж! Бурханаас эмээдэг, зүрхийг нь нэвт шувт мэддэг, Түүнд хамгийн сайн сайхныг хүсдэг хүн л ингэж чадна.

Иймээс л Бурхан хүмүүсийг бүгдийг нь аварсан ч гэлээ, тэдэнд бус, Мосед л итгэсэн юм. Бурхан Египетийн чанга атгаас Израилийг чөлөөлсөн ч, тэдэнд зүрхээ нээгээгүй. Нөхөрлөлийн энэ нөхцөл Шинэ Гэрээн дээрх Бурханы хүүхдүүдэд хэрэгжих үү? Дараагийн бүлгээс үзэцгээе.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Надад өгөгдсөн (итгэмжлэгдсэн) бүгд Эцэгээс... Хүүгээс ... өөр хэн ч Эцэгийг мэдэхгүй. (Матай 11:27)

Санаа: Бурханаас “Би чамд итгэж байна” гэдэг үг сонсох шиг том сайшаал байхгүй. Бурхантай нөхөрлөхөд итгэлцлийн суурь чухал бөгөөд энэ нь Эзэнээс эмээдэг хүмүүст л бий.

Эргэцүүлэл: Мосе Бурханаас эмээдэг, Бурханы зүрхийг мэддэг, Бурханы итгэлийг даадаг байсан. Есүс ч Бурханаас дуртайяа эмээдэг, Аавынхаа зүрхийг мэддэг, бүх итгэлийг нь даадаг байсан. Эдгээр нь ямар уялдаатай байна? Бид ч ариун эмээхүйг тээвэл, юу болох вэ?

Залбирал: Эзэн минь ээ, би Таны итгэлийг даамаар байна. Таныг дагаагүй, үгээ сахаагүй, Таны хүслийг өөрийнхөөсөө чухалчилж, Таны сайн сайхны төлөө эрмэлзээгүйг минь уучил. Энэ байдлаа өөрчилмөөр байна. Намайг ариунаар эмээдэг болгооч. Үүнийг хийх хүчээр дүүргээч. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Би Эзэн Есүсийнхээ итгэлийг даасан хүн байхыг сонгож байна.

*Замд Тэр бидэнтэй ярилцаж,
Бичвэрийг бидэнд тайлбарлаж байхад
нь зүрх маань [бидний дотор]
шатаж байсан бус уу?*

— Лук 24:32

35 | ТА НАР МИНИЙ НӨХӨД

Мосе, Абрахам хоёрын амьдрал нь Бурхантай дотно харилцаа тогтооход юу шаардагдахыг үлгэрлэн харуулдаг. Эзэн Мосегийн тухайд бүр “*Миний бүхий л гэрт* итгэмжит билээ” (Тооллого 12:7) хэмээн дуу алдсан. Тэр үеийнхэн дунд Эзэний итгэлийг даачих өөр хүн байсангүй. Аймшигтай мэдэгдэл.

Есүс энэ чансааг өөрчилсөн үү? Есүс Өөрт нь итгэсэн бүхэнд нөхөрлөлөө дэлгэсэн үү? Мэдээж үгүй гэж хариулах боловч, Есүсийн үйлчлэлийн босгон дээр Иоханы бичсэн мэдэгдлээр судалгаагаа эхэлье:

Алгасалын баяраар Иерусалимд байхдаа Есүсийн хийсэн тэмдгүүдийг олон хүн үзээд Түүний нэрэнд *итгэжээ (найдах болов)*. Харин Есүс өөрийгөө тэдэнд *эс даатгасан (эс найдсан)* нь Тэрээр бүх хүнийг мэдэж байсных билээ. (Иохан 2:23-24)

Даатгах (найдах) гэдэг нь “тултлаа найдаж, түшиглэх - бүрэн итгэл үнэмшилтэй байх, итгэлээ өгөх”¹ гэсэн утга бүхий, сонирхолтой үг юм. Гэхдээ хамгийн сонирхол татмаар нь Есүс тэгж найдаагүй. Хүмүүс хэдийгээр Есүст тултал найдаж, түшсэн ч, Есүс тэдэнд найдаагүй. Хүмүүс ихэнхдээ л найдваргүй байдгийг Есүс дэндүү сайн мэдэж байжээ. Есүс хүмүүсийг хайрласан, хүмүүст үйлчилсэн ч, андын хэмжээнд авч үзээгүй. Хүмүүн биеэр үзэгдсэн Бурхан - Есүс Өөрт нь итгэсэн хүмүүст Бурхан Мосед хандаж байсан шиг хандаагүй.

Бүгдээрээ сүүлчийн зоог дээр очицгооё. Өнгөрөгч гурван

жилийн үйлчлэлийн хугацаанд Есүст итгэсэн хүмүүсийн дийлэнх нь итгэл даамгүй байв; олонх нь Есүсийг нэг бол нууцаар, нөгөө бол холоос дагах юмуу ашигтай үед л дагадаг байлаа. Дагалдагч нар нь ч бүгдээрээ шахуу Түүнийг орхиж явсан бол, Иудас бүр урвасан.² Есүс хүмүүст яагаад итгээгүйг одоо арай тодорхой ойлгов уу?

Сүүлчийн зоог дээр Есүс хамгийнхаа л дотны хүмүүстэй сууж байв. Тэгээд талархаж хайрласан сэтгэлээр “Намайг сорилтод байх үед Миний хажууд зогсож байсан нь та нар мөн” (Лук 22:28) гэжээ. Үндсэндээ, тэднийг найдаж болох хүмүүс хэмээв. Тэр оройдоо Петр томоохон бүдэрсэн боловч, гэмшээд илүү үнэнч зүрхээр эргээд ирэхийг нь Есүс мэдэж байжээ.

Иудас тэр чигээрээ урвах ёстой байсан бөгөөд үлдсэн арван нэгт нь Есүс “Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй” (Иохан 15:15) хэмээн айлджээ. “Дахиж буюу цаашид” хэмээсэн нь тэр хүмүүс нэгэн цагт зарц гэгдэж байсныг илтгэнэ. Энэ чинь илчлэл бус, зүгээр л наад захын Англи хэл. Энэ зарчмыг Паул ч задалж бичсэн:

Гэхдээ хэдийгээр өв залгамжлагч нь бүгдийн эзэн мөн боловч хүүхэд байхдаа зарцаас ялгагдах юмгүй байдаг. (Галат 4:1)

Бид Бурханы хаанчлалын өв залгамж нар байтал, Бурхан яагаад биднийг зарцын хэмжээнд байлгана вэ гэж асуух ёстой. Хариулт нь: Хамгаалах гэж! Биднийг Ананиа, Сапфира хоёрын хувь зохиолыг давтахыг Бурхан хүсэхгүй. Бурхан үүнийг таалахгүй.

Наяад онд Лиза, бид хоёр нэг нь 450 ажилтантай, нөгөө нь 150 ажилтантай, дэлхийн хэмжээний хоёр ч цуглаанд ажилладаг байлаа. Аль альд нь удирдлагын асуудал байхыг харсан боловч, сүйд майд бололгүй явсаар, өөрсдийнхөө үйлчлэлийг эхлүүлэх үедээ удирдлагын тал дээрээ нөгөө туйл руу нь хадуурчихсан юм. Мэдээж зарим нь оновчтой санаа байсан ч, зарим нь нэг тиймэрхүү л байв. Нэг Бидний бүтээсэн нэгэн уриа нь “Би ажилтан болгоныхоо анд нөхөр нь болно” гэдэг уриа байлаа. Ямар донгио ухаанаар бүтээсэн уриа болохыг харж байгаа биз.

Анхны маань ажилтан Жастин гэдэг залуу байлаа гэж төсөөлье. Би түүнтэй ихэд дотно нөхөрлөж, сагс тоглож, тогтмол хамтдаа

хооллох, видео үзэх гэх мэт анд нөхдийн хийдэг зүйлсийг байнга хийнэ. Эхэндээ гоё л байв. Гэхдээ жилийн дараа би түүнд мэдээж их бага хэмжээгээр үг хэлэх ёстой болсон. Тэгээд ширээний нөгөө талд өөдөөсөө харуулан суулгаж байгаад их л зөөлнөөр: “Жастин, чи надтай аялж байхдаа, манай ширээн дээр ирж, ном материал сонирхож байгаа хүмүүстэй эелдэг харилцах хэрэгтэй. Тэд чинь Бурханы нандин хүмүүс учраас, инээмсэглэж, яриа хөөрөө үүсгэх хэрэгтэй” гэж хэллээ.

Тэгтэл юу болсон гэж санана. Жастин над руу хуруугаараа зааснаа, намайгаа зүсэн зүйлийн зохисгүй үйлдэлд буруутгаж гарав. Миний алдаатай үйлдлийг жагсааж ирээд л тоочлоо. Надад ч *Яана аа? Би үнэхээр итгэдэг гэж үү?* гэж бодогдоод л. Жастин намайг шүүмжлэлийн нүдээр харж байгааг нь би танив. Тэгээд түр зогсоод, яах ёстойгоо Ариун Сүнснээс асуулаа. Тэгтэл Ариун Сүнс: “Түүнийг үйлчлэлээс чөлөөл” хэмээн зөөлнөөр айлдав.

Би ч Жастиныг ярьж дуустал нь хүлээгээд: “Жастин, би чамайг энэ ажлаас чөлөөлж байна” гэж хэлэв.

Жастины хилэгнэсэн гэж. Манайхаас уур савсуулсаар одов. Би ч түүний төлөө хамаг л сэтгэлээ зориулсан болохоор, уйллаа. Тэгтэл гэнэт Ариун Сүнс: “Тэр эргэж ирнэ. Хоёр дахин итгэмжтэй болно” хэмээн шивээнэв.

Гурван сарын дараа Жастин залгаж байна. Тэгээд: “Бурхан надтай маш тод яриад, зэмлэсэн. Би танаас уучлал гуйхаар залгаж байна. Бурхан намайг Лиза, та хоёрын амьдралд ямар байр сууринд тавьсныг мартаж орхиж. Та хоёрт удирдагч шигээ биш, харин найз шигээ хаа хамаагүй хандаж. Намайг уучлаарай” гэв.

Би ч тэр даруй: “Жастин, би чамайг уучилна аа” гэж хэллээ. Тэгээд бид хоёр хэдэн тооны эв найрамдлын үгс хэлэлцсэнийхээ дараа би түүнээс эргэж бидний төлөө ажиллах уу гэж асуутал, Жастин баяртайгаар зөвшөөрсөн бөгөөд дахиж энэ тал дээр бидний хооронд хэзээ ч асуудал үүсээгүй юм.

Эдүгээ би өөр сэтгэлгээтэй болсон. Ажилтан маань Жастины умартсан зүйлийг бүрэн ухамсарлахаас нааш би ямар ч ажилтантайгаа зүрхнийхээ нарийн нандин юмсыг хуваалцадггүй. Багтайгаа хөндий хүйтэн байсандаа юмуу зай авсандаа бус, зүгээр л тэднийг хамгаалахын тулд тэр. Тэднийг Жастин шиг байдалд

Бурханаас эмээхүй

оруулмааргүй байна. Тэгээд ажилтан маань байр сууриндаа тогтоод авсныг нь мэдбэл, нөхөрлөж эхэлдэг. Багийн маань олон хүн миний дотны нөхөд.

Тэгэхээр, Эзэн үндсэндээ: “Чи өв залгамжлагч - хаанчлалын маань хүү, охин мөн боловч, Би чиний амьдралд хэн болох, чи Миний хувьд хэн болохыг бүрэн ухамсарлахаас чинь нааш, Би чамайг зарцын төвшинд л барьж байна. Энэ нь чамайг Ананиа, Сапфира хоёр шиг шүүхээр оруулалгүй, хамгаалахын төлөө юм” гэж байна.

Есүс доорх гурван хүнд:

“Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол эс мэдэх юм. Харин Би та нарыг анд нөхөд гэж дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ” (Иохан 15:15) хэмээн айлдсан.

Есүс үндсэндээ “Өнөөдрийг хүртэл Би та нарт төлөвлөгөө, нууц зөвлөгөө, зүрхнийхээ нарийн нандин юмсыг буюу дотроо дэлгэдэггүй байлаа. Харин одооноос Би Мосе, Абрахам хоёрт найдсан шигээ та нарт *найдна*” гэжээ. Тиймээс л Есүс бид бүгдэд:

“Та нар... *аваас*... Миний нөхөд мөн” (Иохан 15:14) хэмээн айлдсан.

Бид Есүсийг бидний найз хэмээн зоргоороо дуулж, номлож, ярьдаг бөгөөд зарим маань зүгээр л нэг хам шигээ ханддаг. Гэхдээ Түүний мэдэгдлийг гүйцээж уншдаг уу? Түүнтэй нөхөрлөх болзол нь юу билээ?

“Та нар *тушаасныг минь үйлдбээс*, Миний нөхөд мөн.”

Болзол гэж байна аа: *Эзэнээс эмээхүй* - Түүний Үгд чичирч, ямар ч утгагүй, ямар ч ашиггүй, зовиуртай байсан ч, тушаалыг нь шуурхай бөгөөд бүрэн гүйцэт даган биелүүлэх. Абрахам, Мосе хоёр Бурханаас эмээдэг учраас л Бурхан тэдэнтэй андлалцсан шигээ бидэнд хандана. Эзэний зүрх бидний хувьд оройн дээд хүсэл болохын цагт Эзэн бидэнд итгэж, андын төвшинд хүлээн авна. Ертөнцийн Бүтээгчтэй нөхөрлөх шиг ер бусын хүндэтгэл, завшаан үгүй.

Хичээлийнхээ төгсгөлд бидний зүгээс үүсч болзошгүй нэгэн асуултыг гаргаж тавья: Есүс бидэнд тушаал өгдөг үү? Өгдөг. Дан

ганц Шинэ Гэрээнд л гэхэд таван зуу гаруй тушаал бий. Эдгээр нь аврагдахад шаардлагатай тушаал бус, үнэгүй өгсөн бэлэг. Эдгээр нь Бурханыг алдаршуулахын төлөө, бидний зүгээс сахих хүчтэй болгогдсон тушаал юм. Есүс явахаасаа өмнө хамгийн сүүлд: “Иймээс та нар яв... *та нар тушаасан* бүгдийг минь сахин биелүүлэхийг тэдэнд (бүх үндэстэнд) заа” (Матай 28:19-20) хэмээсэн.

Ариун эмээхүйн хамгийн том ашиг нь Есүстэй тогтоох нөхөрлөлд удирдах юм. Харин бусад ашгийг нь дараагийнхаа хичээлээр үргэлжлүүлцгээе.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: “Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн.”
(Иохан 15:14)

Санаа: Бид итгэснээрээ л Есүсийн итгэлийг олохгүй. Эзэн Өөрөөс нь эмээдэг хүмүүстэй л нөхөрлөдөг.

Эргэцүүлэл: Утгагүй, ашиггүй, тэр бүү хэл зовиуртай байсан ч, Есүсийг шуурхай бөгөөд бүрэн гүйцэт дагах хэрэгтэй юу? Түүнтэй нөхөрлөсний ашиг тус бий юу?

Залбирал: Эзэн минь ээ, би юу юунаас илүү Таны дотно найз байхыг хүснэ. Би Таныг зайнаас мэддэг бус, ойр дотно байхыг хүсч байна. Би Эзэнээс эмээхүйг - Таныг болзолгүй дагаж, бүх зүрх, сэтгэл, бие, хүчээрээ хайрлаж, хүмүүсийг Тантай адил үнэнээр хайрлахыг сонгож байна. Есүсийг нэрээр гуйж байна. Амень.

Шийдвэр: Би Есүсийн найз байхыг сонгож байна! Би Түүний тушаал бүрийг дагана.

ЭРДЭНЭСИЙН АШИГ ТУС

Зургадугаар долоо хоног

*Хөл доорх замаа дэнсэл.
Зам бүхэн чинь дайвшгүй байг.*

— Сургаалт үгс 4:26

36 | БУРХАНЫ АМЛАЛТЫГ ТОГТНООХ

За, одоо ариун эмээхүйн олон талын ашиг тусад анхаарлаа хандуулцгаая. Эдгээрээс хэдийг нь хэдийнээ үзсэн бөгөөд үүн дотор хамгийн аугаа нь Бурхантай дотно нөхөрлөх талаар сурсан. Тэгэхээр “Танаас эмээгчдэд зориулан Таны хуримтлуулсан, Таны дотор хоргодогчдод Таны соёрхсон сайн сайхан ...хичнээн агуу” (Дуулал 31:19) болохыг үргэлжлүүлэн сурцгаая.

Энэ гайхамшигтай яриаг эхлүүлэхээсээ өмнө түгээмэл байдаг, нэгэн ташаа ойлголтыг тодруулах хэрэгтэй. Хүмүүс туршлагаа Бичээсээр хэлбэршүүлэхийн оронд Бичээсийг өөрийнхөө юмуу ерөөлийн туршлагын линзээр орчуулах гээд байдаг. Үндсэндээ, Бурханы амлалтыг *Бурхан биелүүлж өгбөл, тун сайн. Гэхдээ биелүүлж өгөхгүй байсан ч, тэр аугаа Бурханыг би яах ч аргагүй учраас, зүгээр ээ* гэсэн бодолдоо дийлдээд, “Биелж ч мэдэх, биелэхгүй ч байж мэдэх” үзэгдэл мэтээр төсөөлдөг. Энэ итгэл нь Бурханыг үр хүүхдээ алагчилдаг Бурхан шиг харагдуулдаг бөгөөд гэтэл үүн шиг худал үгүй. Ийм ойлголт нь цаагуураа Эзэний талаар шууд л битүүхэн дургүйцэл төрүүлэх.

Гэтэл бодит байдал нь тэнгэр газар шиг өөр юм. Мэдээж бид Бурханы хэлсэн зүйлд сэтгэл хангалуун байх ёстой. Энэ үнэнийг Бичээсээр баталъя. Тэгэхээр, ихэнх хүний автомат гэж үздэг Библийн нэгэн амлалтыг тогтооё. Бурхан Абрахамд “Исаакаас гарсан нь л чиний үр удам гэж нэрлэгдэх болно” (Эхлэл 21:12) хэмээсэн. Бурханы энэ бөгөөд өмнөх үгс нь нийлээд “Абрахам нэгэн үндэстний эцэг болох бөгөөд айсуй Мессаиа нь Исаакийн удмаас төрнө” гэдэг тэнгэрийн амлалтыг шулуутгажээ.

Үүнийг санангаа, Бурхан Исаакт гэрлэх охиныг нь сонгож өгснөөр Исаакийн ургийн хэлхээ эхэлснийг харъя. Абрахамын зарц нь Исаакт сүйт бүсгүй олохоор Абрахамын нутгийг зорьжээ. Хол газрыг туулан ирээд, хот айлын худгийг бараадан, Бурханаас андуурч эндүүршгүй тэмдэг хүссэн нь асууж гуйлгалгүйгээр арван тэмээг нь сэтгэлээрээ услаад өгөх охин л “*Танаас Исаакт заяасан хүн байг!*” (Эхлэл 24:14) гэдэг хүсэлт байв.

Тэгэхээр, түр зогсоод цөлийн уртыг туулсан ганц тэмээ арван таван минутын дотор 110-190 литр ус уучихдгийг хэлэх хэрэгтэй. Энэ тоогоо арваар үржүүлбэл, залуу бүсгүйн хувьд сайн дураараа татахад яггүй их ус болох нь. Ёстой гайхамшиг л ийм залбирлыг биелүүлэх байтал, Ребека бүсгүй зарцын гуйлтыг төгс биелүүлэв! Тиймээс тэрбээр Исаакийн гэргий байх тэнгэрийн төгс сонголт мөн байв.

Зарц Ребекаг дагуулсаар харьж, Исаак, Ребека хоёр гэрлэв. Гэтэл Бурханы амлалтанд нүсэр саад тулгарчээ. Ребека хүүсэр учир хүүхэд төрүүлэх боломжгүй байв! Бурхан алдчихав уу? Ребекаг хүүсэр гэдгийг нь мэдсэнгүй юу? Одоо амлалт хэрхэн биелнэ? Яахаараа очиж очиж ийм хүүхнийг сонгов? Одоо Исаак, Ребека хоёр яана? Зүгээр л нэг өдөр умай нь гайхамшгаар нээгдэж, амлалт өөрөө биелэхийг нь харзнах уу?

Хариултаа олохын тулд Абрахамыг л эхнийхээ сэжүүрийг болгоё. Тэрбээр эрэлхэг залбиралтай хүн байв. Абрахам л Бурханыг зөвт арван хүний төлөө мөн чанараа сахиж, Содом, Гоморраг сөнөөхгүй байхад уриалсан байдаг. Хүүдээ ч бас үүнийг сургасныг нь Бичээсээс харж болно. (Эхлэл 18:19) Үүнийг санаад, дараах эшлэлийг уншина уу:

Эхнэр нь хүүсэр учир Исаак түүний төлөө ЭЗЭНд *залбирсанд* ЭЗЭН *хариулж*, эхнэр Ребека нь жирэмсэлжээ. (Эхлэл 25:21)

Ёстой Бурхан л хөдлөхгүй бол, хүн яаж ч дийлэхгүй амлалт гэж байдаг бол, тэр нь Ребекагаас хүүхэд төрөх явдал байсныг дахиад хэлье. Гэхдээ хамаг учир үүнд байсангүй. Исаакийн залбирал л Бурханы амлалтыг баталгаажуулсан юм. Исаак *гуйх* ёстой байсан. Еврей толь бичиг дээр “Гуйх гэдэг үгийн язгуур нь Эзэн рүү хашхирах гэсэн утгатай” гэж тэмдэглэжээ. Тиймээс тэр нь зүгээр

нэг хүсэлт бус, харин хариултаа авахаас нааш салахгүй, улайрсан хүсэлт байжээ. Эзэн ийм залбиралд дуртай.

Зөвгийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна.
(Иаков 5:16)

Элч Иаков чин зүрхний гал халуун залбирал л үр нөлөөтэй байдгийг хэлжээ. Тэрбээр борооны төлөө залбирсан Елиаг жишээ болгов. Елиа толгойгоо хоёр өвдгөндөө хавчуулаад, долоонтаа шатаж залбирсан бөгөөд зарц нь тэнгэр шинжихээр долоонтаа уул оод авирсан. Елиа Бурханы амлалт газар дээр биелэхийг нь харан хартлаа бууж өгөөгүй (1Хаад 18:41-45-ыг үзнэ үү).

Исаак Бурханы хүслийг мэдэж, газар дээр биелэн биелтэл нь хашхирчээ. Тэгвэл энэ л үнэн итгэгч хүн бүрт хамаатай бус уу?

Аяа ЭЗЭН, үг тань тэнгэрт Мөнхөд *бат тогтжээ*. (Дуулал 119:89)

Тэнгэрт Эзэний Үг тогтоогдсон. Газрыг дурьдалгүй, зөвхөн тэнгэрт гэсэн нь тохиолдол биш юм. Яагаад тэр вэ? Магтаалч “Тэнгэрс бол ЭЗЭНий тэнгэрс, Харин дэлхийг Тэрээр хүний хөвгүүдэд өгчээ (Дуулал 115:16). Эзэн тэнгэр, газрыг эрхшээдэг ч (1Коринт 10:26), тодорхой хугацаанд хүн төрөлхтөнд эзэмшүүлжээ.

Лиза, бид хоёр айл болохдоо, байр түрээсэлдэг байлаа. Тэр орон сууц бидний өмч биш боловч, бид орон гэрээ болгон амьдран сууна. Байрны эзэд нь хүрч ирээд, тавилгаа байршуулах, тохижуулах зэрэг бидний амьдрах арга барилд хошуу дүрэхгүй. Гэхдээ тусламж хүсбэл, байрны эзэд бидэнд тусална.

Яг үүнтэй адил Эзэн газрыг өмчилдөг ч, хүн төрөлхтөнд түрээсэлжээ. Ийм учраас л Еден цэцэрлэгт Эзэн дайрч ирээд, Адамын гараас жимсийг нь цохиж унагаагүй юм. Бурхан хүн төрөлхтөнд газрыг эзэмшүүлжээ (Эхлэл 1:26-28). Үүнийг ойлгосон болохоор, одоо бүгдээрээ “Эзэний Үг газар дээр хэрхэн биелдэг билээ?” гэж асуух ёстой. Бичээс “Хоёр юмуу гурван гэрчийн *амаар* ямар ч үг батлагддаг” (2Коринт 13:1) гэжээ. Мөн Исаиа дээр Эзэн:

Бурханаас эмээхүй

Амнаас минь гарсан Миний үг Над уруу хоосон буцаж ирэхгүй,
Харин юу хүссэнийг минь хэрэгжүүлж, Юунд илгээснийг минь
гүйцэлдүүлнэ (Исаиа 55:11) ч гэдэг.

Аль аль эшлэл дээр нь *ам* гэдэг үгийг цохсон нь сонирхолтой.
Бурханы амаа хүслээ мэдүүлдэг ч, газар дээрх эрх мэдлийг хүлээж
авсан хүн л амаараа гаргаж хэлж байж, тэр үгийг нь газар дээр
тогтооно. Үндсэндээ Эзэнийг газар дээр ирээд, ажлаа хийх хүсэлт
тавьж байгаа хэрэг. Товчхондоо бид Эзэнээс хүслээ биелүүлэхийг
нь гуйхаас нааш, Эзэн манай “түрээсийн байранд” дур мэдэн
ирэхгүй.

Бурхан Абрахамд амлалтаа өгсөн. Исаак “Аавын минь Бурхан
Та, надаас үндэстнийг төрүүлж, үр удмыг минь ерөөхөө амласан.
Гэргийн минь умайг нээж, хүүхэд хайрлаач” гэж залбирсныг нь
төсөөлж байна уу? Үүний хариуд Бурхан хүслээ тогтнуулжээ.

Тэгэхээр, одоо бидний хамгийн том үлгэр дууриал - Есүсийг
харцгаая.

Тэрээр махбодынхоо өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах
Нэгэнд чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөсөн.
Тэр эмээдэг байсан тул Бурхан Түүнийг *сонссон* билээ. (Еврей 5:7)

Мөн *луйлан шалан гуйсан* гэсэн утгыг давтахдаа, энэ удаа *Бурханд
үзүүлэх гүн хүндэтгэл* бүхий үгтэй хавсаргажээ. Энэ бол дараагийн
түлхүүр. Хүмүүстээ өгсөн Бурханы амлалтыг газар дээр тогтнооход
мятрашгүй итгэлээс гадна Эзэнээс эмээхүй шаардлагатай. Бурхан
Есүсийн залбирлыг “Сонссон” гэж буйг тэмдэглээрэй. Залбирах
нь нэг хэрэг бол, Бурхан залбирлыг *сонсох* нь өөр хэрэг. Хариултаа
авдаггүй залбирал гэж байдаг уу? Байлгүй яахав. Иаков “Та нар...
буруугаар гуйдаг учраас... хүлээн авдаггүй” (Иаков 4:3) гэсэн.
Тиймээс бид сэдлээ эргэж харах хэрэгтэй ба сэдлийг минь Эзэнээс
эмээхүй л зохих ёстой байранд нь тогтоож хайрладаг.

Бурханаас эмээх үедээ бид Бурханы амлалт буюу хүсэл газар
дээр тогтнохыг зоригтой гуйж, тунхаглаж чадах бөгөөд энэ нь
тэнгэрт шигээ газар дээр ч тогтоно. Магад иймээс л элч Паул газар
дээрх амьдралынхаа адаг дээр “Итгэлийн сайн тэмцлээр тэмц.

Мөнх амийг зуур” (1Тимот 6:12) гэж бичээ юм болов уу? Энэ бүхэн нь тэмцэл бөгөөд итгэлээрээ бид мөнх амийн хангамжийг зуурдаг.

<>< Хувийн эргэцүүлэл >>

Эшлэл: Тэрээр Өөрөөс нь эмээгчдийн хүслийг биелүүлдэг. Тэдний хашхирахыг нь бас сонсдог, тэднийг авардаг. (Дуулал 145:19)

Санаа: Хүмүүс туршлагаа Бичээсээр хэлбэршүүлэхийн оронд Бичээсийг өөрийнхөө юмуу өрөөлийн туршлагын линзээр орчуулах гээд байдаг.

Эргэцүүлэл: Би итгэлээ Бичээсийн тунхагаас салгаад, өөрийнхөө юмуу өрөөлийн туршлагатай нийлүүлсэн үү? Миний амьдрал, гэр бүл, нөлөөллийн ертөнцөд хараахан биелээгүй яваа амлалт бий юү? Би амьдралаа эдгээр тэнгэрлэг амлалтын гадуур төвхнүүлээд байна уу? Тэдгээр амлалт газар дээр биелэхийн төлөө хашхиран гуйхад би бэлэн үү?

Залбирал: Эзэн минь ээ, сүнсээр залхуу байж, Таны Үгийн төлөө тэмцэлгүй, амлалттай, амлалтгүй амьдарч ирснийг минь уучлаарай. Би Таны Үгийг биелүүлэхийн төлөө тэмцэхийн оронд туулсан амьдрал, үзсэн туршлагаараа замнажээ. Үүнийгээ гэмшээд, итгэлийн сайн тэмцлээр тэмцэж, Таны хүсэл тэнгэрт шигээ газар дээр биелэхийн төлөө залбирах тэмцлийг сонгож байна. Амень.

Шийдвэр: Би итгэлийн сайн тэмцлээр тэмцэж, мөнх амийн зүйлсээс зуурч, миний ертөнцөд Бурханы хүсэл тогтнохыг харахыг сонгож байна.

*Бурханаас эмээдэг хүн
амьдралтай айдасгүй тулдаг.*

*Бурханаас эмээдэггүй хүн
бүхнээс айж явдаг.*

— Ричард Халверсон

37 | АЙДСЫГ СӨНӨӨДӨГ АЙДАС

Өнөөдөр бид айдсаар дүүрэн, зовлонт дэлхий дээр аж төрж байна. Үнэндээ энэ бүхэн нь улам л эрчимжихийг Есүс ч хэлсэн. Юу айсууг сэрдхийтэл дүрсэлсэн нь: “Тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдсэнээс болж орон дэлхийд ирж буй зүйлсийг тэд ёрлож, айснаасаа ухаан алдана.” (Лук 21:26) Эдгээр айдас, зовнил нь найдвар, амар тайван, тайвшрлыг хөөж, түгшүүр, зүрхний шаналан, байнгын тамлалыг л авчирна. Тэгвэл хор тайлагч нь юу вэ?

Иймээс ЭЗЭН хүчит мутраараа надад айлдан энэ хүмүүсийн замаар явахгүй байхыг надад сануулан хэлэхдээ: —Энэ хүмүүсийн хуйвалдаан гэж үзэж байгаа бүхнийг хуйвалдаан гэж хэлж болохгүй. Тэдний айж байгаа юмнаас бүү ай, бүү сүрд. Та нарын ариун хэмээн үзэх ёстой нэгэн нь Түг түмдийн ЭЗЭН юм. Тэрээр эмээдэс тань байх болно. Тэр та нарыг айлгах болно. Дараа нь Тэр ариун газар болно. Гэхдээ Израилийн хоёр гэрийг цохих чулуу, бүдрүүлгийн хад, Иерусалимын оршин суугчдын урхи ба занга болно. (Исаиа 8:11-14)

Ариун эмээхүй нь аюулгүй байлгах Бурханы амлалтаар баталгаажсан тул бусад бүх айдас, зовнилыг сөнөөх. Түр зогсоод бодоод үзнэ үү. Таныг бүхэл бүтэн Америкийн Нэгдсэн Улсын зэвсэгт хүчин хамгаалах гэрээтэй гээд бод доо. Та бол хамгаалах ёстой нэн тэргүүний этгээд бөгөөд таны аюулгүй байдлыг бүх нөхцөл боломжоор хангахыг Америк улсын генералууд шат шатны цэргийн дарга нарт үүрэгдэнэ. Таныг хаана байсан ч, хаашаа явсан

ч, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт иж бүрэн зэвсгээр хамгаална. Энэ бол үлгэр л дээ. Гэхдээ ийм юм болбол, та бараг л төгс аюулгүй байдлыг мэдэрнэ байх. Гэвч энэ бүхэн нь Аугаа хүчирхэг Бурханы “Би чамайг аюулгүй байлгана” хэмээх амлалтын дэргэд юу ч биш юм. Бидэнд:

“Танаас эмээгчдэд зориулан Таны хуримтлуулсан, Таны дотор хоргодогчдод Таны соёрхсон сайн сайхан Хүний хөвгүүдийн өмнө хичнээн агуу вэ! Та тэднийг оршихуйнхаа нууц газарт Хүний хуйвалдаанаас нуун Та тэднийг хэл амны хараалаас Майхандаа нууцалж хамгаалдаг” (Дуулал 31:19-20) хэмээн амласанд ч гайхалтгүй.

Биднийг хорлож хохироох гэсэн этгээдээс Бурханы нөмөр дор айх аюулгүй нууцлагдах элбэг дэлбэг сайн сайхны амлалт нь бүгдэд бус, харин *Эзэнээс эмээдэг* хүмүүст л зориулагдсан амлалт болой. Лиза, бид хоёр ч олон жилийн турш худал, гүтгэлгэ, ял, заналхийлэл үзсэн. Би найз нөхөддөө: “Намайг битгий гүүгэлдээрэй. Баахан л шүүмжилсэн нийтлэл гарч ирнэ шүү” гэж захидаг юм. Гэвч Лиза, бид хоёр биеэ өмөөрөлгүй, чимээгүй л байсаар ирсэн. Харин ч бид энэ бүх цохилтыг эмээгч Бурхандаа даатгадаг бөгөөд Тэр ч биднийг итгэмжтэй хамгаалсаар ирсэн. Амархан байгаагүй ээ. Энэ их ялыг Эзэнд даатгаж байгаагаа илэрхийлэн, хумбайлгаж хавсарсан алгаа тэнгэр өөдөө өргөөд: “Аав аа, Таны мугарт даатгаж байна, биднийг хамгаалаач” гэж хашхирахад, Аав минь ч хэзээ ч хөсөрдүүлээгүй.

Ариун эмээхүй миний мэддэг олон хүнийг ч хамгаалахыг харсан. Хэдэн жилийн өмнө би хотынхоо 1,500 хүнд номлосон юм. Тэр цуглаан дээр олон хүн айдсаа Эзэнээс эмээхүйгээр сольж билээ. Тэр цуглаан дээр айдсаас чөлөөлөгдсөн ээж, охин хоёр маргааш орой нь дэлгүүрээс гэртээ харих замдаа хутга, буу шийдэм болсон гурван залууд олзлогджээ. Тэр гурав нөгөө хоёроос гэртээ дагуулж орохыг шаарджээ. Дээрэмдэж, хүчиндэж, магадгүй бүр хөнөөх санаатай байсан биз.

Хожим ээж нь надад: “Өмнөх орой нь чөлөөлөгдөөгүй байсан бол, би айдастаа хөшөөд, хэлснийг нь үг дуугүй хийх байсан байх” гэж хэлсэнээ, араас нь “Гэхдээ би тэдний гэртээ дагуулж ор гэсэн

тушаалыг дагалгүй, Есүсээс аврал гуйн, чангаар залбирч эхэлсэн. Залбирах тусам, итгэлтэй байдал, хүч, амар тайван минь улам л бэхэжсэн.

Нөгөө гурав салгалж эхэлснээ намайг залбирлаа зогсоохыг тушаасан л даа. Эцэстээ тэвчихээ болиод, хилэгнэн: “Наадахаа боль, боль, боль!” гэж хашхирч гарсан гэж ярьсан юм. Тэр гурав яаж ийм зоригтой бүсгүйтэй таарна гэж мэдэх билээ. Гурван дээрэмчин ээжээс нь болж самуурч байх хооронд охин нь амжиж гэртээ ороод, тусламж дууджээ. Харин нөгөө гурав охиныг нь алга болсныг мэдмэгцээ, дороо зугтсан байна.

Мөн яг тэр жил намайг Техасын Хьюстонд үйлчлэх үеэр нэгэн залуу бүсгүй айдсаа ариун эмээхүйгээр сольж билээ. Тэр долоо хоногтоо бүсгүйг дэлгүүрээс гараад, машиндаа суутал арын суудлаас нь хутга барьсан хүн гараад иржээ. Тэгээд машинаа асаагаад хөдлөхийг тушааж. Бүсгүй айдаст автахын оронд Есүсээс зогсоо зайгүй тусламж гуйн орилжээ. Ийм маягаар хэдэн цаг давхих зуур нөгөө эр бүсгүйг дуугаа хураахыг шаардсан ч, бүсгүй үгэнд нь орсонгүй. Эцэстээ нөгөө эр “Зогс!” гээд, бүсгүйг машинаа зогсоомогц, арын хаалгаар нь арилаад өгчээ.

Арам хаан Елишаг баривчлуулахаар цэргүүдээ илгээсэн түүх бий. Елишагийн зарц хааны морьд, морин тэрэг, цэргүүдийг түрүүлж үзээд, үлэмж айжээ.

Гэтэл Елиша: “Бүү ай! *Манай тал* тэднээс олон!” гэж хэлээд “Өө, ЭЗЭН, түүнд харуулахын тулд нүдийг нь нээгээч” (2Хаад 6:16-17) хэмээн залбирсан. Эзэн нүдийг нь нээсэн. Тэгээд зарц нь уулын бэлээр үй олон тэнгэрлэг хүлэг, галт тэрэг байхыг үзжээ.

Есүс Өөрийг нь чулуугаар нүүлгэж алахад бэлэн хүмүүстэй байнга таардаг байв. Нэг удаа цугласан олон Есүсийг хадан дээрээс шидэж алахыг завдсан ч, Есүс амь насанд нь заналхийлсэн ийм тохиолдол болгон дээр ямар ч гэмтэлгүй, зүгээр л гараад явчихдаг байсан (Лук 4:29; Иохан 8:59; 10:39-ийг үзнэ үү).

Бурхан нэг л тохиолдолд Өөрөөс нь эмээдэг хүнд зовохыг зөвшөөрдөг - Бурханы алдрын төлөө дээрээс зөвшөөрөгдсөн нөхцөлд. Гэхдээ ийм нөхцөлд ч ариун эмээхүй нь хүний айдсыг зайлуулдаг. Дэлхий дээрх хамгийн хүчирхэг эзэн хаан - Вавилоны Небухаднеззарын өмнө зогссон гурван Еврей залууг санаж байна

уу? Тэр хаан аварга шүтээн бүтээгээд, улс даяар хөгжим явмагц, даяар олноороо мөргөхийг зарлигджээ.

Нөгөө гурван залуу Бурханаас эмээдэг байсандаа, хааны зарлигийг дагаж, нүгэл үйлдэхээс татгалзжээ. Тийнхүү тэднийг ганц дохилтоор халуун зууханд хаяулж чадах, догшин Небухаднеззарын өмнө аваачигдав. Гурван залуу айсан уу? Үүнийг өөрсдөө шийдэцгээ. Гагцхүү хилэгнэсэн хааны өмнө хэлсэн үгийг нь үзнэ үү: “Бидний үйлчилдэг Бурхан биднийг аврах бол дүрэлзсэн галтай зуухнаас ч хаантан таны гараас ч биднийг Тэр аварна. Хэдийгээр тэгэхгүй байсан ч, өө хаантан, бид бурхдад тань үйлчлэхгүй мөн таны босгосон алтан хөрөгт мөргөхгүй гэдгийг та мэдсүгэй гэв” (Даниел 3:17-18).

Ямар айхтар итгэл вэ! Бичээс “Небухаднезар хилэнд автаж, Шадрах, Мешах, Абеднего нарт хандан царай нь хувирчээ” (19-ээр эшлэл) гэсэн ч, гурван залуу айдасгүй бөгөөд амгалан байжээ. Тэр гурав Бурханаас эмээдэг бөгөөд Бурхан тэднийг амьд, үхсэнийх нь алинд ч чөлөөлж чадахыг мэдэж байв. Ингээд зууханд хаягдсан ч, ямар ч гэмтэлгүй, тэр бүү хэл түлэнхий ч үнэртүүлэлгүй эсэн мэнд гарч иржээ. Тэд үхлээс айгаагүй.

Бурханаас үлэмж эмээдэг элч Паул ч ийм хандлагатай хүн байв. Тэрбээр цаазлуулж болзошгүй нөхцөлд орохдоо ч “Юунд ч ичихгүй, харин бүрэн зоригтой байх юмсан гэсэн миний хүслэн болсон горьдлого болоод найдварын дагуу одоо ч урьдын адил амиар ч бай, үхлээр ч бай биед минь Христ өргөмжлөгдөх болно. Миний хувьд амьдрах нь Христ, үхэх нь ололт юм” (Филиппой 1:20-21) хэмээн мэдэгджээ. Яагаад Христийг алдаршуулахын төлөө үхэх нь амьдралаас дээр юм бэ? Зарим орчуулагч нар бүр “хавьгүй дээр” ч гэдэг. Цэц ухааны эхлэл болох Бурханаас эмээхүй нь энэ амьдралд ч, ирэх амьдралд ч бидэнд зүйтэй үзэл бодол хайрладаг. Тиймээс л Есүс “Махбодыг хөнөөгчдөөс бүү ай. Учир нь тэд сэтгэлийг хөнөөж үл чадна. Харин махбод болоод сэтгэлийг хоёуланг нь тамд устгаж чадах Түүнээс айгтун” (Матай 10:28) хэмээн мэдэгджээ.

Олон жилийн өмнө би аялан үйлчилдэг байхдаа, хөвгүүдийнхөө төлөө их айдаг байлаа. Гэтэл энэ тухайд Бурхан надад: “Жон, амьдралд чинь байгаа аливаа айдас нь загалмайн хөлд тавиагүй

зүйлсийг чинь л илтгэх. Тэр хэсэг дээрээ чи өөрөө эзэн суусаар байна” гэж хэлсэн юм. Би тэр оройдоо гэмшээд, хөвгүүдээ Бурханд бүрэн даатгасан бөгөөд дахиж тэднийхээ аюулгүй байдлын төлөө зовниогүй юм. Эзэнээс эмээхүй нь биднийг бүх зүйлээ Есүст өргөхөд чиглүүлдэг. Үүнийг хийхдээ бид бусдын хүслэн болдог ч, олж чаддаггүй айдсаас эрх чөлөөтэй, амар амгалан, итгэлтэй амьдарна.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ЭЗЭНээс эмээхүй нь чухам амь. Үүгээр бялхагч нь амар нойрсож гай хөнөөл эс амсах. (Сургаалт үгс 19:23)

Санаа: Амьдралд чинь байгаа ашиггүй айдас болгон нь загалмайн хөлд тавиагүй зүйлийг чинь л илтгэж байгаа юм. Тэр хэсэг дээрээ та өөрөө эзэн суусаар байна.

Эргэцүүлэл: Би амьдралынхаа аль тал дээр айдастай тэмцэлдэж байна? Эрүүл мэнд үү, санхүү юу, гэрлэлт үү, хүүхдүүд үү, ажил уу, сургууль уу, гологдохоос уу, итгэлээсээ болж хавчигдахаас уу эсвэл өөр зүйлээс үү? Амьдралынхаа аль талыг би Эзэн Есүст бүрэн даатгасан, аль тал дээр нь өөрөө эзэн суусаар байна?

Залбирал: Эзэн минь ээ, Танд (тэр, тэр талаа) бүрэн даатгагдаагүйг минь уучлаарай. Тэр тал дээрээ би өөрөө эзэн суусаар байгаагаа мэдлээ. Энэ тал дээр ариунаар эмээдэггүй байснаа ч мэдлээ. Тиймээс гэмшээд, (тэр талаа) болоод амьдралынхаа бусад бүх талыг Эзэн Есүст бүрэн даатгаж байна. Амень.

Шийдвэр: Есүс бол миний Эзэн. Би амьдралынхаа бүх талыг Эзэнийхээ эрх мэдэлд өгч байна. Түүний хүслээр хийгдэх болтугай.

Явах ёстой замаар нь хүүхдийг сурга.

Тэрээр өтөлсөн ч түүнийг орхихгүй.

— Сургаалт үгс 22:6

38 | ӨВ

Ариун эмээхүйн өөр нэгэн том ашиг нь: Бурханлаг өв болой. Хэдэн зүйлийг асууя л даа. Бенедикт Арнолд гэхээр танд юу санаанд орж байна? “Урвагч” гэж бодогдов уу? Тэгвэл Тереза эх? Чаритигийн илгээлтийн эзэд? Адольф Хитлер? “Сая сая хүнийг хороосон дарангуйлагч алуурчин” гэж бодогдов уу? Тэгвэл Альберт Эйнштейн? “Харьцангуйн онолыг нээсэн эрдэмтэн” гэж бодогдов уу?

Санаанд чинь орсон бодол чинь магадгүй тэдгээрх алдартны үлдээсэн өв байх. Үнэндээ хүн бүр өв бүтээдэг. Тиймээс бид миний үлдээсэн өв сайнаар дурсагдах уу эсвэл муугаар дурсагдах уу гэдгийг бодох ёстой. Үүнээс ч том асуудал нь бидний өв тэнгэрт хэрхэн үзэгдэх вэ - Бурханы мөнх хаанчлалыг бүтээн байгуулахад ашиг тустай байсан гэгдэх үү эсвэл хор хөнөөлтэй байсан гэгдэх үү?

Өв гэдэг үгийг Мириам - Уэбстер “Өмнөх үеэс залгамж үедээ дамжуулах юмуу залгамж үед нь очих зүйл”¹ гэж тодорхойлжээ. Бурханаас эмээхүй нь бидний залгамжлалд хэрхэн нөлөөлдөг вэ? Бүгдээрээ дахиад итгэлийн өвөг - Абрахамаа жишээ болгоё. Уулан дээр тэнгэрэлч Абрахамыг хүүгээ хөнөөхөөс таслан зогсоох үед Эзэн Абрахамд:

“Би үнэхээр чамайг *ерөөж* (*ерөөн, ерөөсөөр байх болно*), үр удмыг чинь тэнгэрийн одод, далайн эргийн элс мэт асар олон болгоно (*үржүүлэн, үржүүлсээр байх болно*). Үр удам чинь дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэх болно” (Эхлэл 22:17) хэмээн айлджээ.

Би энэ эшлэлийг олон жил уншихдаа, яагаад үгээ дахиж байгааг нь гайхдаг байлаа. Эцэстээ бүр сониуч зандаа дийлдээд

нэгэн раббигаас асуутал, рабби: “Ийм маягийн үгийн давталт нь Еврей ухаанд үржлийг илэрхийлдэг... Тэгээд нэг үг нь одоо цаг дээр, нөгөө үг нь ирээдүй цаг дээр байгаа нь Бурхан одоо цаг дээрх ерөөлөө Абрахам дээр, ирээдүй цаг дээрх ерөөлөө Абрахамын хойч үе дээр буулгахаа амлаж байгаа юм. Товчхондоо “Абрахам аа, Би чамайг ерөөхдөө, үр удмаар чинь дамжуулан чамайг үргэлжлүүлэн ерөөсөөр байна” л гэсэн үг” гэж тайлбарлаж билээ.

Ариун эмээхүй нь бидний үр хүүхдэд ч ашигтай. “Тэд дайсныхаа үүд хаалгыг эзлэх болно.” Үүн шиг гайхамшиг байх уу. Энэ тухай удахгүй ярина. Гэхдээ эхлээд нөгөө раббигийн өөр нэгэн тайлбарыг хэлье. Ариун эмээхүй нь үр удмаар маань дамжин биднийг үргэлжлүүлэн ерөөсөөр байх бөгөөд энэ нь энэх төдийгүй, өнө мөнхийн амьдралд ч хүчинтэй ажээ.

Үр хойч минь бидний ойрх ирээдүйд ч, ирэх амьдралд ч эдлэх хүндэтгэл, нөлөөллийг үржүүлэх маягаар өнө мөнхийн хувь тавиланг маань шийдвэрлэх нь байна. Үүнийг жишээгээр тайлбарлая. Арван улирал Нью Орлеанс Сэинтс багийн Үндэсний хөл бөмбөгийн Лигийн холбогчоор тоглосон Арчи Маннинг гэдэг тамирчин байлаа. Тэр хүний дарангуй удирдлага дор баг нь ганц удаа л хожил, хожигдлоороо тэнцээд, бусад есөн улиралд нь дан хожигджээ. Тэр хүнийг хэн ч дурсахгүй үлдэж болох байсан ч, Пейтон, Ели гэдэг хоёр хүү нь нийт дөрвөн Супер цом хожиж, Супер цомын болоод лигийн хамгийн үнэ цэнэтэй тоглогч нараар тодорсон юм. Тийнхүү эдүгээ дийлэнх хүмүүс Арчиг хоёр хүүгээр нь мэддэг бөгөөд эцсийн дүнд тэрбээр спортын ертөнцөд аугаа хүндэтгэл, нөлөөллийг хүлээн авсаар байна.

Хаанчлалыг байгуулалцсан үр удмынхаа дуулгавартай хөдөлмөрийн ачаар бид өнө мөнхийн амьдралд ч аугаа хүндэтгэл, нөлөөлөл хүлээн авах нь гарцаагүй. Үүний тод жишээ нь мөн л Абрахам. Түүний удам болох Иосеф, Самуел, Давид, Даниел, Исаиа тэгээд мэдээж Есүс тэргүүтэй олон хүн өвөг Абрахамынхаа өнө мөнхийн нөлөөллийг өргөжүүлсэн юм. Түүний өв одоо ч үргэлжилсээр. Энэ ерөөл нь Бурханаас эмээдэг хүмүүст хамаагай бөгөөд тэрбээр “Мөнхөд дурсагдаж, түүний эвэр хүндэтгэлтэйгээр өргөмжлөгдөнө” (Дуулал 112:6,9). Хүмүүс тэнгэрт очихоор л бүх юм эхэлнэ гэж боддог. Гэвч тийм биш ээ. Итгэгч - бид өнө мөнхийн түүхээ хэдийнээ бичиж эхэлсэн бөгөөд “Түүний сайн үйлс мөнхөд дурсагдана” (Дуулал 112:9).

Одоо бүгдээрээ үр удмыг минь “Дайсныхаа үүд хаалгыг эзлэгч” болгох Бурханы амлалтыг үзье. Одоогийнхоор бол - үр удам минь Бурханыг үздэггүй хүмүүст ялагдалгүй, харин амжилттай удирдагч, нөлөөлөгч нар (Дэд хууль 28:13) болно гэж хэлж болно. Энэ үг ганц Абрахамд болоод түүний яс махны тасархайд хамаатай гэж бодож байна уу? Тийм бол, бидэнд “Абрахамын ерөөлийг Христ Есүсээр харийнханд ирүүлэхийн тулд юм. Ингэснээр бид итгэлээрээ Сүнсний амлалтыг хүлээн авах юм” (Галат 3:14) гэж хэлснийг санаарай. Энэ бол гайхамшигт мэдээ!

ЭЗЭНийг магтагун! ЭЗЭНээс эмээдэг, Тушаалуудад нь ихэд баярладаг хүн Юутай ерөөлтэй! Үр удам нь дэлхий дээр хүчтэй болно. Чигч шударгын хойч үеийнхэн ерөөгдөнө. (Дуулал 112:1-2)

Үеийнхэн гэдэг нь “Урт цаг хугацаа”² гэсэн утгатай бөгөөд залгамжлалыг илэрхийлдэг.³ Зехариа “Өршөөл нь Түүнээс *эмээгчдэд* үеэс үед байна” (Лук 1:50) гэж зөгнөсөн. Биеэс минь төрсөн үр хүүхэд амжилттай байгаад зогсохгүй, энэ амлалт нь үе дамжин үргэлжлэх нь байна. 18-аар зууны эхээр төрсөн хоёр хүний амьдрал үүний хамгийн тод жишээ болдог.

Эхнийх нь Макс Жюкс. 1874 онд нийгэм судлаач Ричард Дагдэйл Нью Йоркийн хойд нутгийн 13 шоронгоор орохдоо, дөрвөн өөр овогтой боловч, цусан төрлийн холбоотой зургаан хүнийг олжээ. Энэ явдал түүний сониуч занг өдөөн, ургийн холбоо хамаарлыг гүнзгийлэн судлахад хүргэсэн бөгөөд судалгаа нь явсаар, 1720 - 1740 оны хооронд төрсөн Макс Жюкс гэдэг Дани цагаач дээр аваачжээ. Дагдэйл олон жилийн нөр их судалгааныхаа дүнд Жюксийн удмын 540 хүнийг олж тогтоосон байна. Тэр дунд 76 ялтан, эмсийн хүрээлэнгийн 18 даамал, 120 янхан, 200 гаруй халамжийнхан байжээ. Товчхондоо удам дамжсан нүгэл нь ийм зүй зохисгүй зан авирыг тархааж, улсыг өнөөгийн ханшаар хэдэн арван сая долларын хохиролд хүргэжээ.⁴

Тэгвэл Макс Жюксийг мөн л тухайн цагт амьдарч байсан Жонатан Эдвардс гэдэг хүнтэй жишье. Тэрбээр олон ном бичиж, олон хүнийг үндэстнүүдэд сайнмэдээг хүргэхэд уриалан дуудсан, сэргэн мандуулагч хүн байв. Тэрбээр 1727 онд Сарах Пьерпонттой гэрлэсэн бөгөөд тэд Эзэнээс эмээдэг гэр бүл байжээ. Тэд шөнө болгон унтахаасаа өмнө хамтдаа Библи уншиж, залбирна. Тэднийх 11 хүүхэдтэй бөгөөд

Жонатан өдөр бүр хүүхэд болгоныхоо төлөө залбирдаг байжээ. Тэрбээр “Айл болгон жижигхэн чуулган байх ёстой” гэдэг байв.

Жонатан, Сарах хоёрын удмын ил болсон 1,394 хүн нь Бурханаас эмээдэг хүмүүст зориулагдсан “*Дайсныхаа үүд хаалгыг эзэлж, хүүхдүүд нь хаа ч амжилтанд хүрнэ*” гэдэг амлалтыг илчилдэг. Түүний үр удмаас: Коллеж, их сургуулийн 13 захирал, 65 профессор, Америкийн нэгдсэн улсын 3 сенатор, 30 шүүгч, 100 хуульч, 60 эмч, 75 цэргийн дарга, 100 Бурхан зарц, илгээлтийн эзэн, нэр алдартай 60 зохиолч бөгөөд Америкийн Нэгдсэн улсын дэд ерөнхийлөгч төрсөн нь Аарон Бүрр байв. Эдвардсын удмынхан улс орондоо нэг ч төгрөгийн хохирол учруулаагүй байна.⁵

Би хөвгүүдийгээ жаахан байхад нь эрт нас барчих бий, аавыгаа зарим үед жилийн 200 хоног аялж номлодгийг минь жигших бий, аавыг нь ийм ажилд дуудсан Бурханыг жигших бий гэж ихэд айдаг байлаа. Нэг орой гэрээсээ хол конференц дээр номлож байхдаа, би ариунаар эмээхүй байгаа учраас л, хөвгүүдийнхээ амьдралыг Есүст төгс даатгаж чадахгүй байгаагаа ойлгосон юм. Тэгээд: “Аав аа, энэ дөрвөн хөвгүүн минийх биш, Таных. Та тэдний амьдралыг хүссэнээрээ жолоодох болтугай. Харин муу Диавол чи, тэдэнд хэзээ ч хүрэхгүй!” хэмээн хашхиран залбирсан юм. Тэр өдрөөс хойш би хөвгүүдийнхээ амьдралын төлөө айгаагүй ээ.

Төдөлгүй Бурхан Үгээрээ дамжуулан надад маш чухал үнэнийг илчлэв. Аароны ач хүү Финехас Бурханы ч төлөө, Израилийн ч төлөө халуун сэтгэлтэн байжээ. Хүчирхэг ариун эмээхүй нь түүнийг бусдын зугтдаг юмыг хийхэд хүргэж, тэрбээр зөвд зоригтой хүн байв. Иймд Бурхан: “Харагтун, Би түүнд (болоод *үр удамд нь*) амар тайвны гэрээгээ өгч байна” (Тооллого 25:12) гэжээ. Үндсэндээ, Финехасын ариун эмээхүйн ачаар Бурхан үр удамтай нь дотно байхаа амлажээ. Үгээр Лиза, бид хоёрын дув дуулгавартай байдалд хөвгүүдийн минь хамгаалалт оршихыг Ариун Сүнс надад харуулсан хэрэг.

Түүнээс олон жилийн дараа буюу өнөөдөр миний дөрвөн хүү бүгдээрээ Мессенжер Интернэйшнэлд хамгийн багадаа есөн жил ажиллаж байна. Хоёр нь олон танигдсан зохиолч болж, бүгдээрээ удирдах ажил хийж, хамгийн чухал нь Бурханаас ариунаар эмээн амьдарч байна. Хөвгүүдээ яаж ийм бурханлаг хүмүүжүүлчихэв гэж хүмүүс байнга асуудаг. Гэтэл энэ нь үнэндээ бид хоёрын ухаантай ямар ч хамаагүй бөгөөд ер нь эцэг эх - бидний алдааг тоочбол, хэдэн ботиор

тоологдох биз. Гэхдээ бид Бурханаас ариунаар эмээж амьдарсан.

Хөвгүүд маань өсвөр насандаа янз янз болох үед Лиза, бид хоёр Бурханы хүсэл хөвгүүдийн минь амьдралд тогтнохын төлөө уйлан хайлан залбираад, өөрсдөө хичээнгүйлэн ариунаар амьдарсаар ирсэн. Бид хэзээ ч итгэлээ алдаагүй. Та ч алдах ёсгүй. Бурханаас эмээдэг хүмүүст Бурхан “Үр удам нь дэлхий дээр хүчтэй болно” (Дуулал 112:2) гэж амласан.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Эхнэр чинь гэрийн чинь доторх үр жимстэй усан үзмийн мод лугаа адил, хөвгүүд чинь ширээг чинь тойрон буй чидун модны нахиа лугаа адил билээ. Харагтун, учир нь ЭЗЭНээс эмээдэг хүн ийнхүү ерөөгдөх болой. (Дуулал 128:3-4)

Санаа: Ариунаар эмээж амьдрах үед та үр удамтайгаа харилцан гүйдэлтэй нэгэн чухал холбоогоор холбоддог. Үр удам чинь нэр нөлөөтэй хүмүүс болоод зогсохгүй, тэднээр дамжин эргээд та өөрөө ерөөгдсөөр байна.

Эргэцүүлэл: Би хүүхдүүдээ (эсвэл ирээдүйн хүүхдүүдээ) хэрхэн үздэг вэ? Тэдний ирээдүйд зовнидог уу? Тэднийгээ Есүст бүрэн даатгасан уу? Тэднийхээ өмнө ариунаар амьдардаг уу? Тэдний одоогийн зан авирын дагуу харж, залбирч, ярьж байна уу эсвэл Бурханы амлалтын дагуу харж, залбирч, ярьж байна уу?

Залбирал: Эзэн минь ээ, ариунаар эмээж амьдарбал, мөнх настай өвийг хүлээж авна гэж Таны Үг амласан. Үр хүүхэд минь энэ дэлхий дээр хүчирхэгжиж, нэр нөлөө, амжилттай байж, Таны ч, миний ч нэрэнд хүндэтгэл авчирна гэдэг Таны амлалтанд би итгэж байна. Эдгээр амлалт биелэхийн төлөө би зоригтойгоор залбирсаар байна. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Миний үр удам газар дээр хүчирхэг байж, явсан газар бүрийдээ амжилтанд хүрч, дайсныхаа үүд хаалгыг эзэлнэ.

*Хүний жинхэнэ цэц ухааныг
бүрдүүлэгчийг тодорхойлъё гэвээс,
Бурханаас эмээхүйг
тодорхой илэрхийлсэн
үг л хамгийн тохиромжтой.*

— Хиппогийн Августин

39 | ХАМГИЙН ЧУХАЛ ЗҮЙЛ

Энэ нь дангаараа бүтэн номын дайны, өргөн сэдэв юм. Гэхдээ энэ сэдвийг хөндөхгүй бол, манай номын сэдэв цогцлохгүй. Тиймээс энэхүү бүлгийг ариун эмээхүйн амин чухал хэсгийн оршил хэмээн үзээрэй.

Бүтээгчийн зүрхнээс ундарсан - наран, саран, оддыг элээн орших, бидний энэ дэлхийгээс ч баталгаатай, амийн, үнэний, хамгаалалтын үгийг сонсоно уу:

Мэргэн ухааныг олдог хүн, Ухаан бодролыг өөрийн болгодог хүн ерөөлтэй ээ. ...Тэр нь хүсэл татагч юутай ч зүйрлэшгүй. (Сургаалт үгс 3:13, 15)

Дэлхий дээрх юу ч Бурханлаг цэц ухаантай эгнэшгүй. *Юу ч!* Тиймээс л бидэнд “Мэргэн ухааныг ол. Олсон бүхнээсээ Ухааран ойлгохуйг ол. Энэ нь мэргэн ухааны эхлэл” (Сургаалт үгс 4:7) бөгөөд үүнийг олбоос, “Түүний зам нь тааламжит Бүх жим нь амар тайван” (Сургаалт үгс 3:17) гэжээ.

Бид гаргаж байгаа шийдэр болгон дээрээ Бурханы цэц ухааныг хайх хэрэгтэй. Учир нь “Мэргэн ухааныг өндөрт үнэл, Тэр чамайг өргөмжилнө Түүнийг тэвэр, тэр чамайг *алдаршуулна*” (Сургаалт үгс 4:8). Юутай гайхамшигт амлалт вэ! Алдаршуулна гэж хөрвүүлсэн үг нь “Өргөх, дээшлүүлэх, өргөмжлөх” гэсэн утга бүхий Еврей үг. Бурханы өргөснийг хэн ч доош хийхгүй! Тиймээс цэц ухаан нь мөнхөд тогтох ач холбогдлын зам ажээ.

Цэц ухааныг олж илрүүлэх ёстой. Энэ нь далд байдаг хэдий ч, хүрэшгүй эд биш. Нэгэнт олоод авбал, бузгай ашигтай. Тэгэхээр, үүнийг хэрхэн олох вэ?

ЭЗЭНээс эмээхүй нь Мэргэн ухааны *эхлэл*. (Дуулал 111:10; Сургаалт үгс 9:10)

Энэ үг нь Библи эхний эшлэл дээр ч бий: “*Эхэнд* Бурхан тэнгэр ба газрыг бүтээжээ.” Эхэнд гэдэг нь “Эхлэх газар, цэг” гэсэн утгатай үг. Ариун

Бурханаас эмээхүй

эмээхүй нь цэц ухааны *гараа цэг* ажээ. Ингэж дүрсэлье: Таныг өнө мөнхөд амжилттай байлгах цэц ухаанаар дүүрэн нэгэн агуулахыг төсөөлнө үү. Гэхдээ тэр нь ганц л хаалга, ганц л түлхүүртэй бөгөөд ариун эмээхүйгээр дамжиж байж л тийш нэвтрэх боломжтой ажээ. Исаиа “ЭЗЭНээс эмээхүй нь түүний эрдэнийн сан (*Санг тайлах түлхүүр*) билээ” (Исаиа 33:6) гэжээ.

Үндсэндээ, Эзэнээс эмээхүйгээс өөр мөнх орших цэц ухаан үгүй. Ариун эмээхүй нь өнө мөнхийн цэц ухааны эхэн боловч, тэндээс ундрах ашиг нь цаашаа сунан сунан үргэлжилсээр байна:

ЭЗЭНээс эмээхүй нь амийн *ундарга*. Үхлийн *занганаас* энэ л зайлуулна. (Сургаалт үгс 14:27)

Ундарга, занга гэдэг хоёр үг дээр төвлөрөье. Ундарга гэдэг Еврей үг нь “Урсгал” юмуу тасрашгүй хөврөл гэсэн утгатай. Сайн сайхан амьдрах нь санаандгүй зөв шийдвэрийн үр дүн бус, харин урт удаан үр жимстэй, цэцэн шийдвэрийн тасрашгүй урсгал юм.

Занга гэдэг хоёр дахь үг нь хавх юмуу урхийг илэрхийлнэ. “Энэ Еврей үг нь анчны хавханд тавигдах өгөөш гэсэн язгуур утгатай.”¹ Занга бүтээмжтэй байхад хоёр зүйл хэрэгтэй байдгийг анчин мэднэ. Нэгдүгээрт - амьтан хараад таньчихгүйн тулд далд байх ёстой. Хоёрдугаарт - үхлийн амандаа оруулахын тулд өгөөштэй байх ёстой. Ийнхүү энэ хоёр түлхүүр үгийн утга дээр дөрөөлж байгаад, дараах үнэнийг уншина уу:

ЭЗЭНээс эмээхүй нь *мэргэн ухааны сургамж (зааварчилгаа)* ... (Сургаалт үгс 15:33).

Дээрх хоёр үнэнийг нэгтгэбэл, ариун эмээхүй нь Бурханы цэц ухаант зөвлөгөөний тасрашгүй урсгал - оргилуур гэдгийг ойлгож байна. Хэзээ ч зүүрмэлзэхгүй, нойрсохгүй, яг энэ эгшинд биднийг амьдралдаа цэцэн шийдвэр гаргахад минь тасралтгүйгээр дасгалжуулж байдаг зөвлөх болой.

Бурханы цэц ухаанаас тасарч, дур мэдсэн хүн төрөлхтөн өөрийгөө их л мундаг шийдвэр гаргалаа хэмээн хуурч, хөнөөлтэй шийдвэр гаргасаар ирснийг энэ олон мянган жилийн түүх баталсаар байна. Яагаад тэр вэ? Үхэл, хөнөөлийн арга зам нь нөгөө анчны занга шиг л нууц, далд байдаг. Сайн, ухаалаг, ашигтай, гоё харагдах зүйлс нь зүгээр л таныг адгийн, мунхаг, хөнөөлтэй, гашуудалтай болж таардаг зүйл рүү даллах. Тэгвэл Эзэнээс эмээхүй нь биднийг *ийм урхинаас*

итгэмжтэйгээр эргүүлэх арга замаараа хамгаалдаг буюу.

Өнөөгийн энэ нийгэмд жигтэйхэн мэдлэг боловсролтой эрчүүд, эмэгтэйчүүд нэр нөлөөлөл доор хүмүүсээ сүйрүүлэх шийдвэр гаргасаар байна. Зарим нь энэ мунхаглалаа ч үзэх нүдгүй. Тэд ариун эмээхүйг няцааснаараа “Бодол санаандаа хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ. Өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон.” (Ром 1:21-22) Оюун санаа харанхуйлах үед нүд харанхуйлж, үхлийн далд хавханд орж дуусах нь цаг хугацааны л асуудал болно.

Тийм боловч, нөгөө тал нь ч бас үнэн. Ариун эмээхүйг тас тэвэрбээс, бид алхам тутмаа өнө мөнхийн ашигтай шийдвэр гаргах чадвар хайрлагч, хэзээ ч татрашгүй цэц ухааны зөвлөхтэй болно. Би өөрсдөө үхлийн хавх, зангийг мэдэхгүй байлаа ч, ундарга маань биднийг нууц хавхнаас сэргийлсээр байна.

Энэ зарчмаа Бурхантай гэрээ байгуулаагүй боловч, Түүнээс эмээж явдаг нэгэн хүнээр жишээлэн судлая. Тэрбээр Герарын Абимелех. Абимелех Абрахамын гэргий Сарахыг өргөөндөө оруулжээ. Төдөлгүй, шөнө дүлээр Бурхан түүн дээр ирээд: “Чи авсан энэ эмэгтэйгээсээ болж үхнэ. Учир нь тэр эмэгтэй бол гэрлэсэн эмэгтэй” (Эхлэл 20:3) хэмээв.

Абимелех ч Бурхан руу: “Эзэн минь ээ! Би энэ хэргийг гэмгүй зүрх, зэмгүй цэвэр гараар үйлдсэн билээ” (Эхлэл 20:4-5) хэмээн хашхирсан. “Эзэн минь ээ” гэдэг нь “Эзэнтэн минь, миний Эзэн” гэсэн утгатай. Тэгэхээр, Абимелех Бурханаас эмээж явдаг нь үг, хандлагаас нь бэлхэнээ харагдах. Тэгээд Бурхан түүнд хэрхэн хариулсныг үзнэ үү:

“Тийм ээ, чи үүнийг гэмгүй зүрхээр үйлдсэнийг Би мэднэ. Мөн *чамайг Миний эсрэг нүгэл хийхээс хамгаалсан нь Би* бөгөөд чамайг Би түүнд хүргүүлээгүй.” (Эхлэл 20:6)

Абимелех өөрөө мэдээгүй ч, Эзэнээс эмээхүй нь түүнд зөвлөж, үхлийн занганаас хамгаалжээ. Энэ нь Сарахыг Абрахамын охин дүү гэж танилцуулсан зальжин нууц занга байсан ч, ариун эмээхүй нь Абимелехийг хамгаалжээ. Яахаараа Бурхантай гэрээ байгуулаагүй, Бурханы бичмэл үггүй, шүтээн шүтэгч тэр харийн хаан бусдын гэргийг авахаас эмээв? Хариулт нь Паулын бичээст бий: “Харийнхан хуульгүй боловч хуулийн шаарддаг зүйлсийг зөнгөөрөө үйлдвэл, хэдийгээр хуульгүй авч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог. Хуулийн шаарддаг зүйлс зүрхэнд нь бичигдсэнийг тэд ийнхүү харуулж байна. Тэдний мөс чанар ч хамт гэрчилж, бодол санаа нь ч нэг нэгнээ буруутгадаг эсвэл өмгөөлдөг” (Ром 2:14-15).

Бурханаас эмээхүй

Тэгвэл яахаараа харийн хаан хүний гэргийг авахаас салгалтлаа эмээж байхад, өөр нэгэн архаг пастор юмуу чуулганы гишүүн огт айж эмээлгүйгээр хүний гэргийтэй завхайрна вэ? Энэ чинь сансрын эрдэм биш. Тэр пастор юмуу чуулганы гишүүн амаараа Есүсийнх болохоо мэдэгддэг ч, Бурханаас эмээх сэтгэлгүй нэгэн юм. Бидэнд:

Үхлээс ч илүү гашууныг би олж харав. Юу хэмээвээс эм хүний зүрх нь занга, гар нь гинж аж. Бурханд тааламжиг нэгэн нь түүнээс зугтах бөгөөд харин нүгэлтэн нь тэр эмд олзлогдох (Номлогчийн үгс 7:26) гэдэг.

Бичээс *адын нэгэн* бус, харин *нүгэлтэн* буюу ариунаар эмээдэггүй учраас, байндаа хүрч чаддаггүй нэгэн л унана гэжээ. Тэрбээр Христэд итгэдэг нэртэй байж ч болно. Иаков өөрсдийгөө итгэгч хэмээдэг хүмүүст “Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга” (Иаков 4:8) гэсэн.

Манай “Алдарт” Барууны сайнмэдээ бидэнд Бурханы цэц ухаанаас өөр, *хулхи* нигүүлслийг зааснаараа, Бурханаас эмээхүйг зүрхнээс маань системтэйгээр устгажээ. Ийнхүү биднийг нүглээс сахигч хориг - хүчийг зайлуулаад, оронд нь завхарсан зөвлөгөөтэй эрүүл бус ундаргыг үүсгэжээ. Тэгвэл жинхэнэ нигүүсэл нь ариун эмээхүйтэй зөрчилддөггүй юм.

Учир нь бүх хүнд аврал авчрагч Бурханы нигүүлсэл үзэгдэж, сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг үгүйсгэхийг, мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг бишрэлтэй амьдрахыг бидэнд *сургадаг*. (Тит 2:11-12)

Бид Бурханы жинхэнэ нигүүлсэл, ариун эмээхүй хоёрыг салгаж болохгүй. Эдгээр нь нэг цул бөгөөд хоёулаа үхлийн занганаас зайлах ухаанд *сургадаг*.

Бурханд итгэдэг нэртэй зарим хүний бурханлаг бус авир үйлдэл нь цоо шинэ гамшиг биш ээ. Энэ заль маяг Израилийн ч, чуулганы ч түүхнээ оршсоор ирсэн бөгөөд хожмын энэ өдрүүдэд ч тэмээнээс том тэмдэгтэй байхыг Есүс хэлсэн. Ариун эмээхүйн хомсдол нь хүмүүсийн зүрх сэтгэлийг наанаа үнэний дүртэй ч, үнэндээ нүгэл, үхэл рүү сэм хөтлөх харанхуй зөвлөгөөнд нээх.

Манай нийгэмд хуульгүй байдал хүчээ ч, хурдаа ч авчээ. Яг л налуу тойргоор өндөр хурдтай шарвах мэт. Энэ “алдарт” хуурамч нигүүлсэл нь ариун эмээхүйг итгэгч хүмүүсийн зүрхнээс устгасаар байвал,

хуульгүй байдал нь заль мэхээрээ Христэд итгэдэг хүмүүсийг зүгээр л сүрэг сүргээр нь арчаад л гарна. Бидэнд ариун эмээхүйн сэргэлт хэрэгтэй. Учир нь энэ л биднийг зогсоо зайгүй тулгарах мунхаглалаас аварсаар явна. Дийлэнх нь заль мэхэнд унаж тусч байсан ч, ариун эмээхүй л бидний зүрхийг үнэнтэй шулуутган зэрэгцүүлсээр байна.

Ариун эмээхүйг аугаа эрдэнэ мэт хайрла. Сая сая доллараас ч илүү, үнэт эдлэлээсээ ч илүү, гоё орон байраасаа ч илүү нандигнаж яв. Хүн үнэтэй сайтай юмаа хамгийн л найдвартай банк, хадгалах өрөө, сэйф, дохиоллын системээр хамгаалдаг ч, Эзэнээс эмээхүй шиг эрдэнэ үгүй болой. Тиймээс л “Зүрх юугаан урьтан хамгаал. Амийн булгууд түүнээс ундарюу” (Сургаалт үгс 4:23) гэжээ.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: “Мэргэн ухаан дуудаагүй гэж үү? ...Намайг ологч нь амийг үнэхээр олж, ЭЗЭНээс тааллыг нь хүртэх атал Надад нүгэл үйлддэг нь өөрийгөө хорлоно. Намайг үзэн ядагч бүхэн үхлийг хайрлагчид болой.” (Сургаалт үгс 8:1, 35-36)

Санаа: Христийг дагадаг хүнд цэц ухааныг олох шиг чухал ажил үгүй. Эзэнээс эмээхүй нь цэц ухааны оргилуур бөгөөд биднийг үхлийн занганаас хамгаалж байдаг.

Эргэцүүлэл: Би элсэн дээр шугам татаж үзсэн үү? Би Бурханы үгийг сөрдөг нийгмийн мэргэн ухаанд нэвтрэхгүй байхаар шийдсэн үү? Би Бурханы Үгийг дагадгаасаа юмуу итгэл үнэмшлээсээ болж хавчигдахад бэлэн үү? Өдөр тутмынхаа шийдвэрт Есүсийн цэц ухааныг хэрхэн хичээнгүйлэн хайх вэ?

Залбирал: Аав аа, Есүсийн нэрээр Таны цэц ухаан, ойлголтын төлөө хаширч байна. Хүлээж авах чих, нүдийг минь нээгээч. Өөрийнхөө нүдэнд мэргэн тэнэг баймааргүй байна. Энэ дэлхийн юу юунаас дээгүүр Эзэн Есүсийнхээ л цэц ухаантай хөөцөлдөж, найдахыг хүснэ. Дуулгавартай зан, итгэлээсээ болж хавчигдах байсан ч, Таныг л дагая. Амень.

Шийдвэр: Гаргах шийдвэр болгон дээрээ Эзэн Есүсийнхээ цэц ухааныг эрэлхийлэх болно.

Даруу хүн л Бурханаас эмээнэ.

— Хиппогийн Августин

40 | АМЖИЛТТАЙ АМЬДРАЛ

Сургаалт үгс номын гүн цэц ухаанд миний “Хүчирхэг ихэр” гэж нэрлэдэг нэгэн зүйл оршино. Энэ хоёр чанар нь Бичээс дээр нэг нэгнээ дэрлэн, гар гараасаа хөтлөлцөх нь олонтаа. Үүнийг дараах эшлэл дээр хэлжээ:

ЭЗЭНээс эмээхүй ба даруу дорд байдалд эд баялаг, алдар хүнд, амь нь шагнал болно. (Сургаалт үгс 22:4)

Даруу байдал, ариун эмээхүй хоёр нь холбоотой. Бурханаас эмээдэг атлаа үнэнээсээ даруу биш хүн ч үгүй, үнэнээсээ даруу атлаа Бурханаас эмээдэггүй хүн ч үгүй. Олон хэлбэрийн хуурамч даруу зан байдаг учраас, “Үнэнээсээ” гэдэг нь тун чухал. Энэ талаар дараагийнхаа бүлгээр дэлгэрэнгүй ярина.

Бурханы жагсаасан гурван амлалтыг үзье: Баялаг, хүндэтгэл, урт удаан амьдрал. Баялгийг Еврейгээр *осер* гэх бөгөөд “Хөрөнгө чинээ, эд баялаг” гэх утгатай. Энэ нь газар, эзэмшил, мал сүрэг, удам угсаа гээд л бүхий л төрлийн баялгийг илэрхийлнэ. Утга нь ч тодорхой бөгөөд ариун эмээхүйг дагалдах энэ амлалт нь ганц удаагийн биш юм. Магтаалч мөн:

ЭЗЭНийг магтагтун! ЭЗЭНээс эмээдэг, Тушаалуудад нь ихэд баярладаг хүн юутай ерөөлтэй! ...Гэрт нь хөрөнгө *баялгууд* байна. Зөвт байдал нь мөнхөд тогтоно (Дуулал 112:1, 2) гэжээ.

Баялгийг мөн л *осер* хэмээх Еврей үгээр хэлжээ. Яг эндээс болзошгүй нэгэн асуудал үүсдэг. Баялаг, чинээлэг байдлыг бурханлаг байдалтай авцалдахгүй гэж үздэг хүмүүс бий. Гэхдээ бид уламжлалын төлөө Бичээсийн тодорхой үнэнийг дараад байвал, энэ чинь бардамналын индикатор болох бус уу? Харин бардамнал нь ариун эмээхүйн эсрэг зүйл гэдэг нь тодорхой.

Олон жилийн тэртээ би ч үүний базуурт орж явсан. Үйлчлэлийнхээ эхэн дээр Лиза, бид хоёр үйлчлэгч нар олон хүнийг зуурдын баялагтай хөөцөлдөхөд хүргэгч, баялгийн сайнмэдээг зааж байхыг нь хардаг байлаа. Үүнээс тун аймшигтай үр дагавар төрж, хүмүүс бөөн бөөнөөр шүтээн мөргөлийн нэгэн хэлбэр болох шуналд унасан юм. Олон хүн жинхэнэ итгэлээсээ төөрч, өөр дээрээ зүсэн зүйлийн зовлон буулгасан. Тэгтэл ийм үзэгдлээс халширсан мань хоёр нөгөө туйл руу нь хадуурчихав. Баялаг, чинээлэг, хөгжил цэцэглэлийн талаарх сургаал бүрээс дайжаад л. Гэвч эцэстээ Ариун Сүнс бидний энэ төлөвшилгүй байдлыг засварлаж өгсөн юм. Тэгээд Бурханаас жинхэнээсээ эмээдэг хүн баялгийг зүй зохистой захиран зарцуулж, шуналын занганаас холуур явдаг гэдэг үнэнийг бид хоёр сурч билээ.

Баялаг, эд хөрөнгийн зорилго нь юу вэ? Бусдыг л ерөөх юм. Энэ номыг бичих хугацааг хүртэл манай үйлчлэл даян дэлхийн 130 улсын пастор, удирдагч нарт 118 хэл дээр 53 сая сургалтын материал буюу ном, хичээл тараажээ. Түүнчлэн дагалдагч бэлтгэх MessengerX аппыг бүтээснийг маань 230 улсын хүмүүс татан, хэрэглэж байна. Ямар ч үнэ төлбөргүй шүү. Энэ том төсөлд хэдэн арван сая доллар зарцуулагдсан. Эдгээр хүчин зүтгэлийг дэмжсэн эрчүүд, эмэгтэйчүүд бурханлаг байдлыг ядуу зүдүү, гачигдаж дутагдаж явахуй гэж итгэдэг байсан бол, яана?

Тиймээс шунал бөгөөд хүмүүсийн амьдралыг өөрчлөхийн төлөө баялгийг эзэмшихийн хооронд том ялгаа бий. Бурханаас үнэнээсээ эмээдэг хүмүүс нь шуналаас дайждаг. Шинэ Гэрээнд Есүсийг цовдлуулсны дараа ийм явдал болжээ:

Есүсийн *шавь байсан* Иосеф гэгч Ариматын нэгэн баян хүн орой нь хүрч ирлээ. Тэр хүн Пилатад бараалхаж, Есүсийн цогцсыг гуйхад Пилат өгөхийг тушаав. (Матай 27:57-58)

Иосеф чинээлэг хүн байсан бөгөөд Бичээс түүнийг Есүсийн дагалдагч гэжээ. Гэхдээ хувь заяаны даажингаар Есүсийн дагалдагч нар бүгдээрээ шахуу зугтаад, нуугдчихсан бол, энэ баян хүн магадгүй Бурханаар эмээдэг сэтгэлийн чин зоригоороо Еврейчүүдийн айдас болсон Ромын сүр хүчинд авталгүй, Пилат дээр ороод, Есүсийн биеийг гуйжээ. Энэ эр зориг биш гэж үү?

За, санааг минь мушгих бий. Ядуу хүнд Бурханаас эмээх сэтгэл байдаггүй гэж хэлэх гэсэнгүй! Материаллаг баяллаггүй хүмүүс Бичээс нэг бий. Тэглээ гээд тэдний бурханлаг байдал сул байсан уу? Үгүй чшш! Жинхэнэ баялаг нь мөнгөөр юмуу хөрөнгөөр хэмжигдэхгүй, харин бусдад туслах чадвараар хэмжигддэг. Бидэнд үүнийг амлажээ:

Түүний ариун хүмүүс ээ, Та нар ЭЗЭНээс эмээгтүн! Учир нь түүнээс эмээгчдэд Юу ч дутагддаггүй. Залуу арслан ч гачигдан өлсөж байдаг. Харин ЭЗЭНийг хайгчид Ямар ч сайн юмаар гачигдахгүй. (Дуулал 34:9-10)

Хаанчлалын төлөө залбирал, хоол, санхүү, сургаал, дагалдагч бэлтгэл, зочломтгой зангаар дорвитой нөлөөлөх нь бурханлаг хүсэл юм. Тэнгэрлэг даалгавраа биелүүлэхэд шаардлагатай бүх төрлийн эх үүсвэрээр хангагдах нь сайн хэрэг. Бурханлаг хүмүүс үүнийг л мөрддөг бөгөөд явцын дундаа өөрсдөө ч ерөөгддөг. Харин бардам, шашинлаг, атаархуу нь яагаад итгэгч нар ядуу байх ёстой талаар маргалдаж, Бичээсийн үндэсгүй итгэл үнэмшлээрээ хүмүүсийг боогдуулахад л хамаг хүчээ барна.

Соломон хаан Эзэнээс эмээхүйгээр л ард түмнээ захирч байжээ. Энэ хугацаанд нь “Соломоны бүх өдрүүдэд Данаас Беершеба хүртэлх Иуда ба Израиль амар жимэр амьдарч, хүн бүр өөрийн усан үзэм, инжрийн модон дор суудаг байв (*Гэр бүл болгон хувийн сууц, цэцэрлэгтэй байв*)” (1Хаад 4:25). Үүгээр барахгүй “Иуда болон израильчууд далайн эргийн тоо томшгүй элс шиг олон байсан бөгөөд тэд *идэж ууж, баярлан цэнгэлдэж* байлаа” (1Хаад 4:20) гэдэг. Одоо “*Гэр бүл болгон хувийн сууц, цэцэрлэгтэй байв*” гэдэг үгийг тунгаана уу. Тэр улс даяар тусламж, ажилгүйдэл, ядуурал байхгүй, бүгд хангалуун байж! Эзэнээс эмээхүйн хайрладаг цэц ухаан нь нөлөөлөл дор хүмүүст маань ч үр шимээ

хүртээдгийг улс даяараа ивээгдсэн энэ жишээнээс харж болно. Удирдагч нар маань бүгдээрээ Эзэнээс эмээхүй дор алхалдаг бол, яах бол?

Нэгэн зүйлийг хэлэхэд, энэ амлалт нь Ребекагийн умай нээгдэхийн төлөө зуучилсан Исаакийн залбиралтай адил тэмцэж олдог амлалт биш юм. Есүс бидэнд “Тагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” (Магай 6:33) хэмээн амласан.

За, дараагийн амлалтыг үзье - *хүндэтгэл*. Эхэн эшлэл дээрх хүндэтгэл гэдэг үг нь “Хүндэтгэл, алдар, эрхэмсэг байдал, хөрөнгө чинээ” гэсэн утга бүхий *кабод* гэдэг үг болой. Бурханы алдрыг үзэх гэсэн Мосегийн хүсэлтийг энэ үгээр илэрхийлснийг бид өмнөх бүлгээрээ үзсэн. Энэ нь байр суурь, хэргэм зэргийг дагалддаг бус, харин зан чанарыг дагалддаг эрх мэдэл, жинг агуулсан үг. Тэгэхээр, ариун эмээхүйн дараагийн ашиг нь: Өргөмжлөл ажээ. Энэ нь таныг нэр хүндтэй, хүндэт хүн болгодог. Сургаалт үгс нь энэ ашиг тусыг мэдэгддэг цорын ганц ном биш ээ. Магтаалч Бурханаас эмээдэг хүмүүсийг “Эвэр нь *хүндэтгэлтэйгээр* өргөмжлөгдөнө” (Дуулал 112:9) гэж хэлэхдээ, яг ижил Еврей үг хэрэглэсэн байдаг.

Сургаалт үгс номын ёст эмэгтэйг аваад үз. Тэрбээр ер бусын чанартай. Найдвартай, цэцэн цэлмэг, хичээнгүй, эрч хүчтэй, хөдөлмөрч, цэцэглэнгүй, чинээлэг, эелдэг, хүмүүст тусладаг, дорой хүмүүсийг өмгөөлдөг. Энэ дунд бидний анзааралгүй өнгөрдөг, авч хэлэлцдэггүй нэгэн чанар нь “Хүч чадал, хүндэтгэлээр хувцаслана” (Сургаалт үгс 31:25) гэдэг үг юм. Өөрөөр хэлбэл, хүн хувцас өмсдөг шиг тэр бүсгүй хүндэтгэлийг өмсдөг бөгөөд хүндэтгэл нь түүний оршихуйн хаанаас нь л бол хаанаас нь харагдах ажээ. Тэгвэл түүний талаар тоочсон сүүлчийн чанар нь?

Дур булаам байдал хуурамч, гоо үзэсгэлэн ч хоосон тул ЭЗЭНээс *эмээгч* эмэгтэй л магтаал авах учиртай. (Сургаалт үгс 31:30)

Ариун эмээхүй! Бурханаас эмээдэг хүн бүхэн дээрх эмэгтэй шиг өргөмжлөгдөх бүрэн боломжтой. Миний бие өдий олон жил аялахдаа, алдар нөлөөтэй олон удирдагч, хувь хүнтэй уулзаж явсан. Тэд нийгэмдээ хийсэн юмтай, том нөлөөтэй улс. Гэхдээ би тэдний ажил үйлсээс илүү уулзахад л үнэртдэг нэр хүндэд нь өөрийн эрхгүй

татагддаг юм. Цаанаа л нэг оршихуйтай. Тэд гэрэл, хайр, хүндэтгэл, өргөмжлөл цацруулдаг. Үр хүүхэд нь аав ээжээ хайрлан хүндэтгэдэг бөгөөд хамтран зүтгэгч, олон сайхан нөхдөөрөө хүрээлүүлнэ. Хамгийн сонирхолтой нь, тэд олонд алдаршаагүй, эгэл хүмүүс байдаг. Дуудлага нь юу вэ? Бурханаас эмээх!

Эхлэл эшлэл дээрх гурав дахь амлалт нь *урт удаан амьдрал* буюу урт наслахуй. Урт наслах нь даруу чанартай нягт холбоотой. Энэ амлалтыг дараагийнхаа бүлгээр дэлгэрүүлж үзье.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: ЭЗЭНээс эмээхүй нь ёрын мууг үзэн ядах... Намайг хайрлагсдыг би хайрлана. Баялаг, алдар суу, үргэлжид байх хөрөнгө ба зөвт байдал надад бий. (Сургаалт үгс 8:13, 17-18)

Санаа: Ариун эмээхүй ба даруу чанар нь баялаг, хүндэтгэл, урт нас амладаг. Баялаг нь бидэнд байгаа мөнгө, хөрөнгөний хэмжээгээр бус, бусдад туслах чадвараар хэмжигдэнэ. Хүнийг хэргэм зэрэг, байр суурь биш, зан чанар нь л өргөмжилдөг.

Эргэцүүлэл: Би баялгийг эрүүлээр хардаг уу? Би баялгийг зовнисондоо, айсандаа юмуу шунагласандаа хөөж байна уу? Тэгвэл ариун эмээхүйгээр бусдад дорвитой тусласны хариуд ирдэг амлалтанд итгэсэндээ, баялгийн араас явдаг болмоор байна уу? Нэр хүндээр хувцаслах гэдгийг юу гэж ойлгож байна?

Залбирал: Тэнгэрийн Бурхан Аав аа, Та надад жинхэнэ даруу чанар, ариун эмээхүйг мөрдөх замдаа бусдын төлөө үйлчлэх тэнгэрийн даалгавраа биелүүлэхэд минь амласан жинхэнэ баялаг, хүндэтгэл, урт насаа хайрлаарай. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Тэнгэрийн Аав минь жинхэнэ ариун эмээхүй, даруу чанарыг мөшгиж яваа надад баялаг, хүндэтгэл, урт насыг амласан.

Ухаарагч хүн цэх замаар явах.

— Сургаалт үгс 15:21

41 | ТӨГСГӨСӨН ШИГ ТӨГСГӨХ

Төгсгөсөн шиг төгсгөх талаар ярилгүйгээр амьдарсан шиг амьдрах тухай ярилтгүй байх. 18-аар бүлэг дээр бид урт наслах талаар ярьсан ч, энэ бүлгээрээ арай дэлгэрүүлж, Эзэнээс эмээхүй, даруу чанар нь энд ямар чухал үүрэг гүйцэтгэдэг талаар судалгаа хийнэ.

ЭЗЭНээс эмээхүй ба даруу дорд байдалд Эд баялаг, алдар хүнд, амь нь шагнал болно. (Сургаалт үгс 22:4)

Ариун эмээхүйн нэгэн гайхмаар ашиг тус нь өдөр хоног маань уртсах юм. “ЭЗЭНээс эмээхүй нь амьдралыг уртасгах” (Сургаалт үгс 10:27). Ёстой догь! Түүнчлэн ариун эмээхүйн цэц ухаан нь “Өдөр хоног чинь надаар уртсах. Амьдралын он жилүүд чамд нэмэгдэх” (Сургаалт үгс 9:11) гэсэн учраас, энэ нь ганц удаагийн явдал биш ажээ. Нас маань уртсаад зогсохгүй, өдөр хоног маань үр бүтээлтэй байх аж.

Энэ тухай дахин Арван тушаал дээр ч баглан хэлсэн. Эзэнээс эмээхүй нь ямар ч болзолгүйгээр аав ижийгээ хүндэтгээд, ингэснээрээ эргээд “Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” (Ефес 6:3) хэмээн амласан. Мөн л урт наслах төдийгүй, үр бүтээлтэй байхыг хэлжээ. Бид залбирахдаа эдгээр амлалтыг гуйж болно.

Нэгэнт үүнийг мэдсэн болохоор, амьдралын чанар чансаа үгүй бол, урт наслахын жаргал үгүйг хэлэх хэрэгтэй. Соломон амьдралынхаа уйд автсан он жилүүддээ “Төрөх өдрөөс үхэх өдөр

дээр” (Номлогчийн үгс 7:1) хэмээн бичиж явжээ. Энэ үгийг бичиж байхдаа тэрбээр амьдрах утга учраа алдаад байсан нь илэрхий байна. Тэгвэл юу амьдралыг чанар чансаатай болгодог юм бэ? Жинхэнэ даруу чанар хийгээд Эзэнээс эмээхүй болой.

Олон жилийн өмнө би залбирал дундаа энэ үгийг уншсан юм:

Уззи хааны өөд болсон жил би Эзэнийг сэнтийн дээр өргөмжлөгдөн дээдлэгдэн заларч, Түүний нөмрөгийн хормой сүмийг дүүргэж байхыг харлаа. (Исаиа 6:1)

Исаиа Эзэнийг хамаг алдраар нь үзжээ. Тэрбээр сэнтийдээ залрагч аугаа хүчирхэг Бурханыг, нүсэр тэнгэрэлч нарыг, тэдний дуу чимээнд байгууламжийнх нь хаалганых нь шон доргин чичирхийлж байхыг үзсэн талаар өмнө уншсан. Энэ явдал Исаиагийн амьдралыг орвонгоор нь өөрчилсөн.

Уг түүхийг уншаад би: “Эзэн минь, би яг үүн шиг Есүсийг цоо шинээр хармаар байна!” гэж хашхирч билээ.

Тэгтэл Ариун Сүнс чихэнд минь: “Би үүгээр энэ түүхийг эхлүүлээгүй. Буцаад эхнээс нь унш” хэмээн шивэглэв.

Би зог туссан ч, Түүний зааснаар үйлдтэл, энэ удаа “Уззи хааныг өөд болсон жил” гэдэг үг хуудсаасаа сугараад гараад ирэв.

Тэгтэл: “Исаиа Намайг цоо шинээр үзэхээс өмнө Уззиа үхэх ёстой байсан” гэх нь сонсогдов.

Тухайн үед би Уззиаг Израилийн юмуу Иудагийн олон хаадын нэг гэдгээс нь өөр юм мэддэггүй байлаа. Тэгээд түүний амьдралыг судлал, нэн сонирхолтой юмсыг олов. Тэрбээр арван зургаахан насандаа Иудагийн хаанаар өргөмжлөгдөөд, тавин хоёр жил хаанчилжээ. Үүнийг үзэглэж суугаа энэ эгшинг хүртэл Жон Бивэр миний бие яг л тавин хоёр жил Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн засаглал дор амьдарсан болно. Тэгэхээр, Уззиа овоо удаан захирчээ.

Арван зургаахан настай хөвгүүн сая сая хүнийг захирах эрх мэдлийг хүлээн авахдаа, маш цэцэн алхам хийж, Бурханыг эрэлхийлжээ. “Тэрээр ЭЗЭНийг эрэлхийлэх тусам Бурхан түүнийг амжилттай болгов” (Шастирын дэд 26:5). Пөөх, үнэхээр амжилтанд хүрч! Бурханы цэц ухаан Уззиаг гараанаас нь л тосложээ. Уззиа эдийн засгаа бэхжүүлж, хотуудаа сэргээж, хүчирхэг зэвсэгт хүчин

байгуулж, аавынхаа алдсан газар нутгийг эргүүлж авчээ. “Ингээд түүний нэр алдар алс хол түгж, тэрээр хүчирхэг болтлоо асар ихээр тэтгүүлж байлаа” (2Шастир 26:15).

Гэвч Уззиагийн хувьд Соломоны нэгэн ижил Эзэнээс эмээхүйг нандигнаагүй юм. Тэгээд ийм эмгэнэл тохиож:

Гэвч хүчирхэг болмогц түүний зүрх сэтгэл ихэд бардам болсноос болж тэрээр завхарч, өөрийн Бурхан ЭЗЭНий эсрэг харш юм хийв.
(2Шастир 26:16)

Уззиа замынхаа эхэнд тээж байсан даруу чанар, Эзэнээс эмээхүйгээ замынхаа дундаас гээжээ. Энэ хүчирхэг ихэр чанар нь эрчилсэн хүчтэй учраас, анх түрэлт өгсөн зан чанар нь алга болчихсон байсан ч, амжилт, үр жимс нь тодорхой хугацаанд үргэлжлэн гарсаар байдаг.

Гэтэл дараагийн эшлэлд тун сонирхолтой зүйл хэлжээ:

тэрбээр... Бурхан ЭЗЭНий эсрэг харш юм хийв. Тэрээр утлагын тахилын ширээн дээр утлага уугиулахаар ЭЗЭНий сүмд орсон юм. (2Шастир 26:16)

Ариун Сүнс надаас: “Хүү минь, зүрхийг нь бардамнал шивэх үед Уззиагийн шашинлаг байдал ихэссэн үү, багассан уу?” гэж асуусан юм. Хариу нь тун мэхтэй болохыг би шууд л ойлгов. Хүн бардам болоход, сүнслэг байдал нь багасдаг гэж би боддог байлаа. Гэтэл Уззиа Эзэний өмнө сүнслэг үйл хийхээр сүмд явж оржээ. Ариун Сүнс надаас үүнийг асуугаагүй бол, би ч үүнийг ойлгохгүй байх байв.

Би ч гайхаж цочирдсондоо, өөрийн эрхгүй: “Уззиа *илүү* сүнслэг болж!” хэмээн дуу алдав.

Ариун Сүнс зүрхэнд минь: “Бардамналын сүнс, шашинлаг сүнс хоёр нь хөтлөлцөж, нэг нэгнээ хаацайлан, бэхжүүлж явдаг юм.” Бардам зан нь хүнийг бардам байгаагаа улайхаас хорьдог бол, шашин нь сүнслэг зан үйлдлээрээ бардам зангаа хаацалдаг.

Ингэтэл Есүсийн үеийн Фарисайчууд санаад оров. Тэр удирдагч нар Уззиатай л адил анх Иеховаг гэх цэвэр хайр, ариун эмээхүйгээр

эхэлж байсан нь лавтай ч, явцын дунд зүрх нь бардамнажээ. Тэд Бурханаас холдсон боловч, сүнслэг зан үйлд оролцох нь улам эрчимжсэн.

Тахилч нар Уzziатай нүүрэлдэж, Бичээсийн бус, болчимгүй явдлыг нь хэлжээ. Гэтэл үнэнтэй нүүр тулсан Уzziа тахилч нарт хилэгнэсэн (Энэ нь даруу зангүй болсныг нь илтгэнэ). Тэгтэл гэнэт духан дээр нь уяман өвчин бий болсон. Уzziа үлдсэн амьдралаа хүнээс тусгаар, тун уйтай өнгөрөөжээ. Хүү нь хаан ширээг залгамжилж, эцэстээ Уzziа өөд болсон.

Энэ түүхийг ард түмний нүдээр харцгаая. Иуда, Иерусалимын хүмүүс хааныгаа уяман өвчин туссаныг нь л мэдсэн. Олон нийтийн сүлжээ яаж тэсрэхийг төсөөлж байна уу? “Яана аа, хаан маань уяман өвчин тусчихаж. Ямар гээчийн гай вэ!” гэсэн коммент урсаад л. Энэ өвчний цаана юу болсныг хэн ч мэдэхгүй. Гэхдээ Ариун Сүнс бидэнд нарийн учрыг нь тайлсан буюу Уzziа ариун эмээхүй, даруу зангаа гээсэн учраас л, ийм гай болжээ.

Үүнийг үзээд би өнөө цаг үеийн талаар Эзэнээс лавлав. Сайн сайхан явж байгаад, хөл алдсан орчин цагийн удирдагч нарынхаа төлөө ч элэг минь эмтэрлээ. Алдаа нь голдуу л гэр бүлээс гадуурх явдал байж таардаг ч, архидалд, хар тамхинд донтох, шунал зэрэг ёрын муу, зохисгүй явдалтай орооцолдсон байх нь ч олонтаа. Үйлчлэлээ биднээс түрүүлж юмуу зэрэгцэж эсвэл бүр сүүлд эхлүүлсэн удирдагч нар унахыг нь гашуудан харж явлаа. Яахаараа ийм хар хэрэг хийдэг байна аа? Ийм замаар яваад сүйрсэн бусдаасаа сургамж авдаггүй гэж үү?

Энэ удаа Ариун Сүнс надад: “Хүү минь ээ, унасан удирдагч нарт гормоны асуудал бус, бардамналын асуудал байсан юм” хэмээв. Бидний гэрчлэн харсан духан дээр туурсан уяман өвчний цаана - завхайрал, ёс бус явдал зэрэг өөр зан үйлдэл л уналтад хүргэдэг. Ариун эмээхүй, даруу занг нь бардамнал эзэлснийг нь бид яахан харах билээ. Ийм юм болох үед гагцхүү Бурхан л мэддэг. Бардамнал нь хүний харааг муутгадаг учраас, удирдагч хүн өөрөө ч өөрийгөө мэдэхгүй.

Хүн гээч нь Бурханыг эрэн хайсныхаа ачаар л хүний зэрэгт хүрснээ сүндэрлэсэн амжилтынхаа сүр хүчинд цохиулахдаа, дорхноо умартах. Халгиж цалгиж явах үедээ “Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй” (Иохан 15:5) гэсэн Есүсийн үгийг бүү маргаарай.

Тэр өдөр Ариун Сүнс үндсэндээ: “Жон, бардамнал чинь хэдий чинээ үхнэ, чи Есүсийг төдий чинээ тод харна” гэдгийг л зааж өгсөн юм. Өөрчлөлт нь амин чухал бөгөөд Есүсийг цоо шинээр харахгүй бол, бид Түүний зэрэгт өсөх боломжоо гээнэ. Амьдралаа сайн дуусгаж чадаагүй олон аугаа эрчүүд, эмэгтэйчүүд даруу зан, ариун эмээхүйгээ алдсанахаа үр дагавраас мултарч чадна гэдэгтээ итгэжээ. Бүү мэхлэгд. Даруу зангаас зуур, Есүсээс бүрэн хамаарч яв, ариун эмээхүйг эрдэнэ мэт нандигна. Үүнийг хийж чадбал, Бурхан баялаг, хүндэтгэл, урт удаан наслахыг амлажээ.

<>< Хувийн эргэцүүлэл ><>

Эшлэл: Хэлж байгааг минь хүлээн ав Амьдралын чинь он жилүүд нэмэгдэх болно. (Сургаалт үгс 4:10)

Санаа: Бардамнал хэдий чинээ үхнэ, Есүсийг төдий чинээ тод харна. Жинхэнэ даруу чанар нь ариун эмээхүйгээс үндэслэдэг. Есүсгүй юу ч хийж чадахгүйгээ мэдэх. Тиймээс, бид бүрэн бөгөөд бүр мөсөн Есүсээс л хамаарахыг сонгоно.

Эргэцүүлэл: Амьдралд минь даруу зан байна уу? “Би өөрөө чадна, мэднэ” гэдэг тал амьдралд минь бий юү? Эзэний зөвлөгөөгүй, өөрөө төлөвлөдөг үү? Түүний баталгааг хайлгүй, толгой мэдэн шийдвэр гаргадаг уу? Тийм бол, энэ хандлагаа хэрхэн өөрчлөх вэ? Талархал нь хэрхэн намайг зоригтой ч, даруу ч байлгадаг вэ?

Залбирал: Аав аа, амьдралынхаа энэ, энэ, энэ тал дээр (тоочин нэрлэ) бардам байсныг минь Есүсийн нэрээр уучлаарай. Өөртөө найдаж, өөрийгөө бусдаас дээгүүр бодсонд уучлаарай. Есүсийн цусаар намайг цэвэрлээч. Би Таны мэлмийн өмнө өөрийгөө даруусгаж, ингэснээрээ бусдыгаа ч өөрөөсөө дээгүүр үзэж байна. Амень.

Шийдвэр: Би даруу зан, Эзэнээс эмээхүйгээр амьдралаа хөтлүүлэх болно.

*Би “Бурхан минь,
тивүүдийг ханаргаж,
биднийг өршөөж,
Танд алдрыг өргүүлэхийн төлөө
Бурханаас эмээхүй,
гэмшлийн сэргэлтийг
илгээгээч” л гэж байнга залбирдаг.*

— Эй Даблью. Тозер

42 | ЭРДЭНЭСИЙГ ОЛОХ

(Санамж: Сэдвийнхээ агуулгыг гүйцэт илэрхийлэх үүднээс энэ бүлгээ арай урт бичлээ. Та номоо өдөр бүр уншиж байгаа бол, энэ бүлгийг өглөө бөгөөд орой уншихад зориулан хоёр хэсэгт хуваасан болно.)

ӨГЛӨӨНИЙ УНШЛАГА: АШИГ ТУСЫГ НЬ НЭГТГЭН ДҮГНЭХЭД

Ариун эмээхүй нь ганц номд багтахааргүй гүн гүн ашиг тусаар хангадаг. Бүгдийг нь нарийвчлан өгүүлэх аваас хэдэн богиор тоологдох биз. Би бараг гучаад жил хайгуул хийхдээ, Бичээсээс Ариун Сүнсний тайлсаар байгаа зүйлсийг өнөө хүртэл биширсээр явна. Тэгэхээр, номлолоо дуусгахаасаа өмнө дахиад хэдэн амлалтыг авч үзмээр байна. Тус бүрийг нь цааш цаашдынхаа судалгаа, нээлтийн оршил гэж үзээрэй. Амлалт бүрийг зүрхэндээ хүлээн ав. Яагаад бүтэхгүйг нь элдвээр бүү шалтаглан тооч. Бурханд сануулан хэл. Бурханаас эмээдэг хүмүүсийн хувьд эдгээр нь олоод, хадгалах ёстой эрдэнэ лугаа адил болой.

ЭЗЭНээс эмээдэг, Түүний замаар замнагч хүн бүр юутай *ерөөлтэй* (*хөөртэй*) вэ! Чи гарынхаа хүч хөдөлмөрийг хүртэх үедээ (*хөөртэй* эдэлж) аз жаргалтай (*хөөртэй*) байх бөгөөд сайн сайхан байна. (Дуулал 128:1-2)

Хоёрхон эшлэлд “хөөртэй” гэдэг үг гурав давтагдах! Бурханаас жинхэнээсээ эмээдэг хүн баяр хөөрөөр бялхдаг. Үүний нэг хэсэг нь ажил хөдөлмөрөө баяр хөөртэй хийх юм. 1980-аад оны эхээр намайг ИВМ (АйБиЭм)-д инженерээр ажиллаж байхад тохиолдсон нэгэн явдлыг би хэзээ ч мартаггүй. Бид хамтрагчийнхаа ажил хөдөлмөрийн

гучин найм дахь жилийн ойг тэмдэглэж байлаа. Ажлынхаа өдрийг эхлүүлэхээсээ өмнө бид хэд түүний албан өрөөнд бөөгнөв.

Баяр ид дундаа орж байтал нөгөө хүн: “Гучин найман жилийн турш өдөр бүр энэ газрыг үзэн ядлаа” гэж хэлтэл, бусад нь ч толгой дохиод, инээлдэв.

Би ч тэнд ажилд ороод хэдхэн сар болж байгаа юу ч мэдэхгүй залуу байсан болохоор, бүр гайхаж орхив. Тиймээс: “Тэгээд яагаад ажиллаад байдаг юм?” гэж асуулаа.

Түүнийг над руу эргэх тэрхэн зуур инээдэм нь ханиадам болж хувираад: “Жон, энэ чинь ажил шүү дээ! Идэж, өмсөхийн тулд ажил хийдэг юм” гэж хариулахад, бусад нь ч санал нэг байгаа нь царайнаас нь харагдав. Би ухаалаг эрчүүдийн дунд зогсоогүйгээ ойлгоод, амаа үдсэн юм.

Би сайн цалинтай ажил хийх гэж л инженерээр суралцсан. Гэтэл тэр хүний үг миний ариун бус айдсыг илчилчих шиг. Тэгээд би өөрийгөө гучин найман жилийн дараа ингэж хэлээд зогсож байхгүй гэж хатуу шийдсэн юм. Энэ айдас миний амьдралыг удирдахгүй, би Бурхандаа итгэнэ. Тэр цагаас хойш би ажил хөдөлмөрийнхөө үр жимсийг ёстой л эдэлж яваа гэдгээ бардам хэлж чадна. Энэ амлалт Бурханаас эмээдэг хэн бүхэнд хүчинтэй.

Магтаалч цааш нь:

Эхнэр чинь гэрийн чинь доторх Үр жимстэй усан үзмийн мод лугаа адил, Хөвгүүд чинь ширээг чинь тойрон буй Чидун модны нахиа лугаа адил билээ. Харагтун, учир нь *ЭЗЭНЭЭС ЭМЭЭДЭГ ХҮН* ийнхүү ерөөгдөх болой (Дуулал 128:3-4) гэжээ.

Та ажил хөдөлмөрийнхөө үр жимсийг эдэлж, хань ижил чинь цэцэглэж, нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой хөвгүүд чинь танаас хөндийрөлгүй, дотно харилцаатай байна. Гэтэл энэ бүхнээр хүмүүс - үнэндээ нийгэм бүхлээрээ гачигддаг. Маш их мөнгөтэй байлаа ч, амьдралдаа сэтгэл дундуур. Хань ижилтэйгээ ч таарахгүй, үр хүүхэд нь ч аав ээжээсээ хол хөндий. Гэр бүл нь цэцэглэхээсээ илүү гундах. Тийм боловч тэнгэрийн найдвар бий.

Энэ амлалтын найдвар нь онцгой бөгөөд ер бусын. Энэ нь чуулганд явдаг юмуу Есүстэй харилцаатай нэртэй хүмүүст зориулагдаагүй, харин онцгойлон “Эзэнээс эмээдэг хүн ийнхүү ерөөгдөх болой” гэжээ.

Уншигч авгай (Энэ нь доромж үг бус, хүнийг авгайлсан хүндэтгэлийн үг болно) таны энэ номын аялал бариандаа орох дөхөж байна. Та Бурханаас эмээхүйг сонгосондоо л энэ хүртэл хамт аялсан буй за. Эдгээр амлалт нь залбирлаар гуйж болох амлалт болой. Ариунаас эмээсний шагнал - амлалтаа авахын төлөө Исаак шиг Бурханы руу хашхираарай. Би ч ийм амлалт амьдралд минь хэзээ ч биелэхгүй байх гэмээр олон сар жилийг туулсан боловч, Бурханы амлалтад найдсаар, залбирсаар байдаг байлаа. Тэгээд тэр бүх амлалт бидний амьдралд биелээд удаж байгааг эдүгээ баттай хэлж чадна.

Бурханаас эмээдэг хүмүүсийн талаар өгүүлсэн өөр нэгэн гүн дууллыг үзье:

ЭЗЭНийг магтагун! ЭЗЭНээс эмээдэг, тушаалуудад нь *ихэд баярладаг* хүн юутай ерөөлтэй! Үр удам нь дэлхий дээр хүчтэй болно. Чигч шударгын хойч үеийнхэн ерөөгдөнө. (Дуулал 112:1-2)

Мөн л ариун эмээхүйтэй “Баярлах” гэдэг үг уялдаж байна. Сүнсний хүч болох баяр хөөр нь аз жаргалын мэдрэмжтэй адил нөхцөл байдлаас хамааралгүй, Бурханы мөнхийн Үг дотор оршин, бидэнд хүч тэнхээ хайрласаар, хавьгүй үр бүтээлтэй, үр жимстэй болгодог.

Түүнчлэн ариун эмээхүй нь хүний хойч үед хэрхэн нөлөөлдгийг дээрх эшлэл хэлжээ. Энэ амлалт биднийг амжилттай болгоод зогсохгүй, үр удам минь ч хүрэлцэх ажээ:

Гэрт нь хөрөнгө баялгууд байна. Зөвт байдал нь мөнхөд тогтоно. Тэрээр хэзээ ч ганхахгүй. Зөвт хүн мөнхөд дурсагдах болно. Тэрээр муу мэдээнээс айхгүй. ЭЗЭНд итгэн түүний зүрх бат болой. Зүрх нь гуйвшгүй. Тэрээр өстнүүдээ харахдаа ч хүртэл айхгүй. (Дуулал 112:3, 6-8)

Саяхан нэгэн итгэгч бүсгүйтэй ярилцаж байтал, тэрбээр энэ амьдрал дуусах үед мөнхийн амьдрал нь эхэлнэ гэв. Тэгэхээр нь би тэр даруй: “Үгүй ээ, дахин төрсөн хүмүүсийн хувьд мөнхийн амьдрал маань хэдийнээ эхэлсэн” гэж хэлсэн юм. Бидний одоогийн хайрын хүч хөдөлмөр өнө мөнхөд үргэлжилнэ. Гэхдээ ариунаар эмээдэггүй хүмүүст энэ амлалт хамаагүй. Үнэндээ харин ч эсрэгээрээ - “Тэдний хайр, хорсол, агаа жөтөө хэдийнэ мөхөж, наран доор хийгддэг үйлсэд тэд цаашид үл оролцох бөлгөө” (Номлогчийн үгс 9:6).

Бурханаас эмээхүй

Бурханаас эмээдэг хүмүүс муу мэдээнээс айхгүй. Олон нийтийн сүлжээ эзэрхсэн энэ цагт үндэсний болоод дагалдах - бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь шар мэдээгээр, тэр дундаа муу мэдээгээр бөмбөгдөж байна. Олон хүн яана даа хэмээн сүрдэж байна. Гэхдээ Бурханаас эмээдэг хүмүүс ирээдүйгээс аюуж, сүрдэх шаардлагагүй бөгөөд харин ч өөртөө итгэлтэй бөгөөд айдасгүй байна.

ЭЗЭНээс эмээгчдэд бат итгэл (*бий*). Энэ нь хүүхдүүдэд нь хоргодох газар. (Сургаалт үгс 14:26)

Ариун эмээхүйг өөртөө итгэх итгэл дагалддаг. Олон хүн үүнд эрмэлздэг ч, олж авах боломжгүйг нь төдөлгүй ойлгох. Миний анд, Техасын нэр хүндтэй пастор Жон Хагээ шиг Бурханаас эмээдэг удирдагчийг би бараг л үзээгүй дээ. 1973 онд нэг этгээд цуглаан дээр нь орж ирээд, Жон руу хоёрхон метрийн зайнаас гар буугаар зургаан удаа буудсан юм. Нэг ч дальдчилгүй, байрандаа бат зогссон Жоныг нэг ч сум оноогүй билээ. Тэр явдлаас хойш тавин жил өнгөрсөн ч, найз маань эрүүл саруул, сайнмэдээгээ номлосоор л яваа. Жоны оронд олон хүн шууд л айж сандчаад, ухаанаа алдан, орилж чарлаад, аль нэг тийшээ нуугдахаар гүйх байсан байх. Гэтэл Жон буутай этгээдийн өдөөс нэг ч цавчилгүй, цоо ширтсээр зогссон гэдэг.

ЭЗЭНий тэнгэрэлч эмээгчдийнх нь эргэн тойронд байж Тэднийг чөлөөлнө. (Дуулал 34:7)

Бурханаас эмээдэг хүнийг тэнгэрэлч нар хамгаалах үүрэгтэй. Шинжээч нар хожим Жоныг чиглэсэн сумны гурав нь зүүн талаар нь 15 см - н зайтай, гурав нь баруун талаар нь 15 см - н зайтай зөрсөн байсныг тогтоосон юм. Хоёрхон метрийн зайнаас ингэтэл зөрж!

Туршлагүй бууч ч хоёр метрийн зайнаас зургаан сум тавихад, ядаж ганц ононо. Тиймээс би л хувьдаа тэр сумыг Бурханы тэнгэрэлч л зайлуулсан гэж итгэдэг.

Иудагийн Иехошафат нь “Зүрх нь ЭЗЭНий замуудад зоригжсон” (2Шастир 17:10) хаан байжээ. Хаанчлалынхаа гуравдугаар онд тэрбээр Бурханы Үгийг заалгахаар улсынхаа хот болгон руу тахилч нарыг илгээсэн. Тэгээд:

Иудагийн эргэн тойрон дахь бүх газрын хаанчлал дээр ЭЗЭНээс эмээхүй байсан бөгөөд тэд Иехошафатын эсрэг дайтсангүй (2Шастир 17:10) гэдэг.

Ариун эмээхүй дотор аугаа хамгаалалт оршвой. Библийн өөр нэгэн жишээ нь гэр бүлээ Бурханаас эмээхүйд удирдан, шүтээнээс нь салгасан Иаков болно. Үүний дараа “Тэд хөдөлсөн бөгөөд тэдний эргэн тойрон дахь бүх хот дээр Бурханы сүрдүүлгэ байсан тул Иаковын хөвгүүдийн хойноос хэн ч мөрдөн хөөсөнгүй.” (Эхлэл 35:5) гэдэг.

Эзэнээс эмээдэг хүмүүст олон зүйл амлагджээ. Энэ үгийг л үзнэ үү:

Өдөр бүр ЭЗЭНээс эмээж амьдар. Ирээдүй чухамдаа буй тул итгэл найдвар чинь үл тасарна. (Чи үүнийхээ төлөө *шагнуулна; найдвар чинь хөсөрдөхгүй.*) (Эхлэл 23:17-18)

Тодруулсан хоёр үгийг үзнэ үү. Эхнийх нь - найдвар хомс үед сүнсний олон удирдагч нар урам үг дээр төвлөрөөд, харин Бурханы Үгийг дагалдах хэрэгсэл болгодог. Яахав, нэгийг эргэцүүлдэг сонсогч нарт нийцүүлэх үүднээс хоёрын зэргийн эшлэл хэлэх боловч, үндсэндээ урам зоригийн түүхээр л нүдээд байдаг. Ийм маягийн түүх нь мэдээж тодорхой хэмжээнд ашигтай бөгөөд хүмүүсийг нэг хэсэгтээ түрдэг ч, Холливүүдийн эр зоригийн дуулиас гавихгүй, ариун эмээхүй шиг мөнхийн *шагналгүй* л эд.

Эзэнээс эмээхүй нь биднийг олон талаар ерөөдөг: Хүслийн биелэл (Дуулал 145:19-ийг үзнэ үү), итгэмжтэй найз нөхөд (Дуулал 119:63, 74, 79), биеийн эдгэрлийг амлаж (Сургаалт үгс 3:7-8), хэний хүү болохыг минь тодорхойлж (Дуулал 60:4), олон хүний мөрөөсдөг амьдралын зүг чигээр хангадаг.

ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ? Түүнд тэрээр сонгох ёстой замыг нь зааварчилна. Сэтгэл нь сайнд оршиж, үр удам нь газар нутгийг эзэгнэх болно. (Дуулал 25:12-13)

Ариун эмээхүйг эс нандигнагч нь ямар ч ухаангүй хүн юм. Та үүний үнэ цэнийг ойлгосон бол, өөртөө хав дараад байлгүй, Иехошафат хаан шиг хүрээнийхээ хүмүүст Бурханаас эмээхүйг заагаарай.

ОРОЙН УНШЛАГА: АРИУН ЭМЭЭХҮЙГ ОЛОХ

Гучаас олон жилийн тэртээ Эзэн надад энэ эрин цагт ариун эмээхүйг тодосгосон эцсийн нүүдлээ хийхээ илчилж билээ. Энэ сэргэлтийн хамгийн том үр дүн нь Есүсийн зорьж ирэх Сүйт бүсгүй - чуулганы талаар Бичээсийн хэлсэн ганц дүрслэлийн биелэл болой. Хэдийгээр “Ач холбогдолтой” чанар нь төөрөгсдөд хүрэхэд чухал боловч, чуулганыг “Ач холбогдолтой” чуулган гэж дүрслээгүй. Хэдийгээр хүчтэй чуулган байгуулахад удирдлага чухал боловч, чуулганыг “Удирдлага төвтэй” чуулган гэж дүрслээгүй. Хэдийгээр хүн ганцаараа бус, харин нийтээрээ байх нь чухал боловч, чуулганыг “Олон нийтийн” чуулган гэж хэлээгүй. Есүсийн зорьж ирэх чуулганыг ганц чанараар л дүрсэлсэн нь:

түүнийг ямар ч толбо, үрчлээсгүй эсвэл алив ийм юмгүй, харин *ариун*, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн билээ. (Ефес 5:27)

Ариун чуулган! Ариун байдал нь Бурханаас эмээхүй дотор л төгөлдөршдөг учраас, Бурхан таныг энэ аугаа сэргэлтийн нэгэн нөлөөлөгч нь болгох хүсэлтэй. Тиймээс, яриагаа дуусгахаасаа өмнө ариун эмээхүйгээ хэрхэн өсгөх талаар заавал ярих хэрэгтэй.

Малайзид болсон мөнөөх мартагдахааргүй, ер бусын цуглааныг дахин санацгаая. Бурханы ер бусын, хүчирхэг оршихуй илэрхийлэгдэх үед би ч аюумшигт автан чичрэхдээ “*Жон Бивэр, чи ганц буруу үг хэлж, ганц буруу үйлдэл хийв ээ*” хэмээн дотроо бодож байлаа.

Ийн бодсоор, тайзан дээр урагш хойш найгаж зогстол, амнаас минь чихийг минь дэлдийлгэсэн нэг үг гараад ирсэн нь “Энэ бол Эзэнээс эмээхүйн Сүнс!” гэсэн зоригтой мэдэгдэл байв. Өмнө ингэж бодож, эргэцүүлж ч явсангүй.

Тэгтэл гэнэт толгой дотор гэрэл цацраад, дотроо: “*Тийм байна шүү дээ. Энэ чинь Ариун Сүнсний илрэл байна!*” хэмээн хашхирч билээ. Үүнийг би өөрөө хэзээ ч ухаж ойлгож чадахгүй байсан ч, Бичээс Есүсийн талаар:

ЭЗЭНий Сүнс, Мэргэн ухааны ба ухаарлын сүнс, Зөвлөгөөний ба хүч чадлын сүнс, Мэдлэгийн хийгээд ЭЗЭНээс эмээхүйн сүнс Түүн дээр оршино (Исаиа 11:2-3) гэсэн юм.

Есүс Ариун Сүнсний илэрхийлэгдэх дээрх долоон замаар бүрэн төгс амьдарсан боловч, Эзэнээс эмээх нь л Түүний хүслэн байжээ. Тэгэхээр, *Эзэнээс эмээхүйн Сүнсийг хэрхэн хүлээж авахыг* мэдэх ёстой. Есүс: “Та нар ёрын муу атлаа хүүхдүүддээ сайн бэлэг өгөхөө мэддэг бол тэр тусмаа тэнгэрлэг Эцэг тань Өөрөөс нь гуйгсдад Ариун Сүнсийг өгөх нь лавтай бус уу?” (Лук 11:13) гэсэн.

Зүгээр л тэнгэрийн Аваасаа гуйх хэрэгтэй. Гэхдээ зүгээр нэг асуусан төдий болох бус, харин хүлээж аван автлаа үнэн голоосоо гуйсан шиг гуйх ёстой. Энэ үгийнхээ өмнө Есүс: “Би та нарт хэлье. Гуй, тэгвэл та нарт өгөгдөнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” (Лук 11:9) гэж хэлсэн нь цөхрөлтгүй, тууштай байхыг л сургажээ.

1994 онд миний бие конференцдээр “Айлын” пасторт донгодуулсан явдлыг санаж байна уу? Маргааш өглөө нь эзгүй барилгын талбай дээр очоод, “Би юун дээр буруудав” гэсэн хайгуулаар эхлүүлсэн залбирал минь эцэстээ ариун эмээхүйн төлөө хашхираагаар өндөрлөж билээ. Би гуйлтдаа “Үгүй” гэдэг хариултыг хүлээж авахгүй гээд шулуудчихсан байсан юм. Тухайн үедээ өөрөө ч ойлгоогүй боловч, тэр залбирал амьдралыг минь орвонгоор нь эргүүлсэн, амин чухал эгшин байсныг эдүгээ мэднэ. Одоо ч Эзэнээс эмээхүйн Ариун Сүнсээрээ өдөр бүр шинээр дүүргэж өгөхийг Аваасаа гуйдаг. Энэ ярианд жинтэй ач холбогдолтой өөр нэгэн Бичээсийг үзье:

Хүү минь, үгсийг минь хүлээн авч, Тушаалуудыг минь дотроо нандигнаваас, Мэргэн ухаанд чих тавьж, Ухаан бодролд зүрхээ зүглүүлвээс, Ухаарлыг чи чангаар дуудаж, Ухаарал ойлголтын төлөө дуугаа өндөрсгөвөөс, Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж, Нууц эрдэнэ мэт түүнийг хайваас ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно Бурханы мэдлэгийг олж авна. (Сургаалт үгс 2:1-5)

Хүн ариун эмээхүйг алдагдсан алмаз, сүйн бөгж, үнэт эдлэлийнхээ араас амь тавьдагтай адил сэтгэлээр л хайх ёстой. Үхлээс ч айхыг

Бурханаас эмээхүй

мэдэхгүй, амь биеэ ч тоодоггүй эрдэнэсийн эрэлчдийн талаар кино, нэвтрүүлэг үзээ биз дээ. Жишээ нь 2004 онд бүтээгдсэн *Нэйшнэл трэжер*¹ гэдэг кино бий. Тэнд 1700-гаад оны үед нуусан эрдэнэсийн санг олохын төлөө амьдарч яваа Бенжамин Гэйтс гэгч залуу гарна. Тэрбээр эрдэнэсээ олохын төлөө цаг, эр хүч, нэр төр, эрх чөлөө - бүгдийг нь золионд гаргана. Яахав, эрдэнэс нь нэг л өдөр замхрах, мөнх бус эд боловч, бидний хувьд тийм хүмүүсийн няцашгүй, тууштай занг нь үлгэрлэн дууриах хэрэгтэй.

Бид яг ийм шийдэмгий зангаар Бурханы Үг, цэц ухаан, тэнгэрийн зөвлөгөө, ариун эмээхүйд хандбал, дийлдэшгүй их ерөөгдөнө. Бид чинь Бурханы мөнхийн эрдэнэсийн төлөө амиа тавьж яваа улс. Бурхан биднээс нуудаггүй. Бурхан бидний төлөө. Бидний хайгуулыг дээрээс захаа мушгин дэмжиж, олзондоо хүрэх үед минь нир хийтэл баярлана. Тэгээд шагналдаа хүрэхэд минь бүр ч их найр наадам хийнэ.

Тэр нэгэн өглөө барилгын талбай дээр миний дотор мэндэлсэн Эзэнээс эмээхүйн ханашгүй өлсгөлөн таны ч дотор төрнө гэдэгт чин сэтгэлээсээ найдаж байна. Үүнийгээ хамгаас үнэт эрдэнэ шигээ элгэндээ нандигнаж яваарай. Ингэж чадсан хүн Бурханы хайрладгийг хайрлаж, үзэн яддагийг нь үзэн ядаж, чухалчилдгийг нь чухалчилна. Та хүмүүсийг гүнээ хайрлаж, тэднийг сүйрүүлэгч нүглийг үзэн ядна. Та нөлөөллийнхөө ертөнцийг өөрчилсөндөө мөнхийн мөнхөд баярлана.

Энэ уралдааныг хэрхэн эхлүүлсэн нь бус, хэрхэн дуусгасан нь л чухал болохыг санаж яваарай. Бидэнд үлэмж найдвар хайрласан дараах хоёр эшлэлийг үзнэ үү:

Та нарыг *бүдрэхээс хамгаалж*, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд...
(Иуда 24)

Тэр та нарыг Эзэн Есүс Христийн маань өдөр гэм зэмгүй байлгахаар төгсгөл хүртэл бататгана. (1Коринт 1:8)

Сайн төгсгөх нь амьдарсан шиг амьдрахын хамгийн чухал тал бөгөөд Бурхан бидэнд үүнийг гүйцэтгэх хүчийг хайрласан. Таныг

Бурханы энэ эрдэнэтэй танилцуулах нь нэр төрийн хэрэг байлаа. Энэ үнэнийг өөртөө дараад байлгүй, цааш нь түгээгээд өгөөрэй. Ойр хавийнхандаа хүргээрэй. Ингэж чадах аваас, айсуй өдрүүдэд гарз хохирол ч бага, чуулган ч эрүүл байна.

Юу юугүй хүрээд ирэх Сүйт залуутайгаа уулзахад бэлтгэх сүйт бүсгүйн ариун эмээхүйн өөрчлөлтийг хөндлөнгөөс нь ажиглаад суулгүй, энэ хүчирхэг нүүдлийн нэг хэсэг болоорой. Та ариун эмээхүйг хайрласнаараа, Сүйт залуутайгаа дотносож, аврал чинь төлөвшиж, үр жимс чинь сагсайж, өнө мөнхийн өв бүтээнэ.

<>< Хувийн эргэцүүлэл >>>

Эшлэл: Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен. (Иуда 24-25)

Санаа: Сайн төгсгөх нь амьдарсан шиг амьдрахын хамгийн чухал тал. Бурханы бэлэг болгож өгсөн ариун эмээхүй таныг эцсээ хүртэл чинь хүчтэй бөгөөд зэмгүй сахина.

Эргэцүүлэл: Ариун эмээхүйгээ өсгөхийн тулд би юу хийж болох вэ? Би ариун эмээхүйд тэмүүлж, эцэж цуцалгүй хөөцөлдөж байна уу? Би үүнийг хамгаас нандин өмч шигээ хайрладаг уу? Ингэж амьдрахын тулд би өдөр тутамдаа юу хийх вэ?

Залбирал: Аав минь ээ, Та намайг Эзэний Сүнсээр, цэц ухааныхаа Сүнсээр, ойлголтынхоо Сүнсээр, зөвлөхүйнхээ Сүнсээр, хүч чадлынхаа Сүнсээр, мэдлэгийнхээ Сүнсээр, Эзэнээс эмээхүйнхээ Сүнсээр дүүргээч. Эзэн Есүс Христийн өдөр ял зэмгүй байхын тулд эцэс хүртэл намайг хүчтэй байлгаач. Есүсийн нэрээр. Амень.

Шийдвэр: Эзэнээс эмээхүй - миний эрдэнэ.

БУРХАНЫ АУГАА ЧАНАРЫН ЗАХ ЗУХААС ...

Нэгэнтээ Израилийн түүхнээ Бурхан хүмүүсийнхээ ариун эмээхүйг өсгөхийн төлөө ингэж асуужээ:

Тэгвэл та нар Намайг Хэнтэй адилтгаж, хэнтэй харьцуулах вэ?
(Исаиа 40:25)

Энэ асуултыг илбээд өнгөрөх бус, элдэж эргэцүүлэх ёстой түүхэн үе байдаг бол, тэр нь өнөөдөр л байх учиртай. Өнөөдөр хүн төрөлхтөн олон нийтийн сүлжээ, гол хэвлэл мэдээ, зурагт зэрэг платформоор өөрийгөө чөлөө завгүй “Алдаршуулж” байна. Алдартай тамирчид, Холливүүдийн гяланцаг жүжигчид тэргүүтэй хэрэгтэй, хэрэггүй хүмүүс зогсоо зайгүй үзүүлэн болсоор. Алдартныг тэнхээ мэдэн алдаршуулах нь наанаа хоргүй мэт боловч, хүний алдраар тасралтгүй тэжээгдэх явдал нь цаанаа Бурханы алдрыг мэдэрч, эргэцүүлэх зайгүй болгох.¹

Лиза, бид хоёр хорин таван жилийн тэртээ хөвгүүдээ өсгөж байх үедээ яг ийм асуудалтай тулгарч билээ. Тэр үед олон нийтийн сүлжээ, апп энээ тэрээ байгаагүй учраас, мэдээллийн урсгал арай л тогтуун байж. Тийм боловч хөвгүүд маань нэр бүхий нэгэн мэргэжлийн сагсан бөмбөгчинд улайраад амжжээ. Тухайн үедээ л Америкийн хамгийн алдартай тамирчин явсан түүнийг олон ч хүн шүтдэг байсан, одоо ч шүтсээр яваа.

Бурханы аугаа чанарын зах зухаас ...

Нэг удаа бид гэр бүлээрээ Зүүн эрэгт үйлчлэхдээ, далайн эргийн нэгэн зочид буудалд буугаад байв. Бид далайн эрэг дээр хэдэн цаг байж байгаад, дөнгөж өрөөндөө орж ирээд байлаа. Хөвгүүд маань нэг ийш, нэг тийш дайвалзуулан, навсайлтал нь цохих Атлантын далайн чанга давалгааг үзээд, айх, бишрэх зэрэгцжээ.

Би ч гурван томтойгоо яриа дэлгэхээр суулаа. Гүйдэг, том шилэн хаалганы цаад руу хуруугаараа заагаад: “Ёстой аймаар том далай байгаа биз?” гэлээ.

Нөгөөдүүл ч дуу дуугаа авалцан: “Харин тх... аа... үү...” л болцгоож байна.

Тэгэхээр нь би: “Бид захыг нь л харж байгаа энэ шүү дээ. Гэтэл энэ далай цаашаа хязгааргүй том” хэмээн гайхууллаа.

Хөвөн зөөлөн алчууртаа шигдсэн хөвгүүд маань: “Пөөх, паах!” л гэнэ.

- “Бас хамгийн том далай ч биш. Үүнээс том ч далай бий. Номхон далай. Энэ хоёроос гадна өөр хоёр ч далай байгаа.”

Хөвгүүд минь дэлгээтэй хаалганы цаана пүс пас цалгилан оволзох давалгаан чимээг сонсонгоо, чимээгүй л толгой дохино.

Энэ үеэр ЭнБиЭй - гийн тоглолт ид дундаа орж байлаа. Нөгөө тоглогчийн ололт амжилтыг хэвлэл мэдээлэл, ИйЭсПиЭн, дээрээс нь хөвгүүд маань найз нөхөдтэйгээ ам уралдуулан ярьж байв. Ялангуяа ганц гараараа бөмбөгөө атгаж байгаа нь манай хэдийг ангайж бүлгийгтэл нь бишрүүлж л дээ. Тиймээс тэр их усыг их бага хэмжээгээр бишрээд байгааг нь далимдуулан: “Хөвгүүд ээ, Бурхан та нарын харж байгаа бүх усыг, дээрээс нь аавынх нь ярьсан бүх усыг атгаж байдгийг мэдэх үү?” (Исаиа 40:12) гэлээ. Тэгтэл... “Донннн!” Нүүрээр нь гайхшрал жирэлзээд л явчихав.

Тэгэхээр нь би цааш нь далайн хэмжээг бус, хүчийг нь аль болох энгийнээр тайлбарлаж өглөө. Тэгээд дөрвөн хүүдээ нэг миллийн (1,6 км) хэмжээтэй солир Нью Йорк хотын эргээс хэдэн зуун миллийн зайтай Атлантын далайд унабал, Америкийн Зүүн эрэг, Каррибын, Өмнөд Америкийн Атлантын эргийн бүх хотыг сөнөөх хэмжээний давалгаа үүсгэхийг хэлэв!2 Үүгээр барахгүй, эргээ дагаж ханарсаар, Европ, Африкийн эргийн хэд хэдэн хотыг ч сүйрүүлнэ. Тэгээд “Тэгвэл бүх далайн ус тэр чигээрээ эргээсээ задарбал, хүн төрөлтхөн яах вэ? Газрын далай ийм хүчирхэг атал

Бурхан усных нь дусал болгоныг гарынхаа алган дээр жинлэж байдаг!” гэлээ.

Дараа нь яриа маань шөнийн тэнгэр рүү халив. Тэгээд ярианд минь автсан хөвгүүдээсээ: “Библи Бурханы аугаа чанарыг өөрөөр бас юу гэдэг гээч?” л гэлээ.

- “Юу гэдэг юм?” л гэгцгээж байна.

“Далайг хэн алгандаа хэмжиж, Тэнгэрийг төөлж тооцоолсон бэ?” (Исаиа 40:12) гэдэг. Би ч гараа урдаа бариад л, төө гэдэг нь эрхий хурууны үзүүрээс чигчий хурууны үзүүр хүртэлх хэмжээ болохыг харуулав. Би тэр өдөр хөвгүүдээсээ асууснаа өнөөдөр танаас асуумаар байна: “Та ертөнцийн хэмжээ хэтийн талаар эргэцүүлж явсан уу? Энэ чинь бидний оюуны хүчин чадлаас давсан зүйл. Ертөнцийн цар хүрээг хальт тунгаах нь Бурханы алдрын хумсын чинээ хараад өнгөрөхтэй л адил.

Одоо миний бичих зүйл бага зэрэг онолын зүйл боловч, би ч хөвгүүддээ тайлбарласан шигээ аль болох хялбарчлах гэж оролдъё, та ч аль болох ойлгохыг хичээнэ үү. Эдгээр баримтыг хичээнгүйлэн тунгаасан хүн Бурхан аугаа чанарт өөрийн эрхгүй уулга алдах. Учир нь “Тэнгэр нь Бурханы сүр жавхланг зарлана...” (Дуулал 19:1) гэх.

Ертөнц дээр тус бүр 100 сая орчим одтой, тэрбум тэрбум галактик байдгийг эрдэмтэд тооцоолдог. Галактикийн өөрийнх нь хэмжээ галактик хоорондын зайнаасаа хамаагүй жижиг.

Манай дэлхийн нар эдгээр галактикийн аль нэгэнд нь оршино. Манай галактик ч хэмжээ хязгааргүй сунайн тогтох бөгөөд бид шөнөөр тэнгэр өөд харахдаа, ертөнцийг бүхлээр нь үздэг бус, ертөнцийн хэлтэрхий болох өөрсдийнхөө аж төрдөг жижигхэн галактикийг буюу Сүүн замыг л үздэг юм. Цаашилбал, манай галактикийн оддын дийлэнх нь хүний дан нүдэнд үзэгдэхээргүй, хол оршдог учраас, үнэндээ бид Сүүн замаа ч бүхлээр нь үздэг бус, өчүүхэн хэсгийг нь л хардаг ажээ.

Тэгвэл шөнө дан нүдэнд харагддаг оддыг авч үзье. Манай дэлхийтэй хамгийн ойр буюу 4.3 гэрлийн жилийн зайтай оршдог од нь нар юм. Тэгэхээр, ихэнх хүн үүнийг сайн ойлгохгүй учраас, жаахан судалгаа хийцгээе. Гэрэл нь цагт биш, *секундэд* 186,282 миллийн хурдтай аялах. Энэ нь цагт ойролцоогоор 670,000,000 милл

болно. Нисэх онгоц цагт дунджаар 500 милл нисдэг. Тэгэхээр, гэрэл нь төсөөлөхийн аргагүй хурдтай аялдаг байна!

Энэ нь ямар галзуу хурд болохыг төсөөлүүлэх үүднээс нар руу аварга том тийрэлтэт онгоц хөөргөжээ гэж бодъё. Дэлхийн нөгөө талд байршдаг Ази тив рүү хийх аялал маань ойролцоогоор нэг хоног буюу 23 цаг үргэлжилдэг. Тэгвэл би тэр онгоцоороо нар руу шууд нислэг үйлдбэл, ойролцоогоор хорин нэгэн жил аялна! Хорин нэгэн жилийн өмнөх үеэ санаад тэр цагаас өнөөдөр хүртэлх хамаг цагаа онгоцонд (Ядаж цонхны дэргэд суусан л байгаасай) өнгөрөөжээ гээд төсөөл дөө. Газраар аялах дуртай хүмүүс ийм аялал хийх ямар ч боломжгүй. Учир нь шатахуун ч нэмэхгүй, морь ч харалгүй, нэг ч зогсолгүй давхисан ч, ойролцоогоор 200 жилийн дараа л хүрнэ! Тэгвэл гэрэл дэлхий рүү хэр хурдтай аялдгийг асууя. Хариулт нь: 8 минут 20 секунд!

За одоо нараа түр орхиод, дэлхийтэй хамгийн ойр өөр нэгэн од руу нүүе. Газраас 4.3 гэрлийн жилийн зайтай оршдгийг хэдийнээ ярьсан. Тэгвэл газар, нар тэгээд хамгийн ойр одны масштабын загварыг гаргабал, иймэрхүү дүр зураг гарч ирнэ: Пропорциор нь дэлхийг хатаасан хар үрлэн перецний хэмжээтэй гэж тооцоолбол, нар нь найман инчийн диаметртэй бөмбөгийн дайтай болно. Яг энэ хэмжээсээр тооцоолбол, дэлхийгээс нар хүртэлх зай нь 26 ярд буюу америк хөл бөмбөгийн талбайны дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээтэй болно. Гэхдээ тэр 26 ярд газрыг онгоцоор 21 жил нисч байж л туулдгийг бүү мартаарай.

За, газар - нарны загвар нь ийм байдаг бол, дэлхийд хамгийн ойр од нь манай үрлэн перец шиг дэлхийгээс хэр хол болохыг таах уу? Мянга, хоёр мянган ярд эсвэл бүр милл гэж бодож байна уу? Ха... хол дутна. Хамгийн ойрхон гээд байгаа од нь манай үрлэн перец - дэлхийгээс дөрвөн мянган миллийн зайд байршина! Түүрүүн гаргасан тооцооллынхоо дагуу, үрлэн перец шиг дэлхийгээ Нью Йоркийн хаа нэгтээ тавьчихбал, хорин нэгэн жил нисч байж хүрэх нар маань Нью Йоркийн хаа нэгтээ 26 ярд газрын зайд байрших бол, дэлхийд хамгийн ойр од нь 1,000 миллийн зайд буюу Лос Анжелесийг өнгөрөөд Номхон далайн хаа нэгтээ очиж байрших нь байна! Тэгээд тийшээ онгоцоор шууд нислэг үйлдэхэд 51 *тэрбум* жил болно! Тавин нэгийн ард 9 тэгтэй жил шүү! Гэтэл оддын гэрэл 4.3-хан жилийн дотор дэлхийд хүрдэг!

За, цаашаа явъя. Шөнө хүний дан нүдэнд үзэгддэг тэдгээр од нь 100 - 1,000 гэрлийн жилийн цаана бий. Гэвч зарим нь бүр 4,000 гэрлийн жилийн цаана ч оршино. (Эдгээр нь манай өчүүхэн галактикийн хамгийн хязгаарын одод биш гэдгийг санаарай.) Би тэдний ядаж нэгэнд нь хүрэхийн тулд онгоцоор ямар хугацааны аялал хийх талаар тооцоо гаргах гэж оролдох ч үгүй. Гэхдээ нэг зүйлийг мэдээрэй: Шөнөөр нүдийг чинь баясгадаг, 4,000 гэрлийн жилийн цаадах, тэдгээр одод нь үнэндээ хурдаа нэг ч саалгүйгээр, цагт 670,000,000 миллийн хурдтай аялагч одны Абрахам, Сарах хоёрыг гэрлэж байх үед үлдээсэн гэрэл газарт хүрч байгаа үзэгдэл гэдгийг!

Түүнчлэн ганц манай өчүүхэн галактик дээрх оддыг л Сүүн зам гэж нэрлэхгүй. Бусад тэрбум тэрбум галактик руу бид ороо ч үгүй! Үүнээс гадна эдгээр галактик нь асар хол зайтай оршдгийг санаарай! Жишээ нь, манай хамгийн ойрын хөрш галактикийг Андромеда гэдэг. Биднээс 2.3 сая гэрлийн жилийн цаана орших! Бодоод үз дээ - тэр галактикаас гэрэл цагт 670,000,000 миллийн хурдтай аялаад байхад л хоёр сая жилийн дараа дэлхийд хүрэх нь! Гэтэл энэ чинь манай хамгийн ойрын хөрш галактик. Гэтэл цаана нь хэдэн тэрбумаараа бий! Үүнийг ойлгоход хүний ухаан сох дутах!

Ийм хэмжээ хязгааргүй ертөнц Бурханы эрхийгээс чигчий хүртэлх сунгаанд л багтаж байдгийг Исаиа мэдэгдснийг сана! Соломон ч Бурханы Сүнсээр “Гэхдээ Бурхан үнэхээр газар дээр оршино гэж үү! Харагтун, тэнгэр болон тэнгэрсийн тэнгэр ч Таныг багтааж чадахгүй билээ. Тэгвэл Миний барьсан энэ өргөө хичнээн ч өчүүхэн юм бэ!” (1Хаад 8:27) хэмээн тунхагласан. Тиймээс, Хэний тухай яригдаж буйг хальт мулт харж эхэлж байна уу?

Энэ бүхнийг хөвгүүддээ ярьж өгсний дараа ЭнБиЭйгийн од байх ёстой байрандаа орж билээ. Бүтээгчийнхээ аугаа чанарыг эргэцүүлснийхээ дараа хөвгүүд маань тэр хүнд сүжрэхээ больсон юм.

Гэхдээ уншигч таныг би нэг алхам цааш явуулмаар байна. Тэнгэрийн Аав минь хэтийдсэн үйлсээрээ ангайлгаад зогсохгүй, нарийн ширийн ураараа ч алдраа алмайртал гайхуулах. Түүний бүтээсэн байгаль дэлхийг судлах гэж шинжлэх ухаан үй олон жил үлэмж мөнгө хөрөнгө зарцуулсаар. Гэтэл Бурханы бүтээлдээ шингээсэн цэц ухааных нь үзүүрт нь л шүргэх. Хариулт олоогүй

Бурханы аугаа чанарын зах зухаас ...

асуулт зөндөө. Бурханы ур хийц, материалын бүтэц нь гайхамшиг хэвээрээ л.

Амьд амьдрал тэр чигээрээ эс дээр тогтдог. Эс нь хүний бие, ургамал, амьдрал тэргүүтэй амьд бүтээлийн бүтэц болно. Инженерийн дээд зэргийн гайхамшиг болсон хүний бие нь ойролцоогоор 100,000,000,000,000 эсээс бүтдэг бөгөөд (Энэ тоог тооцоолж байна уу?) олон ч төрөл зүйлтэй. Бурхан маань дийлдэшгүй цэц ухаанаараа эдгээр эсийг тус бүр тодорхой үүрэгтэй бүтээжээ. Тэдгээр нь цаг цагаараа өснө, үржинэ, үхнэ.

Хүний нүдэнд ил үзэгдэхгүй эдгээр эс нь хүний нээж олсон хамгийн жижиг бүтэц хараахан биш ээ. Эс нь молекул хэмээх өчүүхэн бүтцээс тогтох бөгөөд молекул нь элемент гэгдэх бүр жижиг бүтэцтэй, харин элемент нь атом гэгдэх бүр ч өчүүхэн бүтцээс тогтоно.

Атом нь илэрхийлэхийн аргагүй өчүүхэн бөгөөд өгүүлбэрийн төгсгөлд тавигддаг цэгт л тэрбумаас ч олон атом багтах жишээний. Атом хэдий өчүүхэн боловч, өөрөө тэр чигээрээ хов хоосон орон зайнаас бүрдэнэ. Атомын бусад хэсэг нь протон, нейтрон, электроноос бүтнэ. Протон, нейтрон нь атомын төвд байршдаг маш өчүүхэн нягт цөм дотор бөөгнөн оршино. Харин эрчим хүчний бяцхан бөөм болох электрон нь гэрлийн хурдаар мөнөөх цөмөө тойрон эргэлдсээр оршино. Эдгээр нь юмсыг барьцалдуулан тогтнуулж байдаг бүтэц ажээ.

Тэгэхээр, атом нь хаанаас эрчим хүчээ авдаг вэ? Үүний эрчтэй хэсгийг ямар хүч агуулдаг вэ? Эрдэмтэд үүнийг *цахилгаан соронзон хүч, цөмийн хүч* гэдэг. Эдгээр нь үнэндээ бүрэн тайлбарлаж дийлэшгүй юмаа дүрслэх гэсэн л гоё нэрс юм. Учир нь Бурхан “Эрх мэдлийнх нь үгээр бүхнийг Хүү барьдаг болой” (Еврей 1:3), “Тэр бүх юмсын урьд байна. Бүх юмс Түүгээр оршин тогтнодог” (Колоссай 1:17) хэмээн хэдийнээ айлдсан буюу.

Одоо хэсэг зогсоод, тунгаана уу. Ертөнц ч агуулж дийлэшгүй, бидний Аав болох алдарт Бүтээгч маань ийм ажгуу. Бурхан ертөнцийг алгаараа төөлдөг ч, өчүүхэн дэлхийг болоод үүн доторх бүх бүтээлийг нь тун нарийн ур аргаар бүтээснийг нь хамгийн хөгжингүй шинжлэх ухаанаар судлаад, судлаад өдий хүртэл барахгүй л байна. Магтаалч:

Таны мутрын бүтээл тэнгэрсийг, Таны цогцлоон байгуулсан сар, оддыг Би тунгаан бодму. Хүн гэгч юу болоод Та түүнд санаа тавьж, Хүмүүн гэгч юу болоод Та түүнийг анхаарна вэ? (Дуулал 8:3-4) хэмээн дуу алдсанд ч гайхалтгүй ажээ.

Энэ үг бүхнийг илтгэх бус уу. Миний бодлоор магтаалч Бурханы сэнтийг хүрээлэгч үлэмж тэнгэрэлчийн бодлыг л давтаж хэлсэн болов уу. Тэд Бурханы аугаа чанарын ер бус, хэмжээ хэтийг бишрэхдээ, “Ариун, ариун, ариун” хэмээн тасралтгүй дуу алдсан юм. Бурхан хэрхэн энэ их уудмыг асар түвэгтэй, нарийн бүтцээр урлахыг нь үзсэн тэнгэрэлч нар хожим хүнийг бүтээж буй Бурханы үйл хэргийг үзээд: “Энэ чинь юу вэ? Энэ жижигхэн гариг дээрх бүр өчүүхэн энэ хүмүүст Бурханд юунд ингэтэл анхаарна?” хэмээн дуу алджээ.

Тэр ярианаас хойш хөвгүүд минь энэ үеийн алдартнуудад унаж тусахаа больсон юм. Бурханы яруу алдрын дэргэд энэ гаригийн аливаа сор сод болгон нь зүгээр л ёлтойдгийг тэд ойлгожээ. Та ч бас энэ хавсралтаас нэгийг ойлгосон болов уу. Уншсан зүйлээ Исаиагаар дамжуулан хүмүүсээсээ асуусан Бурханы үгээр гийгүүлэн эргэцүүлнэ үү: “Тэгвэл та нар Намайг Хэнтэй адилтгаж, хэнтэй харьцуулах вэ?” (Исаиа 40:25)

Мэдээж Бурханы бүтээлийн гайхамшиг, цэц ухааны тухай үй түмэн ном бичиж болно. Гэхдээ энэ миний гол санаа биш ээ. Зүгээр, танаар Бурханы бүтээлийн үйлсийг гайхуулж, бишрүүлэх гэсэн л санаатай. Эдгээр нь Бурханы суу алдрыг тунхагладаг болой!

НОМЫН ЗҮҮЛТ

Зохиогчийн тэмдэглэл

1. Чуулганаараа эсвэл жижиг бүлгээрээ Бурханаас эмээхүй номын видео сургалтаар судлалаа хийх боломжтой. Эзэнээс эмээх, эрүүл эмээх сэтгэл болон ариун амьдралаар хэрхэн амьдрах талаар зохиолч Жон Бивэр Бурханы Үгийн дагуу видео хичээлээрээ хөтлөн дагуулна.

Танилцуулга

1. Spurgeon, Charles. “Charles H. Spurgeon Quote,” Quotefancy. Accessed November 15, 2022. <https://quotefancy.com/quote/786372/Charles-H-Spurgeon-The-fear-of-God-is-the-death-of-every-other-fear-like-a-mighty-lion-it>.

Бүлэг 1

1. Номлогчийн үгс 1:8 Мессэж Библи
2. Номлогчийн үгс 1:9
3. Номлогчийн үгс 7:1
4. Номлогчийн үгс 1:15
5. Номлогчийн үгс 12:2–6

Бүлэг 3

1. The Complete Word Study Dictionary
2. Webster, Noah. “Awe.” In Webster’s 1828 American Dictionary of the English Language. Editorium, 2010.

Бүлэг 5

1. Еврей 12:29 tells us God is a “consuming fire”; Ром 8:15 tells us He is Abba Father.

Бүлэг 6

1. Butler’s Lives of the Saints: Concise Edition Revised & Updated, Michael Walsh, ed. (New York: HarperSanFrancisco, 1991), 29–30.

Бүлэг 8

1. “How Many Grains of Sand Are in One Square Inch?” WikiAnswers, accessed September 10, 2022, https://math.answers.com/other-math/How_many_grains_of_sand_are_in_one_square_inch.

Бүлэг 11

1. Johannes P. Louw and Eugene Albert Nida, Greek-English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains (New York: United Bible Societies, 1996), 684.
2. Louw and Nida, Greek-English Lexicon of the New Testament: Based on Semantic Domains, 540.
3. “Signs of Decline & Hope among Key Metrics of Faith: Barna Access.” barna.gloo.us, 2021. <https://barna.gloo.us/articles/signs-of-decline-and-hope>.

Бүлэг 12

1. Louw and Nida, 765.

Бүлэг 13

1. See Luke 5:14; John 6:15; Philippians 2:7 NKJV; Hebrews 5:4; & Isaiah 42:2

Бүлэг 15

1. Spiros Zodhiates, The Complete Word Study Dictionary: New Testament (Chattanooga, TN: AMG Publishers, 2000).
2. Louw and Nida, 433.

Бүлэг 16

1. Louw and Nida, 429.
2. Leon Morris, The Gospel according to Matthew, The Pillar New Testament Commentary (Grand Rapids, MI; Leicester, England: W.B. Eerdmans; Inter-Varsity Press, 1992), 175.

Бүлэг 19

1. C. S. Lewis and Clyde S. Kilby, *C.S. Lewis: Letters to an American Lady* (Grand Rapids, MI: Eerdmans, 1997).

Бүлэг 20

1. Louw and Nida, 662.

Бүлэг 29

1. “Intimate Definition and Meaning: Collins English Dictionary,” Intimate definition and meaning | Collins English Dictionary (Harp-erCollins Publishers Ltd), accessed November 15, 2022, <https://www.collinsdictionary.com/us/dictionary/english/intimate>; “intimus”–WordSense Online Dictionary (15th November 2022) URL: <https://www.wordsense.eu/intimus/>

Бүлэг 35

1. Louw and Nida, 375.
2. See Иохан 3:1–2; 6:26, 66; 12:42; 19:38; Марай 26:14–16.

Бүлэг 38

1. Merriam-Webster.com Dictionary, s.v. “legacy,” accessed November 1, 2022, <https://www.merriam-webster.com/dictionary/legacy>.
2. Ludwig Koehler et al., *The Hebrew and Aramaic Lexicon of the Old Testament* (Leiden: E. J. Brill, 1994–2000), 217.
3. Warren Baker and Eugene E. Carpenter, *The Complete Word Study Dictionary: Old Testament* (Chattanooga, TN: AMG Publishers, 2003), 231.
4. Richard Louis Dugdale, *The Jukes: A Study of Crime, Pauperism, Disease and Heredity*, Georgia State University College of Law Reading Room, January 1, 1969, <https://readingroom.law.gsu.edu/cgi/view-content.cgi?article=1000&context=buckvbell>.
5. Robert Alan Ward, “The Descendants of Jonathan Edwards,” *White Mountain Independent*, September 27, 2019, https://www.wmicentral.com/community_beat/religion/the-descendants-of-jonathan-edwards/article_9e54e16d-59c5-5cf2-a99f-dea187da978a.html.

Бүлэг 39

1. The proper understanding of this Hebrew word is the lure or bait placed in a hunter’s trap. Warren Baker and Eugene E. Carpenter, *The*

НОМЫН ЗҮҮЛТ

- Complete Word Study Dictionary: Old Testament (Chattanooga, TN: AMG Publishers, 2003), 585.
2. Baker and Carpenter, The Complete Word Study Dictionary: Old Testament, 18.

Бүлэг 42

1. Jon Turteltaub, dir., National Treasure, (2005; Burbank, CA: Walt Disney Entertainment), 2005, DVD.

Хавсралт

1. Facts and figures are from a book I wrote years ago, A Heart Ablaze, in Chapter 4, titled “The Glory of the Lord” (Nashville, TN: Thomas Nelson, 1999), 31–44.
2. Since I first wrote this, better scientific models have been created. According to research, coastal towns may be okay if a meteor hits the middle of the ocean. But no one knows for sure what would happen. Here are some interesting articles on the speculation: <https://www.nytimes.com/1998/01/08/us/what-if-huge-asteroid-hits-atlantic-you-don-t-want-to-know.html> and <https://www.space.com/35081-asteroid-impact-ocean-computer-simulations-solar-system.html>.

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайртай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)*



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

Татаж аваарай:  MessengerX.com

САЙНЫГ УУ, БУРХАНЫГ УУ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

ЭРСЛЭН СЭРЭВ

Сэрээд, ертөнцөө өөрчил



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:



MessengerX.com

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:  MessengerX.com

Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл



Та Бурханы Хаанчлал дотор үзэгч юм шиг мэдрэмж тээж явна уу? Үйлчилмээр байгаа боловч хэрхэн гэдгээ мэдэхгүй байна уу? Бурханд үйлчлэхийг хүсдэг ч дараах асуултад хэрхэн хариулаахаа мэдэхгүй зөрчилдөж явна уу: Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Бурханы Хаанчлалын төлөө надад өгөгдсөн бэлэг авьяас ямар үүрэгтэй вэ? Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч байгаа гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Би “Чуулганд” бүтэн цагаар үйлчилдэггүй. Тэгэхээр миний дуудлага чухал биш гэсэн үг үү гэх мэт асуулт танд байна уу?

Тэгвэл энэ бүх асуултад энэхүү ном хариулах болно. Бурханаас хүлээн авсан бэлэг авьяасаа үржүүлэн Түүнийг алдаршуулж амьдрахад тань энэ ном чиглүүлж тусална.

Хүндэтгэлийн шагнал

Мартагдсан чанарын хүчийг сануулахуй



Христэд итгэдэг хүн Бурханыг хязгаарлахыг хүсэхгүй ч, олонх маань “хүндэтгэл” хэмээх сүнсний нэгэн зарчмыг мэдэхгүйгээсээ болоод амьдралд маань хүрэлцэх Бурханы чадварыг санаандгүйгээр хумидаг байна. Хүндэтгэл нь манай соёлд мартагдах шахсан ойлголт болсон хэдий ч, энэ нь Бурханы хаанчлалыг бидний амьдралын тал бүр дээр нэвтрүүлэгч гол судас болохыг та энэ номын хуудсаас харах болно.

Хүндэтгэлийн шагнал номдоо Жон Бивэр таныг Бурханы үнэлэмжийн системтэй зэрэгцүүлж, Бурханы ерөөл бүрийг хүлээн авах байр сууринд гаргах хүндэтгэх дуудлагыг хэрхэн хүлээж авахыг зааж өгчээ. Библийн хөдлөшгүй үнэнийг эдгээр зарчмыг үйл хөдлөл болгох хүчирхэг түүхтэй хавсаргасан энэ ном танд энэхүү мартагдсан чанарыг цоо шинээр харах хараа өгөхөөс гадна хамгийн чухал нь үүнийгээ амьдралынхаа тал бүр дээр хэрэгжүүлэх гал халуун хүсэл тэмүүллийг авчирна.


Татаж аваарай:



MessengerX.com

АДАМАНТ

Олон санаат ертөнцөд үнэнийг олох



Үнэн гэж юу вэ? Энэ бол манай цаг үеийн тодорхойлогч асуулт. Хүн бүр өөрийн гэсэн санал бодолтой бөгөөд үнэнийг олох улам л хэцүү болсоор байна. Үүний шалтгаан нь магадгүй бид *хэнийг* хайх ёстой байтал, *юуг* хайгаад байгаагаас тэр биш үү?

Үнэнд нэр бий. Үнэн нь цаг хугацаанаас урт, энэ эгшнээс илүү бодитой бөгөөд соёлын урсгалыг дагаж мяралздаг гол биш, харин хөдлөшгүй, ялагдашгүй, доргишгүй хад - бид бүгдийн болохыг хүсдэг булангийн чулуу юм.

Гүн гүнзгий теологийн шинжтэй атлаа дэндүү дотно бичигдсэн “Адамонт” ном нь олон санаагаар хуйларсан энэ ертөнцөд зангуу чинь болж, зүг чигээ алдсан энэ дэлхий дээр чамд тодорхой чиг харуулах болно.

Татаж аваарай:



[MessengerX.com](https://messengerx.com)

Бурханд ойрт

Бурхантай дотно амьдрахуй




Бурхан бидэнтэй дотно нөхөрлөх хүсэлтэйг Бичээс ахин дахин хэлдэг. Бид Бурхан руу ойртохдоо, Ариун Сүнсний оршихуй нь бидний амьдралд тохиосон, хамгийн эрч хүч хайрлам, гайхамшигтай, өөрчлөгч үйл явдал болохыг олж мэддэг. Өөрт байхгүйгээ ч мэдэхгүй зүйлээ хүсэх боломжгүй. Харамсалтай нь, олонх маань Бурхантай дотно амьдрах амьдралыг эдлэхгүйгээр, зүгээр л хөндий хоосон шашиндаа л ханачихдаг.

Бид Бурханы ариун чанарыг үл хэрэгсэх бөгөөд Ариун Сүнсийг хүлээж авахын тулд амьдралаа цэвэрлэхгүй атлаа Ариун Сүнсээр дүүрэх гээд байдаг. Гэтэл бид чинь Бурхантай ойр дотно байхын төлөө бүтээгдсэн бүтээлүүд. Ертөнцийн Бүтээгч бидэнд Өөрийг нь алс холоос зан үйл, үгээрээ хүндэтгэх бус, харин та Бурханы зүрхийг мэддэг, Бурхан таны зүрхийг мэддэг, утга төгөлдөр, дотно харилцаатай байх урилга өгчээ.


Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

X MessengerX

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 125 гаруй хэлээр үнэ төлбөргүй
- Апп болон онлайнаар үзэх боломжтой
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

Бурханаас ЭМЭЭХ ГЭЖ ЮУ?

Та Бүтээгчтэйгээ дотно нөхөрлөхийг хүсдэг үү?

Тэр танаас нэг л хол, бүр хүрэшгүй мэт санагддаг уу? Тэгвэл Бурхан танд тун ойр байдаг боловч, таны зүгээс Бурхантай хамт алхаж амьдрахдаа нэгэн зүйлийг буюу чухамдаа Бурханаас эмээхүйг гээгдүүлсэн байж болзошгүйг Жон Бивэр батлан өгүүлжээ.

Энэхүү номдоо Жон Бивэр авралаа айдас чичрэлээр гүйцэлдүүлэх нь юу гэсэн үг болохыг цоо шинээр харуулахдаа, энэхүү чанар нь ор тас мартагдснаас болж, бүрэн бүтэн, үр жимстэй амьдралд хүргэдэг зам нь ул болсныг сануулжээ. Ариун эмээхүй нь:

- Бурхантай дотно байхын амин чухал чанар
- Бусад бүх айдас, зовнилоос чөлөөлдөг
- Бидний дотоод сэдэл, санааг цэвэршүүлдэг
- Биднийг жинхэнэ цэц ухаан, ойлголт мэдлэгт хүргэдэг бөгөөд

Бурханы бидэнд зориулсан амьдралыг тайлдаг байна. Энэ чанарыг хөгжүүлж, үүнээс зуурсныхаа ачаар л бид бусдын олж авч чаддаггүй амар тайван, баяр хөөрийг олно. Бурханаас эмээхүй нь биднийг Бүтээгчийнхээ өмнө бэмбэгнэж амьдруулах бус, харин ч мөнхөд өөрчилж, амьдралын тээ өөр, өндөр төвшинд амьдруулна.



ЖОН БИВЭР Бурханы Үгийг найраагүй, зоригтой заадгаараа алдартай, олон улсын номлогч, шилдэг борлуулалттай номын зохиолч. Түүний ном дэлхийн 125 хэл дээр хөрвүүлэгдэж, хэдэн сая хувиар борлуулагдсан болно. Тэрбээр гэргий Лизатайгаа дэлхийг өөрчлөгч Христийн үнэнч дагалдагч нарыг хөгжүүлэх зорилготой Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үүсгэн байгуулсан юм.



Үнэ төлбөргүй материал татаж авах бол **MessengerX.com**

Скэйндана уу



Энэхүү ном нь **ЗОХИОЛЧИЙН БЭЛЭГ** тул **ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.**